

**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
НИЙГМИЙН УХААНЫ САЛБАР**

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

ПОЛИТОЛОГИ

№ XVI

**МУИС ПРЕСС ХЭВЛЭЛИЙН ГАЗАР
2018он**

POLITOLOGY
SCIENTIFIC JOURNAL

№ 16 ()

XVI

ISSN 2227-6904

Key title: Politology

EDITORIAL BOARD

Editor in chief:	Turtogtokh.J
Associate Editor	Munkhbat.S
Secretary:	Batbold.Ts
Board members:	Ganbold.Ts
	Dovchin.Yo
	Bazarpurev.S
	Tsend-Ayush.G
	Ulziisaikhan.Ch
	Undrakh.D
	Bumdari.D
Technical Editor	Yesukhei.T

ПОЛИТОЛОГИ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№16 ()

XVI

ISSN 2227-6904

Key title: Политологи

РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ:

Эрхлэгч:

Ж.Төртогтох

Орлогч эрхлэгч:

С.Мөнхбат

Нарийн бичгийн дарга:

Ц.Батболд

Гишүүд:

Ц.Ганболд

Ё.Довчин

С.Базарпүрэв

Г.Цэнд-Аюуш

Ч.Өлзийсайхан

Д.Ундрах

Д. Бумдарь

Техник редактор:

Т. Есүхэй

АГУУЛГА

Өмнөх үг.....	9
---------------	---

УЛС ТӨРИЙН ОНОЛ, ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Д.Болд-Эрдэнэ Улс төрийн философи сэтгэлгээний үечлэл.....	10
Ц.Ганболд, Л.Идэр “Цагаан түүх” дэх улс төрийн үзэл санаа, түүхэн нөхцөл байдал.....	20
Г.Цэнд-Аюуш, Н.Ариунаа Анархизм – нийгэм-улс төрийн аядуу үзэл баримтлал болох нь.....	27
Ц.Батболд Төр төвтэй үзэл ба түүний онолын хувьсал өөрчлөлт.....	30
Ч.Баатар Төр хувийн хэвшлийн түншлэлийн талаарх онолын зарим асуудлууд.....	44

УЛС ТӨРИЙН ИНСТИТУТ

Turtogtokh Janar The Legislature and Political Development: A Comparison between Korea and Mongolia.....	59
Д.Сүхболд Хоёр танхимтай парламентийн ангилал, хэв маяг.....	79
Д.Ундрах Парламентийн гишүүний хариуцлагыг дээшлүүлэх шаардлага, арга зам.....	93
Ц.Батболд Баялгийн үндэсний үзэл ба Монгол дахь шинэ колоничлолын шинжүүд.....	102
Н.Бурмаа Үндсэн хууль үеэ өнгөрөөн өөрчлөгддөг, харин санхүүгийн хяналт оршин тогтносоор байдаг ..	121

АРДЧИЛЛЫН ОНОЛ, ПРАКТИК

С.Базарпүрэв, Б.Насанбат Ардчилал ба боловсролын харилцан хамаарлын асуудал.....	135
--	-----

Д.Бумдарь	
Шууд ардчиллын хэлбэрүүд: Харьцуулсан судалгаа.....	143

ХАРЬЦУУЛСАН УЛС ТӨР, ЭМПИРИК СУДАЛГАА

Д.Оюунчимэг, Г.Цогтдэлгэр	
Иргэдийн улс төрийн үзэл суртлын тархалтыг улс төрийн газарзүйн үүднээс тодорхойлох судалгаа.....	154

У.Батцэрэн, Ү.Батбаяр	
Улс төрчийн имиж бүрдүүлэх технологи ба улс төрийн мэргэжлийн онцлог.....	169

Ч.Өлзийсайхан, Ц.Өлзийжаргал	
Монголын нийгмийн дүр төрх.....	177

Г.Цэнджав	
Олноо өргөгдсөн Монгол улсын эдийн засгийн тусгаар тогтнолын асуудалд.....	187

М.Батбаатар	
Хүн амын шилжин суурьших үйл явц: Хотжилт ба хөгжлийн сорилтууд.....	196

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

А. Жамбал	
Арабын улс төрийн сэтгэлгээ.....	211
Исламын улс төрийн сэтгэлгээ.....	215
Еврейн улс төрийн сэтгэлгээ.....	221
Панарабизм ба панисламизм.....	226

CONTENTS

Foreword.....9

POLITICAL THEORIES AND CONCEPTS

Bold-Erdene D.,
Historical periods in political philosophy10

Ganbold Ts., Ider L.
Political ideology and historical situations in the “Tsagaan tuukh”.....20

Tsend-Ayush G., Ariunaa N.
Anarchism as a moderate socio-political ideology27

Batbold Ts.
State centrism and its theoretical evolution.....30

Baatar Ch.
Some theoretical issues of public and private sector partnership.....44

POLITICAL INSTITUTIONS

Turtogtokh Janar
The Legislature and Political Development: A Comparison between Korea and Mongolia.....59

Sukhbold D.
Classification and typology of bicameral parliament.....79

Undrakh D.
Methods and requirements of increasing political responsibility of Parliament members.....93

Batbold Ts.
Resource nationalism and features of neocolonialism in Mongolia102

Burmaa N.
While constitution changes, financial control exists.....121

DEMOCRATIC THEORY AND PRACTICES

Bazarpurev S., Nasanbat B.
Interdependence of democracy and education.....135

Bumdari D.
Direct democracy: Comparative analysis.....143

COMPARATIVE POLITICS, EMPIRICAL STUDIES

Oyuncimeg D., Tsogtdelger G.
Study of defining public political ideologicdissemination according to political geography.....154

Battseren U., Batbayar U.
Political image making technology and peculiarities of political vocation169

Ulziisaikhan Ch.Ulzijargal Ts.
Socialappearance of Mongolia.....177

Tsendjav G.
For the issue of economic independence of Mongolia in 1910s.....187

Batbaatar M.
Population migration process: Urbanization and development challenges.....196

GLOSSARY TERMS

Jambal A.
Arabic political thoughts.....211
Islamic political thoughts.....215
Jewish political thoughts.....221
Pan-Arabism and Pan-Islamism226

ӨМНӨХ ҮГ

МУИС-ийн Улс төр судлалын тэнхимээс эрхлэн гаргадаг “Политологи” эрдэм шинжилгээний сэтгүүлийн ээлжит дугаар эрхэм уншигч та бүхний гар дээр очиж байна. Сэтгүүлийн маань энэхүү дугаар нь өмнө гарсан цувралуудын ололт, амжилт, туршлага дээр суурилсан болно.

Дэлхий дахины улс орнуудын харилцаа, хамтын ажиллагаа өргөжин тэлэхийн хэрээр улс төрийн мөн чанар, агуулга улам бүр гүнзгийрч түүний үүрэг роль өсөн нэмэгдсээр байгаа билээ.

Ийм учраас улс төрийн мөн чанарыг ойлгон таниулах, энэ талаарх зөв үнэлэлт дүгнэлтийг өгөх улс төрийн мэдлэгийг бий болгодог улс төрийн шинжлэх ухааны гүйцэтгэх үүрэг их юм. Эдүгээ улс төрийн шинжлэх ухааны онол-арга зүй, судалгааны аргахэрэгсэл, улам нарийсан хөгжиж онолын болон эмпирик судалгаа шинжилгээний мэдлэгүүд даяаршиж байна.

Улс төрийн мэдлэгийн даяарших үйл явц нь дэлхий дахин, бүс нутаг, улс орнуудад ардчилсан хөгжлийн ололт амжилтыг баталгаажуулах, түүнийг хөгжлийн шинэ шатанд гаргахад чухал үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд цаашид ч гүйцэтгэсээр байх болно.

Монголд шинээр үүсэн төлөвшиж буй улс төрийн шинжлэх ухааныг хөгжүүлэх үйлсэд энэ салбарын эрдэмтэн судлаачид ихээхэн хүчин чармайлт гаргаж байдгийн тодорхой нэг илрэл нь энэхүү сэтгүүл юм. Сэтгүүлийн эл дугаарт улс төрийн онол, үзэл баримтлал, улс төрийн институт, ардчиллын онол, практик, харьцуулсан улс төр, эмпирик судалгаа, улс төрийн түүх, нэр томъёоны тайлбар зэрэг улс төрийн шинжлэх ухааны олон чухал сэдвүүдээр эрдэмтэн судлаачдын бичсэн өгүүллүүдийг нийтэллээ.

Манай сэтгүүл дугаар тус бүрдээ улс төр судлалын салбарт сурч буй магистрант, докторант, удирдагч багш нарын эрдэм шинжилгээний хамтарсан бүтээл, өгүүллэгүүдийг байнга нийтэлдэг. Мөн манай сэтгүүлд гадаад, дотоодын судлаачдын өгүүллийг байнга хэвлүүлдэг. Ийнхүү бид сэтгүүлийнхээ чанарыг сайжруулж олон улсын түвшинд хүргэх зорилт тавин ажиллаж байна.

РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ
УЛС ТӨРИЙН ФИЛОСОФИ СЭТГЭЛГЭЭНИЙ ҮЕЧЛЭЛ

Д.Болд-Эрдэнэ

*ШУА-ийн Философийн хүрээлэн. Эрдэм шинжилгээний
тэргүүлэх ажилтан, салбарын эрхлэгч, доктор (Sc.D), профессор*

Keywords. Philosophy, political philosophy, period of political philosophy mentality, classic political philosophy, modern political philosophy

Улс төрийн философи сэтгэлгээний үечлэл

Улс төрийн философи нь уг чанаратаа философи юм. Тиймээс философид хамаарах бүх зүйл улс төрийн философид мөн хамаатай. Философи нь туулж өнгөрсөн замаа эргэн харж, түүнээс ямагт суралцаж цаашид дэвшин өөрчлөгдөх боломжоо эрж хайж байдаг. Философич Жон Шанд “Бусад ухаан үүсэхэд нөлөөлсөн өнгөрсөн дэх тэр зүйл рүүгээ эргэж хандах, түүнээс сорьц авах явдал философид их байдаг. Философи нь амьдрал болон сэтгэлгээнээс урган гардаг тэр асуудлыг байнга авч үздэг. Түүхийн янз бүрийн үеүдэд байсан сэтгэгчидтэй холбогдож, тэдэнд байгаа зарим гол асуудлуудыг олж хардагт философийн сэтгэл татам шинж чанар оршино”¹ хэмээн бичсэн нь сонирхолтой байна.

Улс төрийн философи бол түүхэн үзэгдэл. Харин үүний илрэл, үзэгдэх байдал нь улс төрийн философийн үзэл сэтгэлгээ юм. Улс төрийн философи сэтгэлгээний түүх нь улс төрийн амьдралын салшгүй хэсэг, түүний тусгал болдог. Философийг зарим хүмүүс зөвхөн философичдын эцэс төгөсгөлгүй хийсвэр маргаан төдийгөөр ойлгох нь байдаг. Тэгвэл энэ нь Б.Расселийн хэлсэнчлэн “Эрт дээр үеэс эхлээд философи нь аливаа нэг тогтсон сургууль болон цөөн тооны эрдэмтдийн хооронд явагдаж буй маргаан төдий зүйл байсангүй. Тэрээр нийгмийн амьдралын салшгүй нэг хэсэг байсаар ирсэн...”² Энэ агуулгаараа улс төрийн философи сэтгэлгээ нь хүн төрөлхтөний түүхийн бүхий л үед оршин үйлчилж ирэхдээ тухайн бүс нутгийн онцлог, хүн ард түмний соёл иргэншил, сэтгэх хэв шинж, амьдралын хэв маяг, нийгэм дэх олон бүлэг давхаргын эрх ашиг, сонирхол, үзэл санааны оюунлаг тусгал болсоор иржээ.

¹ Philosophy and Philosophers J Shand Penguin 1994 p. 9

²Бертран Рассел. Өрнийн философийн түүх: Эртний философи. I боть. (Орч: Н.Энхцогт, Ц.Алтантуяа) УБ., 2012, 9 дахь тал.

Улс төрийн философийг танин ойлгох үйл явцын нэг үндсэн чиглэл нь түүний үзэл санааны түүх, уламжлалыг сэргээн санаж, судлах явдал юм. Ингэж судлах нь сэтгэлгээг *түүхчлэх ойлгох арга хандлагатай* холбоотой. Философич Мэл Томпсон үүнтэй холбогдуулан “Түүхэн хандлагыг хүлээн зөвшөөрөх явдал философийн хувьд маш чухал. Өнөөдөр ч гэсэн философи сэтгэлгээ өнгөрсөн үед байсан асуудлуудтай холбоотой ... Платоны нийгмийн тухай үзэл болон бодит байдлын мөн чанарын тухай ойлголт, Аристотелийн шалтгаант чанарын тухай санаа, Декартын тодорхой байх шаардлага зэрэг нь эдүгээ ач холбогдлоо алдаагүй байна, тэгээд ч тэдгээр нь өнөөгийн хандлагатай гарцаагүй холбогддог. Тэр ч бүү хэл, тэр үеийн ойлголт, категори өнөөдөр ч хэрэглэгдсээр байна. ...Философи нь өнгөрсөнөөс сорьц авч байдаг. Энэ нь одоогийн зүйл гарч ирсэн тэр суурийг “малтаж” буй хэрэг бөгөөд үндэслэгээ, тайлбаруудын баталгаажсан байдлыг олж харах гэсэн оролдлого юм”³ гэж бичсэнээс үзвэл түүхчлэх хандлага нь улс төрийн философийн өнгөрсөнөө эргэн санах, туулсан зам мөрөө шинжих гол арга болох нь тодорхой байна.

Улс төрийн философи сэтгэлгээг түүхчлэх нь аргачлалын хувьд олон талтай ч энэ нь уг чанартаа сэтгэлгээтэй холбоотой үзэл санааны түүхэн баримтыг задлан шинжилж, нэгтгэн цэгцлэх, бүлэглэн ангилах явдал юм. Философич Генрих Струве бичихдээ “Түүхийн баримтуудын задлан шинжилгээ бол философийн үндсэн зорилтуудыг шийдвэрлэх, нийтлэг ертөнцийг үзэхүйг буй болгох учиртай түүний зорилгод хүрэх зөвхөн нэг хэрэгсэл юм. Энэ зорилтыг бүрэн биелүүлэх явдал зөвхөн түүхэн үнэний салангад элементүүдийг үзүүлсэнээр бус харин эдгээр элементийг нэгэн, бололцооны хэрээр бүрэн, цэгцтэй бүхэлд холбох өөрөөр хэлбэл тэдгээрийг нийлүүлэн нэгтгэсэнээр нөхцөлдөнө. Хамгийн бие даасан сэтгэгч ч гэсэн шинэ, хавигүй сайн ертөнцийг үзэхүйг бүтээх эрмэлзэлдээ өмнөх үеийнхээ нээсэн үнэнүүдийг ашиглах ёстой. Тэгэхдээ энэ нь шинжилгээнд агуулагдаж байгаа маргашгүй баримтуудыг синтезлэж гаргасан түүхийн шинжилгээг гүйцээсний үндсэн дээр л бололцоотой юм.”⁴ гэж бичээд цааш нь онцлохдоо “философийн талаарх түүхэн синтезийн анхны зорилт бол өнгөрсөн үеийн философийн эх сурвалжуудыг зохих ангиллын дагуу бүлэглэх явдал юм. Энэ эх сурвалжуудыг нь бид *философийн чиглэлүүд* буюу *сургуулиуд* гэдэг нэрээр төсөөлдөг юм...”⁵ гэсэн нь анхаарал татаж байна.

³Мэл Томпсон. Философи. Удиртгал 24 дахь тал.

⁴ Г.Струве. Введение в философию, разбор основных начал философии вообще. Хрестоматия по философии. Составители: П.В. Алексеев, А.В. Панин. М., 1998, С. 39

⁵ Мөн тэнд. С. 39

Түүхэн үечлэлийн арга нь улс төрийн философи сэтгэлгээний түүхийг судлах түүний олон арга хандлагын зөвхөн нэг чиглэл нь юм. Энэ нь улс төрийн философийн үзэл санааны олон урсгал чиглэл, сэтгэгчдийн үзэл санааны хувьсал өөрчлөлтийг тодорхой түүхэн цаг үеүүдээр нь ялган зааглаж, өөр хооронд нь харьцуулан жишиж, тэдгээрийн ялгаа онцлог, нийтлэг шинжүүдийг тодруулж, түүний хөгжлийн түүхэн бүхэл үйл явцыг оюун санаандаа “сэргээн санах” боломжийг олгодог. Тийм болохоор хүн төрөлхтөний олон зууны туршид хуримтлуулсан философи, улс төрийн үзэл санааг философичид эмхлэн цэгцэлж, эрэмбэлэн үечлэх оролдлогыг ямагт хийсээр иржээ. Энэ чиглэлээр түүхэн үечлэлийн олон арга зүй, хандлага гарч ирсэн байдаг.

Философчид хүн төрөлхтөний улс төрийн философи сэтгэлгээний онол, түүхийг хэлбэршилийн (формацийн) болон бүс нутаг, цаг хугацааны ангилалын дагуу үечлэн судалж иржээ. Харин сүүлийн үед цаг хугацаа, бүс нутаг, иргэншлийн ангилалын арга зүйг нэг мөр баримтлан сэтгэлгээг голлон судлах болсон байна. Энэ арга хандлагын үзэл санааны үндсийг А.Тойнби, О.Конт, М.Дюверже, К.Дойч, Р.Арон, Лео Штрауснар тавьж, тэдний бүтээл, туурвилд энэ нь тусгалаа олж, нарийвчлагдан боловсрогджээ.

Английн түүхийн философич Арнольд Жозеф Тойнбигийн хүн төрөлхтөний түүхийн үечлэлийн үзэл санаа нь улс төрийн философи сэтгэлгээний түүхийн үечлэлд онцгой нөлөөтэй юм. Тэрээр түүх бол үл тасалдах чанарын илрэл гэж үзэж байв. Учир нь түүнийхээр хүн төрөлхтөний түүх бол амьдрал тасралтгүй байдагтай адил тасралтгүй үргэлжилдэг. Түүхийн үл тасалдах чанар нь мөн орон цагийн тасралтгүй шиг хүн төрөлхтөний оршихуйн тасалдлыг “юүлж урсгаж буй” хэрэг. Хөдөлгөөний мөч бүр дараах мөчийн эхлэл болохын хамт бас бие даасан, төгс бүхэл чанартай байдаг. Үүний илрэл нь нийгэм, иргэншлүүд юм. Салангид иргэншлүүд бол өөртөө явцуурсан түүхийн арлууд биш, цаг хугацааны үе шатууд юм. Цаг хугацаа буй дор, зөвхөн тэнд л түүх оршино. Цаг хугацаа бол хүн нийгмийн төлөв байдал өөрчлөгдөж солигдоход нөлөөлдөг талбар юм. Чухамхүү энэ халаа сэлгээгээр түүхийн агуулга илэрдэг. Түүхч нь “цаг хугацааны өртөөчин” юм. Цаг хугацааг өртөөлөн буухиалах энэ үйл явцад ой санамж онцгой ач холбогдолтой гэж тэр үзээд хүмүүний туршлага хуримтлах, хөгжих хүрээ болох түүх, цаг хугацааг эмхлэн цэгцлэх хэрэглүүр болох ой санамж хоёрын жам ёсны гүн холбоог онцлон дурдсан байдаг.⁶ А.Ж.Тойнбигийн түүхийн үечлэлийн энэхүү философи нь улс төрийн философийн түүхийн үечлэлийн арга зүйн суурь, тулгуур болж байдаг.

Философич, нийгэм судлаач К.Дойч улс төрийн үзэл, сэтгэлгээ хийгээд мэдлэгийн ямар ч салбар ухаан үүсэл, хөгжлийн үйл явцад *философийн; эмпирик,рефлексийн буюу*

⁶A.J.Toynbee. A Study of History 1934-1961

эмпирик байдлыг хянан засварласан үе хэмээх гурван үндсэн үе шатыг туулсан болохыг онцлоод түүндээ тохирсон үечлэлийн аргачлалыг санал болгосон байдаг. Түүний үзэж байсанаар *эхний үе* буюу *философийн үе* нь он цагийн хувьд барагцаалбал Платон, Аристотелийн үеэс 1861-1865 оны Америкийн иргэний дайн хүртэл;*хоёр дахь үе болох эмпирик үе* нь Америк дахь иргэний дайнаас дэлхийн II дайн хүртэл үргэлжилсэн. Улс төрийн философийн хөгжлийн гуравдахь үе дэлхийн II дайны дараа эхэлж өнөөг хүртэл үргэлжилжээ гэж үзсэн байдаг.⁷

Улс төрийн философи сэтгэлгээний хөгжлийн түүхийг үечлэн авч үзэх К.Дойчийн ангилалын зэрэгцээгээр Францын улс төрийн философич М.Дювержегийн үечлэлийн арга зүй улс төрийн философийн түүхийг бодитой авч үзэж, судлах явцад жинтэй үүрэг гүйцэтгэдэг. М.Дюверже улс төрийн үзэл санаа хөгжлийнхөө явцад дараах үндсэн гурван түүхэн үеийг туулсан гэж үзсэн байна.

Энэ нь; *нэгдүгээрт, эртнээс-ХVIII зуун хүртэлх үе*. М.Дюверже энэ үеийн гол төлөөлөгчдийн тоонд Аристотель, Н.Макиавелли, Ж.Боден, Ш.Л.Монтескье зэрэг эртний болон дундад зуун, сэргэн мандалтын эхэн үеийн томоохон сэтгэгчдийг хамруулжээ;

Хоёрдугаарт, ХVIII-ХIX зууныг бүхэлд нь төрийн мэдлэгийн нэгэн үетэй болгон авч үзжээ. Энэ үед А.Де. Токвиль, О.Конт, К.Маркс зэрэг сэтгэгчдийн үзэл санаа ихээхэн нөлөөтэй байжээ.;

Гуравдугаарт, улс төрийн үзэл, философи бие даан хөгжих болсон өнөө үеийг хамруулан үзжээ.

Тэрээр *эхний үед* эртний сэтгэгчдийн болон дундад зууны шашны номлол, улс төрийн үзлийн суурь агуулга аргууд нь анхлан боловсрогдсон, *Хоёр дахь шат* нь улс төрийн сэтгэлгээг цэгцлэн оновчтой болгох үе бөгөөд Сэргэн мандалт, Соён гэгээрүүлэлт, Шинэ үеийг хамруулсан. *Гурав дахь үеийг* орчин үеийн улс төрийн философийн үндсэн төрхийг тодорхойлох үзэл урсгалууд бүрэлдэн бий болох үе буюу ХIX зууны эцэс ХХ зууны эхэн үеийг хамруулсан байдаг. Түүний энэ ангилалт хүн төрөлхтөний улс төрийн философи мэдлэгийг түүхийн цаг хугацааны он дарааллын үүднээс улируулан үзэж, тэдгээрийг өнгөрсөн, одоо, ирээдүйн гурван цагийн шүтэлцээнд нь тодорхой авч үзэх бололцоог олгож байгаараа арга зүйн ач холбогдолтой юм. Тиймээс ч өнөөгийн судлаачид улс төрийн философи сэтгэлгээний шинжлэх ухааны хөгжлийн түүхэн үеүдийг тусгайлан шинжилж, улируулан үзэх явцдаа М.Дювержегийн дээрх үечлэлийн аргачлалыг тодорхой байдлаар ашиглаж байдаг юм.

⁷Основы политологии. (Под ред: В.П. Пугачева.) М.,1992, 9 дахь тал

М.Дювержегийн аргачлалыг бүтээлчээр баяжуулж, үр ашигтай хэрэгжүүлсэн философич бол Р.Арон юм. Тэрээр “Социологийн сэтгэлгээний хөгжлийн үе шатууд” хэмээх суурь бүтээлдээ энэ талаарх үзэл бодлоо тал бүрээс нь үндэслэж, хүн төрөлхтөний улс төр, нийгмийн сэтгэлгээний түүхийг тодорхой үечлэн шинжилсэн байдаг.⁸

ХҮИ-ХҮШ зууны үеийн Францын түүхчид дэлхийн түгээмэл түүхийг *эртний үе, дундад зуун, дахин сэргэлтийн үе, шинэ үе буюу ХҮИ-ХҮШ зуун* гэж үечлэн авч үзсэнийг хожмын үеийн судлаачид уламжлан авч, XIX зууныг шинэ үед багтаан ХХ зууныг *нэн шинэ үе* хэмээн нэрлэж нэмж үечилсэнийг өнөөгийн түүхчид, философичид судалгаандаа өргөн хэрэглэдэг байна. Энэ мэтээр цаг хугацаа, бүс нутгийн үечлэлийн арга зүйг сүүлийн үед Оросын болон манай судлаачдын ном, бүтээлд нэлээд өргөн хэрэглэх болсон байна.⁹

Тэгэхдээ дээр онцолсон К.Дойч, М.Дюверже, Р.Арон болон улс төрийн үзэл сэтгэлгээний түүхийг авч үзэх бусад үечлэл, үе шатны арга зүй, аргачлал нь их төлөв улс төрийн шинжлэх ухаан түүний үзэл сэтгэлгээний хөгжлийн түүхэн логиктой нилээд тохирч байдаг. Харин улс төрийн философи сэтгэлгээний хөгжлийн онцлогийг тэр бүр бүрэн дүүрэн илэрхийлэхэд учир дутагдалтай байдаг гэсэн шүүмжлэлт санаа нилээдгүй гардаг. Үүнтэй холбогдуулан философичид улс төрийн үзэл сэтгэлгээ болон улс төрийн философи сэтгэлгээний ялгаа онцлог, харьцааны тухай асуудлыг гаргаж ирэх нь байдаг.

Философич Лео Штраус “Улс төрийн философийн түүхийн удиртгал” хэмээх бүтээлдээ “Ер нь улс төрийн философи ба улс төрийн сэтгэлгээ нь нэг зүйл биш юм. Улс төрийн сэтгэлгээ нь улс төрийн амьдралтай зэрэгцэж хамт үүсэн бий болсон. Харин улс төрийн философи бол улс төрийн тодорхой амьдрал дотор, ардаа бичмэл гэрч баримт үлдээсэн Грект үүссэн...”¹⁰ гэж онцлон тэмдэглэсэн байдаг.

Улс төрийн философи сэтгэлгээний хөгжлийн үечлэлийн асуудлыг авч үзэхдээ улс төрийн эмпирик үзэл, сэтгэлгээ болон философийн хийсвэр үзэл сэтгэлгээ хоёрын ялгаа онцлогийг бодитой тооцож үзэх хэрэгтэй болдог. Энэ агуулгаар авч үзвэл дээрх сэтгэгч, философичидын санал болгодог үечлэл нь улс төрийн философи хийгээд улс төрийн үзэл

⁸Р.Арон. Этапы развития социологической мысли. М.,1993.

⁹ “История политических и правовых учений”. М., 1988, “История политических учений”. М.,1978, Мальцев, В.А. “Основы политологии”. М.,1988, Панарин, А.С. “Политология”. М.,2000, Гаджиев, К.С. ”Политическая философия”. М.,1999, Гончаров, Д.В., Гонтарева, И.Б. “Введение в политическую науку”. М.,1996, “Политичесие учения: история и хрестоматия”. М.,2000, “История политических и правовых учений”.ред: В.С.Нерсисянц. М.,1996, ”История политических учений”. Выл.1-3.ред:О.В.Мартышина.М.,1994-2000, А.Жамбал.”Улс төрийн сургаалын түүх” (Эртний үе). УБ.,2001, Улс төрийн шинжлэх ухаан. Ред: Ё.Довчин. УБ.,2010 гэх зэрэг.

¹⁰Л.Штраус. Введение в политическую философию. М., 2000, С 198

сэтгэлгээний хөгжлийн логиктой ерөнхийдөө тохирч байдаг ч бас ялгагдах онцлогтой болохыг үгүйсгэх аргагүй юм. Учир нь улс төрийн философи сэтгэлгээ, улс төрийн үзэл сэтгэлгээ хоёр нь өөр хоорондоо нягт нарийн холбоо хамааралтай, харилцан бие биенээ нөхөн, сэлбэж байдаг ч тэдгээрийн хооронд тодорхой ялгаа зааг бас байдаг. Тухайлбал улс төрийн философи нь нилээд хийсвэр оюунлаг мэдлэгийн хэлбэр байдаг бол улс төр шинжлэл түүний үзэл сэтгэлгээ нь нийгмийн улс төрийн бодит үзэгдэл, баримтуудтай холбоотой харьцангуй эмпирик онол болж байдагаараа онцлогтой. Энэ агуулгаараа улс төрийн философи нь улс төрийг философидох хийсвэр оюунлаг мэдлэгтэй гол төлөв холбогддог бол улс төр шинжлэл нь улс төрийн амьдрал, үзэгдлийн түүхэн бодит эмпирик баримтуудтай их төлөв холбогддог. Америкийн улс төр шинжээч Д.Истон өөрийн боловсруулсан улс төрийн тогтолцооны онолын загварыг “ улс төрийн амьдралыг ойлгох урт хугацаанд хэрэглэгдэх эмпирик чиглэлийн суурь онол ...”¹¹ гэж нэрлээд түүгээр “...улс төрийн нам, сонирхолын бүлэг, засгийн газар болон сонгогчид зэрэг бүрдлүүдийн үйл ажиллагааг судлах болно”¹² гэсэн байдаг.

Улс төрийн философи нь угтаа эмпирик онол биш юм. Улс төрийн философи нь улс төр шинжлэлдээ улс төрийн тодорхой үзэгдлийг авч үзэх, түүнийг хангалттай үндэслэхэд шаардагдах философийн арга, зарчмыг өгч байдаг бол улс төр шинжлэл нь улс төрийн философидоо улс төрийг философидон авч үзэхэд шаардагдах эмпирик баримт, бодит материалыг өгч байдаг. Энэ агуулгаараа улс төр шинжлэл нь улс төрийн философийн судлагдахууны бодит үндсийг өргөтгөн тэлэхэд өөрийн зохих хувь нэмэрээ оруулдаг байна.

XVII-XVIII зууны үед Франц, Англид хөрөнгөтний ардчилсан хувьсгал ялж, Европ, Умард Америкт улс төрийн институт, нам, хөдөлгөөн, сонирхолын бүлэг, парламентат ёс, зарчим болон иргэний нийгмийн улс төрийн сонголтын бодит бааз, хөрс суурь бүрэлдсэн нь улс төрийн философийн судлагдахууны хүрээг өргөтгөх, түүний хийсвэрлэлийн багтаамжийг тэлэхэд чухал нөлөө үзүүлсэн байдаг. Нөгөө талаар улс төрийн философичид улс төрөөс философидох бодит баримтаа олж авч, түүнд суурилдаг болохоор тэр нь улс төрөөс хол хөндий байх аргагүй, харин ч түүнтэй нягт уялдаа хамааралтай байх нь зүйн хэрэг. Тэр ч байтугай үүнтэй холбогдуулан зарим философичид философи нь тухайн цаг үеийн улс төрийн бодлогыг зөвтгөх хэрэгсэл болж, философичид нь төр, засгийн эрх мэдэлтнүүдийн зарц болсоныг хурцаар шүүмжлэсэн нь байдаг. Ийм шүүмжлэлт санаа Германы философич А.Шопенгауэр, Ф.Ницше нарын зохиол бүтээлүүдэд тодорхой

¹¹Д.Истон. Улс төрийн системийн шинжилгээ.

¹²Мөн тэнд.

тусгалаа олсон байдаг. Эндээс үзвэл улс төр шинжлэл түүний эмпирик үзэл, улс төрийн философийн хийсвэр үзэл сэтгэлгээ хоёрын хөгжлийн үечлэл, үе шат нь ерөнхий агуулгаараа (зарим тодорхой ялгаа онцлог байдаг ч) тохирч нийцэж байдаг гэж үзэхэд нэг их ташаарал болохгүй юм. Тэгэхдээ ингэлээ гээд дээрх оюунлаг өв сэтгэлгээний хоорондын холбоо хамаарал, ялгаа онцлогийг анхаарлынхаа гадна орхиж болохгүй юм.

XX зууны томоохон философич Б.Рассел “Өрнийн философийн түүх: эртний философи” хэмээх суурь бүтээлдээ философийн түүхийг МЭӨ VI зууны үеийн Грекээс эхлүүлэн түүний хөгжлийн түүхэн бүхэл үеийг үечлэн ангилсан байдаг.

Б.Рассел “теологоос ялгагдах ямар нэг шинжтэйн хувьд философи нь МЭӨ VI зууны үед Грекэд анх үүсэн. *Эртний үеийн* түүхээ туулан өнгөрүүлсэний дараагаас тэрээр христийн үүслийн эринд болон Римийн эзэнт гүрэн унасан эринд дахин теологийн нөлөөнд орсон байна. Өөрийн *хоёр дахь* агуу их сэргэн мандалтын үе буюу XI-XIV зууны үеэс хэрэв II Фридрих хаан зэрэг цөөн тооны үймээн, самуун дэгдээгчдийг тооцохгүй юм бол католик сүм хийдийн дээр гарч иржээ. Энэ үед Реформацийн эринд өөрийн оргил түвшиндээ хүрсэн тэр замбараагүй байдалд цэг тавигджээ. *Гуравдахь үе нь* XVII зуунаас манай өнөө үеийг хүртэл үргэлжилж байгаа бөгөөд өмнөх үеүдээ бодвол шинжлэх ухааны нөлөөг дээд зэргээр амсах болсон. Энэ үеийн цөөн хэдэн философич католик сүм, хийдийн үүднээс ортодоксаль* байр сууринд үлдсэн ч тэдний онолд иргэний төр улсын асуудал сүм, хийдээс илүүтэй байр эзлэх болжээ”¹³ гэсэн байдаг. Түүний энэ ангилалт нь улс төрийн философийн түүхийг үечлэн ангилах онол-арга зүйн чухал үлгэр загвар болдог юм.

Хэдийгээр улс төрийн философи сэтгэлгээний түүхийг үечлэх олон арга хандлага байдаг ч Өрнөдийн философи, нийгэм-улс төрийн хийгээд эрх зүйн сэтгэлгээний үүсэл хөгжил нь *1)эртний үе* (м.э.ө. V-IV зуунаас м.э V зуун)*2)дундад зуун* (V-XV зуун) *3) дундад зууны төсгөл үед багтах Дахин сэргэлт ба Реформацийн хөдөлгөөний үе* (XV- XVI зуун) *4)шинэ үе*XVII- XVIII зуун) *5)XIX зуун* *6)XX зуунаас өнөөүе* гэсэн үндсэн үеийг туулсан гэсэн үечлэлийн нийтлэг жишиг хандлага байдаг. Улс төрийн философи сэтгэлгээ нь нийт нийгмийн ухамсарын хүрээн дотор багтаж түүнтэй хамт үүсэн хөгжиж ирсэний хувьд дээр дурдсан түүхэн үеүүд түүнд мөн нэгэн зэрэг холбогдоно гэж үзэж болохоор байдаг. Тэгэхдээ философичид улс төрийн философийн үүсэл хөгжлийн түүхэн үйл явц,

**Ортодокс* –“ил тод санаа”, “зөв үзэл”, “үнэн итгэл” гэсэн утга санааг илэрхийлсэн Грек үг бөгөөд энэ нь аливаа итгэл үнэмшилд буюу ямар нэг сургаал, ертөнцийг үзэх үзлийн талд бат тууштай зогсох үзэл.

¹³Бертран Рассел. Өрнийн философийн түүх: эртний философи”. 12-13 дахь тал.

үндсэн үе шатуудын тухай асуудлыг эргэн харж шинэ байдлаар нарийвчлан судлах шаардлагатай хэмээн сүүлийн үед үзэж, тэр талаар зарим санаа бодлыг томъёолон тавьж байна.¹⁴

Оросын философич К.С.Гаджиев улс төрийн философийн судлах асуудал, үндсэн үзэл санаа, онолын төлөвшил хөгжлийн дотоод логик, агуулгыг авч үзэх үндсэн дээр Эртнээс (мээ V-IV зуунаас) Шинэ үеийн эхлэл буюу XVII зууны эхэн хүртлэх урт хугацаа нь улс төрийн философийн *угтвар үе*, XVII зуунаас XIX зууны эхэн хүртлэх үе бол улс төрийн философи бүрэлдэн төлөвших урьдач нөхцөл бүрэлдсэн үе байсан бөгөөд түүний үндсэн дээр XIX зууны төгсгөлд улс төрийн философи ерөнхий философи хийгээд нийгэм улс төрийн сэтгэлгээнээс *тусгаарлан* XX зуунд *бие дааж хоёр янзын хандлага чиглэлээр хөгжих* болсон гэж үзэж байна.¹⁵

Өнөө үед улс төрийн философи сэтгэлгээний түүхийг судлан авч үзэхтэй холбогдон улс төрийн философич Лео Штрауссын үечлэлийн арга зүй философич судлаачдын анхаарлыг татах болов. Сүүлийн үед түүний боловсруулсан үечлэлийн арга зүйг нилээдгүй хэрэглэх болсон байна. Тэрээр улс төрийн философийн түүхийг *сонгодог* хийгээд *орчин үе* гэсэн хоёр том үед зааглан үзэж, тэдгээрийн харилцан хамаарал, нийтлэг, өвөрмөц шинж, онцлогийг тодорхой шинжилсэн байдаг.¹⁶ Л.Штраусс хүн төрөлхтөний улс төрийн философи мэдлэгийн сонгодог үеийг Сократаас эхтэй гэж үзсэн бол орчин үеийнхийг нь Н.Макиавеллээс эхлэн тооцсон байна. Түүний энэ саналыг дэмжиж Америкийн философич Дж.Кэтлин бичихдээ: “Сократ бол Өрнөдийн улс төрийн философийн “загалмайлан эцэг”, харин Макиавелли бол үндэслэгч нь юм”¹⁷ гэсэн байдаг.

Унгарын философич Андраш Ланци “Улс төрийн философи уу, эсвэл улс төрийн судлал уу?” хэмээх өгүүлэлдээ улс төрийн философийн түүхэнд оруулсан Лео Штрауссын үүрэг оролцооны тухай бичихдээ “Дэлхийн хоёрдугаар дайнаас хойшхи үед позитивист улс төрийн судлал шинжлэх ухааны нэрээр халхавчлан шинжлэх ухаанд хүрээгүй гэж зарласан аливаа хандлагыг няцааж байсан оюун санааны тийм үед Лео Штраус бол

¹⁴А.Жамбал. Улс төрийн философийн судлах асуудлын тухайд. Философи, Эрх зүйн судлал. XXII боть, УБ.,2007, 140 дэх тал.

¹⁵К.С. Гаджиев. Политическая философия. 45-105 үзнэ үү.

¹⁶*Strauss, L.* “What is Political Philosophy”.Glenneco., 1959, *Strauss, L.* “Introduction to Political Philosophy”. NY.1986, *Strauss, L.* “The City and Man”.Chicago., 1969, *Catlin, D.* “The Story of Political Philosophers”. NY., 1939

¹⁷Catlin, D.”The Story of Political Philosophers”. NY., 1939

сонгодог улс төрийн философийн үнэт зүйлсийг хэвээр хадгалж, тайлбарлах талаар хамгийн их ухамсартай хүчин чармайлт тавьсан хүн гэж болох билээ”¹⁸ хэмээсэн байдаг.

Польш гаралтай нэрт улс төрийн философич Лео Штраус орчин үеийн улс төрийн философийн хөгжилд арилашгүй ул мөрөө үлдээж чадсан ХХ зууны томоохон философич мөн. Тэрээр юуны түрүүнд орчин үеийн улс төрийн философийн түүхийг бүхэлд нь бүрэн агуулгаар нь харж, үнэлэх боломж олгосон философи сэтгэлгээний түүхэн үечлэлийн аргачлалыг санал болгосон. Хэдийгээр Лео Штраусын аргачлал нь ерөнхий шинжтэй боловч түүний онол, арга зүйн ач холбогдол нь үлэмж их юм.

Улс төрийн философи сэтгэлгээний түүхийг *сонгодог* болон *орчин үеийн* хэмээн ангилах нь түүний хөгжлийн түүхэн үйл явцыг бүхэл агуулгаар нь бүрэн бүтнээр нь харж, баримжаалах боломжийг юуны өмнө олгодог. Түүнчлэн түүний энэ ангилал ерөнхий боловч энэ хүрээнд улс төрийн философийн түүхтэй холбоотой тодорхой баримт хийгээд асуудлыг тусгайлан судлах, улс төрийн философийн үзэл санааны үндэс, сэтгэгчдийг товойлгон авч үзэх боломжтой байдаг. Эцэст нь энэ ангилалт нь хүн төрөлхтөний улс төрийн философи сэтгэлгээний түүхэн хөгжлийн үйл явцын динамик хийгээд статик шинжийг тодруулан тэдгээрийн харилцан шүтэлцэл, хамаарал, уг гарвал, өвөрмөц онцлог, дотоод логик агуулгыг нь тодорхой шинжлэн үзэх боломжийг олгодгоороо арга зүйн ач холбогдолтой байна.

Abstract. Political philosophy is the historic phenomenon. Philosophers explain that political philosophy mentality has many different opinion. Leo Strauss’s category of classic and modern political philosophy tend to recognize in nowadays. In this article have been put out many ideas about period of political philosophy mentality.

НОМ ЗҮЙ

1. Алексеев. П.В, Панин. А.В. Хрестоматия по философии. М., 1998
2. Андраш Ланце. Улс төрийн философи уу, эсвэл улс төрийн судлал уу?”. Бодрол бясалгал-1991, № 10
3. Арон. Р Этапы развития социологической мысли. М.,1993
4. Болд-Эрдэнэ. Д. Улс төрийн философи: удиртгал. УБ.,2015

¹⁸Андраш Ланце. Улс төрийн философи уу, эсвэл улс төрийн судлал уу?”. Бодрол бясалгал-1991, № 10, 37 дахь тал.

5. Гаджиев. К.С. Политическая философия. М., 1997
6. Гончаров, Д.В., Гоптарева, И.Б. “Введение в политическую науку”. М.,1996
7. История политических и правовых учений”. М., 1988,
8. “История политических учений“. М.,1978
9. “История политических и правовых учений”.ред: В.С.Нерсесянц. М.,1996,
10. ”История политических учений”. Выл.1-3.ред:О.В.Мартышина.М.,1994-2000
11. Жамбал.А.Улс төрийн сургаалын түүх.(Эртний үе). УБ.,2001
12. Жамбал. А. Улс төрийн философийн судлах асуудлын тухайд. Философи, эрх зүй судлал. УБ., 2000
13. Истон.Д. Улс төрийн системийн шинжилгээ
14. Кант. И Трактаты и письма. М., 1980
15. Мальцев,В.А. “Основы политологий”. М.,1988
16. Основы политологии. (Под ред: В.П. Пугачева.) М.,1992
17. Панарин, А.С. “Политология”. М.,2000,
18. “Политичесие учения: история и хрестоматия”. М.,2000,
19. Струве.Г “Философийг задлан шинжлэх үндсэн эхлэл, философи дахь удиртгал” Варшав. 1890 (Философи эх бичгийн эмхтгэл. 40 дэх тал)
20. Рассел Бертран. Өрнийн философийн түүх: Эртний философи. I боть. (Орч: Н.Энхцогт, Ц.Алтантуяа) УБ., 2012.
21. Томпсон. Мэл. Философи. Удиртгал . УБ.,2002
22. Улс төрийн шинжлэх ухаан. Ред: Ё.Довчин. УБ.,2010
23. Штраус. Л. Введение в политическую философию. М., 2000
24. Catlin, D.”The Story of Political Philosophers”. NY., 1939
25. *Strauss, L.*”What is Political Philosophy”.Glenneco., 1959, *Strauss, L.*”Introduction to Political Philosophy”. NY.1986, *Strauss, L.* “The City and Man”.Chicago., 1969,
26. A.J.Toynbee. A Study of History 1934-1961
27. Philosophy and Philosophers J Shand Penguin 1994

“ЦАГААН ТҮҮХ” ДЭХ УЛС ТӨРИЙН ҮЗЭЛ САНАА, ТҮҮХЭН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Ц.Ганболд

МУИС, ШУС,

МУИС, Улс төр судлалын тэнхимийн профессор

Л.Идэр

МУИС, Улс төр судлалын тэнхимийн докторант

Түлхүүр үг: Төр, Цагаан түүх, төрт ёс

Хураангуй: Монголчуудын төрт ёсны үзэл санаа, түүнчлэн хууль цааз, цэрэг, дипломатын ёс, заншил, шашны зан үйлийн хэм хэмжээнүүд Монголын нийгмийн харилцааг зохицуулахад чухал хүчин зүйл болж байсан бөгөөд улмаар эдгээр нь Монголчуудын төрт ёсны сэтгэлгээг хөгжүүлэхэд чухал нөлөө үзүүлжээ гэсэн дүгнэлтэнд хүрч байна.

Манай улсад Юань гүрний үеийн төрт ёс, улс төрийн сэтгэлгээний талаархи судалгаа хомс боловч энэ үеийн төрт ёс, төрийн үзэл, сэтгэлгээний гол чиглэл хандлагыг “Хоёр ёсны сургаал” тодорхой хэмжээгээр төлөөлнө гэж үзэх үндэслэлтэй юм. Хубилай хаан Умард Хятадыг эзлэн сууж байхдаа хятад түшмэдийн тусламжтайгаар тэдний эртний хуулийг орчуулан сонирхон судалж тэр дундаа Хятадын эртний Тан улсын хуулийг анхааран үзэж байжээ.

Энэ нь нүүдэлчний ахуй, зан заншил, төрийн хэв маягт тохируулан байгуулсан “Их засгийн агуулгаар эртний соёлт Хятадыг барьж болохгүйг ойлгож байсантай холбоотой. Хубилай хаанд тухайн үеийн хятад түшмэд нэлээд зөвөлгөө өгч ятган “Хятад улсыг эзэлье гэвэл заавал Хятад улсын хуулиар явах хэрэгтэй. Хятад улсын хууль хэрэглэвэл сая удаан тогтож чадна”¹⁹ гэж хэлж байв. Мөн Хубилай хааны бичгийн түшмэл Сюй Хэн “Монгол улс говь хязгаарын чанад үүссэн учир эдүгээ тэдний уг ёс Хятад газарт таарахгүй болсон

¹⁹ Баярсайхан Б. “Арван буянт номын цагаан түүх” УБ, 2002 он, 18-р тал

тул Хятад ёс хууль авч хэрэглэхээс өөр аргагүй болсон”²⁰ гэж бичсэн байна. Хубилай хаан ширээнд суухаасаа өмнө хятад түшмэл Яо Шу нарт хятадыг захирах хууль боловсруулах тухай шийдвэр өгсөн ба үүний үндсэн дээр 1262 онд зохиосон “Ярьж эмхэтгэсэн хуулийн бичиг (“Чжан-Дин-Тяо-Гэ”)” гарсан юм. Үүний дараа 1264 онд “Шинэ эмхэтгэсэн хуулийн бичиг”(Синь-Дин-Тяо), “Жиюан”-ийн 8-р онд “Эрхэн зөвлөлийн мужаас өргөн боловсруулсан хуулийн бичиг” (Шан шу-шэн зоу-дин-тяо-гэ) “Жиюан”-ийн 28-р онд (1291) “Жи-юаний шинэ хууль” (Жи-юан-синь-гэ) зэрэг хууль батлагдсанаас гадна Юань гүрний үед зохиосон нилээд бүрэн хэмжээний том хууль гэвэл “Их Юаний нэвтэрхий хууль”(Юань-дянь-жан), “Их Юанийн хууль цаазын бичиг”, (Түн-жи Тяо-гэ) болон “Ертөнцийг засах магад хууль” (Зин-ши-да дянь) зэрэг болно”²¹. Эдгээрээс “Их Юань улсын нэвтэрхий хууль” 1322 оноос өмнө гарсан хааны зарлиг, хуулиудын эмхэтгэл бөгөөд агуулга нь улс төр, нийгэм, эдийн засаг, соёлын бүхий л салбарыг хамарсан байжээ. Мөн Хубилай хааны төр засах хөтөлбөр буюу “Монгол улсын арван буянт номын цагаан түүх” төрийн бодлогын үндэс, төрийн их хаан, төрийн албан хаагч, шашин мяндагтны эрдэм чадал, тэдгээрийн баримталбал зохих албан ёс зүйн хэм хэмжээ, тэдгээр албан тушаалтнуудын үйлдсэн аливаа гэмт үйлдэлд ногдуулах ял шийтгэлийн хэлбэр зэргийг тусгасан нь төрт ёс, улс төрийн сургаалийн гол эх сурвалж юм.

Зарим судлаач “Хуулийн эмхэтгэл тэр тусмаа “захиргаа ба хууль засаглалын хэм хэмжээ” мөн нөгөө нэг утга нь “Төр ёсны сургаалийг... агуулсан хоёрдмол шинжтэй”²² бүтээл гэж үзсэн байна. “Цагаан түүх” бол төр засах хөтөлбөр юм. “Цагаан түүх” нийгмийн харилцааг зохицуулж, засаглалын хэм хэмжээг тогтоосон үзэл баримтлалуудыг тусгасан байгаа юм. “Арван буянт номын цагаан түүх”-ийг сурвалж бичигт “Монгол улсын дөрвөн төрийн арван буянт номын цагаан түүх” гэж тэмдэглэсэн байдаг бөгөөд зарим нэг судлаачдын бүтээлд “XIII-XIV зууны Монголын төрт ёсны сэтгэлгээн дэх цоо шинэ чиглэлийн үзэл санаа гарч ирсэн, гэж дүгнэсэн байна”²³. Энэхүү төрт ёсны сэтгэлгээ нь МЭӨ III зууны үед буюу Хүннү гүрний үетэй холбон авч үздэг. ”Хубилай хааны төр ёсны шинэтгэл бол Монголын нийгмийн сэтгэлгээний түүхэнд энэ зууны эхэн хүртэл уламжилсан ертөнцийн засаг хийгээд номын засгийг тэгшид явуулах зорилго бүхий хоёр ёсны номлол”²⁴ юм. XIII зууны 60-аад оны дунд үеэс Монголын эзэнт гүрний төрийн байгууламжийн бүтцэд

²⁰Мөн тэнд

²¹Далай Ч. Монголын түүх. (1260-1388) Гутгаар дэвтэр, УБ хот, 1992 он, 71 дэх тал

²²Баярсайхан Б. “Арван буянт номын цагаан түүх” УБ, 2002 он, 19-р тал

²³“Монголын философийн түүх” (XIII-XVIII зуун)УБ., 2000 он, 280 дахь тал

²⁴Монголын төрийн байгуулал улс төрийн сэтгэлгээний хөгжил (МЭӨ III- МЭ XX) УБ.,1995 он, Тэргүүн боть 63 дахь тал

өөрчлөлт орж, эрх мэдлийн төвлөрөл Дорно зүгт шилжиж “Хятад маягийн” хэв загвар бүхий “Юан гүрэн” байгуулагдсанаар “Монгол төрийн язгуур ашиг сонирхол, Чингисийн бодлогын залгамж шинж алдаагүй бөгөөд харин ч тухайн нөхцөлд зохицуулж, баяжуулсан гэж үзэлтэй”²⁵

“Цагаан түүх” Хубилай хааны төрийн үзэл, зарлигийн эмхэтгэл, хоёр ёсыг тэгш хослон явуулах агуулгатай юм. “Хоёр ёсыг тэгшид эндүүрэлгүй явуулахын товчоо арван буянт номын цагаан түүх”²⁶ гэж бичсэн нь уг сургаалын агуулгыг бүрэн илэрхийлж байгаа юм. Мөн нөгөө талаар улс төрийн баримт бичиг болох талаас нь “төр засах хөтөлбөр” гэж үздэг. Энэхүү эх сурвалжийн бөөгийн мөргөл буюу тэнгэр газар, байгаль шүтэх үзэлд тулгуурласан төрт ёсны үзэл сэтгэлгээнээс бурханы шашны үзэл сургаалд шилжин хөгжүүлснийг харуулна.

Хубилай эртний Төвд, Энэтхэгийн хаадын үзлээр шашин төрийг тэгш явуулах хоёр ёсны харьцааг зөв тогтоох улсын номын ёсоор засах энх амгалан болгох, мөн төрийн ёсоор засах жаргалын дээдийг эдлүүлэх үндсэн үзэл санааг баримтлан төр ёсыг тогтоосон байна. Энэ тухай “Цагаан түүхэнд” “ Дээд шашны үндэс номын эзэн лам ба их төрийн эрхэм ертөнцийн эрхэт хаан хийгээдийн үнэн номын засаг хивийн зангиа мэт алдаршгүй, хүнд хааны засаг алтны буулга мэт эвдэршгүй” гэжээ. “Цагаан түүхэнд” зааснаар бол Хубилай хааны ертөнцийн төрийг засах үндсэн “Эрт хүн амын тоо томшгүй наслах цагт хутагт саманд бодь сацийн хувилгаан олноо өргөгдсөн маха самади нэрт хаан Энэтхэгийн очирт суурины Магадын оронд хоёр ёсны дөрвөн их төрийг байгуулсан ажгуу. Тэр мэт хойно хүн амьтны зуу наслах цагт Хачийн Кашмир улс, Кушаны Монгол улс, Заан уулын Солонгос улс, Лигийн Сартуул улс, Түнхүний Нанхиад улс, Ингийн Төвд улс, Шингүний Балба улс тэргүүтэн замбуу тивд харьяат 16 их улс бүгд тус бүр хоёр ёсоор явах бөгөөтөл ялангуяа Энэтхэгийн Сүдданы хааны Артасиди нэрт хан хөвгүүн хааны төрийг хатадад шүтсэн цагтаа эрт Махасамди хаан байгуулсан хоёр ёсыг үлэмж шинэтгэн тансаг гайхамшигт явуулжээ. Хойно түүнчлэн ирсэн Кэнэскэгийн улсын эзэн Кэрүа нэрт хаан магадаар хоёр ёсыг явуулсан ажгуу. Тэр цагт бичний ураг Хар төвд улсад худагт хоньсим бодиссацийн хувилгаан нь Соронзон Гомбо нэрт хөвгүүн болон төрж мянган алтан хүрдийг эргүүлэгч хаан хэмээн алдаршаад тэрээр хамаг амьтанд туслан сэтгэж бүрүүн Томи ангуугийн хөвгүүн Томи жүгээ нэртийн бурханы номлосон таван язгуурт үсэг

²⁵Монголын төр ёс, эрх зүйн сэтгэлгээний зарим асуудал УБ., 2002 он, 64 дэх тал

²⁶Арван буянт номын цагаан түүх ОМАХ, 1981, 72-р тал

хийгээд эртний Богдсын байгуулсан дөрвөн их төрийг төгс бүхий ухаж ийн хэмээн Энэтхэгт илгээв”²⁷ гэсэн ажгуу.

Энэтхэгчүүд “Цагаан зааныг” бэлгэшээдэг бөгөөд “Цагаан түүхэнд” Аражаварад нэрт цагаан зааны оройд алтан хумхыг рашааны усаар дүүргэн тавьж олон шагилууд язгуутан зэрэглэн суусны дотор тэр их зааныг авч ирвэл тэр хумхыг хэний өвөрт ороод рашааны ус нь асгаралгүйгээр авбал буяны дээд заяат хаан хэмээюү”²⁸ гэж Энэтхэгийн домог зүйн агуулга бүхий санааг тусгасан байна. Энэ нь “Хоёр ёсны сургаал” Энэтхэгээс гаралтай болохыг өгүүлж буй баримт юм.Хубилай хааны үзлээр ертөнцийн төр ёсыг хэрэгжүүлэгч нь нэгдүгээрт: хаан, хоёдугаарт: номын багш, гуравдугаарт: бурханы лам хувраг ажээ. “Цагаан түүхэнд” зааснаар бол “Хоёр ёсноос анх урд номын ёсыг эрхэлж явуулагчин хэмээвэл төрийн хаанд авшигийн дөрвөн их мөрнийг хэн урсган чадвал номын эзэн гүүш хэмээгдэюү. Далай мэт судар тарни хоёрыг хоцролгүй хэн ухвал сурвал цорж лам хэмээн хотолд өргөгдьюү, зуун түмэн судрыг дүрвэлгүй хэн ухвал хягаарлалгүй билэгт азарай хэмээюү”²⁹ гэжээ. Ертөнцийн ёсыг урьтал болгодоггүй харин номын ёсыг урьтал болгож байв.

Гэтэл ертөнцийн ёсыг илүүд үзэж номын ёсыг огоорох аваас “Үнэн үгсээр үл явж, худал үгсийг хэрэглэнэ. Хоёр ёсоор үл явж магад хуулиар тогтооно. Үгээгүй ядууг үл хайрлан баялагуудын нүүрийг харна. Буянтан сайдыг хөнгөлж, худалч ховчийн үгээр явна. Дээрэнгүй догшин сэтгэлээр хоёр төрийг эвдэюү. Амьгүй чулуунаас ус эрьюү. Шүүсэн хар хорын усыг идээн болгоюү. Баримтгүй салхийг цаламдьюү. Тунгалаг далайг алгаар ууюү. Цаст ууланд явах арсланг бороогоор түүдьюү. Огторгуйгаар үймэгч тасыг урхидьюү. Түн модноо явах барст гаранга босгоюү”³⁰ гэж сургажээ. Энэ нь ертөнцийн хамаг муу бүхний үүдийг нээх тухай заасан бус уу. Мөн дээрх санаануудын өмнө тодотгол болгож “Бас хойд хойд цагт номын ёсоор ил явж, ертөнцийн үйлийг зөвшөөрнө” гэж номлосон нь ирээдүйг харсан төрийн номлолын нэг хэсэг гэж ойлгож болохоор байна. Цаашилбал “Цагаан түүхэнд “Бас эрт шигмүни бурхан ирээдүйг онож зарлиг болруун, Гөрөөдийн хаан арслан бөхөд гаднын зад дайсан хүч үл хурьюү. Егүүтгэхийн учир нь хэзээ хүрвэл уушигнаас нь хорхой гараад идэж алах мэт. Миний шашинд бус тэрсүүд хүч үл хурьюү. Мөнхүү миний ёстон самуурч эвдэх больюү гэж хоёр ёсоор үл явах ертөнцийн ёсыг хэрэгжүүлэгчийн төр, улсын ирээдүйн өнгө төрхийг тодорхойлон номлосон байна. Хоёр ёсны үзлийг хооронд нь нэгтгэн номлох бус тус бүрийн номлол, гүйцэтгэх ёстой үүргийг “... буян хилэнц хоёр,

²⁷Арван буянт номын цагаан түүх ӨМАХ, 1981, 73-74-р тал

²⁸Арван буянт номын цагаан түүх ӨМАХ, 1981, 80-р тал

²⁹Арван буянт номын цагаан түүх ӨМАХ, 1981, 77-р тал

³⁰Арван буянт номын цагаан түүх, Хөх хот, 1981, 93-94-р тал

цагаан хар хоёр, хүнд хөнгөн хоёр, үнэн худал, сайн муу, жаргал зовлон хоёр, эд ялгалыг үл мэдэхийн тулд үнэн номын засаг хэвийн зангиа мэт алдаршгүй, хүнд хааны засаг алтан буулга мэт эвдэршгүй хоёр ёсыг холилгүй тус бүр сайтар хичээгдэхүй” гэж сургажээ. Эндээс төр шашны үзэл номлолыг үндсэнд нь хатуу зөөлөн хоёртой холбон авч үзэж болох юм. Ертөнцийн буюу төрийн хууль цаазаар хүний зан мөр үйлийг, шашин номлол, сургаалаар сэтгэлийн гэгээрлийг засах гэсэн үндсэн санаатай ажээ.

Төрийн суу билэгт хаан, төрийн их сайд, түшмэлийн эрдэм боловсрол, бие, сэтгэлийн ёс жудгийг гурван их үйл, дөрвөн их төр, зургаан их үлгэр, долоон их бин, есөн их бэлгээр тэгшитгэн тогтоожээ. Энэ нь төрийг улам хүчтэй болгох гэсэн санааг нь зөвхөн хааны хүч, эрдмээс хамааралтай байдаггүй түүнийг хүрээлсэн ард түмэн, түшмэл буюу төрийн аппарат гэсэн гурвал хэлбэрээр оршин байж төр, улс хүчтэй байх тухай сургасан номлол юм. Ард иргэнийг амгалан тайван байлгах нь төрийн үүрэг хэдий ч иргэдэд сургасан номлол, сургаал цөөнгүй байна. Хубилай төрийг үзэх үзэлд хоёр ёсыг эрхэмлэн тэгш явуулахыг сургаж төрд эрдэм чадал ихт төрийн сайд түшмэлийн дагах ёстой ёс журмыг чухалд үзэж төрөөс тогтоосон хэм хэмжээг дагахаас гадна сэтгэлийн буюу номын засгийг чухалчлан үзэж түүний ёсыг хатуу номлон сургаж байв. Хубилай хоёр ёсыг тэгш явуулж байхыг эрхэмд үзэж төрийн албан ёсны тэмдэглэлт өдрүүдийг түмэн олон тэмдэглэн өнгөрүүлж байх тухай “Цагаан түүхэнд” нарийн зааж өгсөн байна.

“Цагаан түүхэнд” тэнгэр заяат Монголчуудын уламжлалт төрт ёс, улс төрийн сэтгэлгээний тэдгээрээс салгаж болшгүй логик холбоо бүхий язгуурын ойлголтыг дахин давтан өгүүлсэн байна. Үнэндээ бол Юан гүрний төрийн их шүтлэг гарцаагүй “Мөнх хөх тэнгэр” агаад тэрхүү их хүч, эзэн богд Чингисийн соёрхол ивээлээр “Их гүрнийг” байгуулсан нь гарцаагүй юм. Энэ тухай мөнх хөх тэнгэрийн хүчинд их суу залийн ивээлээр сод богд Чингис хааны соёрголоор таван өнгө, дөрвөн харь их улс дорно улаан Хятад, Нангиад, Умар дорно хар Төвд, Битүүд, Дорно өмнө Балба, өрнө Хэлиэд, Өрнө умар тэшиг, төвийн дөчин түмэн хөх Монгол Ойрад” гэсэн хэмжээлшгүй их газар нутгийн эзэн зөвхөн Монголчууд л байсныг гэрчлэн өгүүлсэн нь төрийн бодлогын залгамж чанар нүүдэлчдийн нарийн байсныг харуулна. Хубилай хаан “Тэнгэризмийн ёс зүйг нь буддын шашин болгон өөрчилсөн”³¹ нь төрийн уламжлал шинэчлэлийг хослуулах арга ухааныг нарийн эзэмшсэнийг харуулна. “Уул үзээгүй хормой шуух, ус үзээгүй гутал тайлах” гэсэн ардын зүйр үг нөгөө талаар төрийн “алтан аргамж”, “хар хайрцагны бодлого” гэж байсан бол түүний тод жишээ “Хубилай сэцэн хааны” энэхүү бодлого байлаа.

³¹Арван буянт номын цагаан түүх ОМАХ, 1981, 80-р тал

”Хоёр ёсны асуудлын талаар нилээдгүй мэдээг агуулсан сурвалж бол цагаан түүх зохиол юм. <<Арван буянт номын цагаан түүх>> гэдэг энэ номыг голчлон <<Цагаан түүх>> хэмээн нэрлэж заншжээ. Цагаан түүх ном нь хэд хэдэн хувилбартай. Энэ нь XIII зууны түүхийн тулгар бичгийн нэг мөн. Тус ном бол Хубилай цэцэн хаан зохиосон хэмээн Ордосын Хутагтай цэцэн хун тайж мэдээлжээ. Мөн эрдэнийн товчид иш татан бичсэн оршил өчил ч бас бий. Улс төрийг засан тохижуулахад хамгийн гол анхаарах зүйл <<Энх-Амгалан>> сахиулах, нөгөө нь <<Зол жаргалтай>> байлгахад чиглэсэн гол санаа байдгийг номонд тэмдэглэжээ. Тэгээд ч <<хэмжээгээрээ бага боловч утга ёс, гүн улс төрийн гүн ухааны зохиол мөн>>³²гэдэг нь тодорхой ажгуу.

Монголчуудын төрт ёсны асуудлыг олон талаас нь авч үзэх хэрэгтэй. Төрт ёс зан заншил, ёс зүйн тухай өгүүлэхэд зан үйлийн асуудалд анхаарлаа хандуулах нь чухал юм. Зан үйл нь нилээд төлөвшин тогтож ирэхдээ улс гүрэн ёс дэг, зан заншил, бүхнийг дагаж мөрдөх хэв ёсны шинжтэй болдог ажээ. Ийм учраас монголын төрт ёс, ёс заншлын уламжлалаас суралцах шинэ нөхцөл байдалд тохируулан хэрэглэх зүйл олон буй юм. Эртний монгол газар нутаг дээр төр улс үүсэн тогтсон цагаас эхлэн төр, засаглалын хэм хэмжээ бий болон төлөвшиж иржээ. Монгол улсад төр зан заншил уламжлалтай салшгүй холбоотой хөгжиж иржээ. Төрд зан заншил уламжлал ихээхэн нөлөөтэй байсан нь амьдрал ахуйтай ойр, хүний оюун ухаанд шингээж өгч байснаараа онцлог юм. Ийнхүү ард түмний зан заншил, хэв ёсыг дээдэлж чадсанаар Монгол улсын төр хүчин чадалтай, амьдралд хэрэгжиж биелэлээ олж байжээ. Монголын төрийн уламжлал нь дараа дараагийн үедээ уламжлал болон төр засаглалын эх сурвалж нь болж хөгжиж ирсэн. Монголын төрийн уламжлал, зан заншлын хэм хэмжээ нь онцлог төдийгүй нийгмийн харилцааг зохицуулахад зонхилох нөлөө үзүүлж он цагийн явцад улам төгөлдөржин боловсронгуй болсоор ирсэн байна. Эртний Монгол нутагт амьдарч байсан нүүдэлчдийн төр, улс байгуулах гэсэн хүсэл, сэдэл, үйл ажиллагаа нь тэдний өөрсдийнх нь дотоод, гадаад хөгжлийн өвөрмөц онцлог бүхий шууд үр дагавар байв.

Монгол газар тархай, бутархай байсан олон овог аймгийг нэгтгэн нягтруулж, төр улс байгуулсан нь юуны өмнө тэдгээр овог, аймгийн нэр хүнд бүхий удирдагчийн үйл ажиллагааны шууд үр дагавар, нөгөө талаар монгол төрийн үндэс суурийг бүрэлдүүлэн төлөвшүүлэхийн эхлэл, үүсгэл, түүнчлэн хэв ёс зан заншлын хэм хэмжээг хойш хойшдоо өвлөн уламжлуулах түүхэн бодитой үйл явц байжээ. Монгол нутагт үлдэж хоцорсон хад чулуунд сийлсэн үйсэнд бичсэн хаадын зарлиг захиас, мөн пайз, тамга, гэрэгэ зэрэг төрийн үйл явцтай холбоотой эх баримт сэлтүүд нь Монгол оронд төрт ёс хөгжиж хойч

³²Арван буянт номын цагаан түүх, Хөх хот, 1981, 70-р тал

үедээ уламжилж ирсний баталгаа ач холбогдолтой эх сурвалж мөн. Монголчуудын төр ёсоо хүндлэн дээдлэх, хуулиа чанд сахин биелүүлэх нь хэдийгээр нэгдсэн төр түүнээс өмнөх үеийн төрийн хэмжээний хүчин чадлын нэгэн илрэл боловч Монголчуудын нэн эртнээс эхлэн <<Хөх тэнгэр>>-ийг шүтэн биширч хааныг тэнгэртэй адилтгаж түүний гаргасан зарлигийг бүхнээс хүчтэй хэмээн үзэж байсан нь Монголчуудын төрөө хүндлэх, хуулиа дээдлэх үзэл бодол төлөвшихөд чухал нөлөө болсон байна. Шашны зан үйлийн ийм байдлыг шилжүүлэн авч төрийн хуульд тусгаж хуульчилж байсан нь Монголчуудын төрт ёсны үйл ажиллагааны нэгэн өвөрмөц онцлог байв.

Abstract: The state of Mongolian is ideas, rule of law, military, diplomacy, custom and religious rituals were important factors to regulate Mongolian social relations then the conclusion is that all of those things were an important impact to development of the state of Mongolian mind.

Номзүй

- Арванбуянтномынцагаантүүх.Монголынтүүхэнсурвалжбичгийн 2-р боть, УБ.,2006он
- Баярсайхан Б. “Арван буянт номын цагаан түүх” УБ, 2002 он
- Бира Ш. Монголын түүх, соёл, түүх бичлэгийн судалгаа УБ., 2001 он
- Бира Ш.Түүвэрзохиол, “Монголднэгдсэнтөрбайгуулагдажфеодализмбүрэлдэнтогтсоннь” УБ.,1960он
- Далай Ч. Монголын түүх. (1260-1388) Гутгаар дэвтэр, УБ хот, 1992 он
- Ишжамц.Н “Монголднэгдсэнтөрбайгуулагдажфеодализмбүрэлдэнтогтсоннь” УБ.,2002он
- Лүндэндорж Н. Эрх зүйн сэтгэлгээний чиг хандлага УБ., 2003 он
- Лүндэндорж Н. Төрийн онол УБ., 2005 он
- Монголынтөр, эрхзүйнтүүхУБ., 2010 он
- МонголынфилософийнтүүхУБ., 2000 он
- Санждорж.М “Монголтөрийнтүүхээс” УБ.,1998он
- Баярхүү.ГМонголыннэгдсэнтөрийнболондарааүеийнхуульцааз, заншлынхэмхэмжээгхарьцуулансудалсаннь /XIII-XVIII зуун/ УБ.,1997он
- Жамбал.АУлстөрийнсургаалийнтүүх УБ.,2001он
- Жүгдэр. Ч Монголд феодализм тогтох үеийн нийгэм-улс төр, гүн ухааны сэтгэлгээ /Эртнээс XIV зуун хүртэл/ УБ.,1987 он
- Жүгдэр. Ч XV-XVIII зууны Монголын нийгэм-улс төр, гүн ухааны сэтгэлгээний хөгжлийн тойм УБ.,1984 он
- Чагдаа Х “Монголчуудын философи сэтгэлгээний үүсгэл, түүхэн уламжлал УБ., 2006 он

Юндэндорж А Эртнийөрнө, дорнынмэргэдийнулстөрийнсэтгэлгээнийонол, сургаал, тэргүүндэвтэр, УБ., 2001 он

Юндэндорж.А, Атар.ЮӨрнө, дорнынмэргэдийннийгэм-улстөрийнонол, сургаал, дэд, гутгаардэвтэр, УБ., 2003 он

АНАРХИЗМ - НИЙГЭМ-УЛС ТӨРИЙН АЯДУУ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ БОЛОХ НЬ

Г.Цэнд-Аюуш

*МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар,
Улс төр судлалын тэнхмийн зөвлөх дэд профессор, доктор*

Н.Ариунаа

*МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар,
Улс төр судлалын тэнхмийн докторант*

Түлхүүр үг: Анархист үзэл, албадлага, эрх чөлөө, шударга ёс

Анархизм- латин үгнээс гаралтай анархос- буюу захирагчгүй, засагчгүй засаглал гэсэн утгыг илэрхийлнэ/. Анархизм- хүн эрх чөлөөтэй байхад басхүү түүнийгээ эдлэхэд төр үргэлж саад болдог тул аливаа нэг албадлага, хууль дүрэмгүйгээр хүмүүний нийгэм хамтын амьдралаа өөрийн жам ёсны үндсэн дээр зохион байгуулж оршин тогтнох ёстой³³ гэж номлодог үзэл баримтлал. Анархизмыг аливаа төр засагт дайсагнан ханддаг, жижиг хувийн өмчтөний эрх ашиг, тариачны аж ахуйг том үйлдвэрлэлд тулгууласан нийгмийн дэвшлийн эсрэг сөргүүлэн тавьдаг хувиа аргацаасан жижиг хөрөнгөтний мөлжлөгийн шалтгаан, ангийн тэмцэл, пролетарийн диктатурыг ойлгож чаддаггүй нийгэм- улс төрийн урсгал³⁴ гэж марксистууд үздэг байв. Угтаа бол анархизм аливаа хэлбэрийн албадлага, хүчирхийлэлд тулгуурласан засаглалыг халах, оронд нь иргэдийн эрх чөлөөт, сайн дурын холбоо бүхий “нийтийн сайн сайхан”-ны үйлсэд зориулагдсан үзэл санааг номлодог, түүнийгээ нийгмийн амьдралд хэрэгжүүлэхийг гол зорилго болгодог. Хэдийгээр төр, засаггүй нийгмийн тухай үзэл санаа анархизмын үндсэн агуулга, гол зорилго болдог хэдий ч анархизм бүхэлдээ нэгдмэл, цогц онол, сургаал болж боловсрогдоогүй, зорилгодоо ямар арга замаар хэрхэн хүрэх талаар анархистууд харилцан ялгаатай өөр өөр ойлголт төсөөлөлтэй байсанд хэргийн гол оршино. Тиймээс улс орнуудын түүхэн

³³ <https://en.wikipedia.org/wiki/Anarchism>

³⁴ Философийн толь. УБ., 1990, 25-р тал

практикт анархизмын үзэл санаа хэрэгжиж байгаагүй, хэрэгжих боломж өнөө цагийн улс төрийн нийгэмд хэрэгжих боломжгүй гэдгийг улс төрийн үйл явц бэлхнээ харууллаа. Анархист үзэл санааны үүслийг Эртний Хятадын гүн ухаантан Лао цигийн “хүмүүний хоорондын эелдэг, харилцан ойлголцлоор хамтын нийгмийг зохион байгуулах” үзэл санаанаас үүдэлтэй гэж үзэж болно. Хожим нь Германы улс төрийн зүтгэлтэн М.Штирнер/жинхэнэ нэр нь Каспар Шмидт/, Ж.Прудон ба Оросын анархист үзэлтэн М.А.Бакунин нарын нэртэй холбоотой бөгөөд тухайн үедээ тэдний үл гүйцэлдэх гэгдэх үзлийг К.Маркс, Ф.Энгельс, В.И.Ленин нар шүүмжлэн няцааж байсан. Анархизмыг анархи ёс буюу дэг журамгүй, эмх замбраагүй явдалтай адилтгаж үл болно. Өнөө цагийн олон ургальч үзлийн өнцгөөс харвал анархизм бол төрийн засаглалын дарангуйлал, төрийн хүчирхийллийг эсэргүүцдэг эв нийцтэй байдал, нийгмийн найрслыг эрхэмлэсэн чөлөөт чин хүслэнгийн төлөөх үзэл санааны цогц мөн гэж ойлгох нь зүйд нийцнэ. Анархист үзэл баримтлалын тулгуур зарчмууд нь тэгш эрх, ахан дүүсэг ёс, бие хүний бүрэн эрх чөлөө, хүмүүний харилцан туслалцах харьцахуй юм. М.А.Бакунин аливаа төр ямар ч хэлбэрээрээ ард олныг дарангуйлах хэрэгсэл болдог тул оросын сая сая тариачин түмэн өөр өөрсдийн амьдрал ахуйгаа төрөөр мэдүүлэхгүй зохицуулж ирснийг / хөдөөгийн хүй нэгдэл-Г.Ц/ тооцож үзэх ёстой хэмээн номлож байв. Бакунины анархист үзэл баримтлалын нийгмийн зорилго, хүсэл тэмүүлэл нь оросын тариачин, ажилчны тус бүрийнх нь холбоот байгууллагыг нэгтгэсэн “чөлөөт холбоо”-нд тулгуурласан хамтын нийгэм байгуулах санаа байжээ. Ийм хамтын нийгэмд ажилчин, тариачны холбоо нь газар, хөдөлмөрийн хэрэгслийг хамтран эзэмшиж ашиглах ба хөдөлмөрийн ашиг, үр дүнг нь хамтач ёсны дагуу оруулсан хувь нэмрээр нь тооцож хуваарилах ёстой ажээ. Оросын хөдөөгийн хүй нэгдлийн уламжлал бол ирээдүйд социализмд ирэхэд их ач холбогдолтой гэж тэрбээр үзсэн юм. Ийм уламжлалыг Оросын сая сая тариачид, ард олон хэдэн зууны туршид уламжилж ирсэн. Барууны орнуудад фабрикийн болон хотын ажилчид зонхилдог, харин Орос, Польшид мөн ихэнх славян газар нутаг дээр хүн амын дийлэнх нь тариачид байсаар ирсэн. Энэ патриарх ёс бол аливаа асуудлыг шударгаар шийдэх хамгийн сайн арга. Энэ бол “тариачны ардчилал”. Социал ертөнцийн гол хууль бол нийгмийн эв санааны нэгдэл ба эрх чөлөө. Эв нэгдэл, эрх чөлөө харилцан шүтэлцээтэй. Хүн бүрийн эрх чөлөө бол нийтийн эв санааны нэгдлийн үр дүн, эв санааны нэгдэл бол хувийн эрх чөлөө орших зайлшгүй нөхцөл мөн. Энэ хоёр үнэт зүйлс хоёулаа хүмүүсийн нийгмийн хамтын амьдралаар нөхцөлдөж үүссэн. Энэхүү анархизмын хамтач ёсны үзэл баримтлалд П.А.Кропоткин “харилцан туслалцах биосоциологийн хууль”-ийг томъёолсон бөгөөд хүмүүс угтаа байгалийн жамаар хоорондоо тэмцэлдэх биш, харин бие биедээ тэмүүлж хамтран аж төрөх, ажиллах хүсэлтэй байдаг... үүнд төр , хувийн өмч саад учруулдаг

хэмээжээ. Түүний үзэл санааг талархан дэмжигчид баруун европын ялангуяа Итали, Швейцари, Франц зэрэг орнуудад нэлээдгүй байсан байна. Мөн түүний үзэл санааг Оросын И.С.Тургенев, Ф.М.Достоевский, А.И.Герцен, Н.П.Огарев, А.А.Блок нарын зэрэг аугаа уран зохиолчид, яруу найрагчид дэмжиж захидлаар харилцдаг байжээ. Бакунин өөрийн анархи социализмын чин хүслэнгээ “хувь хүмүүс хамтралд, хамтрал нь- мужид, муж нь-үндэстэнд, үндэстэн нь-Европын нэгдсэн холбоонд, ЕНХ нь - бүх дэлхийн нэгтгэлд гэсэн чөлөөт холбооны зарчимд суурилсан эх орны шинэ зохион байгуулалт” гэж төсөөлж байв. Нийгмийн тийм зохион байгуулалт бүх дэлхийн хөдөлмөрчдийн эрх чөлөө, тэгш ёс, шударга ёсны эхлэлээс улбаатай юм. Ийнхүү Бакунины анархист үзэл санаа бол 1990 он хүртэлх бидний дуулгавартай дагаж мөрдөж ирсэн марксист-ленинист онолын үүднээс дүгнээд үзвэл олон талаараа түүний үзэл санаа утопи шинжтэй амьдралаас тасархай, хэрэгжүүлэх арга замын хувьд бодит гэхээсээ илүү ёс суртахууны зан үйлийг гол болгосон номлол мөн. 1917 онд Орос оронд гарсан Октябрийн хувьсгалын дараа Орост анархист хөдөлгөөн нухчин дарагдсан юм. Харин өнөө цагийн олон ургальч үзлийн үүднээс үзвэл энэхүү анархист үзэл санаа иргэд тэдний эрх ашгийг хамгаалсан өөрийгөө удирдах ёсны байгууллагаас төрд, түүний үйл ажиллагаанд хяналт, шаардлага шахалт үзүүлсэн иргэдийн санал санаачлагыг хөхүүлэн дэмжсэн учир зүйн уялдаа холбогдол бүхий онолын хандлага юм. Учир нь ардчиллын нөхцөлд төрийг царайчилсан, төрийг шүтсэн, түүнд горьдлого, найдлага тавьсан хүмүүсийн ухамсар, үйл байдлыг өөрчлөх “өдөөн түлхэгч хүч” /стимул-Г.Ц/ болж хувирахад чиглэсэн, иргэд өөрөө өөрийнхөө хувь заяаны эзэн байх ёстой гэсэн хувь хүний, хамт олны, социал бүлгийн ухамсар, санал санаачлага, үйл байдлын ач холбогдлыг илүүд үзсэн үзэл баримтлал мөн бөлгөө.

Краткий обзор: социально-политическое течение, обосновывающее целесообразность и необходимость реализации "анархии", то есть освобождения личности от какой бы то ни было экономической, социальной, политической духовно-идеологической власти. Это освобождение личности анархизм усматривает в преодолении сложившегося на определенных этапах общественного развития отчуждения человека от государства, власти, собственности путем ликвидации этих социальных институтов, в отрицании какого бы то ни было государства, отстаивании идей создания федерации автономных ассоциаций производителей.

Ном зүй

1. Энциклопедия. М.,1996
2. Абрамов. Г. Анархизм или социализм. М., 1917

3. Авшинов. П. Анархизм и диктатура пролетарата. Париж. 1931
4. Прумова. Н.М. Социальная доктрина М.А Бакунина. М., 1990
5. Г.Цэнд-Аюуш. XIX-XX зууны улс төрийн сэтгэлгээний хөгжлийн түүхэн тойм. УБ., 2015

ТӨР ТӨВТЭЙ ҮЗЭЛ БА ТҮҮНИЙ ОНОЛЫН ХУВЬСАЛ ӨӨРЧЛӨЛТ

Ц.Батболд

*МУИС, ШУС, Улс төр судлалын тэнхим
дэд профессор, доктор*

Түлхүүр үг: Төр төвтэй үзэл, хүн ба нийгэм төвтэй үзэл, төрийн зохицуулалт, төрийн оролцоо, төвлөрөлийг сааруулах, бюрократ, төрийн шинэ менежмент, сайн засаглал

Товч утга: Уг өгүүлэлд төр төвтэй онолын эрсдэлтэй талуудын талаарх зарим эрдэмтэдийн онолын байр суурийг тусгасан. Төр төвтэй онолоос нийтийн ашиг сонирхлыг шинээр тодорхойлох чиглэлд гарсан онолын хандлагыг авч үзсэн. Эцэст нь төр төвтэй үзэл баримтлалаас нийгэм төвтэй төрийг бүтээхэд шилжиж буй өөрчлөлтийн талаар дурьдсан.

Төр төвтэй онолын эрсдэл, ач холбогдол

Төр төвтэй нийгмийн тогтолцоо нь үндэстэний төр улсууд бэхжиж эхэлсэн XVI-XVII зууны Европ дахь абсолютизмын үеэс үүссэн бөгөөд түүнийг уламжлан хөгжүүлэгч нь капиталист нийгэм дэх төрийн захиргааны бюрократ аппаратууд юм.³⁵ XIX зууны сүүлч XX зууны эхээр их гүрнүүд нөлөөнийхөө хүрээг дахин хуваахын төлөө тэмцэлд орсон явдал нь төрийн этатист хандлагыг эрс нэмэгдүүлсэн. Улс төрийн шинжлэх ухаан болон социологийн ажлуудад төр төвтэй институци үргэлж байсаар ирсэн. XX зууны эхний Европын нийгмийн шинжлэх ухааны түүхэнд төрийн төвлөрөл нь улс төрийн амьдралын гол асуудал боллоо гэж Макс Вебер болон Отто Хинтзе нар үзэж байсан. Фредрих Лист 1841 онд хэвлэгдсэн “Улс төрийн эдийн засгийн үндэсний тогтолцоо” номондоо “өндөр соёлтой хоёр үндэстний хоорондох чөлөөт өрсөлдөөн нь тус хоёр орны аж үйлдвэрийн хөгжлийн төвшин ойролцоо байгаа тохиолдолд л зөвхөн хоёр талын харилцан ашигтай

³⁵ Ц.Батболд. Бюрократ онолын үндэс. УБ., 2013. Тод Магнат ХХК. хт 484. Тал 412

байх бөгөөд хэрвээ бусдаасаа аж үйлдвэрийн хувьд хоцорч байгаа аливаа орон ямар нэгэн хөгжингүй улс оронтой чөлөөт өрсөлдөөнд орох гэж байгаа бол юуны өмнө хүчээ чангатгах ёстой” гэж бичжээ.³⁶

Дэлхийн 1-р дайны дараа нийтийн захиргааны дэг журмууд хатуу чанга болж өөрчлөгдсөн. АНУ болон баруун Европын орнууд хөдөөгийн нийгмийг хотын үйлдвэрлэлийн нэгжүүдтэй ижил иргэншсэн дэг журамтай болгон өөрчлөх захиргааны үйл ажиллагааг өөгшүүлсэн байна. Энэ шаардлага нь нийтийн захиргаанд их хэмжээний хариуцлага хүлээлгэж, маш олон шинэ үйл ажиллагаа болон программууд бий болсон.³⁷

Нидерланд, Франц, Их Британий үйлдвэржилтийн хувьсгал нь зах зээлд төрийн нөлөөгүй буюу “үл оролцох” либераль номлолын үед явагджээ. Францын эрдэмтэн Клод Хэнри де Сэн Семон “аливаа төрд шат дараалсан аж үйлдвэрийн хөгжил хэрэгтэй” хэмээн тухайн үедээ бичиж байв. Түүнийхээр бол хувийн аж үйлдвэрүүд шаардлагатай хөгжлийг бий болгож чадахгүй байгаа нөхцөлд төр оролцох ёстой аж.³⁸

Америкийн улс төр судлаач Н.Глик төрийн аппаратын бүтцийн тархай байдал нь бюрократ системийн улс төрийн ерөнхий стратегийг боловсруулахад саад болдогт анхаарлаа хандуулсан байдаг. Өндөр албан тушаалтай хүмүүсийн зорилго нь үнэт зүйлсийн цогц нэгдмэл байдал болон улс төрийн номлолыг тэр бүр үгүйсгэдэггүй гэж тэр үзсэн байдаг. Бюрократ тогтолцоо нь өөртөө шинэлэг зүйлийг агуулдаг. Учир нь төрийн бодлого, салбар хоорондын баримт бичгүүд, нийгмийн шаардлагаар гарч ирсэн сонирхлын бүлгийн үнэт зүйлс зэргийг хэрэгжүүлдэг нь түүнийг нийгмийн өөрчлөлтийн чухал хэсэгт хамааруулдаг байна. Гэхдээ бүтэц болгон үүргээ гүйцэтгэх явцдаа сэрэмжлэх арга хэмжээ авах ёстой бөгөөд энэ нь нийгмийг аюулаас сэргийлэх гэсэн оролдлого юм. Энэ үүргүүд нь нийгмийн бүх объектуудыг хамардаг. Төрийн зүгээс иргэд болон улс орондоо үйлчилж байгаа үйл ажиллагаа нь түүний бодлогын нэгээхэн чиглэл хэсэг нь болдог.³⁹

Хэрэв Тейлор ажилчинг яаж машин шиг ажиллуулах вэ гэдэг асуулт тавьсан бол, Вебер бүх байгууллагаараа машин шиг л ажиллах хэрэгтэй гэж хариулах байсан гэдэг хошигнол байдаг. Вебер ямар ч нөхцөлд боловсруулсан дүрэм, үйлдлийн явцын дэг журмуудыг ажилтан бүр заавал биелүүлэх үүрэгтэй бөгөөд энэ нь түүнийг хэрэгтэй юуг ч

³⁶Ц.Батболд. Төрийн удирдлагын шинэтгэл/Төрийн албан хаагчийн ширээний ном УБ., 2017 хт402 тал 39

³⁷Ц.Батболд. Төрийн удирдлагын шинэтгэл/Төрийн албан хаагчийн ширээний ном УБ., 2017 хт402 тал 28

³⁸ Ц.Батболд. Төрийн удирдлагын шинэтгэл/ Төрийн албанхаагчийн ширээний ном УБ., 2017 хт402 тал 26

³⁹ Ц.Батболд. Бюрократ онолын үндэс. УБ., 2013. Тод Магнат ХХК. хт 484. Тал 438

хийсэн бүх зохион байгуулалт машин шиг ажиллана гэж үзэхэд хүргэсэн. Бюрократ зохион байгуулалт ямар ч нөхцөлд боловсруулсан дүрэм, үйлдлийн явцын дэг журмуудыг ажилтан бүр дээр хийж боловсруулсан дүрмээр хангагдсан байдаг. Веберийн энэ зохион байгуулалтын концепцид бие хүн байхгүй. Үйл ажиллагааны процедур, дүрэм журмууд нь бүх үндсэн үйл ажиллагааны төрөл, ажилтануудын карьер, бодлого тодорхойлох болон удирдагчдын үйл ажиллагааг чиглүүлж байдаг.

Веберийн тооцсоноор зохион байгуулалтын бюрократ тогтолцоо нь тодорхой, эмх цэгцтэй, нягт нямбай, хурдан, урьдчилан хардаг болон тасралтгүй байдлыг хангах ёстой байдаг. Бюрократ нь янз бүрийн утгатай. Эхний тохиолдолд, энэ ойлголт нь хатуу боловсруулсан дүрэм журмаар процедурыг хэрэглэдэг шинж чанартай. Бусад тохиолдолд бюрократыг томоохон байгууллагын үйл ажиллагааны сөрөг үр дагавараар тодорхойлдог. Веберийн судалгаанд бюрократыг нийгмийн хамтын үйл ажиллагааны тухай рационал харилцаагаар төсөөлдөг.⁴⁰

Тухайн цаг үеийн олон улсын улс төр, эдийн засгийн харилцаа их гүрнүүдийн геополитикийн бодлого нь улс орнуудыг төрөө бэхжүүлэхэд илүү анхаарч, хувь хүмүүсийг төрийн машины эд эс, эрэг шураг болгодог нийгмийн тогтолцоо өмнөх үеэс илүү хөгжих болсон. Төрийн оролцоог нэмэгдүүлж, төр төвтэй нийгмийн хөгжлийг дэмжихэд дараах дөрвөн үндсэн хүчин зүйлс гол нөлөөлөл үзүүлсэн байна. Үүнд:

1. Дэлхийн I дайны дараах олон улсын улс төрийн тавцан дахь улс орнуудын дайсагнасан харилцааны улмаас үүссэн глобальчлалыг хязгаарлах үйл явц нь 1930-аад оны чөлөөт зах зээл дэх эдийн засгийн хямралыг үүсгэжээ. Хямралаас гарах асуудалд тоног төхөөрөмж, техникийн шинэчлэлээс илүүтэй төрийн зохицуулалт, түүнийг зохион байгуулах бюрократ аппаратуудыг бэхжүүлснээр шийдвэрлэжээ.

2. Хямралыг давахад төрийн зохицуулалттай зах зээлийг удирдлага болгосон неолиберализм болон национал-социализм, коммунизмын үзэл сурталд тулгуурласан тоталитаризмын баруун зүүний урсгал нь төрийн оролцоог нэмэгдүүлсэнээр хямралыг даван туулах үндэслэл болсон ажээ.

3. Төр нь тухайн цаг үеийн олон улсын харилцаанд өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх болон батлан хамгаалах үүднээс зохицуулалтыг эрс нэмэгдүүлэхэд хүрсэн. Эс тэгвэл тусгаар тогтнолоо алдах буюу аль нэгэн хүчирхэг төр улсын дагуул улс болох хувь заяа тулгарч байсан билээ. Энд тухайн үеийн геополитикийн ач холбогдол багатай болон олон улсын сонирхлын тэнцвэрийг хадгалж байсан улс орнуудыг оруулан тооцох шаардлагагүй билээ.

⁴⁰ Ц.Батболд. Бюрократ онолын үндэс. УБ., 2013. Тод Магнат ХХК. хт 484. Тал 210

4. Төр нь дэлхийн II дайны үед нийгмийн эдийн засаг, соёл, социал, оюун санааны бүхий л амьдралыг албадан зохицуулах болсон бөгөөд тайван цагт ч сэргээн босгох болон хүйтэн дайны улмаас улс орны хүчирхэг байдлыг хадгалах үүднээс төрийн оролцоо улам нэмэгдэж иржээ.⁴¹

Хүйтэн дайн, хоёр системийн цэрэг, улс төр, эдийн засгийн үзэл сурталжсан тэмцэл, идэвхтэй дүр үзүүлэгч бюрократуудын зүтгэлээр төрийн зохицуулалт, түүний удирдлагын төвлөрөлтийг дээд цэгт нь хүргэж, нийгмийн хөгжил, хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах болсон байна. Нөгөө талаар төрийн зохицуулалт нэмэгдэж, бюрократ аппаратын хүрээ тэлсэн нь төр улсуудын үйлдвэржүүлэлтийг эрчимжүүлэх, төдийгүй олон улсын тавцанд өрсөлдөх чадварыг нь нэмэгдүүлэх гол хэрэгсэл болсон байна. Энэ талаар Вернер Абельсхаузер “төр бол жолоодох хүчин бөгөөд Орос улс үүнийг ашиглаж, барууны эдийн засаг, аж үйлдвэрийн хөгжлийн төвшинд хүрэхийг оролдсон юм” гэжээ.⁴²

Дэлхийн хоёрдугаар дайн дууссаны дараах эхний 30 жилийн хугацаанд эрдэмтэд зарим улс орнуудын ойролцоо өөрсдийн шинжилгээний төвөө байгуулсан. Плуралист эрдэмтэд улс төрийн тоглогчдыг ялангуяа, сонгогдсон албан тушаалтны гаргасан хууль эрх зүйн шийдвэрийг сонирхож байв. Ихэвчлэн тэд "засгийн газар"-ийг АНУ-ын засгийн газрын үйл ажиллагаатай ижил төстэй, мөн улс төрийн намууд бусад бүлгээс илүү улс төрийн нөлөө үзүүлж байгааг дахин анхаарсан нь Дэвид Трумен (1951), Роберт Даль (1961) нар юм. Харин марксист эрдэмтэд 1960-аад оноос эхлэн олон ургальч үзэл нь улс төрийн үйл явцыг хамрахыг эсэргүүцэн бөгөөд “төрийн төвлөрөл”-ийг тодорхой этатист хандлагаар тайлбарлаж эхэлжээ. Гэхдээ энэ нь ерөнхийдөө явцгүй, шинжлэх ухаанч бус нэг үзэл суртлын туйлшралыг хамгаалах гэсэн арга байсан бөгөөд үр дүнд нь социалист систем нурсанаар тайлбарлагдана.

Эрх мэдэл төвлөрөх тусам нийгмийн амьдралд төрийн оролцоо ихсэж бүгдийг зохицуулах гэж оролдог. Төрийн зохицуулалт нь хорих, цагдах, хянах, торгох, шийтгэх гэсэн захиргааны аргаар хэрэгждэг бөгөөд хуулийн нэрийг барин иргэдийн эрхийг зөрчин хүчирхийлдэг. Ингэж төрд эрх мэдэл төвлөрөх тусам ард түмэн өөрийнхөө амьдралыг өөрөө зохицуулах, өөрийнхөө төлөө хариуцлага үүрэх чадвараа алдаж эхэлдэг.⁴³

XX зууны 70-аас 80-аад онуудад барууны орнуудад явагдаж байсан системийн хямрал, түүнээс гарсан онолын гэгээрэл нь бүхэлдээ ардчиллын тухай маргаан хэлцлийн хүрээнд болж байсан ажээ. Бюрократ системийн хямрал нь ардчиллын хямрал болж гүнзгийрсэн

⁴¹ Ц.Батболд. Бюрократ онолын үндэс. УБ., 2013. Тод Магнат ХХК. хт 484. Тал 199

⁴² Ц.Батболд. Бюрократ онолын үндэс. УБ., 2013. Тод Магнат ХХК. хт 484. Тал 195

⁴³ Ч.Сосормаа. Төрийн захиргаанаас нийтийн захиргаа руу: Шинэтгэлийн таван хөшүүрэг. УБ., 2008. Бит Пресс ХХК. хт 225 тал 13

байв. Төр төвтэй нийгэм, түүний төрийн хэт зохицуулалтын үндсийг шүүмжилсэн У.Нисканений “Бюрократын эдийн засгийн онол”, Жордан Туллок, Жеймс Буханин нарын “Нийтийн сонголт”-ын онол зэрэг олон бүтээлүүд гарсан нь төр төвтэй нийгэмд томоохон өөрчлөлт гарахад нөлөөлсөн. Энэ өөрчлөлт нь төрийн үүрэг, оролцоог дахин авч үзэж шүүмжлэлтэй хандаж, түүнийг цомхон, чадварлаг, нийгэмдээ үйлчилдэг болгоход чиглэгдсэн. Энэ шинэтгэл нь нийгэм, эдийн засаг, соёл, оюун санааны өөр өөр нөхцөл бүхий улс орнуудад бараг нэгэн зэрэг өөр өөрийн онцлогоор хийгдэж эхэлсэн.

Мишель Крозье өнөөдрийн ардчилал ба өнгөрсөн үеэс өвлөн авсан улс төрийн институтуудын хямралыг голчлон тэмдэглэсэн. Түүнийхээр орчин үеийн хямрал гэдэг бол юуны өмнө нийгмийн удирдлагын хуучирсан уламжлалт загваруудын хямрал юм. Илүү тодорхой байдлаараа энэ хямрал нь иргэний дэг журмын дезинтеграци, нийгмийн сахилга батын уналт, лидерүүд өсөн гарч ирэх болон иргэдийн улс төрөөс хөндийрөх үйл явц хүчтэй болох байдлаар илэрхийлэгдэж байдаг⁴⁴ гэж үзсэн. “Тоглоомын нөхцөл” өөрчлөгдсөн нөхцөлд орчин үеийн нийгмийн хяналтын хэрэгсэл тохирохгүй байгаа явдал Крозьегийнхээр хямралын гол шалтгаан болж байдаг байна. Тэрээр “...орчин үеийн хямрал бол нийгмийн хяналтын хэрэгслийг хэсэгчилэн нураах (дезинтеграция) явдал юм”⁴⁵ гэж үзсэн байна.

Орчин үеийн нийгэмд оршин тогтнох гурван төрлийн гол аюул байдаг гэж Крозье үзжээ.

Нэгдүгээрх нь - “Контекстуаль аюул” (Тухайлсан үгийн дуудлага) Энэ нь орчин үеийн нийгмийн оршиж буй орчноос үүдэлтэй бөгөөд ардчилсан дэг журмын үйл ажиллагааны уламжлалуудын нэг юм. Ийм аюулд дайнд ялагдсаны дараах бодит үр дагаварын үр дүнд улс төрийн гадаад байдал хүндэрсэн тохиолдол орно. Бараг бүх улс төрийн дэглэмүүд тэдгээрт нийтлэг дутагдлууд оршиж байдаг ч гэсэн “улс төрийн энерцийн хууль”-ийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байдаг бөгөөд дайнд ялагдсаны дараа бараг бүх газарт засаглалын өөрчлөлтүүд явагдаж байдаг аж. Түүний эдгээр эрэгцүүлэх дүгнэлтүүд нь 1945 оны дараах улс төрийн амьдралд ажиглалт хийсний үндсэн дээр хийгдсэн ч гэсэн хүйтэн дайн дууссаны дараах посткоммунист орнуудын өнөөдрийн байдалтай нилээд төстэй юм. “Контекстуаль аюул”-ын ноцтой байдал болон үүсэл нь олон оронд өөр өөр хувилбартайгаар явагдаж байдаг бөгөөд тэдгээр орнуудын нутаг дэвсгэрийн болон соёлын хөгжлийн төвшинг илэрхийлж байдаг. Зарим тохиолдолд улс гүрний амьдралын үндсэн сонирхлыг тасалдуулахад хүргэдэг аюултай ажээ.

⁴⁴ Crozier M., Huntington S., Watanuki J. The Crisis of Democracy. N. 1. 1975.

⁴⁵ Crozier M. On ne change pas la société par décret. P. 16.

Хоёрдугаарх нь зүй тогтлын аюул. Энэ нь улс орны хөгжил дэх нийгмийн бүтцийн болон нийгмийн хандлагын зүгээс гарах аюул хамаарна. Энэ нь нийгмийн дотоод дахь угсаатны зүйн болон тивийн туйлшралын тухай асуудал юм. Түүхэн эрин үеийн суурийн эсрэг хүчинд (дэглэмийн оршин тогтнолд аюултай) нийгмийн янз бүрийн хүчин зүйл байж болох юм. Хэзээ ч юм үүнд язгууртнууд, цэргийнхний давхарга, дунд анги, дараагаар нь ажилчин анги орж байв. Өнөөдөр ийм маягийн аюулын эх үүсвэрийг судлаач радикал үзэлтэй сэхээтнүүдийн дундаас олж харж байсан аж. Эдгээр радикал сэхээтнүүд ардчилсан нийгмийн дутагдалтай талууд болох монополичлол, коррупци, оюун санааны ядуурал зэргийг устгахын тулд удирдлага болон дэглэмийг үндсээр нь өөрчлөх хэрэгтэй гэж үздэг байна.

Гурав дахь аюул нь Крозьегийн үзсэнээр засаглалын системийн дотоодод оршиж байдаг нилээд аюултай чухал зүйл байдаг. Энд гол дутагдал нь дэлхийн улс орнуудын нийгмийн системд шаардлагатай өөрөө өөрийгөө хянах системийн хөгжил хангалтгүй байдаг явдал юм. Орчин үеийн нийгмийн гол асуудал бол тэдгээрийн хэлбэрэлтгүй тогтмол амжилттай шинэчлэлтийн асуудлууд юм. Үүний цаана орчин үеийн засаглалын системийн ирээдүйн хувьд пессимизмийн шинжтэй үзэгдэл нуугдаж байдаг. Сүүлчийн аюулын онцлог бол эдгээр нь цаг хугацааны хувьд тогтмол, бүх цаг үед бүхий л ард түмнүүдэд түгээмэл байдаг ажээ.

“Контекстуаль аюул” нь янз бүрийн цаг үе, нийгмүүдэд өөр өөр шинж чанар, хэлбэртэйгээр илэрдэг бол нийгмийн бүтцийн аюулын хүч нь түгшүүртэй байдал болон цаг хугацаа орон зайн нөлөөлөлтэй байдаг. Системийн дотоод аюул бүгдэд хаана ч үргэлж адилхан аюултай байдаг ажээ. Гадны аюул, гадаад улс төрийн зөрчилдөөнийг улс төрийн гадаад хүчний байршлын арга ухааныг ашиглан тоглоомын нарийн түвэгтэй үйл явцаар дамжуулан зөөлрүүлж болдог. Тэдгээр нь маш олон агентуудаас бүрдэж байдаг учраас “өсгөх тоглоом”-ын маш олон хувилбаруудаас бүрдэж байдаг байна.

Крозьегийн үзэл бодлоор бол засаглалын хямралын энэхүү гаж үзэгдлийг гол гурван хүчин зүйлүүд тайлбарлаж чадах юм. Эдгээрийн нэгд, шинжлэх ухаан техникийн дэвшлийн гайхамшигт хэмжээлшгүй ихээр итгэж байсан явдал бөгөөд тэдгээр нь бүх хүнд тэгш хүртээлтэй зүйл гэж үзэж байсан. Хоёрт, нийгмийн шинэ нөхцөл байдалд уламжлалт ажилчин анги хөгжсөнтэй холбоотой сөрөг уур амьсгал юм. Үүнд нийгмийн сөрөг талуудын хооронд үр ашигтай хэлцлийн нөхцөл байдаггүй бөгөөд энэ нь бараг бүх оронд сунжирсан маягийн үр ашиггүй ажилчдын оролцоог үгүйсгэсэн бюрократ журам юм. Үүний тод жишээ бол Латин Америкийн орнуудад хөдөлмөрчдийн шаардлагыг радикальчлах, гэрээ хэлцлийн процесс бүрэн үгүйлэгдсэн байдаг явдал юм. Гуравт, нийгмийн түгшүүртэй байдлын өсөлтийн нилээд ул суурьтай шалтгаан нь эдийн засгийн

өсөлтийн хурдасгалын үр дагавар болж байдаг. Энэ нь хуучин үйлдвэрлэлийн салбаруудыг халж, шинэ салбаруудыг үүсгэж улмаар хүмүүст газар зүйн болон мэргэжлийн хувьд эмх цэгцтэй байх өндөр шаардлагыг тавьж байдаг. Энэ нь өөрөө эргээд хүчтэй сэтгэл санааны түгшүүртэй байдлыг үүсгэж байна гэж үзжээ.⁴⁶

Крозьегийн бодлоор зүүнийхэн засаглалын асуудлуудыг төрийн капиталист, социалист төрлүүдээс хамаарахгүйгээр түүнд сонгодог зүйл байдаг гэдгийг тойрон гардаг. Тэд энэ асуудал нь юуны өмнө бидэнд өөрт байдаг гэдгийг ойлгож чаддаггүй юм гэжээ.⁴⁷

Бусад эрдэмтэд илүү төвлөрсөн макро социологийн байдлаар төрийн оролцогч талууд болон төрийн бүтэц байгууламжийг шийдвэрлэх нь илүү чухал ач холбогдолтой гэж үзсэн байж магадгүй юм. Харьцуулсан социологи болон улс төрийн шинжлэх ухааны нэрт эрдэмтэд, тухайлбал Рейнхард Бэндикс, Барингтон Мур, Сэмуэл Хантингтон, Сеймоур Мартин Липсет, Стейн Роккан, Хуан Линз, Шуэйл Айсэнстант, болон Чарльз Тилли нар төрийн үйл явцад илүү анхаарал хандуулж, судалгаа шинжилгээ явуулах ёстой гэж үзэж байсан.

Толкатт Парсонс, Липсет болон Роккан (1968) нар анхлан нийгмийн тогтолцооны үзэл баримтлалыг бий болгосон. Сеймоур Липсет улс төрийн намуудын тогтолцооны урт хугацааны зөрүүг ойлгохын тулд "үндэстэнийг бүтээгчдэд" тулгарч буй нөхцөл байдал, тухайлбал хямрал болон тэдний хийсэн сонголтууд дээр анхаарал хандуулах хэрэгтэй юм⁴⁸ гэж үзсэн. АНУ хэмээх шинэ үндэстэнийг бүтээгчдийн хувьд тэднийг "төслийг бүтээгчид" гэж үзэж болно. Учир нь тэдний төслүүд соёлынхоос илүү институц байж болох юм. С.Хантингтон "улс төрийн шинэчлэл"-ийн хэлбэрийг шинж чанар, төрийн байгууллагын хөгжилд чиглэсэн байдлаар нь авч өөрчилсөн.⁴⁹ Ч.Тилли өмнөх ойлголтоос огт өөрөөр төрийг бүтээхээс илүү улс төрийн шинэчлэл, эсвэл үндэстэнийг бий болгох нь тодорхой асуудлыг шийдвэрлэнэ⁵⁰ гэж үзсэн.

Төрийн зохицуулалт давамгайлсан төр төвтэй үзэл баримтлал нь постмодернизмын өөрчлөгдөж буй нийгэмд экологийн, хүмүүнлэгийн, хүний эрхийн гэх мэт нэмэгдэж буй олон асуудлуудад удирдлагын чадвараа алдаж хүнд сурталжсан, хөшүүн хойрго, рационал бус, үрэлгэн хэмээн шүүмжлэгдэх болсоноор түүний оролцоог хязгаарлах, төвлөрлийг

⁴⁶Спиридонова В.И. Бюрократия и реформа (анализконцепции М. Крозье). – М.: ИФРАН, 1997.

⁴⁷ Ц.Батболд. Бюрократ онолын үндэс. УБ., 2013. Тод Магнат ХХК. хт 484. Тал 407

⁴⁸ Seymour M.Lipset. Political Man: The Social Bases of Politics. Anchor Books, Garden City, New York. 477pp, 1960, ISBN 0-8018-2522-9.

⁴⁹ Samuel P. Huntington. (1968)Political Order in Changing Societies.

⁵⁰ Charles Tilly. (1975) The Formation of National States in Western Europe (ed.)

сааруулах хэлбэрээр бүтэц зохион байгуулалт, үүрэг, үйл ажиллагааны хандлагыг шинэчлэн өөрчлөх шаардлага тулгарсан ажээ.

Төр төвтэй онолоос нийтийн ашиг сонирхлыг шинээр тодорхойлохуй өөд

Нийгмийн ухааны голлох онол судалгааны асуудалд олон жилийн өмнөөс төрийн талаар ховорхон дурддаг байсан бөгөөд магадгүй үүнийг онцлон улс төр судлалд олон нийтийн бодлого боловсруулах нь тулгамдсан асуудал болсон нь үнэн билээ. Чухал асуудлыг үл харгалзан улс төр, эдийн засаг, засгийн газрын үйл ажиллагааг тайлбарласан нийгэм төвтэй аргуудыг 1950-1960 оны турш АНУ-д плюралист болон бүтэц-функционалист асуудлууд улс төр, нийгэм судлалд ноёлож байв. Энэ асуудалд үндсэн хуулийн зарчмуудыг тодорхойлох судалгаанууд нь албан ёсны хуурай бөгөөд эртний үзлийн концепци дээр төрийг анхаарч байсан. Өөр нэг чиглэл нь шинжлэх ухааны ерөнхийлсөн судалгаатай илүү нийцдэг.⁸ “Засгийн газар”-ыг голчлон эдийн засгийн ашиг сонирхлын бүлэглэл, эсвэл нэг нэгэнтэйгээ холбогдож улс төрийн шийдвэр гаргадаг нийгмийн норматив хөдөлгөөний хүрээнд авч үздэг. Эдгээр шийдвэр нь бүлэглэлийн үр өгөөжийг хуваарилалтаар ойлгогддог. Нийгмийн “оруулга” болон засгийн газрын хуваарилалт нийгмийн “гаргалгаа” дээр төвлөрсөн. Засгийн газар өөрийгөө тусдаа үйлдэгчээр нухацтай авч үздэггүй бөгөөд харьцуулсан судалгаагаар засгийн газрын янз бүрийн байгууллагуудын үйл ажиллагаа илүү бага ач холбогдолтой нь харагджээ. Засгийн газрын хуваарилалт нийгмийн “оролтууд” болон “гаралтууд” дээр төвлөрсөн.

Оюун ухааны амьдралд голчлон тохиолддог плюралист болон бүтцийн ажиллагааг хөгжүүлсэн парадигм нь үзэгдлийн шинэ шинэ асуудалд чиглэх шаардлагатай болж, зарчмын хувьд өмнөхөөсөө онцлон авч үзэхээргүй болсон. Плюралист үзэлтэнүүд олон нийтийн тухайн бодлогын шийдвэрт тодорхойлогчоор төвлөрөхөд тэд голдуу засгийн газрын удирдагч нар нийгмийн бүлэглэл сонгогч нарын шаардлагаас илүү бүтээлч санаачлагатай байгааг олж тогтоосон буюу засгийн газрын агентлагууд тухайн бодлогын шийдвэр гаргахад хамгийн голлох оролцогчид байжээ. Плюралистуудын онолын өмч дотор эдгээр нь байсан ч ийм чиг баримжааг бүрдүүлэх арга хязгаарлагдмал юм. Нью Хэйвний сонгодог плюралист улс төрчдийн судалгаанд хөдөөгийн шинэчлэлд хувь хүний идэвх санаачлага хүчтэйг хотын дарга Ричард Ли-гээр баримтжуулсан байдаг бөгөөд улмаар төр төвтэй үзэл санааг бүхэлд нь авч үзсэн дүн шинжилгээ нь ул суурьгүй байсан төдийгүй холбооны санг шинэ хэрэгцээнд ашиглах үүднээс үүнийг янз бүрийн хотын дарга нар хийж байсан аж. Улс төр, бюрократын чиглэлээрх ажлууд тухайлбал, Грахам Алисоны “шийдвэрийн амин сүнс”, Мортон Халперины бюрократ улс төр болон гадаад

бодлого зэрэгт засгийн газрын агентлагууд хувь хүний төлөө үйлчилдэг төдийгүй сонгодог плюрализмын хувьд энэ нь нийгмийн ашиг сонирхлын бүлэглэлүүдийн өрсөлдөөний жинхэнэ жишиг байх байсан. АНУ-ын төрийн бүтэц үйл ажиллагааны шинжилгээний хандлага болон төрийн зорилгод хүрэх үзэл санаанд төр гэдэг ойлголт бүхэлдээ алга болсон.

Плюрализм шиг илүү өргөн хүрээнд биш ч гэлээ бүтэц функционалист чиглэлийн оюутнууд өөрсдийн Баруун Европын түүхэн онолуудыг харьцуулсан улс төрийн хөгжилд хэрэглэхээр дэвшүүлсэн бөгөөд тэд түүхэн хэлбэр давтамж, мөн анхны дэвшүүлсэн онол таамаглалууд хоорондоо тааруухан таарч байгааг олж илрүүлсэн байдаг. “Улс төрийн хөгжил” (өөрөө илэрхий хувьсалын онол) нь нийгэм эдийн засгийн өөрчлөлт ерөнхий уламжлалт логикоос илүү төрийг бүрэлдүүлэн бий болгох олон улсын, дотоодын бодит оролдлого хийх замаар төгсдөг. Үүнтэй холбоотой ихэнх судалгаа нь 1954-1972 оны хооронд хийгдэж харьцуулсан улс төр, нийгмийн шинжлэх ухааны судалгаа шинжилгээр зөвлөлгөө өгөх комисын санхүүжилт дэмжлэг түүхэн чиг хандлагатай байсан. Төрийн тухай болон муж, засаг захиргааны талаарх үзэл санааны чиг баримжааг энд нэгтгэн дүгнэхэд, олон талаараа түүхэн харьцууллын үндэслэл нь бодит хэргүүдийг судалсан судалгааны комисын баримталсан гол онолууд харилцан эсэргүүцэлтэй тулгарах нь улам өсөж байв.

Ялангуяа дөнгөж бий болсон сургуулиудад шинэ санаа, чиг баримжаа нь уламжлалт бус түүхэн үндэс гарвал руу түлхэж байв. 1960-аад оны дундаас “Неомарксист” онолыг нухацтай авч үзэн “капиталист төр”-ийн талаарх цуврал амьд маргааныг эхлүүлэх болсон. Одоогоор энэ нь феодализмаас капитализм руу шилжих шилжилтэд улсын үүрэг ролыг өргөн хүрээтэйгээр авч үзэн онолын хувьд салаалан хөгжсөн. Дэлхийн капиталист эдийн засагт төрийн нийгэм эдийн засгийн оролцоо дэвшилтэт үйлдвэрлэлийн капиталист ардчилал, хараат улсын үүрэг рольтой хамт тусгасан. Түүнээс гадна неомарксистууд капиталист төрийн хэрэгжүүлсэн нийгэм эдийн засгийн үүргийн талаар хоёрдмол ойлголттойгоор маргадаг. Зарим нь үүнийг сонгодог дүрэм журмын зэмсэгээр хардаг бол бусад бараа бүтээгдэхүүний талаарх объектив баталгаа өгөгч, эдийн засгийн хуримтлал үүсгэгчээр, өөр бусад нь улс төрийн ангиудын тэмцлийн талбар байдлаар хардаг.

Эдгээр Нео-Марксист маргаанаас үүсэх гол үнэ цэнэтэй онолын асуудал нь харьцуулсан түүхэн судалгаа дахь тодорхой судалж болох асуудал бэрхшээл таамаглалыг авч хэлэлцэх явдал юм. Гэхдээ онолын түвшинд үндсэндээ төрийн талаар бичсэн бүх неомарксист зохиолчид нийгэм төвтэй таамаглалыг гүнзгийрүүлэн үзэж, төр нь бараа бүтээгдэхүүн, үйлчилгээий хэлбэрийг хадгалж, үржүүлэх төдийгүй ангиудын хоорондын тэмцлийн үүрэг ролийг уламжлуулан бүрдүүлэх тал дээр өөрсөддөө эргэлзээ байгаагаа

хүлээн зөвшөөрөөгүй. Автономит улс байж болох олон дүрс хэлбэрүүд тогтсон хуулиар засагладаг цаашлаад нео марксист онолчид бүх улсын бараа бүтээгдхүүний хэлбэр% капитал хуримтлал бий олгох шат, дэлхийн капиталист системийн байр суурийн онцлог үүрэг ролыг ерөнхийлөн авч хийсвэр аргаар хандсан. Энэ нь улсын бүрэлдхүүн бүтэц нийгэмд даяар явуулж байгаа үйл ажиллагаа дахь төрөл бүрийн жин нөлөөг үнэлэхэд хүндрэл учруулсан ба улмаар харьцуулсан судлагаанд зориулсан Нео Марксист схемийн зарим ашигтай талыг хассан.

Одоо хүртэл дэлхийн II дайнаас хойш Америкийн нийгмийн шинжлэх ухаанд энэ талаар загварыг авч үздэг ч Плюралист бүтэцийн функционалист нарын улсын тухай ярих нь хэвээр л байна. Нухацтай сэтгэлэгээтэй нео Марксист хүртэл улсуудын жинхэнэ автономит засгалал байгааг баталгаажуулахад бэлэн бус бөгөөд орчин үеийн нийгмийн шинжлэх ухаанд гарсан чиг хандлагын талаар дуугардаг. Эдгээр шинжлэх ухаанууд нь 18-19 зуунд Баруун европд үйлдвэр ардчилсан хувьсгалаас дангаараа үүсэлтэй юм. Тэдний үндсэн онолчид нийгмийн сайн сайхны төлөө үеэ өнгөрөөсөн монархи аристократ улсуудын талаар бус харин нийгмийн шинжлэх ухаанд зах зээл, үйлдвэрлэлийн хөдөлмөрийн хувиарлалт, ангиудын харилцаа зэргийг ойлгогдохуйцаар тусган авч байв. Үүнийг бий болгосон онолчид Карл Маркс, Хербэрт Спенсер нарыг улс төрийн хувьд эсэргүүцэн үйлдвэрлэлийн капитализм бол цэргийн дэглэм, улсуудын нутаг дэвсгэрийн тэмцэл дээр тулгуурласан гэдэг дээр санал нийлж байсан. Эдгээр хоёр онолчдын хувьд 19-р зууны Английн нийгэм эдийн засгийн хөгжилийг дэлхийн бүх улс оронд бүхлээр нь зөгнөсөн явдал байжээ.

Дэлхийн түүх цааш үргэлжлэн дэлхийн цуст дайнууд колоны төлөөх тэмцэл, улс бүрдүүлэх хувсгалууд, үндэстэнүүдийн колоны эсрэг хөдөлгөөн 19-р зууны Дэлхийн II дайны дараа Нэгдсэн Британиас эзгэнэлээс нэгдсэн Америкын эзэгнэл болж шилжих үйл явц өрнөсөн ба Барууны нийгэм судлаачид сүр хүчтэй, автономит зохион байгууллалттай үйлдэгчээс улс орон төвлөрч бүрэлдэхийг салгаж үүн дээр анхаарч байв. Энэ нь улс төрийн авторитаризм болон тоталитаризм ийн үзэгдлийг тоохгүй гэсэн үг биш. Онолын талбар нь эдийн засгийн хоцрогдоль барууны бус уламжлалт үнэ цэнийг эсэргүүцсэн явдалыг эдийн засгийн нэр томёогоор томьёолж тайлбарлахыг илүүд үзэх болсон. Капиталист чөлөөт Британ мөн АНУ улсууд “Нийгмийг удирдах” нь маргаангүй байсан ба Барууны нийгмийн шинжлэх ухаан онолын голлох загваруудад улс төвтэй тайлбар буурч байгааг олж үзэж болно. Эдгээр загваруудын хувьд түүний орчин үеийн болгох үр дагавар чиглэлийн ойлгох дээр анхаарч байв. хамгий орчин улс Британ, АНУ-д эдийн засгийн өөрчлөлт аяндаа дэвшилттэй явагдаж, засгийн гасзрын хууль тогтоох байгууллагын шийдвэрүүд улс төрийн үндсэн эд зүйлс мэт харагддаг.

Дэлхийн II дайны дараах төрөл бүрийн өөрчлөлт нь нийгмийг өөрчлөх нийгэм төвтэй үзэл улс төрийн ухаанд итгэх итгэл буурахад дэмжлэг үзүүлсэн. 1930-1950 онын Кейнсийн хувьсгалын сэргэлтээр макро эдийн засгийн үндэсний менежмент нь нийгмийн зарцуулалтын хэм хэмжээ болж цаашлаад дэвшилтэд үйлдвэрлэлийн капиталист ардчилалын нийтээр мөрдөх хэм хэмжээ болж цэцэглэсэн. Энд АНУ орж байв. Колоны эзэнт гүрнүүдийн задрал нь шинэ олон олон улс үүсэх нөхцлийг бүрдүүлсэн бөгөөд Барууны чөлөөт ардчилсан хэлбэрүүдийг өөрсдийн улс төрийн байгуулал сонголтондоо энгийнээр бий болгогүй удаан хугацаа болов. Эцэс сүүлд нь 1970-аад оны дундуур магад хамгийн чухлаар Британийн АНУ дэлхийд олон улсын эдийн засгийн эрчтэй тодорхой бус өрсөлдөөнд алдаагүйгээр шаргуу шахаж байсан. Энэ нь магадгүй гайхаад байх асуудал биш бөгөөд энэ нэгдэлд улсыг үйлдэгчидээр нийгмийг бүрэлдүүлж буй зохион байгуулалтай бүтэц гэдгээр ярих шинэ маягийн загварыг бий болгосон. Одоо нийгэм судлалын эрдэмтэд улс төвтэй тайлбарыг дан ганц тоталитари дэглэмтэй сүүлдэ үйлдвэржсэн улсуудаар зогсохгүй Британ АНУ өөрсдөө өгөхөд бэлэн болжээ. Үүнд нийцүүлэн сүүлийн үед Британ АНУ улс дахь олон улсын эдийн засгийн бодлого хөгжлийг тодорхой хэлбэр оруулах аргуудаас үүсэх маргаанд анхаарлаа хандуулж байна. Мөн хэрхэн Британ АНУ улсууд үндэсний үйлдвэрлэлийн дахин бий болох өнөөгийн хичээл чармайлтыг хязгаарлах болон чөлөөлөх тухай тунгаан бодох зэрэгт төвлөрч. Цөөн хэдэн үгэнд хэлбэл талаарх энэ маргаанаас болж олон нийтийн том салбарууд бүх капиталист ардчилалд улс төрийн төв шатанд болж байна. Британ АНУ аас болж тодорхой бус, өрсөлдөөнт, тусгаар тогтносон дэлхийд тодорхой улс шиг илүү харагдах ба ийм олон нэгж, завгарын өөрчлөлт нийгмийн макра ухаанд хэрэгжих хандлагай ба энэ өөрчлөлт нь эдийн засаг нийгмийн харилцаанд улс орны үүүргийн дахин авч үзэх нь орно.

Төр төвтэй үзэл баримтлалаас нийгэм төвтэй төрийг бүтээхэд шилжиж буй өөрчлөлт

Капиталист системийн 1970-аад оны хямрал, 1990-ээд оны социализмыг нураасан ардчиллын гуравдагч давалгааны үр дүнд дэлхий дахиныг хамарсан засаглалын болон захиргааны шинэтгэл явагдаж эхэлсэн аж. Энэ өөрчлөлт нь төрийн үүрэг, оролцоог дахин авч үзэж шүүмжлэлтэй хандаж, түүнийг цомхон, чадварлаг, хувь хүн, нийгэмд үйлчилдэг болгоход чиглэгдсэн. Энэ шинэтгэл нь нийгэм, эдийн засаг, соёл, оюун санааны өөр өөр нөхцөл бүхий улс орнуудад бараг нэгэн зэрэг өөр өөрийн онцлогоор хийгдэж эхэлсэн. Гэвч засаглалын болон захиргааны шинэтгэлийг хэрэгжүүлж буй орнуудын үйл ажиллагааны үр дүнг үнэлж дүгнэх боломж нөхцөл цаг хугацааны хувьд ч болоогүй байна. Энэ утгаараа аль нь сайн, аль нь мууг ч ялгаж таних төгс мэдлэг бүрэн бүрдээгүй байгаа ч

нэг асуудалд аль ч орнууд нийтлэг хариулт өгч байгаа билээ.⁵¹ Энэ бол төр төвтэй уламжлалт үзлээс хүн буюу нийгэм төвтэй “үйлчлэгч” төрийн тухай үзэл баримтлалд шилжиж буй явдал юм.

Хувь хүний хөгжилд тулгуурласан нийгмийн хөгжлийн концепци нь 1990-ээд оноос хүний хөгжлийг хангах объектын хөгжлийн стратегийн шинэ хандлагыг НҮБ-ээс боловсруулж хөгжлийг хэмжих, дэмжих, үнэлж дүгнэж цааш хөтлөх үндсэн арга мөн гэж хүлээн зөвшөөрсөн явдал юм. Эдүгээ энэ загвар нь НҮБ-ийн үзэл баримтлалаас олон улсын хөгжлийн стратеги болсон. Энэ хандлагын үндсэн зарчим нь хүмүүсийн сонголт хийх боломжийг нэмэгдүүлэх явдал юм. Энэ хүрээнд хүний хөгжлийн үндсэн гурван бүрэлдэхүүнийг авч үздэг. Эдгээр нь: Нэгд, эрүүл урт удаан амьдрах нөхцөлөөр хангах; Хоёрт, боловсролыг хүн бүрт шаардлагатай төвшинд олгох; Гуравт, амьжиргааны чадварыг нэмэгдүүлэх, орлогоос тэгш хүртэх боломжоор хангах; зэрэг юм. Хэрэв дээрх гурван сонголтыг хангаж чадвал дараах боломжууд нээгдэнэ. Үүнд: нэгд, нийгэм, улс төр, эдийн засгийн эрх чөлөө; Хоёрт, баялаг бүтээх чадвараа хөгжүүлэх боломж; Гуравт, бие даан ажиллах чадвараа хөгжүүлэх боломж; Дөрөвт, хүний эрхийн баталгаа хангагдах; явдал юм. Энэ ойлголтын хүрээнд ардчиллын чанар, засаглалын үнэлгээ, хүний эрх, хэвлэлийн эрх чөлөө, авлига, хүнд суртал зэрэг янз бүрийн индексүүд орчин үеийн өөрчлөлтийн хэмжүүр, үзүүлэлтүүд болон гарч ирсээр байна. Эдгээр ойлголт хандлагууд нь үйлдвэржсэн нийгмийн дараах түүхэн хөгжлийн үе шат буюу нийгэм (хүн) төвтэй төрийн тогтолцоо руу шилжих явдалтай холбоотой.

Энэ хандлагаар орчин үеийн улс төрийн социологийн судалгаа, шинжилгээний хүрээнд багагүй ажлууд хийгдсэн бөгөөд анхлан АНУ болон Баруун Европын судлаачид үндсэн суурийг нь тавьжээ. Тэдгээр улс төрийн социологичдын төрийн төвлөрөл ба цомхон мэдрэмжтэй төрийн тухай шинжилгээ нь 1970-аад оны сүүлчээс 1980-аад онд голдуу боловсрогдон, ихэвчлэн бусад үзэл баримтлалын бүтэц болон онолын нэмэлт өгөгдлүүдэд нөлөөлсөн байна. Судалгааны фокусын гол цэгт улс төрийн институц ба төрийн захиргааны шинэтгэл, иргэний нийгэм, иргэдийн улс төрийн оролцоо анхаарлыг хүчтэй татах болсон ажээ. Петр Еванс, Дитрих Рюшемер болон Скокпол (1985) зэрэг улс төрийн социологийн эрдэмтэд хамтран ажиллаж төрийг үгүйсгэсэн туйлшралын эсрэг төр, түүнтэй холбоотой салбаруудыг буцааж авчирсан.⁵² Үүний зэрэгцээ өөр бусад улс

⁵¹ Ц.Батболд. Бюрократ онолын үндэс. УБ., 2013. Тод Магнат ХХК. хт 484. Тал 413

⁵² Skocpol T, Evans P, Rueschemeyer D. Bringing the State Back In. New York and Cambridge: Cambridge University Press; 1985.

орнуудын олон эрдэмтэд онолын хувьд нухацтай анхаарал хандуулжээ. (see review in Ogum, 1988)

Скокпол 1985 онд энэ сэдвээр хэлэлцүүлэг өрнүүлж байсан бөгөөд энэ нь маш чухал анхаарал татсан “өөрийн ухамсарт төр” (self-conscious statist)-ийн тунхаг байсан юм. Тэрээр улс төрийн шинжилгээний төвд төрийг байрлуулахыг эрдэм шинжилгээний ажилтнуудад уриалжээ. Энэ хэтийн төлвийн онцлогийг харуулахын тулд Скокпол плюралистууд болон марксистуудыг шүүмжилсэн. Хэдийгээр төрийн уламжлал бүрийн тухай харьцангуй нарийн ойлголттой олон эрдэмтэд байсан ч, тэдгээрийн үзэл бодол нь улс төрийн зөрчилдөөний талбар болсон юм.

Плюралистуудын хандлага нь энэ хэсэгт төвийг сахисанаар иргэдийг оролцуулан өрсөлдсөн сонирхлын бүлгүүдээс нэгийг нь сонгох, сонгогдсон албан тушаалтан давуу талыг эзэмшинэ гэж үзсэн. Марксистууд үүнийг ангийн тэмцлийн нэг талбар бөгөөд капиталистуудын хувийн давуу тал асар их боловч төрийн үүрэг, үйл ажиллагааг үйлчилгээний төр хэлбэрээр дахин боловсруулах ёстой гэж үзсэн.

Төр төвтэй онолыг улс орнуудын улс төрд чухал ач холбогдолтой хүчин зүйл гэж үздэг хандлага ХХ зууны сүүлийн хориод жилд бүрэн өөрчлөгдсөн юм. Гэхдээ капитализмын хөгжлийн шатуудыг туулж, орчин үеийн үйлдвэржсэний дараах нийгмийг бий болгож чадаагүй улс орнуудад энэ онол төдийлөн ач холбогдлоо алдаагүй, нийгмийн хөгжлийн тодорхой үүргийг гүйцэтгэсээр байгаа билээ.

Abstract

The article reflects that some scientists theoretical view of state-centered theoretical risks. Theoretical approaches to define the public interest has been addressed by differences the state-centered theory. Finally, it mentioned that created from the state-centered views to shift the social centered state.

Ном зүй

1. Ц.Батболд. Бюрократ онолын үндэс. УБ., 2013. Тод Магнат ХХК.
2. Ц.Батболд. Төрийн удирдлагын шинэтгэл/Төрийн албан хаагчийн ширээний ном УБ., 2017
3. Ч.Сосормаа. Төрийн захиргаанаас нийтийн захиргаа руу: Шинэтгэлийн таван хөшүүрэг. УБ., 2008. Бит Пресс ХХК.
4. Спиридонова В.И. Бюрократия и реформа (анализконцепции М. Крозье). – М.: 1997.ИФРАН,
5. Crozier M., Huntington S., Watanuki J. The Crisis of Democracy. N. 1. 1975.

6. Charles Tilly. (1975) *The Formation of National States in Western Europe* (ed.)
7. Kate Nash. *Contemporary Political Sociology: Globalization, Politics, and Power*. Oxford., 2010. Blackwell Publishers Ltd.
8. Samuel P. Huntington. (1968)*Political Order in Changing Societies*.
9. Skocpol T, Evans P, Rueschemeyer D. *Bringing the State Back In*. New York and Cambridge: Cambridge University Press; 1985.
10. Seymour M.Lipset. *Political Man: The Social Bases of Politics*. Anchor Books, Garden City, New York. 477pp, 1960, ISBN 0-8018-2522-9.
11. Thomas Janoski, Robert R. Alford, Alexander M. Hicks, Mildred A. Schwartz. *The Handbook of Political Sociology: states, civil societies, and globalization*. Cambridge University Press 2005.

ТӨР ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ТАЛААРХ ОНОЛЫН ЗАРИМ АСУУДАЛД

Ч.Баатар

*Удирдлагын Академи, Нийгмийн удирдлагын
тэнхимийн ахлах багш*

Түлхүүр үгс: Төрийн захиргааны шинэчлэл, Засгийн газар, дэлхийн улс орнууд, онол, үзэл баримтлал, Барих-Ашиглах-Шилжүүлэх, Барих-Өмчлөх-Ашиглах, Барих-Шилжүүлэх, Зах зээлийн зарчим;

Товч агуулга: Тухайн өгүүлийн хүрээнд төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаарх онол, үзэл баримтлал үндсэн ойлголт, түгээмэл хэлбэр, санхүүжилт, манай улс дахь бодлого, эрхзүйн зохицуулалтын талаар холбогдох асуудлыг дурьдсан болно.

Удиртгал

Дэлхийн ихэнх улс орнууд ХХ зууны эцэс ХХI зууны эхээр Засгийн газрын бүтэц зохион байгуулалтыг өөрчлөх замаар улсын салбартаа шинэчлэл хийж, төрийн удирдлагын өөрчлөлт хийж эхэлсэн. Энэ үйл явц нь нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан, технологийн үсрэнгүй хөгжлөөс үүдэлтэй бөгөөд үүнтэй уялдан төрийн захиргааны арга хэрэгсэл ч цаг үеийн шаардлагад нийцэн өөрчлөгдсөн.

Өөрчлөлтийн гол зорилго нь төрийн захиргааны тогтолцоог хамгийн бага зардлаар хэрхэн өндөр үр ашигтай ажиллах вэ? гэдэг бизнесийн зарчимд илүү нийцсэн үйл ажиллагаатай болгох байсан юм. Энэхүү зорилгыг гүйцэлдүүлэхийн тулд дэлхийн улс орнууд дээрх зарчимд тулгуурласан үйл ажиллагааны олон арга хэрэгслийг боловсруулсан хэрэгжүүлсэн. Үүний үр дүн нь төрийн байгууллага нь хамгийн цомхон боловч өндөр чадавхитай, мэргэшсэн хүний нөөц бүхий, гэхдээ эдгээр ажилтан, албан хаагчдад зарцуулж буй зардлаа тусгай тогтолцоогоор хянадаг, тооцдог хүчирхэг ажил олгогч болох цогц зорилтуудыг дэвшүүлж шийдвэрлэх шаардлагатай тулгарсан байдаг.

Энэ бүхэн нь төрийн байгууллагуудыг урьд өмнө байгаагүй олон сорилт, боломжуудтай тулгаруулсан бөгөөд энэ бүхнийг даван туулахын тулд цоо шинэ төрийн захиргааны тогтолцоо, арга хэрэгслүүдийг бий болгожээ. Энэхүү цоо шинэ арга, хэрэгслүүдийн нэг нь төр, хувийн хэвшлийн түншлэл юм. Иймд тухайн өгүүлийн

хүрээнд төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаарх онол, үзэл баримтлалүндсэн ойлголт, түгээмэл хэлбэр, санхүүжилт, манай улс дахь бодлого, эрхзүйн зохицуулалтын талаар холбогдох асуудлыг дурьдсан болно.

Нэг. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн онолын зарим асуудал

Төр, хувийн хэвшлийн түншлэл нь нэлээд дээр үед төрийн үйл ажиллагааны хүрээнд яригдан, хэрэгжиж байсан ч албан ёсоор буюу төрийн үйл ажиллагааны нэг хэсэг болсон үеийг ихэнх судалгааны хийгээд онолын ном, сурах бичгүүдэд 1970-иад оны үе гэж дурьдаг. Жишээлбэл, XVI- XVII зууны үед Франц улсад зарим нэг томоохон компаниуд тухайн үеийн хаант засгийн холбогдох төлөөлөлтэй концессын гэрээ байгуулсны үндсэн дээр зарим нэг нийтийн эзэмшлийн зам, гүүрийн ажилд оролцож, санхүүгийн дэмжлэг үзүүлж байсан баримт байдаг.

Мөн XIX зууны эхээр АНУ-ийн Нью-Йорк хотод нийтийн эзэмшлийн ундны ус дамжуулах хоолой, ариутгах татуурга, бохир зайлуулах байгууламж зэргийг Засгийн газар болон хотын удирдлагуудтай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний үндсэн дээр гүйцэтгэж байжээ. Энэхүү гэрээг судалж үзэхэд одоогийн төр, хувийн хэвшлийн түншлэлийн сонгодог концессын загварт ихэвчлэн тооцогддог ВОО (Барих-Өмчлөх-Ашиглах) гэрээний төрөлтэй ихээхэн төстэй байдаг. Гэхдээ эдгээр үйл явц нь төрийн захиргааны хүнд суртал, тухайн үйл ажиллагааг шууд хамаарсан бодлого, эрх зүйн зохицуулалт байхгүй, төрийн захиргааны хувьд удирдан зохион байгуулах нэгж, алба байхгүй, захиргааны шат дараалсан хяналт, зохицуулалтын нийтлэг дүрэм журам, мэргэшсэн мэргэжилтнүүд бүрдээгүй зэрэг олон бэрхшээлтэй асуудлуудтай тулгарч байжээ. Өөрөөр хэлбэл, энэ нь тухайн үед төрийн захиргааны үйл явц нь уян хатан биш, мэргэжилтэн, үйлчлүүлэгчийн харилцаа нь дээрээс доошоо чиглэсэн хэлбэр ноёрхож байсантай холбоотой байв. Энэ байдал нь яваандаа олон салбарт төрөөс явуулж байгаа бодлого үйл ажиллагаа нь нийтийн ашиг сонирхолтой зөрчилдөх нөхцөл байдлыг бий болгосон нь төр, хувийн хэвшлийн аль алины сонирхлыг харгалзсан, хоорондын харилцааг нь зохицуулах уян хатан, олон талт, бие биендээ ууссан үйл ажиллагааны шийдлийг шаардсан байна. Тодруулбал, нэг талаас засгийн газрын байгууллага, мэргэжилтэн, бюрократуудыг дэмжсэн “төрийн ашиг сонирхол”, нөгөө талаас ард иргэд, зах зээлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа хувийн хэвшлүүдийн ашиг сонирхлыг харилцан зохицуулах хэрэгтэй болсон. Энэхүү тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийн тулд холбогдох төрийн захиргааны арга хэрэгслийн боловсруулан хэрэгжүүлсэн буюу төр, хувийн хэвшлийн түншлэлийн өмнө хийгдэж байсан туршлагыг төрийн зүгээс бодлого, эрхзүйн зохицуулалтаар хангасан үе нь 1970 иад оны үед тохиодог. Иймд ихэнх онолын

ном, сурах бичигт дурьдсанаар 1970 оноос эхлэн төр, хувийн хувийн түншлэлийг дэлхийн улс орнуудад хэрэгжүүлж эхэлсэн гэж үздэг байна.

Дэлхийн 2-р дайнаас хойш эхэлсэн нийгэм, эдийн засгийн үсрэнгүй хөгжил нь дэлхийн улс орнуудын Засгийн газрын бүтэц өргөжин төрийн үйлчилгээ, дэд бүтцийг хөгжүүлэхэд чиглэсэн зардлыг огцом нэмэгдүүлсэн бөгөөд энэ нь 1950-1960 аад оны үед бий болсон эдийн засгийн хямралтай зэрэгцэн дэлхийн улс орнуудад улсын төсвийн ноцтой хомсдолыг бий болгосон. Энэ нь төрийн захиргааны үйл явцад шинэчлэл хийх томоохон шалтгаан болж, төрийн бодлого боловсруулж, хэрэгжүүлэх арга хэрэгслийг үндсээр нь өөрчлөх эхлэл болжээ. Ингэснээр улсын салбарыг цомхон бөгөөд өрсөлдөөнтэй, үр өгөөжтэй, сонголтын уян хатан, ил тод байдлыг нэвтрүүлэн төрийн үйлчилгээг иргэд хийгээд хувийн хэвшлийнхний хэрэгцээ, шаардлагад улам бүр нийцүүлэх оролдлогыг хийж эхэлсэн байна. Энэ хүрээнд хийгдсэн нэг томоохон онол, үзэл баримтлалын өөрчлөлт нь сонгодог либерализмыг нийгэм, эдийн засгийн шинэ нөхцөл байдалтай уялдуулан шинэчлэж, тайлбарласан явдал юм. Энэ нь төрийн зүгээс хэрэгжүүлж байгаа эдийн засгийн бодлого, арга хэмжээг улам бүр либеральчлан нийгмийн ардчилалтай холбож, түүнд тохирсон төрийн захиргааны арга хэрэгслийг шинэчлэн хөгжүүлэх эхлэлийг тавьсан. Энэ өөрчлөлтийн үр дүнд 1970-аад оны эхээр дэлхийн өндөр хөгжилтэй зарим улсуудын (тодруулбал, Англи, Франц, Герман, АНУ, Канад, Австрали, БНХАУ гэх мэт) төрийн болон хувийн хэвшлийн харилцаанд өөрчлөлт гарч, эдийн засгийн либерализм болон нийгмийн ардчиллын хандлагыг хослуулсан томоохон төслүүдийг хэрэгжүүлж эхэлсэн. Мөн тухайн үеэс нийгмийн болон улс төрийн амьдралыг зохицуулахад чөлөөт зах зээлийн эдийн засгийн онол үзэл баримтлалыг түлхүү ашиглаж эхэлжээ. Үүний үр дүнд Кейнсийн онолыг мөрдлөг болгон төрөөс нэгдсэн зохион байгуулалттай хэрэгжүүлж байсан төрийн эдийн засгийн бодлогыг өөрчлөн зах зээлийн зохицуулалтад оруулах, бизнесийн түгээмэл зарчмуудад нийцүүлэн хөгжүүлж эхэлжээ. Энэхүү өөрчлөлтийн гол агуулга нь хувийн хэвшлийн оролцоог дэмжсэнээр нь инновацийг нэмэгдүүлж, төрийн үйлчилгээг илүү үр дүнтэй болгон, учирч болзошгүй эрсдэлийг хувийн хэвшилд илүүтэй шилжүүлж, өрсөлдөөн бий болгох явдал байсан юм.

1970-1980-аад оны үеэс дээрх өөрчлөлтийн үр дүнд Засгийн газрын зүгээс хувийн хэвшлийн оролцоотойгоор үндэсний хэмжээний таваар болон хөдөлмөрийг зах зээлийн чөлөөт эргэлтэд оруулах бодлогыг хэрэгжүүлэн өрсөлдөөнийг нэмэгдүүлэх, төрийн шууд мэдэлд байсан үйлдвэр, үйлчилгээний газруудыг хувьчлах, хувийн хэвшилд үйл ажиллагааг шилжүүлэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлж эхэллээ. Энэ үеэс эхлэн нөөцийн хуваарилалт дахь үр ашигтай байдал нь зах зээлийн хуулиар зохицуулагдах буюу оролцогч талуудын өрсөлдөөнд тулгуурласан нөхцөлд үйлчилгээ, үйлдвэрлэл, бараа

бүтээгдэхүүний үнэ зохисжиж, чанар нь сайжирдаг бөгөөд төрийн монополь байдлаас аль болох зайлсхийх ёстой гэж үздэг шинэ либерал үзэл баримтлал Засгийн газруудын үйл ажиллагааны суурь үзүүлэлт нь болжээ. Ийнхүү 1970-1980-аад оноос Засгийн газрын үйл ажиллагааны хүрээнд хувьчлал, зах зээл, үйлвэрлэлийн арга хэрэгсэл, хувийн хэвшлийн оролцоог ашиглах туршлага нэвтэрч, бүтээгдэхүүн нийлүүлэгч талуудын дунд бий болсон өрсөлдөөн нь үнэ, чанарын өөрчлөлтөд эерэг үзүүлэлтүүдийг бий болгож эхэлсэн байна. Энэ өөрчлөлтийн дагуу дэд бүтэц болон нийгмийн суурь үйлчилгээний байгууллагыг хувьчилах, хувийн хэвшилд шилжүүлснээр өрсөлдөөнт зах зээлийн нөхцөлд хувийн хэвшил хамгийн чанартай үйлчилгээ үзүүлдэг нь тодорхой болжээ. Энэ бүхэн нь улсын салбар, түүнээс иргэдэд үзүүлж буй үйлчилгээний бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тогтолцоог эргэн нягтлах шаардлагыг бий болгосон. Энэ бүхэн нь дэлхийн улс орнуудад төрийн захиргааны цоо шмнэ хандлагыг бий болгосон нь улсын салбарын шинэ удирдлага (New Public Management NPM) юм.

Улсын салбарын шинэ удирдлага нь төрийн захиргаанд ажлын үр дүн болон зардал хэмнэхэд чиглэсэн шинэ хэтийн төлвийг нээсэн. Улсын салбарын шинэ удирдлага гэдэг нь “захиргааны үйл ажиллагааг үйлдвэрийн эдийн засгийн онолын үүднээс тайлбарласан захиргааны бодлогын шинжтэй өөрчлөлтийн багц нэгдэл юм”⁵³.

Швейцарийн судлаач Мастронадри, Шедлер нарын үзэж байгаагаар улсын салбарын шинэ удирдлага нь дараах зорилгыг агуулдаг байна. Үүнд: 1/ орцод тулгуурласан удирдлагаас татгалзаж, зорилго тодорхойлох, үр дүнд хяналт тавих, 2/ хэрэглэгчдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхийг урьтал болгосон үйлчилгээнд чиглэх, 3/ ажлын үр дүн болон төсвийн хариуцлагыг хослуулах замаар захиргааны үйл ажиллагааг зардал хэмнэхэд чиглүүлэх, 4/ зах зээлийн аргаар шийдэж чаддаггүй бүтээгдэхүүнийг бүтээх зэрэг болно⁵⁴.

Тухайн улсын салбарын шинэ удирдлагын үйл явцад тулгуурласан Засгийн газрын үйл ажиллагааны хүрээнд маш олон арга хэрэгсэл шинээр туршигдаж, ашиглагдсан. Эдгээрээс хамгийн үр дүнтэй төрийн захиргааны арга хэрэгслийн нэг нь төр, хувийн хэвшлийн түншлэл юм. Засгийн газрын зүгээс өөрийн гүйцэтгэдэг чиг үүрэг, өөрийн эрх мэдлийн нэг хэсгийг тодорхой хугацаанд хувийн хэвшилд шилжүүлэх, хувийн хэвшилтэй бизнесийн зарчимд тулгуурласан хамтын ажиллагааг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлэх нь тухайн үед цоо шинэ үзэгдэл байжээ. Төр, хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлж

⁵³ Батсүх Ш, Улсын салбарын удирдлага, санхүүжилтийн шинэчлэл: үзэл баримтлал, хэрэгжилт, Улаанбаатар, 2004, 6-8 р тал.

⁵⁴ Төр, хувийн хэвшлийн түншлэлийн сорилт, боломж, Судалгааны тайлан, Удирдлагын академи, Улаанбаатар, 2017, 7-р тал.

эхэлсэн эхний жилүүдэд Засгийн газар нь заримдаа зах зээлд монополь эрх олгох замаар хувийн хэвшлийн байгууллагуудаас бараа, үйлчилгээ худалдаж авах, гүйцэтгүүлэх тохиолдол гарч байсан бөгөөд энэ нь нэлээд хурц шүүмжлэлийг бий болгожээ. Тухайлбал, Их Британид өрнөсөн хувьчлалын жилүүдэд Маргарет Тетчерийн тэргүүлсэн Засгийн газар ийм шүүмжлэлд өртөж байв. Түүнчлэн улсын салбарын шинэ удирдлагыг хэрэгжүүлж эхэлсэн эхний жилүүдэд зарим судлаачдын зүгээс төрийн өмч хөрөнгийг хувьчлах, чиг үүргийг нь хувийн хэвшилд шилжүүлэх нь Засгийн газрын үйл ажиллагааны үндсэн чиг баримжааг алдагдуулна гэж үзэж байв. Иймд төр, хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэхийн тулд тусгай төрийн бодлого, нарийвчилсан эрх зүйн зохицуулалт, холбогдох дүрэм, журмууд нэн шаардлагатай болсон байна. Ялангуяа төр, хувийн хэвшлийн түншлэл нь зах зээлийн харилцаанд суурилан бизнесийн үйл ажиллагааны зарчмаар явагддаг учраас Засгийн газар болон хувийн хэвшлийн харилцан ашигтай байдлыг тооцох нь нэн чухал байлаа. Ялангуяа төрийн болон хувийн хэвшлийн үйл ажиллагааны өртөг, зардал нь нэн ялгаатай, ашигт үйл үзүүлэлтүүд нь өөр өөр байдлаар бодогддог байдал нь нөхцлийг улам бүр хүндрүүлж байлаа. Тухайн үеийн эдийн засагчдын үзсэнээр төр болон хувийн хэвшлийн хооронд харилцан итгэлцэлд суурилсан гэрээ, хэлцэл л (relational contract) хийгдээгүй нөхцөлд ажил гүйцэтгэх аль аль талдаа төвөгтэй болдог. Яагаад гэвэл төр болон хувийн хэвшлийн харилцан ашигтай байх нөхцлийг илэрхийлсэн гэрээ нь сонгодог хийгээд салбар хоорондын өртөгт тулгуурласан гэрээний зарчим дахь дан ганц эдийн засгийн үр ашгаас илүүтэйгээр итгэлцэл буюу урт хугацааны хамтын ажиллагаанд үндэслэх шаардлагатай гэж үзэж байв.

Засгийн газрын үйл ажиллагаанд өмнө нь хэрэглэж байсан гэрээ хэлцэлд бараа бүтээгдэхүүн нийлүүлж байгаа болон худалдан авч байгаа тал аль аль нь өндөр үр ашгийг шалгуур болгосон зарчим баримталдаг. Харин төр, хувийн хэвшлийн түншлэл нь тухайн төсөлд оролцогч талууд бие биеийнхээ үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх замаар үйл ажиллагааны үр дүнтэй, үр ашгийг харилцан хуваалцах явдал байдаг. Гэхдээ санхүүгийн үр ашигтай байдал нь хувийн хэвшлийн хувьд илүү их хамааралтай байж, Засгийн газрын хувьд үр ашигтай байдал нь арай өөрөөр илэрхийлэгддэг. Засгийн газрын зүгээс олон нийтэд нийгмийн сайн сайхан байдал, тогтвортой хөгжлийн үзүүлэлтүүдээр илэрхийлэгдэхүйц эерэг үр дүн, хувийн хэвшлийн зүгээс бизнесийн буюу ашигт үйлийн коффецентээр илэрхийлэгдсэн ашигтай байх нь харилцан үр ашигтай байдал нь төр, хувийн хэвшлийн түншлэлийн өвөрмөц байдлыг илэрхийлдэг. Эндээс үзэхэд төр, хувийн хэвшлийн түншлэл нь төрийн захиргааны шинэчлэлийн хүрээнд бий олон шинэ арга хэрэгслийн нэг бөгөөд Засгийн газраас хэрэгжүүлж байгаа нийгэм, эдийн засгийн бүхий үйл ажиллагаанд хувийн хэвшлийнхний оролцоог нэмэгдүүлэхэд онцгой ач холбогдолтой.

Хоёр. Төр, хувийн хэвшлийн түншлэлийг тодорхойлох нь

Дэлхийн улс орнуудад төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшилд шилжүүлдэг нэлээд олон хэлбэр байдаг боловч доорх доор дурьдсан хэлбэрүүд нь дэлхийн улс орнуудад хамгийн түгээмэл хэрэглэгддэг. Үүнд:

- Засгийн газрын худалдан авах ажиллагаа буюу төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах;
- Төрийн зарим чиг үүрэг, нийтлэг үйлчилгээг хувийн хэвшил тухайлсан гэрээгээр гүйцэтгэх;
- Төр өөрийн зарим чиг үүргээ өөрөө өөрийгөө зохицуулах байгууллага, мэргэжлийн холбоодоор дамжуулан гүйцэтгүүлэх;
- Тухайн хэрэгцээт ажил үйлчилгээг нарийн мэргэшсэн мэргэжлийн байгууллага, хувь хүмүүсээр гүйцэтгүүлэх буюу Аутсорсинг;
- Төрийн зүгээс хувийн хэвшлийн хөрөнгө оруулагчидтай гэрээ байгуулсны үндсэн дээр хамтран ажиллах буюу концесс зэрэг юм.

Улс орнуудын Засгийн газрын зүгээс дараах хэд хэдэн шалтгааны улмаас өөрийн чиг үүргийг хэвшилд шилжүүлэх шаардлага үүсдэг. Үүнд:

- Үйл ажиллагаагаа илүү оновчтой, үр дүнтэй болгох;
- Төрийн захиргааны төвлөрлийг сааруулах;
- Улсын төсвийн ачааллыг бууруулах;
- Улсын салбарын үйл ажиллагаанд хувийн хэвшлийг татан оролцуулах;
- Дэд бүтцийн болон нийгмийн салбарт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах;
- Хэвийн хэвшилд ашиглагдаж байгаа хүний, техник, технологийн нөөцийг нийтийн эрх ашгийн төлөө ашиглах зэрэг юм.

Мөн төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлснээр төрийн үүрэг, хариуцлагыг багасгах, төрийн өмчийн ашиглалтыг сайжруулах, үр ашигтай зарцуулах, төрийн үйлчилгээг бага зардлаар чанартай, илүү олон хүнд хүргэх боломжийг бүрдүүлдэг.

Төр, хувийн хэвшлийн түншлэл буюу PPP, товчилсон нэрээрээ ихэвчлэн ЗР хэмээн нэрлэгддэг энэхүү төрийн захиргааны арга, хэрэгсэл нь маш олон хэлбэртэй бөгөөд дэлхийн улс орон болгон өөрийн төрийн бодлогын онцлог, өвөрмөц байдалдаа тулгуурлан хэрэгжүүлж байна. Дэлхийн улс орнууд төр, хувийн хэвшлийн түншлэлийг өөрийн орны төрийн захиргааны тогтолцоонд тулгуурлан олон төрөл, хэлбэрээр хэрэгжүүлдэг. Гэхдээ

дэлхийн нийтэд нэгэнт тогтсон дараах хэд хэдэн тодорхойлолтын хүрээнд уг төрийн захиргааны арга, хэрэгслийг тайлбарладаг. Үүнд:

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (Organisation for Economic Co-operation and Development) аас: “Төр, хувийн хэвшлийн түншлэл нь Засгийн газар болон хувийн хэвшлийн (үйлчилгээ үзүүлэгч болон санхүүжүүлэгч) хооронд байгуулсан үйл ажиллагааны гэрээ” гэж тодорхойлсон байдаг. *Олон Улсын Валютын Сан* (International Monetary Fund)-гийн зүгээс “төрөөс уламжлалт Засгийн газрын худалдан авах арга замаар үзүүлж ирсэн ажил, үйлчилгээг хувийн хэвшил өөрийн хөрөнгөөр гүйцэтгэх, хөрөнгө оруулалт хийхийг” төр, хувийн хэвшлийн түншлэл гэнэ гэж үзжээ. *Европын Хөрөнгө Оруулалтын Банк* (European Investment Bank)-ны үйл ажиллагааны хүрээнд “төрийн үйлчилгээ болон дэд бүтцийг бий болгох, хөгжлийн дэмжлэг үзүүлэхэд хувийн хэвшлийн нөөц, арга туршлагыг ашиглах зорилго бүхий төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд үүссэн харилцаа”-ны хүрээнд авч үзсэн байна. Харин *Азийн Хөгжлийн Банк* (Asian Development Bank)-ны үйл ажиллагааны хүрээнд “дэд бүтэц болон бусад төрийн үйлчилгээ, тэр тусмаа нийгмийн суурь үйлчилгээг үзүүлэхэд ашиглаж байгаа төр ба хувийн хэвшлийн төлөөллийн харилцан ашигтай хамтын ажиллагаа”-г төр, хувийн хэвшлийн түншлэл гэж үзэж байна. Эндээс үзэхэд төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар дээрх олон улсын эдийн засаг, хамтын ажиллагааны байгууллагууд янз бүрийн тодорхойлолт дэвшүүлж ирсэн ч засгийн газар болон аж ахуйн нэгж харилцан тохиролцсоны үндсэн олон нийтэд чиглэсэн арга хэмжээг хувийн хэвшлээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх үндсэн шинжийг аль ч тодорхойлолт агуулж байна.

Судлаачдын зүгээс өөрсдийн судалгааны бүтээлүүддээ төр, хувийн хэвшлийн түншлэлийг олон янзаар тодорхойлж тайлбарласан байдаг. Жишээлбэл, АНУ-ын төр, хувийн хэвшлийн түншлэлийн нэртэй зөвлөхүүдийн нэг Ричард Нормент (Richard Norment): “Төрийн байгууллагын үйл ажиллагааны янз бүрийн түвшинд хувийн хэвшлийн хэвшлээр ажил гүйцэтгүүлэх зорилготой гэрээт тохиролцоо” гэж үзсэн бол профессор П.Розенау (Pauline Vaillancourt Rosenau): “Засгийн газрын зүгээс хувийн хэвшилтэй хамтын эерэг үр дүн бий болгох, харилцан хамаарал бүхий илүү сайн үр дүнд хүрэхэд чиглэсэн эрх зүйн хамтын ажиллагааны хэлбэр” гэж үзсэн байна⁵⁵. Мөн Нидерландын Делфийн Технологийн Их Сургуулийн профессор М.Ван Хаам (Maarten van Ham): “Төр болон хувийн хэвшил хамтран урт хугацаанд нийтлэг бүтээгдэхүүн үйлдвэрлэх, түгээмэл үйлчилгээ үзүүлэх үйл явц бөгөөд түүнтэй холбогдож гарах шаардлагатай нөөц, эрсдэл,

⁵⁵ А.Л. Ксензов. Теоретические основы государственно- частного партнерства: понятие и основные характеристики, Минск, 2012, стр 1-2.

алдагдлыг харилцан хуваарилах үйл ажиллагаа” гэж өөрийн бүтээлд дурьджээ⁵⁶. АНУ-ын бизнесийн зан үйл судлаач С.Линдер (Linder, Stephen H) өөрийн судалгааны өгүүлэлдээ: “Нийгмийн баялагийг бүтээх үйл явцыг түргэсгэх, зохисжуулахын тулд Засгийн газрын зүгээс хувийн хэвшилд боломжит эрх, үүргийг оногдуулах улс төрийн арга хэрэгсэл⁵⁷” гэж үзжээ. Энэ бүхнээс үзэхэд төр, хувийн хэвшлийн түншлэл нь олон янзаар тайлбарлагдан, олон чиг хандлагад тургуулран хэрэгждэг нь харагдаж байна. Энэ бүхнийг нэгтгэж үзвэл “Төр нь өөрийн зарим чиг үүргийг албан ёсоор хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа хууль, дүрэм, журам, олон улсын холбогдох конвенцид үндэслэсэн гэрээ байгуулсны үндсэн дээр хувийн хэвшилд тодорхой хугацаанд шилжүүлж байгаа үйл явц” гэж үзэж болно.

Олон улсын практикт тухайн төр, хувийн хэвшлийн түншлэлийн үйл ажиллагаа нь одоо байгаа эд хөрөнгийг ашиглаж, эсвэл сайжруулж байна уу, шинээр бий болгох уу гэдгээрээ ялгагдана. Одоо байгаа эд хөрөнгийг ашиглаж, сайжруулж байгаа төр, хувийн хэвшлийн түншлэлийг “Brownfield”, харин шинээр бий болгож байгааг “Greenfield” гэж нэрлэдэг байна.

Төр, хувийн хэвшлийн түншлэл нь тухайн улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа бодлого, хууль эрхзүйн тогтолцоонд тулгуурлан олон хэлбэрээр хэрэгждэг. Улс орнуудадтөр, хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлсэн туршлагаас үзэхэд ихэвчлэн 1/ өөрийн орны төрийн бодлогын онцлог, өвөрмөц байдлаас үүдэлтэй, 2/ олон улсын нийлэг жишигт тулгуурласан, 2/ хэрэгжиж байгаа салбар болон үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан тухай бүрд нь хэрэгжүүлэх арга, хэлбэрийг тодорхойлон хэрэгжүүлж байна.

Дэлхийн улс орнуудын төр, хувийн хэвшлийн түншлэлийн туршлагаас үзэхэд дараах салбаруудад ихэвчлэн хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- *Тээврийн* (Авто зам, төмөр зам, усан зам, далайн тээвэр, боомтууд, агаарын тээвэр, метро болон нийтийн тээврийн бусад төрлүүд);
- *Нийтийн эзэмшлийн* (Усан хангамж, хог хаягдал, нутаг дэвсгэрийн нийтийн байгууламж, нийгэм-ахуйн объектууд, гидротехникийн байгууламж);
- *Эрчим хүчний* (Цахилгаан болон дулааны эрчим хүчийг үйлдвэрлэх, дамжуулах, хуваарилах, дулаан, хийн ба эрчим хүчний хангамж, нийтийн гэрэлтүүлэг, бусад объектууд);

⁵⁶ Van Ham, Hans, and Joop Koppenjan, *Building Public-private partnerships: assessing and managing risks in port development*. 2001.

⁵⁷ Linder, Stephen H. (1999), “Coming to Terms With the Public-Private Partnershi,” *American Behavioral Scientist*, 43 (1), pp. 35-51.

- *Нийгмийн* (Эрүүл мэнд, амралт-эрүүл ахуйн эмчилгээ сувилгаа, боловсрол, соёл, нийгмийн үйлчилгээ, спорт);
- *Байгаль орчны* (Дархан цаазтай юм уу тусгай хамгаалалттай газар нутгийн менежмент, байгаль орчны хамгаалал, ашигт малтмалтын олборлолт гэх мэт.) зэрэг юм.

Эдгээр салбаруудад хэрэгжиж байгаа төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслүүдийн санхүүжилтнь хэрхэн хийгдэж байгаа байдлаар нь дараах гурван үндсэн хэлбэрт ангилдаг. Үүнд:

- Улсын төсвийн суурьтай буюу Засгийн газраас санхүүжих;
- Улсын төсвийн суурь байхгүй буюу хэрэглэгч, зах зээлээс санхүүжих;
- Холимог буюу төсвийн татаастай зэрэг юм.

Эдгээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн санхүүжилтын хэлбэрүүдийн тухай үндсэн ойлголт, онцлог, хэрэгжилтийн талаар тус тусад нь авч үзвэл дараах байдалтай байна.

Нэг. Төсөв суурьтай буюу Засгийн газраас санхүүжэх хэлбэр. Олон улсын практикаас дэлхийн ихэнх улс орнуудад энэхүү санхүүжилт нь урьдчилсан болон дараа гэсэн хоёр үндсэн хэлбэрээр хийгддэг. Урьдчилсан байдлаар хийгддэг санхүүжилт нь Засгийн газрын худалдан авах ажиллагааны хүрээнд ихэвчлэн хийгддэг. Энд нэг асуудлыг дурьдалгүйгээр өнгөрч болохгүй. Хэдийгээр Засгийн газрын худалдан авах ажиллагаа нь онолын хувьд төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшилд шилжүүлж байгаа нэг үндсэн хэлбэр мөн боловч төр, хувийн хэвшлийн түншлэл мөн эсэх талаар олон янзын ойлголт, хандлагууд холбогдох ном, сурах бичиг, судалгааны материалуудад дурьдагдсан байдаг.

Манай улсын хувьдээр дурьдсан төрийн бодлогын өвөрмөц шинж, боловсруулан хэрэгжүүлж байгаа онцлогоос шалтгаалан Засгийн газрын худалдан авах ажиллагаа болон төр, хувийн хэвшлийн түншлэлийг бодлого, эрх зүйн тодорхой зохицуулалтуудаар зааглан авч үзэж байгаа болно. Энэ нь Засгийн газрын зүгээс тодорхой болзол, шаардлага хангасан хувийн хэвшилд тодорхой санхүүжилт олгосны үндсэн дээр хувийн хэвшил тухайн санхүүжилтийн хүрээнд бараа, материал нийлүүлж, ажил, үйлчилгээ гүйцэтгэнэ. Өөрөөр хэлбэл, Засгийн газрын зүгээс урьдчилан төсөвлөсөн эсхүл хувийн хэвшлийн зүгээс санал болгосон мөнгөн дүнд үндэслэж гэрээ байгууллаад хамтран ажиллаж байгаа явдал болно. Энэ хүрээнд хийгдэж байгаа түншлэлийн үйл явц нь гол төлөв Засгийн газрын үйл ажиллагааны нэг хэсэг болохын сацуу үйл ажиллагаа нь ихэвчлэн стандартчилагдсан, тодорхой загвар, хэлбэршилтэд захирагдсан, зах зээлийн хөгжил, нөлөөллөөс ангид байдаг.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн дараа төлбөрт санхүүжилтын хэлбэр нь Засгийн газрын зүгээс олон нийтийн эрх ашигт нийцсэн үйлдвэрлэл, дэд бүтэц, үйлчилгээний чиглэлд хувийн хэвшилтэй хөрөнгө оруулалтын гэрээ байгуулан хамтран ажиллах хэлбэр юм. Өөрөөр хэлбэл дараа төлбөр гэдэг нь, Засгийн газрын зүгээс гэрээний үндсэн дээр ард иргэдэд чиглэсэн үйлчилгээ, үйлдвэрлэл, бүтээгдэхүүн, бараа материалыг хувийн хэвшлийн хөрөнгөөр бий болгож ашиглалтад оруулаад гэрээнд заагдсан нөхцөл, боломж, шалгуурыг хангасан үед эргээд шууд болон хэсэгчилсэн байдлаар эргэн төлөхийг хэлнэ. Манай улсад энэхүү төр, хувийн хэвшлийн түншлэлийн санхүүжилтын хоёр хэлбэр нь нилээд нийтлэг ашиглагддаг. Жишээлбэл, 2016 оны байдлаар урьдчилсан төлбөрт хэлбэрээр улсын хэмжээнд нийт 2791 тендер төлөвлөгдөн хэрэгжсэн бөгөөд нийт төсөвт өртөг нь 866,914.71 сая төгрөг байна⁵⁸.

Харин төр, хувийн хэвшлийн түншлэлийн дараа төлбөрт санхүүжилт нь арай өөр хэлбэрээр хийгддэг. Энд 2009 оны 10 сарын 15-ны өдөр батлагдсан Монгол улсын төрөөс “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого”-ын 4.6.2.-р зүйл⁵⁹, 2010 оны 01-сарын 28-ны өдөр батлагдсан Монгол улсын “Концессын тухай хууль”-ийн 4.1.2.-р зүйлд тусгагдсан концессын Барих - Шилжүүлэх буюу BT (Build - Transfer) төрлөөр гэрээ нь хийгдсэн төслүүдийг дурьдаж болох юм.

Монгол улсын “Концессын тухай хууль” 4.1.2.-р зүйлд зааснаар “Барих-шилжүүлэх гэдэг нь концесс эзэмшигч концессын зүйлийг өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр барьж ашиглалтад оруулан, гэрээнд заасан нөхцөлөөр төрийн болон орон нутгийн өмчлөлд шилжүүлэх⁶⁰” гэжээ. Эндээс үзэхэд Засгийн газраас зарласан сонгон шалгаруулалт болон шууд гэрээ байгуулах нөхцөл, боломж, шалгуур үзүүлэлтийг хангасан хувийн хэвшил концессын зүйл буюу Улсын Их Хурал, Засгийн газар, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан, концессын гэрээгээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад тусгасан ажил үйлчилгээ, үйл ажиллагаа, үйл явцыг өөрийн хөрөнгөөр гүйцэтгэсний дараа гэрээнд тусгагдсан зохих нөхцөл, болзолыг хангасан тохиолдолд Засгийн газар гэрээнд тусгагдсан санхүүжилтыг буцаан олгох явдал юм. Өөрөөр хэлбэл, улсын төсвийн хөрөнгөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшилд гэрээг шилжүүлж байна гэж ойлгож болно.

Манай улсад энэ төрлөөр төр, хувийн хэвшлийн төслүүдийг түгээмэл хэрэгжүүлдэг бөгөөд 2017 оны 09 сарын 30-ны байдлаар улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй Барих

⁵⁸ <https://www.tender.gov.mn/mn/statistic/index>

⁵⁹ <http://www.legalinfo.mn/law/details/6653?lawid=6653>

⁶⁰ <http://www.legalinfo.mn/law/details/312?lawid=312>

- Шилжүүлэх буюу BT (Build - Transfer) төрөлд суурилж гэрээ нь албан ёсоор байгуулагдсан (манай улсад хийгдсэн гэрээний зарим нэг онцлогоос шалтгаалан сууриласан гэж үзэв. Жишээ: DBT буюу Зураг төсөл боловсруулах – Барих – Шилжүүлэх, Зураг төсөл боловсруулах - Буулгах – Барих – Шилжүүлэх гэх мэт) нийт 90 төсөл үүнээс төрийн өмчийн 40, орон нутгийн өмчийн 50 төсөл байна. Орон нутгийн өмчийн төслүүдийг байршлаар нь авч үзвэл Улаанбаатар хотод 19, Баянхонгор аймагт 3, Булган аймагт 5, Говь-Алтай аймагт 10, Дорнод аймагт 1, Завхан аймагт 4, Хэнтий аймагт 5, Ховд аймагт 3 байна. Харин төрийн өмчийн концессын төслүүдийн хувьд концессын төрлийн хувьд Барих - Шилжүүлэх буюу BT; DBT буюу Зураг төсөл боловсруулах – Барих – Шилжүүлэх; Зураг төсөл боловсруулах - Буулгах – Барих – Шилжүүлэх; Тоног төхөөрөмж нийлүүлэх- суурилуулах -шилжүүлэх гэсэн дөрвөн үндсэн төрлийг ашиглан төгрөгөөс гадна БНХАУ-ын юань, америк доллараар эргэн төлөгдөх нөхцлийг нь тооцон гэрээ нь байгуулагджээ.Тухайн “Барих-Шилжүүлэх” төрлөөр байгуулагдсан төрийн өмчийн концессын гэрээнүүдийн мөнгөн дүнг тооцож үзэхэд 2017 оны 09 сарын 30 – ны байдлаар байдлаар манай улсад нийт 224,669.32⁶¹сая төгрөг, 560.32 сая америк доллар болон 1,606.62⁶² юаниар гэрээний дүн нь илэрхийлэгдсэн нийт 40 концессын төсөл хэрэгжиж байна. Харин орон нутагт хэрэгжиж байгаа дээр дурьдсан Барих - Шилжүүлэх буюу BT (Build - Transfer) төрлөөр гэрээ нь хийгдсэн төслүүдийн нийт өртөг 133,314.31⁶³ сая төгрөг болж байна.

Хоёр. Улсын төсвийн суурь байхгүй буюу хэрэглэгч, зах зээлээс санхүүждэг. Дэлхийн улс орнуудад хамгийн түгээмэл хэрэгждэг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэр нь төсвийн суурь байхгүй буюу хэрэглэгч, зах зээлээс санхүүжих хэлбэр юм. Энэ нь тухайн төслийг хэрэгжүүлж буй хувийн хэвшил үзүүлсэн үйлчилгээ, үйл ажиллагааныхаа хариуд зах зээл, хэрэглэгчээс тариф, төлбөр, хураамж хэлбэрээр гаргасан зардал хийгээд ашиг олох нөхцөл, байдал юм. Тухайн хэлбэрээр хэрэгжиж байгаа төр, хувийн хэвшлийн төслүүдийн хувьд Засгийн хөрөнгө оруулалтыг авдаггүй бөгөөд зөвхөн холбогдох бодлого, эрхзүйн зохицуулалтын хүрээнд бизнесийн зарчимд тулгуурлан үйл ажиллагаа явуулдаг. Уг хэлбэрээр хэрэгжиж байгаа төслүүд нь нэн шаардлагатай дэд бүтцийн болон

⁶¹ Монгол улсын Засгийн газрын Тохируулагч Агентлаг Үндэсний хөгжлийн газар, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэлийн 2017 оны 11-р сарын мэдээлийг иш үндэс болгон тооцоолов.

⁶² Монгол улсын Засгийн газрын Тохируулагч Агентлаг Үндэсний хөгжлийн газар, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэлийн 2017 оны 11-р сарын мэдээлийг иш үндэс болгон тооцоолов.

⁶³ <https://www.shilendans.gov.mn/org/7736?form=1239151&year=2017&group=1&task=7821>

нийгмийн суурь үйлчилгээг өөрийн болон өөрийн боломжоор бий болгосон хөрөнгө оруулалтаар бий болгосноор төрд төсөв санхүүгийн хэмнэлт гаргах, ачааллаа бууруулах боломжыг олгодог. Манай улсын Засгийн газраас 2017 оны 09 сарын 30-ны байдлаар энэ хэлбэрт хамаарах нийт 13 төслийн⁶⁴ гэрээг хувийн хэвшилтэй байгуулан хэрэгжүүлж байгаа бөгөөд нийт төслийн өртөг нь ойролцоогоор 34,105,305.27⁶⁵ сая төгрөг байна.

Гурав. Холимог буюу төсвийн татаастай. Энэ төрлийн төр, хувийн хэвшлийн түншлэл нь ихэвчлэн төр, хувийн хэвшлийн түншлэл гэхээсээ илүүтэй төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгждэг. Ихэнхи төр, хувийн хэвшлийн түншлэлийн гарын авлагад дурьдсанаар “хэрэглэгч зардлаа бүрэн нөхөх хэмжээнээс багаар тогтоосон тарифаар төлбөр хийх бөгөөд зардал болон тарифын орлогын зөрүүг төсвийн татаасаар нөхөх⁶⁶”-ийг холимог буюу төсвийн татаастай төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэр гэж үздэг байна.

Эндээс үзэхэд улс орнуудын Засгийн газруудын зүгээс дэд бүтэц, нийгмийн суурь үйлчилгээ болон бусад нийтийн эрх ашигт тустай төслүүдийг хувийн хэвшилтэй хамтран, эсвэл тэдгээрийн тусламж, санхүүжилтээр хэрэгжүүлэх, мөн өөрийн боломжит зарим чиг үүргийг хувийн хэвшилд шилжүүлэх, хамтран ажиллах зорилгоор хийгдсэн гэрээ, түүнийг хэрэгжүүлэх үйл явц нь төр, хувийн хэвшлийн түншлэл гэж үзэж болохоор байна.

Гурав. Монгол улс дахь төр, хувийн хэвшлийн түншлэлийн өнөөгийн байдал

Төр, хувийн хэвшлийн түншлэл нь 1990-ээд дэлхийн улс орнуудын төрийн захиргааны шинэчлэлийн хүрээнд Засгийн газрын үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг болон хэрэгжиж эхэлсэн байна. Энэ үеэс улс орнууд төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэхэд онцгой анхаарч, үүнийг төрийн захиргааны шинэчлэлийн нэг хэсэг гэж хүлээн зөвшөөрч, улмаар Засгийн газрын үйл ажиллагааны хүрээнд нийгмийн өмнө хүлээсэн үүрэг, хариуцлагыг хувийн хэвшил болон төрийн бус байгууллагаар дамжуулан хэрэгжүүлэх, хөрөнгө санхүү, ур чадвараа нэгтгэн тулгарч болзошгүй эрсдэл болон үр дүнгээ хуваалцаж бэрхшээл, сорилтыг даван туулах арга хэрэгсэл болгон нэвтрүүлсэн.

⁶⁴ <http://nda.gov.mn/1281.html>

⁶⁵ Монгол улсын Засгийн газрын Тохируулагч Агентлаг Үндэсний хөгжлийн газар, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэлийн 2017 оны 11-р сарын мэдээлийг иш үндэс болгон тооцоолов.

⁶⁶ Монгол улсын Эдийн Засгийн Хөгжлийн Яам, Азийн Хөгжлийн Банк “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн гарын авлага”, Улаанбаатар, 2014, 69-р тал.

Манай улсын Засгийн газраас төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжихэд анхаарлаа хандуулан “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого⁶⁷”, “Концессын тухай хууль⁶⁸” зэрэг бодлогын баримт бичиг, хуулийг боловсруулан хэрэгжүүлж эхлээд байна. Мөн Монгол улсын “Концессын тухай хууль”-ийг хэрэгжүүлэхтэй холбогдууландараах аргачлал, журмуудыг батлан хэрэгжүүлж байна. Үүнд:

- Концессын зүйлийн зардал ашгийн тооцоо хийх аргачлал (Монгол улсын Төрийн өмчийн хорооны 2010 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан);
- Концесс олгох уралдаант шалгаруулалтын журам (Монгол улсын Засгийн газрын 2012 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн 103 тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан);
- Уралдаант шалгаруулалтын санал үнэлэх журам (Монгол улсын Засгийн газрын 2012 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн 103 тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан);
- Урьдчилсан шалгаруулалтын жишиг баримт бичиг (Монгол улсын Засгийн газрын 2012 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн 103 тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан);
- Уралдаант шалгаруулалтын жишиг баримт бичиг (Монгол улсын Засгийн газрын 2012 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн 103 тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан) зэрэг юм.

Эдгээр бодлогын баримт бичиг, хуулийн зорилго хувийн хэвшил тэргүүлсэн эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангах, бүх талын түншлэлийг хөхиүлэн дэмжих замаар Монгол улсын эдийн засгийн тогтвортой хөгжлийн хангахад түлхэц болоход оршиж байгаа болно.

Монгол улс нь дээрх төрийн бодлогын баримт бичиг, хууль, журмуудад үндэслэн Засгийн газрыг зүгээс хувийн хэвшилтэй концессын гэрээ байгуулах замаар нийгмийн суурь үйлчилгээ, дэд бүтцийн төслүүдийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар амжилттай хэрэгжүүлж эхлээд байна. 2017 оны 3-р улирлын байдлаар манай улсын хувьд

⁶⁷ Улсын Их Хурлын 2009 оны 10-р сарын 15-ны өдрийн 64-р тогтоолоор батлагдсан.

⁶⁸ 2010 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр батлагдан мөн оныхоо 3 дугаар сарын 01-ны өдрөөс хэрэгжиж байгаа.

нийт 103 орчим төслийн концессын гэрээг⁶⁹ Засгийн газрын зүгээс хувийн хэвшилтэй байгуулаад байна. Эдгээр төслүүдийг дээр дурьдсан санхүүжилтынх нь хувьд ангилж үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

- Улсын төсөв суурьтай буюу улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр нийт 90-н төсөл, үүнээс: Төрийн өмчийн 40, орон нутгийн 50 төсөл;
- Улсын төсвийн суурьгүй буюу хэрэглэгч, зах зээлээс санхүүжих нийт 13 төслийн гэрээ нь байгуулагдан хэрэгжиж байна.

2017 оны 3-р улирлын байдлаар манай улсын хувьд холимог буюу Засгийн газрын татаастай үйл ажиллагаа нь явагдах төслийн гэрээ хийгдээгүй байна. Гэхдээ тухайн хэлбэрээр дэлхийн улс орнуудад төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслүүд түгээмэл хэрэгжүүлдэг. Тухайлбал, БНСУ-ын Засгийн газраас концессын BTL (Build- Transfer- and- Lease) буюу Барих-Шилжүүлэх-Түрээслэх төрлөөр олон төслийг хэрэгжүүлдэг бөгөөд энэ төрөл тухайн холимог санхүүжилттэй хэлбэртэй хамаардаг.

Дүгнэлт

Энэ бүхнээс дүгнэж үзэхэд төр, хувийн хэвшлийн түншлэл нь улсын төсөвт хэмнэлт бий болгох, Засгийн газрын гадаад, дотоод өрийг нэмэгдүүлэлгүйгээр дэд бүтэц, нийгмийн суурь үйлчилгээнд шаардлагтай хөрөнгө оруулалтыг хувийн хэвшлийн оролцоо, тусламжтайгаар хийж өндөр үр ашигтай нөхцөл, боломжийг бүрдүүлдэг төрийн захиргааны арга хэрэгсэл юм.

Манай улсын дэд бүтцийн болон нийгмийн суурь үйлчилгээний салбарт хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх нь төрийн болон хувийн хэвшлийн итгэлцэл, хамтын ажиллагааг бэхжүүлэхэд онцгой хувь ач холбогдолтой. Иймд төр хувийн хэвшлийн түншлэлийг үр дүнтэй хэрэгжүүлсэн олон улсын туршлагыг гүнзгийрүүлэн судалж, энэ чиглэлээр Засгийн газрын үйл ажиллагааг улам бүр өргөжүүлэх, боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага улам бүр нэмэгдсээр байна.

Мөн төр, хувийн хэвшлийн түншлэлийн онол, арга зүйн асуудлыг улам бүр нарийвчлан судлахын зэрэгцээ, Монгол улсын төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжин зохицуулах бодлого, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, Концессын тухай хууль болон Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай, Төсвийн тухай хуулиудын уялдаа холбоо, давхардал, хийдлийг судалж, дүгнэлт гаргах

⁶⁹ Монгол улсын Засгийн газрын Тохируулагч Агентлаг Үндэсний хөгжлийн газар, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэлийн 2017 оны 11-р сарын мэдээлийг иш үндэс болгов.

шаардлагатай. Тодруулбал, төр, хувийн хэвшлийн түншлэлийн институцичлалын түвшинд үнэлэлт, дүгнэлт өгөх хэрэгцээ улам бүр тулгамдаж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Нэг. Бодлого, эрх зүйн баримт бичиг:

Монгол улсын төрөөс Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар баримтлах бодлого, Улаанбаатар, 2009.

Монгол улсын Концессын тухай хууль, Улаанбаатар, 2010.

Хоёр. Ном, сурах бичиг, судалгааны тайлан, эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл, цахим мэдээллийн эх үүсвэр:

Батсүх Ш, Улсын салбарын удирдлага, санхүүжилтийн шинэчлэл: үзэл баримтлал, хэрэгжилт, Улаанбаатар, 2004.

Баатар Ч, “Монгол улс дахь “Барих-Шилжүүлэх” төрлөөр хийгдсэн концессын төслүүдийн өнөөгийн байдал”, МУИС-ийн ОУХНУС-ийн 25 жилийн ойн олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэл, Улаанбаатар, 2016.12.01.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн гарын авлага, Эдийн Засгийн Хөгжлийн Яам, Азийн Хөгжлийн Банк, Улаанбаатар, 2014.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн сорилт, боломж, судалгааны тайлан, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Удирдлагын академи, Улаанбаатар, 2016.

А.Л. Ксензов. Теоретические основы государственно- частного партнерства: понятие и основные характеристики, Минск, 2012.

Van Nam, Hans, and Joop Koppenjan, Building Public-private partnerships: assessing and managing risks in port development. 2001.

Linder, Stephen H. (1999), “Coming to Terms With the Public-Private Partnershi,” American Behavioral Scientist, 43 (1).

<https://www.tender.gov.mn/>

<http://www.legalinfo.mn/>

<http://www.nda.gov.mn/>

<https://www.shilendans.gov.mn/>

The Legislature and Political Development: A Comparison between Korea and Mongolia⁷⁰

Turtogtokh Janar, Ph.D

Chairman, Professor, Department of Political Science

National University of Mongolia

Keywords: parliament, Korean National Assembly, State Great Hural of Mongolia, election

INTRODUCTION

In a democratic system, parliament is, on one hand, a representative institution of the people and, on the other hand, exists with a status of a political institution as a policy-making and law-making body. It is guaranteed by the Constitution. In addition legislature serves for political systems actively and becomes its dynamic expression. Parliamentary institution plays a tremendous role in and influences heavily on the political development.

Although there is a difference between the government systems of two comparing countries (Republic of Korea and Mongolia), it could be compared, observed and analyzed through the legislatures and the political developments caused by parliamentary election results at the similar level in terms of particular cases, samples or highlights and time factors. For both countries which democratic process took place effectively in almost at the same period (if we reckon as democracy is since 1988 for the ROK and since 1989 for Mongolia), a comparative observation and analysis are significant to mutually identify and, exchange information and knowledge on the issues such as experiences, obstacles and tendency of political development, political democracy and political culture on the political research arena. Both legislatures are more active political institutions which their policy, activity and decisions are open and transparent to the public compared to the executive branch institutions (President and Government). Some coincidental dimensions such as single-house structure of parliamentary institution based on the unitary form of the state structure, parliamentary terms of office and election frequency (since 1992 the parliamentary elections of two countries have been held the same year) become a basic background to “have a look at” both legislatures comparing them “stable” on a same flat. On the basis of those backgrounds, this paper concerns the influence of the legislature on political development, election procedure, results, post-election changes of political relations and some similar highlights and comparisons among them.

In this work, first, the author will consider general overview of constitutional systems of two countries. Then the author will discuss about the role and the status of parliament in the political

⁷⁰ This paper is originally prepared for the International Convention of Asia Scholars on “Think Asia!” at the Chungnam National University, Daejeon, Korea. The author wants to share its discussion results and some findings for further readers’ references and academic reviews.

system from their historical and functional sides, providing it with some patterns of the legislative institution. Moreover, electoral system and last election results, political parties' seat ratio in parliament and the level of the voter turnout or citizen participation in the elections will be introduced here as well. Finally, it will cover the issues of the legislature's effects in the political development and the process of strengthening of democracy and, furthermore, what potentials it will contain in further democratic process.

A BRIEF INTRODUCTORY TO MONGOLIAN AND KOREAN CONSTITUTIONAL SYSTEM

This part addresses a comparative survey of contemporary Korean and Mongolian constitutional systems in general, and briefly describes government structures.

Table 1. Comparison of constitutional hardware

	Korea	Mongolia
First Constitution	1948	1924
Current Constitution	9 th amendment made in 1987	4 th Constitution in 1992
Government system	Presidential system with National Assembly	Parliamentary republic with President
State structure	Unitary	Unitary

The Constitution of the Republic of Korea is the general instrument of Korean¹ government and the supreme law of the land. On May 10, 1948, the Korean people had held successfully the general election to institute the constituent National Assembly. Thereafter, on May 31, the Assembly was created. As Pak pointed out:

Koreans had to hold a general election in the accessible area of the country to set up a constituent assembly. Ultra-leftist directed by the Communists in the north had destroyed the communication networks, attacked the police offices in the cities and country sides, and agitated the people with their deceptive propaganda so as to block the national election all over the country in the south (Pak, 1976: 116-117).

This first Korean National Assembly established a democratic Constitution for the first time on July 12, 1948. Then, the Constituent Assembly promulgated the Constitution on July 17, 1948. Koreans had confronted little difficulties in making our Constitution. About it Pak noted that “as

we were going to build a political system of liberal democracy, we took the lesson from the historical experience of the Western constitutional democratic system which had developed in the last two centuries” (Pak, 1976: 123).

The government created under the new Constitution was a republic in its basic form, with a curious mixture of both the British parliamentary system and the American presidential system. For six decades, the Constitution has guided the evolution of governmental institutions and has provided the basis for political stability, individual freedom, economic growth and social progress. The original Constitution provided for a presidential system. However, during the preparation of draft proposals of the constitution, parliamentary cabinet system and presidential government system were challenging each other. A Constitution Drafting Committeeⁱⁱ, appointed by the Constituent Assembly, had proceeded to draw a draft constitution. Whereas most members of the Committee favoured a parliamentary system of government, Dr. Syngman Rhee, then the speaker of the Constituent Assembly, opted for a strong presidential form of government (Park, 1962: 23-34). In case of Korean people opinion, at that time, they supported overwhelmingly a model of the parliamentary cabinet system (Pak, 1976: 123).

Table 2. A Chronology of political regime and government system changes in Korea

Republic	Regime Type	System of Government	Term
First	Authoritarian	Presidential	1948-1960
Second	Democratic	Parliamentary	1960-1961
Third	Authoritarian	Presidential	1963-1972
Fourth	Authoritarian	Presidential	1973-1980
Fifth	Authoritarian	Presidential	1981-1988
Sixth	Democratic	Presidential	1988-present

Since 1948, ROK’s Constitution has been amended nine times, with the October 27, 1987 amendment being the last one. The focus of the amendments has generally been on the President’s powers and method of election, and to a lesser extent, the structure of the legislature. The ninth and last amendment was made in 1987. It restored popular elections for the President, who was henceforth restricted to a single five-year term.

The current constitutional system, which started in 1987, was based on a constitutional bill that was passed by the National Assembly on October 12, 1987, and subsequently approved by 93

percent of the voters in a national referendum on October 28. This change of constitutionalism transferred power from the authoritarian Fifth Republic into the Sixth Republic or the country's present-day government system. The current Sixth Republic constitution went into effect on February, 1988 when Roh Tae-Woo was inaugurated as the President.

In case of Mongolia, in 1924, a republic type of government was installed by the first Constitution; it became a Soviet-style Republic with one-party system which lasted until 1990s. The winds of the East European socio-political changes of the late 1980s also came to the country. New democratic and freedom parties were created, and a peaceful, democratic revolution changed the country's political system. What replaced it was a parliamentary democracy. In July of 1990, the first democratic free election took place in Mongolia, and it has become, finally, a parliamentary republic with president and multi-party system.

The 4th Constitution of Mongolia from the 13th of January 1992, ratified to strengthen the new state democratic system and to provide a legal basis and guarantees to the country's development, replaced the former structure and identified political and legal standards to establish the Mongolian state's social structure and democratic principles of Constitutionalism. The new Constitution replaced the totalitarian regime in Mongolia, and provided democratic state systems directed to the principles of power separation, and defined its organizations and regimes.

The form of democracy we know is a representative democracy. The political idea of representation is based on the idea that some person or institution acts on behalf of the people, by re-presenting their beliefs, attitudes and perspectives. The Mongolian political system is one in which the people elect members of Parliament to represent them; hence we have a system of representative government. Our particular kind of representative government is a parliamentary democracy. A more complete explanation will contain details of other aspects of the representative system. For example, Mongolia has adopted a system of parliamentary democracy, whereas the Republic of Korea is a presidential republic with an elected National Assembly.

Government system of the Republic of Korea is a presidential system based on such principles as separation of powers, and checks and balances. The Constitution provides for a three-branch governing system whereby law-making functions are in the preserve of the National Assembly, administrative functions are in the preserve of the executive branch, headed by the President, and judicial functions belong to the courts. Korea's judicial system comprises a Supreme Court, appellate courts, and a Constitutional Court. Structurally, these three branches are highly independent of each other.

According to the Constitution, the President is the Head of State (*The Constitution of Korea*, Article 66:1) and executive power is vested in the Executive branch headed by the President (*The Constitution of Korea*, Article 66:4). The President appoints a Prime Minister who runs the

government as directed by him. The President has power to attend and address the National Assembly, to convene its extraordinary session, and to exercise a veto on the bill passed by it. He/she appoints high-ranking public officials, including the prime minister and chief justice, with consent by the National Assembly.

The legislature called National Assembly or Daehan Minguk Kuk Hoe is a unicameral and has 299 members who are elected to four-year terms. Legislative power is vested in the National Assembly. It can also exercise power to investigate specific matters when deemed necessary. Moreover, the legislature has power for fiscal control which provided by the Constitution and the National Assembly Law. The National Assembly members and the President are elected respectively by universal, equal, direct, and secret ballot by the citizens of the Republic of Korea (*The Constitution of Korea*, Articles 41:1 and 67:1), and the National Assembly's leaders and officers are chosen by the members themselves.

Mongolia is a republic with powers shared among the President of Mongolia, the legislature called the State Great Hural, the Government as Executive Cabinet and the Judiciary. The current Constitution contains a parliamentary system of government with some aspects of a presidential system. The president is Head of State and is elected for a term of 4 years. The 76 members of the unicameral State Great Hural are elected to 4-year terms. By its state structure Mongolia is a unitary State.

A president may be the ceremonial head of state in parliamentary-cabinet systems of government. In case of Mongolia, the president is the head of state, commander in chief of the armed forces, and head of the National Security Council. President nominated by parties in the State Great Hural and elected by popular vote for a four-year term and limited to two terms. The constitution empowers the president to appoint judges, to propose a prime minister, call for the government's dissolution, initiate legislation, veto all or parts of legislation (the Parliament can override the veto with a two-thirds majority), and issue decrees, which become effective with the prime minister's signature. Cabinet appointed by the State Great Hural in consultation with the president. In the absence, incapacity, or resignation of the president, the Speaker of Parliament exercises presidential power until inauguration of a newly elected president.

The Government, headed by the prime minister, has a four-year term and is the highest executive body of the state. Following legislative elections, the leader of the majority party or majority coalition is usually elected prime minister by the State Great Hural. The prime minister is nominated by the president after discussed with the majority party in Parliament and confirmed by the Parliament. The prime minister chooses a cabinet, subject to Parliament approval. Dissolution of the government occurs upon the prime minister's resignation, simultaneous resignation of half the cabinet, or after a Parliament vote for dissolution.

Mongolia’s judicial system comprises a Supreme Court, provincial courts, and a Constitutional Court. Supreme Court serves as appeals court for people and provincial courts but rarely overturns verdicts of lower courts; judges are nominated by the General Council of Courts for approval by the president. The Supreme Court is the highest judicial body. At the apex of the judicial system is the Constitutional Court, which consists of nine members, including a chairman, appointed for 6-year terms, whose jurisdiction extends solely over the interpretation of the constitution.

THE ROLE AND THE STATUS OF PARLIAMENT IN THE POLITICAL SYSTEM⁷¹

Democracy is nowadays practiced through indirect methods, namely the representative system. Thus, when it is stated that sovereignty is vested in the people it means that they have the right to participate indirectly in government through their elected representatives. From the idea of popular sovereignty, we have to cope with the question how the opinions and wishes of the people could be translated into the policies and behavior of politicians. Representation, therefore, is one of the key concepts of democracy (Dahl, 1956; Riker, 1982; Lijphart, 1984). A legislature is usually characterized as a representative institution.

Table 3. Sovereignty rests in the people.

Korea	Mongolia
In democratic countries, sovereignty rests in the people. This basic principle is referred to the Constitution of Korea, stating in Chapter I, Article 1, Section 2, that the sovereignty of the Republic of Korea resides in the people, and all state authority emanates from the people. The people exercise it through direct participation in state affairs and through representative bodies of state power elected by them.	In accordance with Chapter I, Article 3 of the Constitution of Mongolia, state power shall be vested in the people of Mongolia. The people shall exercise state power through their direct participation in state affairs as well as through the representative bodies of state power elected by them.

⁷¹ Note: An earlier version of this chapter was appeared in the Final Report for the field research funded by the Korea Foundation in 2008. The author is grateful to the Korea Foundation for its support for the research project.

The Constitution of the Republic of Korea embodies the principle of separation of powers; National Assembly enjoys an autonomous governmental role, operating independently on the basis of its own constitutional powers. Korean National Assembly is the legislative branch of the government, prescribed by the Constitution to represent the will of the people. Besides, the National Assembly “played a modest role in the expansion of citizen participation” (Kim and Pai, 1981: 37). Political representationⁱⁱⁱ and policy making are kinds of assemblymen main roles. As representatives of the citizens, assemblymen have the right to engage in the legislation, adoption of the budget, inspection or investigation of specific matters of state affairs, etc.

Korean National Assembly has been becoming a vivid image of an institutionalized form of representative democracy in the new history of Korean politics. Since Constituent Assembly was formed by the general and direct election in 1948, changes and development of legislative institutions during this period is entirely and inevitably connected with the political development of the country. During any democratic and non-democratic political systems, the National Assembly has been a public representative in politics and has been implementing its function successfully. On the other hand, it has been a reflection of political regime and political culture in its each authority.

Historical development and significance of the legislature has been studied by parliamentary scholars (Kim and Pai, 1981; Yoon, 1991; Park, 1998: 66-68, 2002: 330-32) and politicians (Kil, 1964: 1-12; Pak, 1976: 115-34) by various attempts. For instance, Park (1998) investigated the changes of the Korean legislature’s policy activity in the context of the historical dimension. As Park briefly emphasized, the Korean National Assembly has a relatively short but turbulent history (Park, 1998: 68). I, the author of this paper, concurred with this, however, not only in terms of parliamentary institutional changes but also development of contemporary Korean politics. From the beginning of the First Republic through the current Sixth one, Korea has experienced a series of political alterations. In line with this, the place of the legislative institution in the Korean political system has ever changed. With the heavy influence of the Constitution, the legislature became the focal point of politics and exercised a great deal of power (See more on Kim and Pai, 1981: 23).

Table 4. A Chronology of the Korean National Assembly (from the time of the Sixth Republic).

Republic	Regime Type	System of Government	Assembly	Term
Sixth	Democratic	Presidential	Thirteenth	May 1988-May 1992
			Fourteenth	June 1992-May 1996

			Fifteenth	May 1996-May 2000
			Sixteenth	May 2000-May 2004
			Seventeenth	May 2004-May 2008
			Eighteenth	May 2008-May 2012
			Nineteenth	May 2012-May 2016
			Twentieth	May 2016-present

As shown in table 4, Sixth Republic has started since May 1988 and the National Assemblies in the current Republic has still been moving forward. Although Republic of Korea is a country of presidential system of government^{iv}, its National Assembly is the most competitive^v, open and democratic materialization of political life, and its role is a lot in Korean political system. The parliamentary institute of this country has overcome plenty of obstacles and hierarchy of political formation and development during the period of authoritarian and democratic political regime, presidential and parliamentary system of government.

During its history, the Korean National Assembly has experienced the both of unicameral and bicameral structures of legislature. For example, first National Assembly was a unicameral, however then, by the first amendment to the original Constitution, made in 1952, provided for a bicameral legislature. Furthermore, the fifth amendment to the Constitution (which corresponds to the first rewriting of the Constitution) was made in 1962 put the presidential system and the single-house legislature back in place. Currently, Korea has a unicameral National Assembly. The organizational components of the National Assembly are the individual members, the presiding officers, the plenary, the committees, the negotiation groups, and the administrative organs for legislative assistance.

Mongolia's Constitution of 1992 established new legal grounds for the status, the functions, and the operation of its permanent parliamentary institution within the state and government structure. State Great Hural of Mongolia is the legislative branch of the government, prescribed by the Constitution to represent the will of the people. It is a unicameral parliament and consists of 76 members in single-seat constituencies, elected by popular vote. Parliamentary elections have been hold five times in confirmity with our first new democratic constitution ratified in 1992. Table 5 shows a chronology of the State Great Hural of Mongolia, from the time of New Constitution.

Table 5. A Chronology of the State Great Hural of Mongolia (1992-up to present).

Regime Type	System of Government	Parliament	Term
Democratic	Parliamentary Republic	Constituent	June 1992-June 1996
		Second	June 1996-June 2000
		Third	June 2000-June 2004
		Fourth	June 2004-June 2008
		Fifth	June 2008-June 2012
		Sixth	June 2012-June 2016
		Seventh	June 2016-present

The functioning of the National Parliament is based on the principles to defend the independence and sovereignty of Mongolia, to form a law-governing power, to ensure the will, aspirations, interests and unity of the Mongolian people and to secure the guarantee and implementation of democracy, justice, human rights and freedom. Nowadays, the Mongolian Parliament has been operating according to the powers as provided for in the Constitution. However, there is a need to perfect the operations of the parliamentary institution to a more upgraded level in accordance with modern conditions and requirements of a political democracy.

As the supreme government organ, the Parliament is empowered to enact and amend laws, determine domestic and foreign policy, ratify international agreements, and declare a state of emergency. The Parliament meets semiannually. Parliament members elect a chairman and vice chairman who serve 4-year terms.

In the country, Parliament decides who will govern. This is an issue of the formation of the government. In parliamentary types of government the political chief executive is selected by majority vote in the parliament. In other words, the strongest party in the parliament provides the necessary political support for its leader to emerge as prime minister, and to select the majority of the members of his government from his party represented in the parliament. In Mongolia's case, to form a government and choose a prime minister, a party needs a simple majority of 39 seats in the Parliament, a legislative body of 76 nation-wide representatives.

The Constitution of Mongolia provides that the State Great Hural may consider, at its initiative, any issue pertaining to domestic and foreign policies of the country. They make representations

on behalf of their constituents to the government and the public service. The passage of legislation by majority vote of the Parliament.

Table 6. Comparison of the legislative structures

#		Korea	Mongolia
1.	House	Unicameral	Unicameral
2.	Individual members	299	76
3.	The presiding officers	Speaker and two vice speakers, elected to two-year terms	Chairman and two vice chairmen, elected to four-year terms
4.	Speaker	Represents the National Assembly; presides over the parliamentary proceedings, maintains order in the house, and oversees its administration	Represents the State Great Hural; co-ordinates as a whole the implementation of the powers of the house
5.	Types of sessions	<p>Two types of legislative sessions are provided, regular and extraordinary.</p> <ul style="list-style-type: none"> - A regular session is convened once every year, on September. The period of a regular session is limited to 100 days; - Extraordinary sessions may be convened upon the request of the President or a quarter or more of the members of the Assembly. The period of an extraordinary session is limited to 30 days. If the President requests the convening of an extraordinary session, he must clearly specify the period of the session and the reasons for the request. 	<p>Three main types of sessions: regular, irregular and extraordinary.</p> <ul style="list-style-type: none"> - A regular session is held once in six months, on October and April, and last not less than 50 working days on each occasion; - Irregular sessions may be convoked in the interim of regular sessions. The irregular sessions are convened at the demand of more than one-thirds of entire members of the State Great Hural or/and at the initiative of the President and the Chairman of the State Great Hural. - In the interim period of the

			regular session, in case of proclamation by the President of a state of emergency or war, the State Great Hural is convened for an Extraordinary session within 72 hours without prior announcement.
6.	The committees	<p>Two types of the committees:</p> <ul style="list-style-type: none"> - Standing committees - Special committees <p>An assemblyman shall become a member of two or more Standing Committees.</p>	<p>Three types of the committees:</p> <ul style="list-style-type: none"> - Standing committees - Subcommittees - Ad hoc committees <p>A member of the State Great Hural shall become a member of not more than two Standing Committees.</p>
7.	Intra-Parliamentary groups	<p>Each political group having 20 or more assemblymen may form a negotiating group which acts as a unit in inter party negotiations within the Assembly. Assemblymen without party affiliation can form separate negotiations groups if their number is 20 or more. Each negotiating group names floor leader and whip, which are responsible for negotiating with other groups.</p>	<p>Party (coalition) group having not less than 8 seats in the State Great Hural may set up a party and coalition group. Members representing several parties, having less than 8 seats in parliament are not set up together one party group. But they may join any of the party and coalition groups. Each group elects its head from amongst its members.</p>

Mezey classified the activities of legislatures and their members into three general headings: policy-making activities, system-maintenance activities, and representational activities (Mezey, 1979: 7-11). Two legislatures are vested with a number of functions under each Constitution, the foremost of which is making laws. Lawmaking process is one of main policy-making activities of the legislatures. Therefore, of the functional activities, that of legitimation is most closely identified in a democracy with a specific institution - the legislature (Jones, 1970: 73). Law-

making function of legislatures is almost universally less important than constitutional doctrine or popular opinion would suggest (Loewenberg, 1971: 177-200; Packenham, 1970: 521-82).

Table 7. Comparison of the legislatures as law-making bodies

#		Korea	Mongolia
1.	Constitutional status	In accordance with article 40 of the Constitution of Korea, the legislative power is vested in the National Assembly.	In accordance with article 20 of the Constitution of Mongolia, the State Great Hural is the highest organ of state power and the supreme legislative power shall be vested only in the State Great Hural.
2.	Constitutional power	The most essential power of the National Assembly is to enact, amend, and abolish laws. The National Assembly deliberates bills, including legislative bills, the government's budget bill, and proposals for ratification of international treaties. It also carries out inspection and audit of the administration, as well as engages in inter parliamentary activities. In short, National Assembly has a large and independent capacity to make the laws of the country, and it performs a constituent function which enhances its political endurance.	The Constitution defines the State Great Hural as the supreme legislative power, providing it with wide-ranging authority to enact and amend laws, to determine domestic and foreign policies, fiscal and monetary policies, and to approve the state budget. The parliament has the power to approve and amend the country's administrative and territorial divisions and the power to determine the legal basis for local self-governing authorities.
3.	Initiative	Bills may be introduced by members of the National Assembly or by the Executive.	The President, MPs, and the Government have the right to legislative initiative. Citizens and other organizations may forward their suggestions on draft laws to those entitled to initiate a law.
4.	Law-taking	A law takes effect 20 days after the	A law is subject to official promulgation through publication

	effect	date of promulgation.	and, enter into force 10 days after the day of publication.
--	---------------	-----------------------	---

The legislative process involves many different actors such as legislative members, parties and factions, the executive, interest groups, and constituents in the district (Kim and Pai, 1981: 26). The initiation of legislation sets in motion the whole process of law-making. Blondel argued that private member bills are a measure of the power of initiation of the legislature (Blondel et al., 1970: 79).

Currently, the Korean Constitution provides that the Executive and individual legislators may initiate legislative proposals, whereas The President, members of the National Parliament, and the Government have the right to legislative initiative in Mongolia. Legislative proposal by the administration or executive branch is called a government bill. As formally prescribed by the law, a bill may be introduced by an assemblyman with the concurrence of 20 or more Assembly members^{vi}, or by the administration. An Act is promulgated by listing it in the official gazette, and an Act shall take effect twenty days after the date of promulgation.^{vii} In case of Mongolia, a law takes effect 10 days after the day of publication.

ELECTORAL SYSTEM AND LAST ELECTION RESULTS

This part of paper sets out to provide a peculiarity of election system of Korean National Assembly and effects on political relations, and, indeed, to expose those significant which are considered to be useful experiences for the parliamentary election of our country.

Elections are connections running from the citizens to government (Boynton and Kim, 1975: 21). Free and fair elections are essential to confer legitimacy on governments, translate the will of the people into viable, accountable parliaments and governments that broaden consensus, facilitate participation in political processes, and promote confidence between communities (Molutsi and Singh, 2003). Legislatures legitimized by popular election. It is, of course, a process in which a vote is held to elect candidates to an office. It is the mechanism by which a democracy fills elective offices in the legislature. Generally, democratic elections are viewed as possibilities through which voters influence political leaders. But even in free democracies they can also be seemed from the top down, as institutions which expand the authority of the rulers over the ruled. For some authors such as Ginsberg (1982), this is the major function of elections - competitive elections as well as elections without choice.

Table. 8. Principles

	Korea	Mongolia
As in the <i>Universal Declaration of Human Rights</i> ^{viii} claims that “The will of the people shall be the basis of the authority of government; this will shall be expressed in periodic and genuine elections which shall be by universal and equal suffrage and shall be held by secret vote or by equivalent free voting procedures.” ^{ix} This proclamation has a very large scope on political life and a deep meaning especially for the level of political development in given country.	In accordance with Article 41 of the Constitution of Korea, the members of the National Assembly are elected by universal, equal, direct, and secret ballot by the citizens.	In accordance with article 21 of the Constitution of Mongolia, the members of the State Great Hural are elected by citizens qualified to vote, based on universal, free, direct suffrage by secret ballot.
To be eligible for election	a candidate must be at least 25 years of age	
The right to vote	20 or older	18 or older

In case of Korean National Assembly

Under the revised electoral system for the Korean National Assembly, out of the 299 members, 245 members are elected by popular vote in single-seat constituencies, while the remaining 54 seats, proportionally, are allocated to political parties that get five or more district seats or 3 percent or more of all valid party votes. The proportional representation system is aimed at appointing Assembly members who will represent national interests rather than local interests. Each voter casts two votes, one for an individual, and one for a closed party list in the proportional representation tier.

In the proportionally representative National Assembly election, parties make a list of candidates and submit it to the election commission (Ka, 2008: 200). For the seats of assemblymen at large, each party listed its candidates at large in their ranking orders. One candidate from each electoral district is selected by a plurality of votes. Seats in both tiers are allocated separately; each party is allocated its parallel share of the proportional or at-large seats plus the district seats won by its candidates. As Park notes that in this ostensibly mixed system, the plurality component is dominant. A voter casts a single ballot in choosing his or her district representative. This vote is counted again as the vote for the candidate’s party list for proportional representation. The at-large seats are divided in proportion to each party’s nationwide vote share among the parties with at least five district seats, or with five per cent or more of the total valid votes (Park, 1998: 75).

However, majoritarian and proportional, which are the most general two electoral systems, are being used for the election of the National Assembly as they are simplest and plainest variation for the election. Voters mostly tend to express dual opinion depending on the peculiarity of the electoral system. It is a requirement to elect a specific one party on the basis of party's election program and a candidate according to his/her order of list order in the party. Due to this "tiny" problem of the mixed system the voters' participation is seen to drop. The reason is that if a voter decides to vote in the election, he/she needs to make a dual vote for the election.

This peculiarity of the electoral system, which can be "problem" for the voters, tends them to vote for the main parties which have long years of experience and are well-known among the public. Although a proportional system helps a lot of parties to be represented in the legislative institution, it is difficult for the small parties to obtain seats to compose legislative majority. Moreover, setting an electoral threshold limits the minimum amount of necessary votes to obtain seats in the parliament. It is, as well, becomes an obstacle for the small parties.

In case of State Great Hural of Mongolia

The majority system is known as plurality system under which the winning candidate is one who bags the highest number of votes. It may then be found that although a party may get a majority of the votes cast in the election, it may not get majority of the seats. Among 199 democratic countries, 91 countries exercise this election where as 72 exercise proportional election system while 30 exercise mixed election system. Among five branches of majority system (First past the post, Two-round system, Party block vote, Block vote, Alternative vote), Mongolia has been exercising first-past-the post system.

In Mongolia, parties or coalition of parties, which officially registered before the day of election, are ensured with the right to nominate to the membership of the State Great Hural. In addition, each party draws up a statement of its position on various issues, called a platform. Voters thus make their decisions on the basis of the individuals running for office, and the political platform of the parties they represent. It is possible for a candidate to run for office in a general election without the backing of a political party. To run as an independent, a person must present a petition, signed by a specified number of voters who support his or her candidacy. Parliamentary electoral law requires that citizens of Mongolia who has obtained not less than 801 of vote cast in the electoral constituency shall be eligible for independent candidacy for the election as member of the State Great Hural.^x

LEGISLATURE'S EFFECTS IN THE POLITICAL DEVELOPMENT AND THE PROCESS OF STRENGTHENING OF DEMOCRACY

According to some researchers' point of view, political trust and evaluation influence on and guide people's behaviour. Therefore, composition of political culture is trust, an evaluation and a perception are the basis of strengthening democracy (Eckstein, 1988: 789-804; Putnam, 1993).

As seen in the research surveys (for instance, see Shin, 2005: 58-60; Park, 2007: 105-109) undertaken under various timelines, methods and samples by international and domestic scholars and research institutes, the reputation of the Korean National Assembly, its members or legislatures and the level of public political trust in them is seen to be decreased in comparison to other political and civil society institutions. It depends on structural factors such as political system and peculiarity of governance, and some political cultural factors such as elected politicians or assemblymen's political behaviour and reputation. Somehow, the National Assembly has been and will be a reflection of political relation on society, a voters' expression of political vote and a vital channel between voter and elected politician and communication between the states.

Currently, parliamentary election system of Korea is can be considered mixed type of system including both of majority and proportional election system. However, mixed electoral system, on one hand, is a lever to enter representatives from those many parties. On the other hand it tends to effect on the drop of electoral participation as ordinary voters face challenges to vote in the election.

A development tendency of our country and its strategic purpose are declared in the Preamble of the Constitution of Mongolia. In the Constitution "We, the people of Mongolia, aspire toward the supreme objective of building a humane, civil and democratic society in the country" (*The Constitution of Mongolia*, 1992, Preamble) which tells us that philosophy of social, political and economic development is inseparably linked with democracy and its values. Therefore, development of our nation should be based on the constitutionalism and democracy in future.

Democratic institutions in Mongolia are being formed and Mongolians are learning democracy and democratic political culture. Nevertheless, we face the biggest challenge of how to use and make those newly formed democratic institutions our own in terms of political development. We have right and wrong. But most importantly, democracy is being successfully developed which is considered to be the basis of Mongolian development sustainability in this changing world. In comparison with other countries of the third wave of democracy, Mongolia, however multiple parties have taken seats in the parliament, has a peculiarity of the political formation of dominant two-party system. The lever to it is majority system of parliamentary election. Generally, there are still two main players in parliament arena such as MPRP and DP which established during the democratic period. Compared to Lijphart's comparison (Lijphart, 1999) legislative regulation in Mongolia builds favorable environment to support winner-take-all or dominant two-party system, generally. This system is expressed by the fact that the party which has more votes with a few percent constitutes its government unilaterally and operates as well.

Dominant two-party system and majority election system might bring adverse outcome which divides Mongolians into two in terms of their political attitudes. One way to prevent it is a precise variant of election system. Election system reform can be one way to form political pluralism. Although, political parties show initiatives of election system reform before every selection, unfortunately, political parties and its authorities in their ruling period care more about whether their initiative can influence positively on strengthening their authority in the next election.

In future, it is required to change our election system and carry out mixed or list proportional election system in order to support political development in Mongolia. This issue is still being in search of the best solution for Mongolian future political development by politicians and researchers. Thus, it is necessary to learn experiences from other countries on implementing mechanism and how to estimate election results clearly and accurately for the public. As a criterium of the mixed election system, we consider National Assembly of ROK, which is one of the broadest relationship with our country in the field of economics, culture, education and politics.

CONCLUDING REMARKS

The role of the Constitution is tremendous in politics of two countries. One fundament for constitutionalism is a principle to regard the rule of law as a superior. Safeguarding and implementing the principle to regard the rule of law as a superior becomes a basis for the development of politics and the country.

Mongolia is a new democracy, which is implementing political and economic transition reforms simultaneously. Political multiple parties, interest groups, non-government organizations, representative institutions established by election and public media instruments which can be said as free and independent are formed according to the Constitution. However, their principle to be democratic and open to society is just at a starting point in some aspects.

Mongolia is a country which is strongly sensitive to democracy and reflective to the advantages of foreign culture and values. However, the risk can affect democratic strengthening that politicians are not potential enough to hold political responsibilities and their function is carrying on in a far distance to public interests, wishes and necessities. Importantly, it is praiseworthy that Mongolia in terms of its political development is staunch for its democratic principle which was chosen two decades ago. National development policy is about to be discussed soon in the Parliament of Mongolia with a purpose of political transparent and fair system apart from corruption is given us even a little hope.

REFERENCES

- Blondel, Jean et al., 1970. "Legislative Behaviour: Some Steps Towards a Cross-National Measurement," *Government and Opposition*. 5 (1), 67-85.
- Dahl, R. A. 1956. *A Preface to Democratic Theory*. Chicago: The University of Chicago Press.
- Eckstein, Harry. 1988. "A Culturalist Theory of Political Change," *The American Political Science Review*. 82 (3), 789-804.
- Ginsberg, B. 1982. *The Consequences of Consent*. Reading, Mass: Addison-Wesley.
- Jones, Charles O. 1970. *An Introduction to the Study of Public Policy*. Belmont: Wadsworth Publishing Co.
- Ka, Sang-joon. 2008. "Electoral Systems in Korea," In the Korea Herald, and the Korean Political Science Association, eds., *Political Change in Korea*. Paju: Jimoondang, 195-202.
- Kil, Ki-sang, ed. 1964. *The National Assembly of the Republic of Korea*. Seoul: Kwang Myong Printing Co.
- Kim, Chong Lim, and Byung-Kyu Woo. 1975. "Political Representation in the Korean National Assembly," In Boynton, G.R., and Chong Lim Kim, eds., *Legislative Systems in Developing Countries*. Durham: Duke University Press, 261-286.
- _____, and Seong-Tong Pai. 1981. *Legislative Process in Korea*. Seoul: Seoul National University Press.
- Lijphart, Arend. 1984. *Democracies: Patterns of Majoritarian and Consensus Government in Twenty-One Countries*. New Haven: Yale University Press.
- _____. 1999. *Patterns of Democracy: Government Forms and Performance in 36 Countries*. New Haven: Yale University Press.
- Loewenberg, Gerhard. 1971. "The Influence of Parliamentary Behavior on Regime Stability," *Comparative Politics*. 3 (2), 177-200.
- Mezey, Michael L. *Comparative Legislatures*. Durham, North Carolina: Duke University Press, 1979.
- Molutsi, Patrick and Anita Inder Singh. 2003. "Strengthening Representative Democracy: Parliamentary and Electoral Systems and Institutions," In *Proceedings of the 5th International Conference of New and Restored Democracies: Research Works and Final Documents*. Ulaanbaatar: Urlakh Erdem printing, 21-52.

Packenham, R. 1970. "Legislatures and Political Development," In A. Kornberg and Musolf, L. eds., *Legislatures in Developmental Perspective*. Durham, N.C.: Duke University Press. 521-582.

Pak, Chan Hyun. 1976. *A Comparative Study of the Congress of the United States and the Korean National Assembly*. Seoul: Kwang Myung Printing.

Park, Chan Wook. 1998. "The National Assembly of the Republic of Korea," *The Journal of Legislative Studies*. 4 (4), 66-82.

_____. 2007. "The National Assembly in the Quagmire of Public Distrust: A Stumbling Block or a Facilitating Agent on Korea's Path toward Democratic Consolidation?," *Political Science in Asia*. 2 (2), 103-114.

Park, Il Kyung. 1962. "Review of the 14-Year History of Korean Constitutional Government," *Koreana Quarterly*. 4 (2), 23-34.

Putnam, Robert. 1993. *Making Democracy Work: Civic Traditions in Modern Italy*. Princeton: Princeton University Press.

Riker, W. H. 1982. *Liberalism against Populism: A Confrontation between the Theory of Democracy and the Theory of Social Choice*. San Francisco: W.H. Freeman and Company.

Shin, Myungsoon. 2005. "South Korea: Citizen's Confidence in Public Institutions," In Takashi Inoguchi, et al., eds., *Values and Life Styles in Urban Asia: A Cross-Cultural Analysis and Sourcebook Based on the AsiaBarometer Survey of 2003*. Institute of Oriental Culture, University of Tokyo.

United Nations General Assembly. 1948. *The Universal Declaration of Human Rights*.

Yoon, Young O. 1991. *Korean Legislative Behavior: a Longitudinal Analysis in Comparative Perspective*. Seoul: Kookmin University Press.

NOTES

¹ According to the Potsdam declaration, Korea was set free from the 36 years of colonialism, and the nation was recovered its liberty on August 15, 1945.

¹ At that time, this Special Committee on Draft Constitution consisted of 30 assemblymen, along with 10 other experts or advisory specialists as Pak said in his book (Pak, 1976: 123).

¹ This activity or function of legislatures is also described as "linkage", as some scholars have defined (See on Loewenberg and Patterson, 1979: 44; Kim and Pai, 1981: 1).

¹ The Constituent Assembly of the Republic of Korea adopted a constitution containing a basically this type of government in 1948 (Park, 1998: 65).

¹ As Kim and Pai (1981: 37) noted in advanced manner, this legislature is the most important linkage institution.

¹ See on Chapter III, Article 52 of the Constitution of Korea or The National Assembly Act, Section 2, Article 79.

¹ For legislative procedures, see section IV. The Legislative Procedures for Acts and Subordinate Statutes, in the *Statutes of the Republic of Korea*, Vol. 1 xv-xviii (1997).

¹ *The Universal Declaration of Human Rights* is a declaration adopted by the United Nations General Assembly in 10 December 1948.

¹ *The Universal Declaration of Human Rights*, 1948: Article 21-3.

¹ *State Great Hural Electoral Law*. 2005, Ch. One, Art. 7, Sec. 2.

ХОЁР ТАНХИМТАЙ ПАРЛАМЕНТЫН АНГИЛАЛ, ХЭВ МАЯГ, ЗАГВАРУУД

Д.Сүхболд

Улаанбаатар Эрдэм Их Сургуулийн багш

Докторант

Хураангуй: Хоёр танхимтай парламентыг ангилал, хэв маягт хуваах судлаачдын шалгуур үзүүлэлтүүд, дэлхийн улсуудад хэрэгжсэн хоёр танхимтай парламентын загварууд болох Язгууртны, Холбооны, Хэлэлцүүлгийн загваруудын талаар өгүүлэв.

Abstract: here are shown main criterions of political researchers and scientists about the classification or styles of bicameral parliamentary system; About key bicameral parliamentary models around the world, such as Aristocratic, Federal and discussed.

Хоёр танхимтай парламентыг ангилж хэв маягт хуваах хэрэгцээ, шаардлага дараах хоёр шалтгаанаас үүдэн гарч байна. Үүнд:

- Англид 1352 онд үүссэн хоёр танхимтай парламентын сонгодог хэлбэр болох ардын танхимаас гаргасан шийдвэрийг хүчтэй язгууртны танхим хянан хэлэлцэж хориг тавьдаг хоёр танхимт парламентын уламжлалт хэв маяг өдгөө алдагдаж олон янзын хоёр танхимт парламентын хэлбэрүүд бий болсон байна.
- Монголд улс төрийн намууд болон иргэний нийгмийн байгууллагууд, судлаачид, олон нийтийн дунд хоёр танхимтай парламентын талаарх үзэл санаа, байр суурь харилцан адилгүй байгаа агаад ялангуяа олон нийтийн дунд хоёр танхимтай парламентыг 1990-1992 онуудад ажиллаж байсан Ардын Их хурал болон Улсын Бага хурлаар ойлгож тайлбарлах хандлага багагүй байна.

Тиймээс орчин үед дэлхийн улсуудад хэрэгжиж байгаа хоёр танхимтай парламентын хэв маяг, загваруудыг судлан тодруулж, улмаар өөрийн орон дахь улс төрийн шинжлэх ухааны эргэлтэнд оруулах шаардлага зүй ёсоор урган гарч байна.

Судлаач Д.Лүндээжанцан “Монгол улс дахь төрийн эрх мэдлийн хуваарилалт” бүтээлдээ хоёр танхимт парламентыг хууль тогтоох явцад дээд танхим хэрхэн оролцох, нөлөөлөх байдлаар нь хоёр ангилсан байдаг. Үүнд:

- Нөлөө багатай дээд танхимын тогтолцоо
- Нөлөө бүхий дээд танхимын тогтолцоо

Нөлөө багатай танхим нь санал нийлэхгүй парламентын шийдвэрийг тодорхой хугацаанд хойшлуулах чадвартай боловч түүнийг гаргахад саад учруулж чадахгүй.

Тухайлбал Их Британи улсын парламентын Лордын танхим нь хуулийн төслийн хэлэлцүүлгийг нэгээс дээш жилийн хугацаанд /санхүүгийн хуулийн төслийг нэгээс дээшгүй сарын хугацаанд/ хойшлуулж чадна. Польшийн Сейм бол баталсан хуулийн талаар Сенатын эсэргүүцлийг үнэмлэхүй олонхийн саналаар давж чадна.

Нөлөө бүхий дээд танхимын зөвшөөрөлгүй аливаа парламентын шийдвэр хүчингүй болдог. Жишээ нь АНУ-ын Үндсэн хуулийн 1-р зүйлийн 7.2-т хуулийн төсөл Конгрессын танхим бүрт батлагдаагүй тохиолдолд хүчин төгөлдөр болохгүй.

Судлаач Д.Лүндээжанцан цааш нь бичихдээ “Хоёр танхимт парламентын холимог тогтолцоо бас байдаг. Францын Үндсэн хуулийн 45. 46-р зүйлийн дагуу Засгийн газрын шаардлагаар парламентын эцсийн шийдвэр гартал хуулийн төсөл нь шийдвэр гаргалгүй нэг танхимаас нөгөөдөө дамжуулан шилжүүлж болох юм. /Завьчлах зарчим/ гэж нэрлэгддэг.

Ерөнхийд нь Их Британи, Итали, Францын туршлагаас үзэхэд сонгох журам нь ардчилсан бус байхын хэрээр дээд танхимын парламентад үзүүлэх нөлөө төдий чинээ бага байдаг. Мөн дээд танхим парламентад үзүүлэх нөлөө ихтэй байхад хоёр танхимын эрх мэдлийн хэмжээ хоорондоо нийлдэг. Харин эсрэгээр дээд танхим нь нөлөө багатай байх тохиолдолд танхимуудын эрх үүргийн хүрээг салгасан байна. Жишээ нь нөлөөтэй дээд танхимтай АНУ-ын парламентын танхимуудын онцгой бүрэн эрхийн ялгаа өргөн биш бөгөөд хоорондоо тэнцвэртэй байдаг. Сенат нь олон улсын гэрээг соёрхон батлах, зөвшөөрөл өгөх эрхтэй байхад, доод танхим нь улсын орлоготой холбоотой хуулийн төслийг нэгдүгээрт авч хэлэлцдэг байна”⁷² хэмээн бичжээ.

Эндээс харахад судлаач Д.Лүндээжанцан парламентын хоёр танхимын аль нь хууль батлан гаргалтанд давуу эрхтэй оролцох вэ гэдэг талаас нь судлан үзсэн нь тодорхой байна. Харин судлаач О.Машбат “Үндсэн хууль: улстөр- эрхзүй, хянал тэнцэл” бүтээлдээ

⁷²Д.Лүндээжанцан “Монгол улс дахь төрийн эрх мэдлийн хуваарилалт” УБ 2014

хоёр танхимт парламентыг ангилах шалгуур үзүүлэлтүүдийг гаргаж ирсэн бөгөөд тухайлбал хууль тогтоох үйл явцад аль нь давуутай оролцох вэ гэдгээр нь биш харин яагаад анхнаасаа хоёр танхимд хуваагдах шаардлагатай байсан болох, ингэж хуваагдсанаар ерөөсөө хууль тогтоох эрх мэдлийг сарниулах зорилготой талаас нь ангилан үзсэн нь сонирхолтой юм. Тэрээр үзэхдээ:

- Ангийн сонирхлын ялгаа
- Муж улсын сонирхлын ялгаа
- Сонгуулийн системийн ялгаа
- Бусад өвөрмөц

гэсэн шалгуураар парламентыг хоёр танхимд хувааж болно хэмээжээ.

Судлаачийн ангилсан хэв маягуудыг тодруулж үзвэл:

- *Ангийн сонирхлын ялгаа:* Ангийн сонирхлын ялгаа, ангийн тэмцэл бол сонгодог капитализмын үеийн үед аливаа нийгэмд тулгарч байсан томоохон асуудлын нэг бөгөөд тэр үед амьдарч асан Ш.Л.Монтескье мөн л энэ өнцгөөс харж, тухайн үеийнхээ Английн төрийн байгууллыг шагшин магтаж, онолынхоо загвар болгон авсан тул “Хууль тогтоох эрх мэдэл харилцан өөр ашиг сонирхолтой, өөр үзэл номлолтой, тус тусдаа сууж хуралдах язгууртны болон ардын төлөөлөгчдөөс бүрдэнэ” хэмээн парламентын эрх мэдлийг задалбал зохих тухай бичжээ. Тэр үеийн Английн парламент Лордын болон Нийтийн танхимд /House of Lords and House of Commons/ хуваагдаж байсныг тэрээр хамгийн зөв хэмээн үзэж байв.

XVII зууны Английн төрийн байгуулалд өнөөдөр нам хэмээх тоглогч хүчтэй түрэн орсны улмаас танигдахгүй болтлоо өөрчлөгдөөд байгаа билээ. Анги давхрааны ялгаа нийгэмд онцын ач холбогдолгүй болсноос үүдэн Лордын танхим оршихын төдий үлдэж, харин Нийтийн танхим улс төрийн гол эрх мэдлийг авснаар⁷³ өнөөдөр Британийг нэг танхимтай парламентын жишээ болгон авах нь түгээмэл болжээ.

- *Муж улсын сонирхлын ялгаа:* Төрийн байгууламжийн холбооны хэлбэрт нэг танхим холбооны муж улсын, нөгөө танхим хүн амын төлөөллийг илэрхийлэх зорилгоор зохион байгуулагдсан байдаг.

Ингэснээр нэг талаас холбооны байгууламжийг бэхжүүлж, нөгөө талаас төрийн тогтолцоонд дарах парламентын жин нөлөөг хязгаарлаж байгаа хэрэг юм.

⁷³М.Дюверже “Улс төрийн байгууламж” 130-р тал

- *Сонгуулийн системийн ялгаа:* Нэгдмэл улс хоёр танхимтай парламентын хэлбэрийг сонгож авах явдал гагцхүү засгийн эрх мэдлийн хуваарьтай холбоотой. Хэдийгээр Европт Унгар, Словени, Словак, Латви, Эстон зэрэг дийлэнхи нэгдмэл улсууд коммунист дэглэмийг халсны дараа нэг танхимтай парламентын хэлбэрийг сонгож авсан боловч зарим нэгдмэл улс, тухайлбал Чех улс хоёр танхимтай хэлбэрийг сонгожээ.

Гэхдээ нэгдмэл улсууд хоёр танхимыг байгуулахдаа сонгуулийн хоёр өөр системийг ашигладаг. Тухайлбал БНЧУ-ын Үндсэн хуульд хоёр танхимыг байгуулах журмыг 18 дугаар зүйлд заахдаа:

1. *Депутатуудын танхимын сонгууль бүх нийтийн, тэгш, шууд сонгуулиар хувь тэнцүүлсэн төлөөллийн зарчмаар, нууц санал хураалтаар явагдана.*
2. *Сенатын танхимын сонгууль бүх нийтийн, тэгш, шууд сонгуулиар дийлэнхийн төлөөллийн дагуу нууц санал хураалтаар явагдана хэмээн тус тус заажээ.*

Хувь тэнцүүлсэн сонгуулийн систем нийгмийг ашиг сонирхлын бүлгээр нь нэг танхимд төлөөлдөг бол дийлэнхи-олонхийн систем нийгмийг газарзүйн тойргийн хуваариар төлөөлдөг. Эдгээр төлөөлөл төрийн тогтолцоонд харилцан өөр үр нөлөө үзүүлдэг. Энэ бол нэгдмэл улс төлөөллийн олон талт байдлыг хангахын тулд парламентын хоёр танхимтай хэлбэрийг сонгосон жишээ юм.

Парламентыг сонгуулийн системээр, илрэх төлөөллийн онцлогоор нь хоёр танхимд хувааж, ингэснээрээ парламентын тогтолцоон дахь улс төржилтийн эрчмийг сарниулах хэлбэр байж болохыг БНЧУ-ын Үндсэн хууль харуулж байна хэмээн судлаач О.Машбат бичжээ.

- *Бусад өвөрмөц* Нэгдмэл улс атлаа хоёр танхимтай парламентын системийг сонгосон улсуудын дотор тэр хоёр танхимаа өвөрмөц байдлаар бүрдүүлдэг улс байна.

Эрх мэдэл хуваарилах онолын үүднээс үзвэл, тийм хуваарийг Ш.Л.Монтескьегийн номлосноор парламентын эрх мэдлийг дотор нь сарниулах явдалд орших нь дамжиггүй. Тухайлбал хоёр танхимыг байнгын хороо маягаар байгуулдаг хэлбэр бас байна.

Норвегийн вант улс хэдийгээр нэгдмэл улс боловч хоёр танхимтай парламенттай. Тэдгээр танхимаа бүрдүүлэх журмыг Үндсэн хуулийнхаа 73 дугаар зүйлд заахдаа: “Парламент гишүүдийнхээ дөрөвний нэгийг Байнгын танхимын /Лагтинг буюу дээд танхим/ бүрэлдэхүүнд томилж, үлдсэн дөрөвний гурав нь Ерөнхий танхимыг Стортинг буюу доод танхим/ бүрдүүлнэ.” Хэмээн заажээ.

Хэдийгээр ийнхүү байнгын хороо байгуулах мэт зарчмаар энэ хоёр танхим байгуулагдах боловч, цаашдаа хэлэцэх асуудал, гаргах шийдвэр зэрэг нь хоёр танхимтай парламентын адил явах ёстойг мөн Үндсэн хуульдаа заасан байдаг.

Парламентын бүх нийтийн сонгуулиар доод танхимыг сонгоод, доод танхимаасаа хашир туршлагатай, мэдлэг боловсрол илүүтэй гишүүдийг сонгон дээд танхимыг байгуулдаг Норвегийн энэхүү загварыг Монгол Улсын 1992 оны шинэ Үндсэн хуулийг тогтоогчдын зарим нь дэвшүүлж тавьж байв.⁷⁴

Тэгвэл АНУ-ын судлаач А.Лийпхартын “Ардчиллын хэв загвар: Гучин зургаан орны төр засгийн хэлбэр ба илрэл”⁷⁵, Техас дахь Бэйлорын Их сургуулийн судлаач Уильям Робертс Кларк, /William Roberts Clark/ Пенсильванийн Их сургуулийн улс төрийн шинжлэх ухааны тэнхимийн профессор Малт Голдер, /Matt Golder/ Сона Наденичик Голдер/SonaNadenichekGolder/ нарын “Харьцуулсан улс төр судлалын зарчмууд”⁷⁶ зэрэг бүтээлүүдэд хоёр танхим тус бүрт үндсэн хуулиар олгогдсон албан ёсны эрх мэдэл болоод дээд, доод танхимуудын бүрэлдэх сонгуулийн систем, мөн дээд танхимын ардчилсан хууль ёсны шинж зэрэг шалгуурыг үндэслэл болгон

- тэнцвэртэй /симметрик/
- Тэнцвэргүй асимметрик/

хэмээн ангилсан⁷⁷ байна.

Тэнцвэртэй танхимууд гэдэгт танхимуудын эрх мэдэл үндсэн хуулиар тэнцвэртэй, эсвэл бага зэргийн ялгаатай олгогдсон болон ардчилсан хууль ёсны шинжтэйг хэлэх ба энэ хоёр шинж нь эрс ялгаатай бол тэнцвэргүй гэж үзнэ. Эрх мэдэл тэнцүү хоёр танхимтай

⁷⁴Гухайлбал АИХ-ын 406-р тойргийн депутат ЧТэрбиш өгүүлэхдээ: *Нэг танхим нь нөгөө танхимаасаа урган гарах зайлиггүй бодит шалтгаан байна гэсэн үндэслэлээ хэлье* /АИХ 1991: XXI, 125/ гээд,

1-рт, Төлөөлөгчдийн танхимд ардын төлөөлөгчид цуглаад, сайн хуульч нараас бүрдүүлсэн
2-рт, Хууль тогтоох танхимыг байгуулна, тэгэхээр Бага хурал нь томилогддог байгууллага болоод, Их хурал нь сонгогддог байгууллага болмоор санагдаж байна /АИХ 1991: XXI, 125/ гэжээ.

⁷⁵А.Лийпхарт “Ардчиллынхэвзагвар: Гучинзургаанорнытөрсасгийнхэлбэрбаилрэл” орч. Д.Ганбат 223-р тал

⁷⁶Chapter 15 of Principles of Comparative Politics (William Roberts Clark, Matt Golder and SonaNadenichekGolder) Mar 23, 2012

парламентын жишээнд АНУ, Швейцар, Бельги, Авсрали, Герман зэрэг улсууд орох ба үндсэн хуулиар олгогдсон эрх мэдэл эдгээр улсуудыг бодвол ялгаатай боловч парламентын хоёр танхим хоёулаа шууд ардчилсан сонгуулиар сонгогддог, энэ нь адил төстэй сонгуулийн систем байдаг гэдгээрээ /congruent bicameralism⁷⁸/ Итали, Японы парламентууд мөн тэнцвэртэй ангилалд орох боломжтой хэмээн тэд үзжээ.

Судлаачдын үзсэнээр дээрх улсуудаас бусад улсууд нь тэнцвэргүй ангилалд хамрагдана. Тухайлбал Их Британи, Канад, Энэтхэг, Франц улсуудын хувьд доод танхим нь шууд сонгуулиар сонгогддог боловч дээд танхим нь шууд сонгуулиар сонгогдохгүй, язгууртны уламжлалыг хадгалсан шинжтэй, эсвэл томилогдсон байдаг учраас хууль тогтоох үйл явцад доод танхим давуутай эрхийг эдлэх агаад энэ үүднээсээ эрх мэдэл нь тэнцвэргүй хоёр танхимт парламентын хэв маягт хамаарагдана.


Тус судлаачид хоёр танхимыг бүрдүүлэх сонгуулийн систем болоод арга журам, төлөөллөөс нь шалтгаалж хоёр танхимт парламентыг:

- /congruent bicameralism/ буюу хоорондоо уялдсан, зохицолдоотой танхимууд
- /incongruent bicameralism/ буюу хоорондоо уялдаагүй, зохицолдоогүй хоёр танхимт парламент хэмээн ангилжээ.

Тодруулбал хоёр танхим сонгуулийн ижил аргаар сонгогдож байвал /congruent/ буюу хоорондоо уялдсан, зохицолдоотой шинжтэй. Тухайлбал Итали, Япон, зэрэг улсуудын хоёр танхим ижил төстэй сонгуулийн системээр сонгогддог.

⁷⁸Нийцтэй хоёр танхимтай парламент

**“Уильям Робертс Кларк, Малт Голдер, Сона Наденичик Голдер
нарын гаргасан ангилал”**



Эх сурвалж: “Principles of Comparative Politics” (William Roberts Clark, Matt Golder and SonaNadenichekGolder) Mar 23, 2012

Дээд танхимыг янз бүрийн аргаар сонгох, эсвэл зарим тодорхой цөөнх хэт төлөөлөгдсөн байхаар бодож хийгдсэн байдгаас үүдэн танхимууд хоорондоо бүрдлээрээ ялгарч /incongruent/ буюу зохицолдоогүй шинжийг агуулах болно⁷⁹.

Олонхи дээд танхим холбооны ёсыг голчлон илэрхийлдэг, эсвэл холбооны улсын цөөнхийг хэт төлөөлөлтэй бүрдүүлсэн танхимууд үүний гол жишээ болно.

Муж улсын хүн амын тоог харгалзахгүйгээр ижил тооны төлөөлөгчтэй байх нь хэт төлөөлөл бий болох нөхцлийг бүрдүүлнэ. Жишээлбэл Швейцар, АНУ, Венесуэлд парламентын дээд танхимд муж улс бүр хоёр төлөөлөгчтэй байдаг. Мөн Германы Бундестрат, Канадын Сенатууд цөөнх нь хэт их, олонхи нь хэт бага төлөөлөлтэй холбооны танхимуудын жишээ болно.

Мөн зарим холбооны бус танхимуудыг зохицолдоогүй гэсэн ангилалд хамааруулж болно. Тухайлбал Францын Сенатыг сонгодог сонгуулийн зөвлөлд /коллегид/ нийт хүн амын гуравны нэгээс бага хүн амьдардаг коммунууд нийт саналын талаас илүү хувьтай

⁷⁹А.Лийпхарт “Ардчиллынхэвзагвар: Гучинзургаанорнытөрсасгийнхэлбэрбаилрэл” орч. Д.Ганбат 223-р тал

байдаг. Хөдөө суурингийн энэ хэт их төлөөллийн улмаас Морис Дювержегийн тодорхойлсончлон: “Сенат нь хөдөө аж ахуйн танхим”⁸⁰ болсон ажээ. А.Лийпхарт болон Уильям Робертс Кларк, Малт Голдер, Сона Наденичик Голдер нарын хоёр танхимт парламентыг үндсэн хуулиар олгогдсон албан ёсны эрх мэдэл болоод дээд, доод танхимуудын бүрэлдэх сонгуулийн систем, мөн дээд танхимын ардчилсан хууль ёсны шинжээр нь ангилсан дээрх ангиллыг үндэслэл болгосны үндсэн дээр орчин үед хоёр танхимт парламентын дараах 4 үндсэн хэв маяг байж болох юм хэмээн энэ чиглэлээр судалгаа хийж буй судлаачийн хувьд үзэж байна. Үүнд:

1. Congruent /bicameralism/ /парламентын хоёр танхим хоорондоо нягт уялдсан, хэв маяг буюу танхимууд ижил төстэй сонгуулийн системээр сонгогддог/

Тухайлбал Итали улсын парламентын хоёр танхимыг хоёуланг нь пропорциональ төлөөллийн системээр сонгох бөгөөд сонгуулийн систем нь зарим улсуудад хэрэглэгддэг улсын хэмжээний гэхээсээ илүү сонгуулийн тойргуудад тулгуурлан явагддаг онцлогтой. Сонгуулийн тойргуудын зарим нь Депутатуудын танхимыг, зарим нь Сенатыг сонгохоор зохион байгуулагддаг. Үүнд:

- Улсын хэмжээгээр олонхийн санал авсан нам эвсэл Депутатуудын танхимд
- Бүс нутгийн хэмжээнд олонхийн санал авсан нам эвсэл Сенатад олонхи болно

Италийн хоёр танхимтай парламент нь ийм ижил төстэй улс төрийн сонгуулиар сонгогддог, хоорондоо уялдсан шинжтэй учраас парламентын 2 танхим нь ижил тэнцүү эрх мэдэлтэй⁸¹, харилцан хараат бусаар ажилладаг ба Үндсэн хуульд онцгойлон зааснаас бусад тохиолдолд хамтарч хуралдахгүй. Хуулийн төслийг танхимууд аль алин нь хүлээн зөвшөөрснөөр хүчин төгөлдөр болно. Аль нэг танхим хуулийн төслийг хэлэлцэн дэмжсэн тохиолдолд нөгөө танхимд уг төслийг шилжүүлдэг бөгөөд хүлээн авсан танхим нь дэмжих, эсвэл татгалзсан шийдвэрийн аль нэгийг гаргаж болдог. Хэрэв ямар нэг нэмэлт өөрчлөлтгүйгээр батлагдвал ерөнхийлөгч батламжилснаар /промульгац/ хуулийн төсөл хүчин төгөлдөр болдог. Харин хуулийн төсөлд ямар нэг нэмэлт өөрчлөлт хийвэл анх хэлэлцсэн танхимд буцаана. Хуулинд Ерөнхийлөгчөөс гадна Сайд нарын Зөвлөлийн дарга, Хууль зүйн Сайд нар давхар гарын үсэг зурж контрассигнаци⁸² хийнэ.

⁸⁰Мөн тэнд 226-р тал

⁸¹Ж.Төртогтох “Парламент судлаын гарын авлага” УБ 2010 46-р тал

⁸²ТөрийнтэргүүнийбатламжилсанбаримбичигболоодхуулиндтухайнасуудлыгхариуцсанЗГ-ынгишүүнгарынүсэгзуржбаталгаажуулахявдал. ЭнэньтөрийнтэргүүнийхариуцлагыгЗГ давхархүлээжбуйннэгилэрхийлэл.

Энэ тохиолдолд ижил төстэй сонгуулийн системээр сонгогддог учир хуулийн төслийг танхимууд аль алин нь хүлээн зөвшөөрснөөр хүчин төгөлдөр болдог. Мөн ижил тэнцүү эрх мэдэлтэй парламентын танхимуудаас арай гэж батлагдан гарсан хуулинд Ерөнхийлөгчөөс гадна Засгийн газар давхар гарын үсэг зурж баталгаажуулдаг явдал нь парламентын түгжээ үүсэх буюу хууль батлан гаргалтыг хэт удаашруулах нөхцлийг бий болгож болох юм.

2. Язгууртны уламжлалыг хадгалсан хоёр танхимт парламент

Доод танхимын гишүүд ард түмнийг төлөөлж, шууд сонгуулиар сонгогдсон байдаг бол дээд танхимын гишүүд томилогдсон, эсвэл угсаа залгамжилсан хэлбэртэй. /Англи, Канад/

Тухайлбал Англи улсад Нийтийн танхим нь 5 жил тутамд болох бүх нийтийн ардчилсан сонгуулиар байгуулагддаг бол Лордын танхим нь томилогдсон болон угсаа залгамжилсан гишүүдээс бүрддэг. Лордын танхимын гишүүдийг бүх нийтийн сонгуулиар сонгодоггүй, харин ерөнхий сайдтай зөвшилцөн Хатан хаан томилдог.

3. Symmetric bicameralism: / тэгш хэмт хоёр танхимт парламент/ Парламентын хоёр танхимын үндсэн хуулийн эрх мэдэл ойролцоо учир хууль тогтоох порцесст адил тэнцүү эрх хэмжээтэй оролцдог.

Энэхүү хэв маяг нь ихэвчлэн холбооны төрийн байгууламжтай улс орнуудад хэрэглэгддэг бөгөөд холбооны хэлбэрт нэг танхим холбооны муж улсын, нөгөө танхим хүн амын төлөөллийг илэрхийлэх зорилгоор зохион байгуулагдсан байдаг.

Ингэснээр нэг талаас холбооны байгууламжийг бэхжүүлж, нөгөө талаас төрийн тогтолцоонд дарах парламентын жин нөлөөг хязгаарлаж байгаа хэрэг юм. Жишээ нь: АНУ-ын доод танхим (Төлөөлөгчдийн танхим) улсын нийт хүн амыг төлөөлж сонгогддог учраас ард түмний хүсэл зоригийг илэрхийлдэг бол дээд танхим (Сенат) холбооны муж улсуудын ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор бүрдсэн байдаг. АНУ холбооны 50 муж улсаас бүрддэг бөгөөд нэг мужийн хууль тогтоох хурлаас 2 төлөөлөгч сонгогддог тул Сенатын танхимын гишүүдийн тоо 100 байдаг. Өдгөө энэ хэлбэр холбооны байгууламжтай улсуудад нэн түгээмэл болсон ба АНУ-аас гадна ХБНГУ, ОХУ зэрэг бүх холбооны улсууд тэгш хэмт хоёр танхимт парламентын энэ хэлбэрийг сонгон авч тэр нь засаглалын легитим шинж болтлоо хөгжжээ.

4. Asymmetric bicameralism: /Тэгш бус эрхтэй хоёр танхимт парламент/

Парламентын хоёр танхим хууль тогтоох процесст адилхан үндсэн хуулийн эрх мэдэлтэй оролцох боловч , дээд танхим нь янз бүрийн улс төрийн бүтцийг төлөөлсөн хандлагатай , харин доод танхим шууд ард түмнийг төлөөлсөн байдаг учир бодлогын хувьд дээд танхимаасаа давуу байдаг. Өөрөөр хэлбэл хууль тогтоох үйл явцад доод танхим давуу эрхтэй оролцоно.

Японд хуулийн төслийг парламентын 2 танхимаар дамжуулан хэлэлцэж батлах ба доод буюу нийтийн танхимаас баталсан хуулийн төслийг дээд буюу зөвлөхүүдийн танхим нь батлахаас татгалзвал нийтийн танхим хоёр дахь удаагаа авч хэлэлцээд дахин баталсан тохиолдолд уг хуулийн төсөл батлагдсанд тооцогддог. Мөн Францад парламентын 2 танхим хоёулаа хуулийн төслийг дэмжсэн тохиолдолд хууль батлагдсан гэж үзнэ⁸³.

Хоёр танхим хоорондоо маргалдаж, нэгдсэн тохиролцоонд хүрээгүй тохиолдолд Үндэсний хурал эцсийн шийдвэрийг гаргаж, эцэст нь ерөнхийлөгч хуулийг батламжилна.

Нидерланд улсад хуулийн төслийг эхлээд доод буюу Төлөөлөгчдийн танхим хэлэлцээд олонхийн саналаар дэмжвэл дээд танхим болох Сенатад шилжүүлдэг. Сенат нь хуулийн төслийн талаар зөвшөөрсөн, эсвэл татгалзсан санал гаргах эрхтэй боловч түүнд нэмэлт өөрчлөлт оруулах, мөн хууль санаачлах эрхгүй. Хуулийн төслийг парламентын хоёр танхим хоёулаа зөвшөөрсний үндсэн дээр батална. Төлөөлөгчдийн танхим хуулийн төсөлд нэмэлт өөрчлөлт оруулж болно. Харин сенатад тийм эрх байхгүй. Сенат зөвхөн Төлөөлөгчдийн танхимаас баталсан хуулийг хэлэлцдэг бөгөөд хэрэв санал зөрөлдвөл Төлөөлөгчдийн танхимын саналаар шийдвэрлэнэ. Тэгш бус эрхтэй парламентын хоёр танхимын тогтолцоонд ард түмний төлөөлөгчдийн танхим буюу парламентын доод танхим нь нийт ард түмний эрхийг төлөөлсөн бага ард түмэн хэмээн тооцогддог.

Дэлхийн улсуудад төрийн байгууламж нь нэгдмэл болон холбооны гэдгээсээ үл хамааран ард түмний төлөөлөгчдийн буюу парламентын доод танхим нь бүх нийтийн шууд сонгуулиар сонгогддог бол дээд танхим болох хууль тогтоох танхимын гишүүд хэрвээ холбооны улс бол холбооны улсуудаас сонгосон төлөөлөгчдөөс, /Америк, Герман/ нэгдмэл улс бол ихэвчэн засаг захиргааны нутаг дэвсгэрийн нэгжийн төлөөлөгчдөөс бүрдэхээс гадна үе залгамжлал юмуу томилгоогоор томилогддог байна. /Англи, Канад/

⁸³Ц.Ганболд, Д.Бадамдаш, Ц.Мөнхцэцэг, Ж.Төртогтох “Европынхолбооныулсуудынпарламент” УБ 1998

Хоёр танхимт парламентыг ангилсан дээрх 4 үндсэн хэв маягийг илүү тодруулах үүднээс хууль тогтоох үйл явцад парламентын хоёр танхимын аль нь давуутай оролцох вэ, тухайн улсын төрийн байгууламж, болоод засаглалын хэлбэртэй хэрхэн уялдаж болох вэ? гэдгийг дараах хүснэгтээр харуулав.

Хоёр танхимт парламентын хэв маягууд	Улс орнууд	Төрийн байгууламж	Засаглалын хэлбэр	Хууль тогтоох үйл явцад аль танхим давуутай оролцох вэ?
<i>1. Язгууртны уламжлалыг хадгалсан сонгодог хоёр танхим</i>	Англи, Канад, Энэтхэг	Ихэвчлэн нэгдмэл төрийн байгууламжтай улсуудад	Бүгд найрамдах болон хаант засгийн аль алинд нь хэрэглэгдэнэ	Бүх нийтийн сонгуулиар сонгогддог ардын танхим хууль тогтоох үйл явцад давуу эрхтэй оролцож эцсийн шийдвэрийг гаргана. Язгууртны танхимын хувьд түүхий цоорхой, луйврын, захиалгын хуулиудыг таслан сэргийлэх, удаашруулах зорилгоор ажиллана.
<i>2. Хоёр танхим ижил төстэй улс төрийн найрлагатай байдаг буюу хоорондоо уялдсан</i>	Итали	Энэ хэв маяг олон улсын практикт ховор тохиолддог	Бүгд найрамдах болон хаант засаглалын аль алинд нь тохирч болно.	Ижил төстэй сонгуулийн системээр сонгогддог учир хуулийн төслийг танхимууд аль алин нь хүлээн зөвшөөрснөөр хүчин төгөлдөр болно. Хууль батлагдахгүй удаж “парламентын түгжээ” ⁸⁴ үүсэх аюултай
<i>3. Тэгш хэмтэй хоёр танхим</i>	АНУ, Авсрал и, Герман, Швейцар ОХУ	Ихэвчлэн холбооны төрийн байгууламжтай улсуудад хэрэглэгддэг загвар	Ихэвчлэн Ерөнхийлөгчийн засаглалтай улсуудад тохирсон загвар	Парламентын хоёр танхимын үндсэн хуулийн эрх мэдэл ойролцоо учир хууль тогтоох порцесст адил тэнцүү эрх хэмжээтэй оролцдог. Парламентын түгжээ үүсэх нөхцөл байдал үүсвэл доод

⁸⁴Тэнцүү эрх хэмжээтэй хоёр танхимт парламентаас хууль батлагдан гарахгүй удахыг “парламентын түгжээ” үүсэх хэмээн нэрлэдэг.

				танхим эцсийн шийдвэрийг гаргадаг
<i>4.Тэгш бус хоёр танхим</i>	Япон, Франц, Испани, Нидерланд	Нэгдмэл болон холбооны алинд нь ч хэрэглэгддэг	Хаант болон Бүгд найрамдах засгийн аль ч хэлбэрт тохирно.	Бүх нийтийн сонгуулиар сонгогддог доод танхим хууль тогтоох үйл явцад давуу эрхтэй оролцож эцсийн шийдвэрийг гаргана.Дээд танхимын хувьд түүхий цоорхой, луйврын, захиалгын хуулиудыг таслан сэргийлэх, удаашруулах зорилгоор ажиллана.

Хоёр танхимтай парламентын загварууд

Хоёр танхимтай парламентын дээрх хэв маягуудаас гадна орчин үед дэлхийн улс орнууд өөрсдийн засаглалын хэлбэр, төрийн байгууламж, сонгуулийн систем, төрт ёсны уламжлал, хууль тогтоох үйл явцад аль танхим давуу эрхтэй оролцох вэ? зэргээсээ шалтгаалж харилцан адилгүй хоёр танхимт парламентын загваруудыг бий болгосон хэмээн судлаачийн хувьд үзэж байна.

Тухайлбал хоёр танхимтай парламентын тогтолцоо нь дэлхийн улсуудад дараах гурван үндсэн загвараар хэрэгжсэн байх үндэслэлтэй юм.

Үүнд:

- 1.Язгууртны уламжлалыг хадгалсан загвар
- 2.Холбооны загвар
- 3.Хэлэлцүүлгийн загвар

Хоёр танхимтай парламент Англид анх үүсэхдээ ангийн сонирхлын зөрчлөөс шалтгаалж, Язгууртны уламжлалыг хадгалсан загварын хэлбэрээр үүссэн бол парламентад ёсны хөгжлийн явцад Холбооны болон Хэлэлцүүлгийн загварын хэлбэрээр дэлхийн улсуудад хэлбэршин тогтжээ.

Хоёр танхимтай парламентын загваруудыг харьцуулсан харьцуулалт

1.Язгууртны уламжлалыг хадгалсан загвар	2.Холбооны загвар	3.Хэлэлцүүлгийн загвар
<p>Орчин үед улс төрийн хувьд консерватив шинжээ хадгалсан буюу дээд танхимаа шинжлэх ухаан, академи, их сургууль зэргээс төлөөлөгч томилон бүрдүүлдэг улсууд цөөн боловч байсаар байгаа агаад дээд танхимыг үе залгамжлал юмуу томилолтоор бүрдүүдэг улсуудын сонгодог жишээ нь Англи, болон Канад, Энэтхэг зэрэг улсууд юм.</p>	<p>Төрийн байгууламжийн холбооны хэлбэрт нэг танхим холбооны муж улсын, нөгөө танхим хүн амын төлөөллийг илэрхийлэх зорилгоор зохион байгуулагдсан байдаг. Ингэснээр нэг талаас холбооны байгууламжийг бэхжүүлж, нөгөө талаас төрийн тогтолцоонд дарах парламентын жин нөлөөг хязгаарлаж байгаа хэрэг юм. Энэхүү загвар нь өдгөө АНУ, Герман, Орос зэрэг бүхий л холбооны улсуудын загвар болжээ.</p>	<p>"Хэлэлцүүлгийн" загвар нь Япон, Франц, Итали, Испани, Нидерланд зэрэг уламжлалт язгууртнуудгүй, эсвэл холбооны төрийн байгууламжгүй боловч зарим улс оронд дээд танхим байгааг зөвтгөхөд ашиглаж байна. Яагаад ийм улсуудад дээд танхим хэрэгтэй вэ? Учир нь улс төрийн зөвшилцөл, хэлэлцүүлэг байж болох юм.</p>



Олон түмний төлөөлөл болох доод танхимаас гаргасан шийдвэрийг илүү язгууртанлаг, боловсролтой, хашир туршлагатай, дээрээс нь угсаа залгамжилдаг элит хэсгийнхэн хянадаг энэ загварыг “Язгууртны уламжлалыг хадгалсан загвар” гэж нэрлэх нь тодорхой.

Харин холбооны төрийн байгууламжтай улсуудын нэг танхим холбооны муж улсын, нөгөө танхим хүн амын төлөөллийг илэрхийлэх зорилгоор зохион байгуулагдсан байдаг агаад хоёр танхимтай парламентын энэхүү загвар бол “Холбооны загвар” юм.

Тэгвэл нэгдмэл төрийн байгууламжтай улсуудад хэлбэржин тогтсон хоёр танхимтай парламентын онцлог нь доод танхимаас баталсан хуулийн төслийг дээд танхим хянан хэлэлцэх, шалгах, алдаатай хуулийн төсөл бол хориг тавих, удаашруулах зорилготой байдгаар тодорхойлогдож байна. Иймээс энэхүү загварыг хоёр танхимтай парламентын “Хэлэлцүүлгийн загвар” хэмээн нэрлэнэ.

Abstract

Here are shown main criterions of political researchers and scientists about the classification or styles of bicameral parliamentary system; About key bicameral parliamentary models around the world, such as Aristocratic, Federal and discussion.

ПАРЛАМЕНТИЙН ГИШҮҮНИЙ ХАРИУЦЛАГЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ШААРДЛАГА, АРГА ЗАМ

Д.Ундрах

*МУИС, ШУС, Улс төр судлалын тэнхим
дэд профессор, доктор*

Өнөөгийн Монголын нийгэмд удирдлагыг хэрэгжүүлж буй субъектуудын хариуцлагагүй байдал, хувийн сонирхолоо нийтийнхээс дээгүүрт тавих, авлига хээл хахуульд автах, хүнд сурталд идэгдэх зэрэг олон харш үйлдэл нь нийгмийн үнэлэмж, үнэт зүйлсийн тогтолцоонд сөрөг төсөөлөл, ойлголт ихсэхэл нөлөөлж, улам ужиграх хандлагатай болж байна. Тиймээс улс үндэстний хувьд хөгжилд хүрч, тогтвортой дэвшлийг хангахын үндэс нь төрийн шат шатны байгууллагуудын үйл ажиллагааны тасралтгүй, үр ашигтай, хариуцлагатай байдлаар тодорхойлогдох нь дамжиггүй. Иймийн учир хариуцлагын тухай, Парламент хэний өмнө, ямар хариуцлага хүлээдэг тухай, өнөөгийн хариуцлагын тогтолцоо оновчтой эсэх, хариуцлагын тогтолцоог сайжруулах шаардлага, арга замын тухай хөндөхийг зорьлоо.

Хариуцлага⁸⁵ нь:

-Төрийн албан тушаалтан ажлаа хариуцан тайлагнадаг байх

-Гэм буруутай үйлдлийнхээ төлөө хариуцлага хүлээдэг байх гэсэн агуулгатай.

Төр иргэдийнхээ өмнө хариуцлага хүлээж, иргэддээ эгэн тайлагнадаг, иргэд нь эргээд хариуцлага шаардах эрхтэй байдаг нь ардчилсан засаглалын амин сүнс, үнэт зүйлс билээ. Гэтэл ардчиллын амлалт ба бодит байдлын хоорондын ялгаа улам нэмэгдсэн, ардчилсан замаар сонгогдсон төрийн түшмэд авлигад автсан, өрсөлдөх чадваргүй, төр засаг нь иргэдийн дуу хоолойг үл тоодог, сонгогчдын итгэл даах чадваргүй гэсэн төсөөлөл шинээр ардчилсан улсуудад түгээмэл болох хандлагатай байгаа талаар судлаачид тэмдэглэж, ардчиллын чанарыг цогцоор нь сайжруулах арга замыг эрэлхийлж байна⁸⁶. Иймээс хариуцлага өөрөө хамгийн “хариуцлагатай” ойлголт болж таарч байна. Хариуцлага гэх ойлголт нь :

○ “хариуцах чадавхи” (capacity)

⁸⁵Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. IV боть. 2008. 2470 тал. ШУА.

⁸⁶Д.Ганбат. Монгол дахь ардчилал ба түүний чанар. 2014.12.10 нийтлэл.

<https://www.news.mn/?id=181848>

- “хариуцан тайлагнах ажиллагаа”(accountability)
- “хариуцлага хүлээлгэх ажиллагаа”(responsibility)
- “ёс суртахууны хэмжүүр” (morality)-ийн цогц юм⁸⁷.

Хариуцлага нь ийнхүү “хариуцлага хүлээх чадавхи”, “хариуцлага хүлээлгэх ажиллагаа”, “хариуцан тайлагнах үйл явц”, “ёс суртахууны шалгуур” бол, Монгол Улсын Их Хурлын хувьд эдгээр чадавхи, үйл ажиллагаа хэрхэн хангагдаж байгааг нягтлах шаардлага гарч байна.

1. Парламентийн гишүүний **“хариуцлага хүлээх чадавхи”** нь тэдгээрийн албан үүргээ гүйцэтгэх эрх мэдэл, чадавхийг тодорхойлж буй хууль, дүрэм, журмаар тодорхойлогдоно. УИХ-ын гишүүний эрх зүйн байдлыг тогтоож, үйл ажиллагааны хэм хэмжээг баталгаажуулах ба хязгаарлаж, тодорхой зөрчил дутагдлыг шийдвэрлэх эрх зүйн зохицуулалтыг багтаасан цөөнгүй хууль тогтоомж, дүрэм журам батлагджээ.

Тухайлбал:

- Төрийн албаны тухай хууль /2002/,
- УИХ-ын тухай хууль /2006/,
- Авлигын эсрэг хууль /2006/,
- УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль /2007/,
- Албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах журам /2007/,
- УИХ-ын гишүүний ёс зүйн дүрэм /2009/
- УИХ-ын сонгуулийн тухай хууль (2011)
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль /2012/,
- Сонгуулийн тухай хууль (2015),
- Захиргааны ерөнхий хууль /2015/,
- Төрийн болон албаны нууцын тухай хууль /2016/,
- Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль /2016/,
- УИХ-ын сонгуулийн тухай хууль зэрэг хууль болон холбогдох дүрэм журмаар зохицуулагдаж байна.

2. Парламентийн гишүүдийн хувьд хуулиар олгогдсон эрх мэдлээ хэрхэн хэрэгжүүлж, хүлээлгэсэн үүргээ хэрхэн биелүүлж буй талаархи **“хариуцан тайлагнах үйл явц”** ямар төвшинд, хэрхэн хэрэгжиж буй авч үзье. Хариуцан тайлагнах ажиллагааг

⁸⁷Даваадулам Ц. *Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар толь бичиг*. УБ., 2010. 8 дахь тал.

дотор нь *-санхүүгийн, -захиргааны, -улс төрийн, -иргэдийн хяналтын* гэж ангилдаг.⁸⁸

а) Эндээс захиран зарцуулах эрх бүхий **санхүүгийн** эх үүсвэрийн зарцуулалт, гүйцэтгэлийн тайлагналыг хангах талаар:

-УИХ-ийн гишүүн үйл ажиллагааныхаа талаар тойргийнхоо сонгогчдод мэдээлэх, сурталчлах зардал болон хэвлэл захиалгын зарим төлбөрийг улсын төсвөөс санхүүжүүлдэг⁸⁹.

- УИХ-ийн гишүүд улс төрийн намаараа дамжуулан мөн төсвийн санхүүжилт авдаг. Улс төрийн намын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дах хэсэгт зааснаар “Улсын Их Хуралд суудал бүхий намд түүний авсан суудлын тоогоор Улсын Их Хурлын гишүүний нэг суудлыг жилд арван сая төгрөгөөр тооцож, Улсын Их Хурлын тухайн бүрэн эрхийн хугацаанд улирал тутам улсын төсвөөс санхүүжилт олгоно. Энэхүү санхүүжилтийн 50 хувийг Улсын Их Хурлын гишүүдийн сонгуулийн тойрогт явуулах үйл ажиллагаанд зарцуулна⁹⁰” гэжээ. Эндээс харахад УИХ-ийн нэг гишүүн сонгуулийн бүрэн эрхийн хугацаандаа 40 сая төгрөгийг улс төрийн намдаа авч, түүний 50 хувь буюу 20 сая төгрөгийг тойрогтоо зарцуулж байна.

-УИХ-ийн гишүүний сонгогдсон тойрогтоо ажиллахтай холбогдсон зардлын хэмжээг УИХ тогтоодог.⁹¹ УИХ-ийн гишүүний сонгогдсон тойрогт тухайн гишүүний саналыг үндэслэн зарцуулахаар төсөвт тусгайлан баталсан мөнгө буюу “тойргийн мөнгө”-ийг 2004 оноос эхлэн төсөвт суулгаж 10 сая төгрөгөөр эхэлж, 2006 онд 100 сая, 2007 онд 250 сая, 2008 онд 500 сая, 2009 онд 1 тэрбум болж байв. “Тойргийн мөнгө”, “гишүүний мөнгө” гэгдэх энэхүү мөнгийг Үндсэн хууль зөрчиж байгаа талаар шийдвэр⁹² гарч, орон нутгийн хөгжилд зарцуулагдахаар

⁸⁸ Даваадулам Ц. *Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар толь бичиг*. УБ., 2010. 8 дахь тал.

⁸⁹ УИХ-ын тухай хууль. 6 дугаар бүлэг. 35 дугаар зүйл, 35.5.

⁹⁰ Улс төрийн намын тухай хууль. 4 дүгээр бүлэг 19 дүгээр зүйл 19.2., 2005

⁹¹ УИХ-ын тухай хууль. 6 дугаар бүлэг. 35 дугаар зүйл, 35.3.

⁹² “УИХ-ийн гишүүний тус тусын тойрогтоо хөрөнгө оруулахаар гаргасан санал, жагсаалтыг үндэслэн УИХ-ын сонгуулийн тойргийн журмаар тойрог тус бүрт тэгшитгэн хуваарилж, зарим төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад тараан байршуулсан 250 сая төгрөг буюу нийт дүнгээрээ төсөвт туссан 19,0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт нь” Үндсэн Хуулийг зөрчсөн гэж үүзэж буй 6 зүйл 7 заалтыг жагсаан бичиж дүгнэлт гаргажээ.” ҮХЦ-ийн 2007 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн 02 тоот дүгнэлтээс.

төсөвлөгддөг болсон хэдий ч зүсийг нь өөрчлөн жил жилийн төсөвт суулгаж ирсэн талаар судлаачид, иргэний нийгмийн байгууллагынхан шүүмжилсээр ирсэн⁹³. Гэтэл одоо 2018 оны улсын төсөв хэлэлцэж буй энэ үед ч 58 тэрбум төгрөгийн зардал бүхий 125 төрлийн хууль зөрчсөн, хөрөнгө оруулалт нэмэгдсэнийг олон нийт “УИХ-ийн гишүүний 3 тэрбум” гэж нэрлэж байгааг Ерөнхийлөгчийн зүгээс анхааруулж, Төсвийн тухай хуулийн зарлагын хэсэгт хориг тавиад байна⁹⁴. Төсвийн хөрөнгийг давхардуулан олгож буй энэ мэт явдлаас төсвийн хөрөнгийг үр дүнгүй тарамдуулан, хяналтгүй зарцуулах нөхцөл бүрдсэн нь харагдаж байна.

б) **Захиргааны хариуцлагын** тухайд хариуцан тайлагнах явдал нь УИХ-ийн гишүүдийн хувьд гаргасан хууль, дүрэм журмын хэрэгжилтийн талаар гүйцэтгэх засаглал, төрийн захиргааны байгууллагын эрх мэдэлтнүүдэд асуулга тавих, тодорхой хяналт шалгалт оруулах санал тавих байдлаар хязгаарлагдаж байна.

в) **Улс төрийн хариуцлагын хувьд** УИХ-ын гишүүд нь хөрөнгө орлогын мэдүүлэг, ашиг сонирхолын бүртгэлээ зохих хугацаанд АТГ-т гаргаж өгч, үндэслэлтэй, үнэн зөв мэдүүлэх замаар албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэх үедээ хувийн ашиг сонирхол нь нийтийн ашиг сонирхолтой зөрчилдөөгүй, албан үүргээ тэгш, шударгаар хэрэгжүүлж буйгаа нотлох үүрэгтэй.

г) **Иргэдийн хяналтын** тухайд парламентийн гишүүд сонгогдсон тойргийн иргэдийн санал, гомдлыг дамжуулах үүрэгтэй. Гэвч санхүүгийн хариуцан тайлагналыг эс тооцвол сүүлийн гурван тайлагналын хувьд үндсэндээ тухайлсан тогтолцоо бүрдээгүй байна.

3. Парламентийн гишүүн өөрийн үйлдлийн үр дагаврыг хариуцах **“хариуцлага хүлээх ажиллагаа”**-ны тухайд Монгол улсад төрийн хууль хэний ч хувьд адил тэгш, үйлчлэх ёстой бөгөөд хэн ч хуулийн өмнө шударгаар хариуцлага хүлээх үүрэгтэй. Өдгөө тогтсон эрх зүйн орчинд төрийн анхан болон дунд шатны байгуулагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдад хүлээлгэх хариуцлага хуулиар хэдийн тодорхойлогдсон байгаа бол, улс төрийн сонгуулийн дүнд сонгогдсон эсвэл төрийн өндөр албан тушаалд томилогдон ажиллаж байгаа албан тушаалтнуудад хүлээлгэх хариуцлага туйлын тодорхой бус, яг хэрэг дээрээ зохицуулалтгүй байна. Хууль зөрчсөн аливаа үйлдэл, хүлээсэн үүргээ

⁹³ С.Оюунтуяа. Сонгогчдын Боловсрол Төв.”Иргэд төсвөө хянана” ТББ-ын сүлжээ. www.tusuv.mn

⁹⁴ МУ-ын Ерөнхийлөгчийн Тамгын газар “Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга 2018 оны төсвийг хэт үрэлгэн байна хэмээн үзэж Төсвийн тухай хуулийн зарлагын хэсэгт хориг тавив” <http://www.president.mn/content/12753>

хангалтгүй биелүүлсэн аливаа зөрчил бүр зохих хариуцлага хүлээх нь зүйн хэрэг. Энд өөрөө өөртөө хариуцлага хүлээх ёс суртахууны үүргээс гадна өндөр албан тушаалтнуудын хувьд улс төрийн хариуцлага хүлээх замаар ардчилсан улс төрийн соёлыг төлөвшүүлэх асуудал ч яригдах ёстой. Монгол улсад парламентийн гишүүнд хариуцлага тооцсон тодорхой тохиолдол тун ч цөөн. Үүний анхны жишээ 1991 онд Улсын Бага Хурлын гишүүн Д.Дамдиныг 20 дугаар тогтоолтой холбогдуулан эргүүлэн татсан бол, нөгөө нь 1999 онд казиногийн тендерийг будлиантуулж, авлига авсан хэргээр УИХ-ийн гишүүн, С.Батчулуун, гишүүн Д.Энхбаатар, Д.Баттулга нарыг хорьсон явдал юм. Үүнээс өөр хариуцлага тооцож, хяналт тогтоож байсан бодит жишээ хорь гаран жилийн түүхтэй Монголын парламентад алга. Хариуцлага хүлээх сонирхол үгүй улс төрчидтэй байхад хариуцлага тооцох чадамжгүй иргэд, иргэний нийгмийн болон хэвлэл мэдээллийн байгууллага хариуцлагын тухай, хариуцлагагүйн хор холбогдлын тухай, хариуцлагатай байснаар сайжрах тухай ярих нь илүүц биз ээ. УИХ-ийн гишүүдэд хариуцлага тооцох талаар гаргасан тодорхой санал санаачлагууд хэлэлцэгдэхгүй дарагдах, “Үндсэн хуультай зөрчилдөнө” гэж ам таглах, “УИХ-ийн гишүүний халдашгүй дархан байдлыг хөндөнө” хэмээн сүр далайлган гацаах, буцаах явдал гарсаар өнөөг хүрчээ. Тухайлбал, нэгэнт өөрөө сонгож, өөрийн эрхийг ацаглаж өгсөн улс төрчийг эргүүлэн татах эрх сонгогчдод байх нь зүй ёсны асуудал тул сонгогдсон улс төрчийг эргүүлэн татах, огцруулах, сахилга, хариуцлага тооцох, хүлээлгэх; улмаар УИХ-д хууль боловсруулж, төсөв батлах, гүйцэтгэх засаглалд хяналт тавих үндсэн үүргээ гүйцэтгэхгүй хоцрох, таслах, санал өгөх эрхээ бусдад шилжүүлэх, төрийн ордонд архи дан согтуурах, хуралдааны танхимд танхайрах, ёс зүйгүй эрээ цээргүй, үлгэргүй аливаа үйлдлийг таслан зогсоох чиглэлд гаргасан нэлээдгүй санаачлагыг улс төрчид өөрсдөө буцааж, төр, ард түмнээр тохуурхсаар өнөөг хүрчээ. Энд:

- 2006 он, УИХ-ын тухай хуулийн гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай заалт
- 2013 он, УИХ-ын гишүүн Ж.Батзандангийн УИХ-ийн гишүүнийг эргүүлэн татах тухай хуулийн төсөл
- 2015 он, Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн өргөн барьсан Сонгогдсон болон томилогдсон төрийн өндөр албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх тухай хуулийн төсөл
- 2015 он, Төрийн ордны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төсөл
- 2015 он, УИХ-ийн хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай төсөл зэрэг чамгүй тооны, ач холбогдол, үр дагаврыг нь үл тоомсорлож эс болох олон хуулийн төсөл, нэмэлт өөрчлөлтүүдийг дурдаж болох байна.

Монгол Улсын **Үндсэн хуулийн** хорин есдүгээр зүйлийн хоёр дахь хэсэгт “УИХ-ын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаална”, мөн зүйлийн гурав дахь хэсэгт “УИХ-

ын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг УИХ-ын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. Уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол УИХ түүнийг гишүүнээс эгүүлэн татна” гэсэн заалт бий. Үүгээр УИХ-ын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх асуудал нь УИХ-ын гишүүний халдашгүй байдалд хамаарахыг тогтоожээ. Гэтэл хуульд УИХ-ын гишүүнийг баривчлах ганцхан үндэслэл байдаг нь **УИХ-ын тухай хуулийн** 6-р зүйлийн 6.9.1-д “УИХ-ын гишүүн гэмт хэрэг үйлдэж байгаад газар дээрээ нотлох баримттайгаар баригдсан тохиолдолд баривчилж болно” гэсэн хуулийн заалт юм. Эдгээр хуулийн заалт нь одоогийн улстөрчдөөс иргэдийн амыг таглаж, биеэ хамгаалдаг ганц хамгаалалт болсоор иржээ. Гэтэл Үндсэн хуульд төрийн өндөр албан тушаалтанд хариуцлага тооцож болохгүй гэсэн заалт үгүй билээ.

4. Парламентийн гишүүдийн хариуцлагатай байдал нь тэдний **“ёс суртахууны илрэлгэж** үзэх үнэлэмж, шаардлага хэрэгжиж чадахгүй байна. Хариуцлага нь үнэ цэнэ хэмээх эрхэм ойлголттой салшгүй холбоотой. Хүн үүрэг, хариуцлагаа үл биелүүлснээс үнэ цэнээ алдаж, нэр хүндээ унагаж, улмаар нийгэмд адлагдахад хүрдэг бөгөөд улс төрчдийн хувьд улс төрийн карьертаа цэг тавихад хүргэнэ. Иргэний хувьд хүлээх үүргийг хууль эрх зүйн ба ёс суртахууны гэсэн хоёр талтай “журамт үүрэг”-т хувааж болно. Ёс суртахууны үүрэг ухамсарлагдсан үүрэг байдаг бол, эрхийн үүрэг албадлагын шинжтэй. Мууг жигшиж, сайныг эрхэмлэх ёс суртахууны чин эрмэлзлэлээс үүдэн гарч байгаа бүхнийг зайлшгүй биелүүлэхийг үүрэг гэж ойлгоно. Үүрэг хүлээнэ гэдэг нь ёс журам сахих явдал юм. Ёс журам сахих үүргийг баян ядуу, хөгшин залуу, эрэгтэй эмэгтэй ялгаагүй хүн бүр хүлээдэг. Үүрэг нь нийгэм, түүний гишүүдийн хоорондын харилцааг тогтмолжуулан зохицуулах арга юм. Үүрэг байгаа газар хариуцлага байна. Үүрэг, хариуцлага хоёр нэг юмны хоёр тал. Иймээс үүрэг хариуцлага гэдэг үгс нэг дор, хоршиж хэрэглэгдсээр иржээ. Өнөөдөр мөрдөгдөж буй эрх зүйн зохицуулалт, хэм хэмжээнүүдийн хүрээнд Парламентийн гишүүдийн хариуцлагын асуудал хариуцлага хүлээх эрх зүйн зохицуулалт, хариуцан тайлагнах ажиллагаа, хариуцлага хүлээлгэх шаардлага, ёс суртахууны хувьд аль аль талдаа хангалтгүй, нэр төдий явж иржээ. Хариуцлага алдсан үйлдэл бүрт хариуцлага тооцож байж хариуцлагажина.

УИХ-ийн дотоод хяналтын механизм болох ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа тогтворжоогүй өнөөг хүрсэн нь нөхцөл байдлыг ийнхүү даамжрахад хүргэсэн гэж үзэх үндэстэй. Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийг 2009 онд 7 бүлэг, 34 зүйлтэй “зарчимд тулгуурласан” хэв маягаар боловсруулж, ёс зүйн дүрмийн биелэлтийг хангаж ажиллах үүрэгтэй ёс зүйн дэд хорооны ажиллах дүрмийг 2010 онд баталсан. Уг дэд хороо нь 9 бүлэг, 70 зүйл бүхий ёс зүйн дэд хорооны дүрмийг удирлага болгон УИХ-ын гишүүдийн ёс зүйн зөрчлийг хянан шалгах, хэлэлцэх, хариуцлага ноогдуулах чиг үүргийг

гүйцэтгэхээр заажээ. Гэвч ёс зүйн дэд хорооны хувьд -бүтцийг нь зохистой тогтоох;-чиг үүрэг, бүрэн эрхийг оновчтой тодорхойлох;-ёс зүйн зөрчил хэлэлцэх нөхцлийг тодотгох;-ноогдох хариуцлагыг оновчтой тогтоох зэрэг зохицуулалт шаардлагатай тулгамдсан асуудлууд байгаагаас үр дүнтэй ажиллаж чадахгүй байна. Нэгэнт зарчмын хүрээнд боловсрогдсон ёс зүйн дүрэм хангалтгүй байж, хариуцлага хийдэх, зөрчил бугших орон зай үүсгэх магадлалтайг бодолцон ийм ёс зүйн дүрэмтэй улс орнууд “Парламентийн гишүүний гарын авлага” гаргаж, хууль эрх зүйн мэдээлэл өгөх, болзошгүй зөрчлөөс сэргийлэх урьдчилсан арга хэмжээг зайлшгүй авч хэрэгжүүлдэг туршлагыг нэвтрүүлэх цаг нэгэнт болсон.

Төрийн албанд хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх, улс төрийн соёл төлөвшүүлэх ажил гадаад орнуудад төрийн албан хаагчдын ёс зүйн байдал, ажил үүргээ хариуцлагатай, шударгаар гүйцэтгэж буй эсэхэд төвлөрч, хараат бус гадаад, дотоод хяналтыг хэрэгжүүлэх замаар хийгдэж байна. Тогтмол үйл ажиллагаатай, тодорхой эрх, чиг үүрэг бүхий энэ мэт байгууллагаас улс төрчид хийгээд төрийн албан хаагчдын ёс зүй, хариуцлагыг хянаж, хэлэлцдэг явдал үр дүнгээ өгч буй жишээнээс бид суралцах хэрэгтэй байна.

- Дэлхийн зарим улс оронд улс төрчдийн санаачилгаар ёс зүйн хяналт тавих үүрэг бүхий тусгайлсан байгууллага байгуулах явдал түгээмэл байна. Жишээ нь, 1994 онд Их Британид Төрийн албан хаагчдын ёс зүйн байдалд хяналт тавих хороо, 1990 онд Төрийн албаны үр ашиг, шударга байдлыг хангах Ерөнхийлөгчийн зөвлөл, Норвегид Төрийн албан хаагчдын ёс зүйн статусыг шалгах ажлын хэсэг, 2000 оноос Болгарын парламентийн гишүүд өмч, орлогоо олон нийтэд нээлттэй болгож, төв хянан шалгах байгууллага болох Нягтлан бодох танхимаар хянан хэлэлцүүлдэг болжээ⁹⁵.
- Хөрөнгө орлогын мэдүүлэгт тавих хяналт, хариуцлагыг тодорхой болгох, оффшор данс, ноогдуулах шийтгэл, нуун дарагдуулсан хөрөнгийг улсын орлого болгох журам, үндэслэл
- Хуралдааны танхимийн доторх болон гаднах дэг, ирц, оролцооны мэдээллийг ил тод байлгах, үнэлгээний систем бий болгох, хүйсийн болон угсаатны тэгш байдлыг хангах эсэх
- Дотоод хяналт: Ёс зүйн хорооны одоогийн бүтцийг өөрчлөх, бүрэн эрх, чиг үүргийг далайцтай болгох, байнгын ажиллагаатай бүтэц тогтмол хяналт тавьдаг болгох,

⁹⁵ Л.Отгонтуяа нар. *Хариуцлагын тогтолцоо*. Төрийн захиргаа сэтгүүл. 2011 №02 /17/. 39 дахь тал

- Хөндлөнгийн хяналт: АТГ-ын зэрэгцээ импичмент, омбудсмений тогтолцоог нэвтрүүлэх, иргэний нийгмийн байгууллагууд, хэвлэл мэдээллийн байгууллага, иргэдийн хяналт-оролцоог дээшлүүлэх
- Улс төрийн практикт бодитой оршдог лоббийн асуудлыг цэгцэлж, лоббийн тухай хуулийг батлах замаар ашиг сонирхолын бүлгүүдийн нөлөөллийг хянах, авлигаас урьдчилан сэргийлэх нөхцлийг бүрдүүлэх, лоббистуудын жагсаалт гаргаж, бүртгэлтэй болгох гэх зэрэг шат дараалсан олон чухал арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ

Ардчиллын чанарыг процедур, агуулга, үр дүнгээр нь хэмждэг. Процедурын буюу эрх зүйт ёс, оролцоо, өрсөлдөөн, хэвтээ ба босоо тайлагнал; агуулгын буюу улс төрийн эрх чөлөө, улс төрийн тэгш байдал; үр дүнгийн буюу хариуцлагаар тодорхойлно. Ардчилсан тогтолцоо, ардчилсан дэглэм, үнэт зүйлсийн эцсийн үр дүн хариуцлагаар хэмжигдэж байгаа нь хариуцлага хэмэх ойлголтын ач холбогдол, үр дагавар хичнээн чухал болохыг харуулж буй хэрэг. Тэрчлэн “Сайн засаглал” бол иргэдийн оролцоог хангаж, ил тод байдлыг эрхэмлэсэн, нийгмийн эгэх хариуцлага дээр тулгуурласан удирдахуй ухаан⁹⁶ гэж ч тодорхойлдог. Хаа сайгүй хариуцлагын тухай ярьж, хариуцлагаар ажлын үр дүн хэмжигддэг тухай дурдаж буй энэ үед улс төрчдийн хариуцлагыг ойлголтын хүрээнд нэг мөр болгож томъёолох, хариуцлагын тогтолцоог бий болгож мөрдөх, хариуцан тайлагналыг хэвшүүлэх, хариуцлага тооцох арга хэлбэрийг тодорхой болгох, иргэний нийгэм-иргэдийн хяналтын тогтолцоог бүрдүүлэх-сайн туршлагыг нэвтрүүлэх, нутагшуулах хойшлуулашгүй шаардлага бий болжээ. Иргэн хуулиар хориогүйг хийх эрхтэй бол, улс төрийн албан тушаалтан хуулиар зөвшөөрсөн хүрээнд л ажиллах эрхтэй.

НОМ ЗҮЙ

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр. 2002-2010

“Ардчилал-Нийгмийн хариуцлага” ЭШХ-ын эмхэтгэл. 2010

В.Өлзийбаяр. “Төрийн албаны манлайллын өөрчлөлт” И-гранд ХГ. УБ., 2009

Аристотель. “Дээд суртахуун” Адмон. УБ., 2008

Д.Дэмбэрэл. “Ёс зүйт төр” УБ. 2011

⁹⁶ Х.Наранжаргал. “Боловсролын засаглал дахь нийгмийн эгэх хариуцлага” бодлогын форум. Глоб Интернэшнл төв. УБ. 2016.

Х.Наранжаргал. “Боловсролын засаглал дахь нийгмийн эгэх хариуцлага” бодлогын форум.
Глоб Интернэшнл төв. УБ. 2016.

Ц. Даваадулам. Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар толь бичиг. УБ., 2010
Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. IV боть. ШУА. УБ., 2008

С.Оюунтуяа. Сонгогчдын Боловсрол Төв.”Иргэд төсвөө хянана” ТББ-ын сүлжээ.
www.tusuv.mn

МУ-ын Ерөнхийлөгчийн Тамгын газар <http://www.president.mn/content/12753>

Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем <http://legalinfo.mn/>

Төрийн албаны тухай хууль

УИХ-ын тухай хууль

Авлигын эсрэг хууль

УИХ-ын гишүүний ёс зүйн дүрэм

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхолын
зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль

Улс төрийн намын тухай хууль

БАЯЛГИЙН ҮНДЭСНИЙ ҮЗЭЛ БА МОНГОЛ ДАХЬ ШИНЭ КОЛОНИЧЛОЛЫН ШИНЖҮҮД

Ц.Батболд

*МУИС, ШУС, Улс төр судлалын тэнхим
дэд профессор, доктор*

Түлхүүр үг: колоницлол, шинэ колоницлол, постколониализм, баялгийн үндэсний үзэл, хамаарлын онол, конвергенцийн онол, Монрогийн номлол, колоницлолын эсрэг хөдөлгөөн
Товч утга: Колоницлол ба шинэ колоницлолын мөн чанар, түүнийг дэмжсэн хамаарлын онол, өнөөгийн Африк дахь баялгийн үндэсний үзэл, шинэ колоницлолын эсрэг Африкийн улсуудын төрийн бодлогын талаар авч үзсэн. Мөн үүнийг Монголын жишээн дээр буулгаж үзсэнээр шинэ колоницлолын шинж тэмдгүүд хэрхэн илэрч байгааг тодруулах зорилго тавьсан.

Постколониализм буюу колонийн дараах нийгэм, улс орнуудыг судлах (Postcolonial studies) хэмээх хандлага нь колоницлол, империализмын соёлын өвд анализ хийх, тайлбарлах, хариу өгөх оюуны сэтгэлгээний аргуудыг агуулсан шинжлэх ухааны нэг хандлага юм. Постколониализмыг судлах хандлага нь хүчирхэг улс гүрнүүдийн зүгээс хөгжиж байгаа болон буурай хөгжилтэй орны газар нутгийг эдийн засгийн мөлжлөгт ашиглах зорилгоор улс орныг нь хянах, дуулгавартай оршин суугчдыг бий болгох үр дагаврыг авч үздэг. Орчин үеийн шинжлэх ухааны энэ хандлага нь түүхэн дэх колоницлолын асуултанд хариулж, колоницлогдож байсан ард түмнүүдийн соёл, үзэл санааны хэлбэрийг эргэн харж сэргээх, тэдний бие даан хөгжих боломж арга замыг хайхад чиглэж байна. Энэ хүрээнд улс төрийн шинжлэх ухаан, философи, социологи, антропологи зэрэг олон шинжлэх ухааны уулзвар дээр үүсэж байгаа шинэ хандлага юм. Онолын хувьд улс төр, нийгмийн шинжлэх ухаануудын онол арга зүйд тулгуурлан, өмнөх колоницлол болон неоколоницлолыг хүлээн зөвшөөрсөн онолын хандлагуудыг, эмпирик судалгаанд Өрнөдийн соёл иргэншлийн хүлээн зөвшөөрдөггүй байсан колоницлолын утга зохиол буюу эрэгтэй, эмэгтэй хүний колоницлогдож буй түүхийг харуулсан түүхэн өгүүллэг зэргийг эргэн харах болсон байна. Вильям Хокингийн тодорхойлсон прагматизмыг Ричард Фэйнман: “Бид хэзээ ч яг зөв байдаггүй, харин бид зөвхөн буруу байхдаа л зөв гэж боддог” хэмээн тайлбарласан байдаг.

Колоничлол ба шинэ колоничлол

Колоничлол бол нэг улсын зүгээс нөгөө улс, үндэстнийг цэрэг, зэвсгийн хүчээр эзлэн авч, түүний бүх нөөцийг ашиглах төдийгүй улс төр, эдийн засаг, соёлоор дарлан ноёрхох үзэгдэл юм. XVII-XX зууны хагас хүртэлх хугацаанд газар зүйн нээлтүүд болон капитализмын хөгжилтэй холбоотойгоор дэлхий даяар колоничлол идэвхжин хөгжсөн байна. Испани, Португал, Их Британи, Франц, Недерланд, Орос зэрэг колонийн эзэнт гүрнүүд өөрийн эзэмшил нутгаа өргөтгөж иргэдээ шинэ газар суурьшуулахад чиглүүлэн тухайн нутаг дэвсгэр дээрх уугуул иргэдийг цэрэг зэвсгийн хүчээр устган цэвэрлэх, боолын наймаа зэргээр нийгэм, эдийн засаг, соёлын хөгжлөөр хоцрогдсон орнуудын ард түмнийг хүч хэрэглэн боолчилж байв. Үүнийг соёл иргэншлийн хөгжлийн жам ёсны үзэгдэл бөгөөд түүний түгэн тархалтын нэг хэлбэр хэмээн үзэх хандлага XIX-XX зууны дунд үе хүртэл түгээмэл байсан. Колоничлолын мөн чанар бол колонийн эзэнт гүрний нийгэм, эдийн засгийн хөгжлийг түргэтгэхийн тулд колони орнуудын нөөц баялагыг тонон дээрэмдсэнээр колоничлогдож буй орнуудад ядуурал, гуйланчлал, өлсгөлөн нүүрлэдэг нь түүний мөн чанарын илрэл юм. Колониализмын үзэл баримтлалд колонитой байна гэдэг бол “тэдний хүчирхэгийн нотолгоо юм” гэж үздэг байв.

Протекционизмын онолыг үндэслэгч Фридрих Лист 1841 онд хэвлэгдсэн “Үндэстний улс төрийн эдийн засгийн тогтолцоо” номондоо “Өндөр соёлтой хоёр үндэстний хоорондох чөлөөт өрсөлдөөн хоёр орны аж үйлдвэржилтийн хөгжлийн түвшин ойролцоо байгаа тохиолдолд л хоёр талын ашигтай байх бөгөөд хэрэв бусдаасаа үйлдвэржилтийн хувьд хоцорч байгаа аливаа орон чөлөөт өрсөлдөөнд орох гэж байгаа бол юуны өмнө өөрийн хүчээ чангатгах ёстой юм” гэжээ. Герман, Итали, Япон, Австри-Унгар зэрэг сүүлд үйлдвэржсэн орнууд шинээр колони олж авах зорилгоор дэлхийн I дайныг өдөөсөн бөгөөд дэлхийн II дайн ч мөн дэлхийг дахин хуваахын төлөөх дайн байсан.

Дэлхийн II дайны дараа НҮБ байгуулагдаж, хоцрогдсон буурай орнуудын бие даасан бүрэн эрхт тусгаар тогтносон байдлыг хүлээн зөвшөөрөхөөр тунхагласан нь колонийн системийг задрахад хүргэсэн юм. НҮБ дахь ЗХУ ба АНУ-ын байр суурь үүнийг хүчтэй дэмжиж байсан хэдий ч тэдний зорилго өөр өөр байсан. ЗХУ колонийн систем задрах нь капиталист системийг сулруулна гэж үзэж байсан бөгөөд коммунист үзэл суртлын хүрээнд колоничлолыг эсэргүүцсэн хөдөлгөөнийг дэмжиж байв. Харин АНУ-ын хувьд XIX зууны эхээр Испанийн колоничлолоос тусгаар тогтносон Латин Америкийн улс орнууд руу “Монрогийн номлол”⁹⁷ хэмээх шинэ колоничлолын бодлогоо хэрэгжүүлж байсан

⁹⁷ Монрогийн номлол-1823 онд ерөнхийлөгч Жеймс Монро АНУ-ын гадаад бодлогын зарчмын асуудлын гурван үндсийг Конгресст мэдэгдсэн. Энэ нь нэгд, АНУ-ын төр, засгийн газраас

туршлагад тулгуурлан колониос тусгаар тогтносон орнуудыг хүлээн зөвшөөрч, тусламж дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах болсноор тэдгээр орнуудын улс төр, эдийн засгийн хүрээнд хяналт тавих болсон байна. Өөрөөр хэлбэл, дэлхийн II дайны дараах дахин хуваарилалтыг хийхдээ үндэстэн дамнасан корпорациудаар дамжуулан Англи, Франц зэрэг колонийн эзэнт гүрнүүдийн хүчийг сулруулж, колонийн нөөц баялагийг нь өөртөө эзэмших боломжийг бүрдүүлсэн неоколониализмын бодлогыг хэрэгжүүлж эхэлжээ.

Неоколониализм бол хөгжлийн буурай түвшинтэй аль нэг улс, үндэстний тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хүлээн зөвшөөрдөг хэдий ч тэдгээр орнуудын баялаг, эдийн засгийн үр ашгийг өөртөө авахын тулд улс төр, эдийн засаг, соёлд нь хяналт тогтоодог зарим хүчирхэг улсуудын бодлого юм. Өөрөөр хэлбэл, орчин үеийн олон улсын харилцааны түвшинд хөгжингүй орнууд буурай хөгжилтэй улс орнуудад өөрсдийн эдийн засгийн ноёрхлоор дамжуулан түүний улс төрийн хүрээг хянаж, өөртөө тааламжтай шийдвэр гаргуулах бодлогын хэрэгжилт гэж ойлгож болно. Онолын хувьд жижиг буурай улс орнууд бие даасан хараат бус байх боломжтой хэдий ч тэдгээр орнууд олон улсын чөлөөт болон бодит (либерал болон реалист) улс төр, эдийн засгийн харилцаагаар дамжуулан үндэстний эрх ашгаа хамгаалж чадахгүй байх үзэгдлийг неоколониализм гэнэ.

Неоколониализмын мөн чанар бол тухайн улс орныг санхүүгийн өрөөр дамжуулан хянах, удирдах арга хэрэгсэл юм. Нөгөө талаар неоколониализм бол өндөр хөгжилтэй зарим орнуудын зүгээс колониос ангижирч тусгаар тогтнолоо олж авсан буурай хөгжилтэй улс орнуудад гадаад эдийн засгийн ноёрхлоо тулган хүлээлгэхийн тулд хэрэгжүүлж буй цэрэг (Ирак, Ливи), улс төрийн (Чили, Арабын хавар гэх мэт) ил, далд халдлага юм.

Шинэ колоничлолын шинж, мөн чанар:

Европын дотоод хэрэгт үл оролцоно; хоёрт, Америкийн дотоод хэрэгт Европын улс орнуудын засгийн газар үл оролцоно; гуравт, Европын орнууд Америкийн улс орнуудын бие даасан байдалд ямар нэгэн хэлбэрээр дайралт хийж колоничлох гэсэн аливаа оролдлогыг няцаах болно гэсэн тунхаглал гаргасан. Хэрэв энэ тунхагийг зөрчвөл АНУ-ын амин чухал эрх ашиг, дотоод хэрэгт оролцсон гэж үзэх болно гэж анхааруулсанаар “бүх Латин Америкийн орнуудыг Европын колоничлогчдоос хамгаалах” нэрийн дор тэдгээр орнуудыг өөрийн дээвэр дор оруулж, тэдний нийгэм, улс төр, эдийн засгийг нь бүрэн хянах болсон. АНУ дэлхийн I дайны дараа албан ёсоор “Монрогийн номлол”-оос татгалзсан хэмээн мэдэгдэж байсан хэдий ч энэ нь албан бус хэлбэрээр үргэлжилсээр байгаа бөгөөд Европын орнуудын үндэстэн дамнасан компаниуд Америкийн нэгэн адил неоколониализмын бодлогыг хэрэгжүүлэх болсон нь өнөөгийн бодит байдал юм.

1. Неоколониализмийн уриа нь эдийн засгийн өндөр өсөлт, түүний хөгжлийг олон улсын байгууллагууд хүлээн зөвшөөрөх явдал юм. “Эдийн засгийн их өсөлт” хэмээх сүржин уриа дэвшүүлдэг.

2. Олон улсын банк санхүүгийн байгууллагууд их хэмжээний зээлийг баялагийн хэмжээнд баримжаалан олгох эрхийг өгнө. Өөрөөр хэлбэл, олон улсын банк, санхүүгийн байгууллагууд тухайн улсын эдийн засаг өндөр хөгжих нь хэмээн хүлээн зөвшөөрч зээлжих эрхийг нэмэгдүүлэн олгож эхэлдэг.

3. Неоколониализмд автагдсан улс орнуудын өр улам бүр ихэсдэг. Өөрөөр хэлбэл, тухайн улс орон өрийн сүлжээнд бүрэн автдаг.

4. Неоколониализмд автагдсан улс орнуудын улс төрийн дэглэм нь ямар байх нь шинэ колонилогчдод огт хамаагүй. Гол нь өөрөөр дамжуулан улс төр, эдийн засаг нь хянагддаг байх ёстой.

5. Неоколониализмийн үед эрх баригчдын шийдвэр үндэсний эрх ашгаа байнга зөрчиж, “амиа хорлох” шинжтэй байдаг. Өөрөөр хэлбэл, төрийн бодлого, шийдвэрүүд улс, үндэстэнийхээ эрх ашгаас урвасан, гадаадынханыг хамгаалсан шинжтэй гарч эхэлдэг.

6. Шинэ колониололд тал засч, гадаадынхантай ашиг сонирхол нийлдэг тодорхой бүлгүүд нийгмийн бүтцэд үүсдэг. Улс төр, төрийн албаны дээд эрх мэдэлтнүүдийн хүрээнд авлига, ашиг хуваах хэлбэрээр, нийгмийн дунд давхарга буюу жижиг дунд үйлдвэр, үйлчилгээнийхэн туслан гүйцэтгэх компаниуд нэрээр, доод түвшинд африкийн хэлээр “хашаан доторх ажилчид” буюу харьцангуй өндөр цалинтай цөөн тооны ажилчид зэрэг нь гадаадын хөрөнгө оруулагчидтай ашиг сонирхол нэгтэй, тэдний эрх ашгийг хамгаалан тэмцдэг нийгмийн хэсэг бүлгүүд бий болдог байна.

7. Эх орондоо иргэд нь хоёрдугаар зэргийн хүн болж, гадаадынхан болон тэдэнтэй хуйвалдагсад нэгдүгээр зэргийн хүн болдог. Өөрөөр хэлбэл, эрх баригчид болон гадаадынхантай ашиг сонирхол нэгтэй этгээдүүдэд хууль үйлчилдэггүй.

8. Иргэдийнх нь эх орондоо сайхан амьдрах итгэл, найдвар алдарч гадаад орнуудад цагаачлах, хямд ажиллах хүч болж гарах нь ихэсдэг байна. Колони орнуудын хүмүүс эх орондоо хөрөнгө хуримтлуулж амьдралаа дээшлүүлэх боломжгүй болон амьдрах орчин нь маш муу зэрэг шалтгаанаас үүдэж байнга цагаачлахыг хүсэж байдаг.

9. Улс, үндэстэнийхээ эрх ашгийг хамгаалахаар тэмцсэн эх орончдыг “намнаж” эхэлдэг. Өөрөөр хэлбэл улс, үндэстэнийхээ эрх ашгийг хамгаалж дуугарсан улс төрчид, иргэний хөдөлгөөнийг популистууд, гацаагчид хэмээн адлах, гутаан доромжлох, улс төрөөс арчиж хаях үзэгдэл ихэсдэг байна.

10. Шинэ колоничлогчдоос хамааралтай эдийн засгийн хараат байдал үргэлжилж, эдийн засаг үл солонгорно. Өөрөөр хэлбэл, өр төлөлтийн асуудлууд болон уул уурхайгаас хараат эдийн засагт бусад өөр өсөлт хөгжлийн боломжууд хязгаарлагддаг байна.

11. Неоколониализмийн үр дагавар хариуцлагыг хүчирхэг гүрнүүд хүлээдэггүй бөгөөд ихэнхдээ тухайн орны төр, засаглал нь чадваргүй, авлигад идэгдсэн, сул доройгоос болсон гэж тайлбарлагддаг. Өөрөөр хэлбэл, үндэстэн дамнасан корпорациудын тарьсан балаг эзэн орны удирдагчдад хамаагүй мэт боловч шаардлага гарвал корпорациудынхаа эрх ашгийг хамгаалдаг.

Колоничлолоос салж неоколониализмын замаар 60-аад жилийн Африкын орнууд өр, өлсгөлөн, ядуурал, иргэний дайн, эдийн засгийн дамбуурал, цагаачлал зэрэг үй олон зовлон бэрхшээлтэй тулгарч олигтой өөдөлсөнгүй.

Хамаарлын онол ба түүний шүүмж

Неоколониализмыг зөвтгөсөн, түүнийг жам ёсны зайлшгүй үзэгдэл хэмээн үздэг онолыг (Dependency theory) хараат байдлын буюу хамаарлын онол гэнэ. Аливаа системийн элемент бүрийг анхааралтай судлах нь хамаарлын онолын гол зарчим юм. Ихэвчлэн энгийн логик бүтцэд аливаа юмс үзэгдлийг задлаад бие биеэ дэмжин гол хүчин зүйлийг илрүүлэхэд оршино. Тухайлбал, хамаарлын системийн ашиглалтын гол хүчин зүйл болох давамгайлах зарчмуудыг тодорхойлоход оршино. Хамаарлын онол нь дэлхийн эдийн засгийн системийн төв хэсэгт чинээлэг улс орнууд байдаг бөгөөд тэдгээрийг тойрч захаар нь ядуу буурай орнууд оршдог гэж үздэг бөгөөд үүнийг эдийн засгийн неоколониализмийн онолын үндэс суурь юм. Эдийн засгийн шинэ колоничлолын үр дүнд хөгжил буурай орнуудын хүний нөөц болон байгалийн баялаг нь дэлхийн эдийн засгийн системийн төвд орших хөгжингүй орнуудын эдийн засаг руу урсана. Энэ нөхцөлд захын улс орнуудын ядуурал доройтол нь дэлхийн эдийн засгийн төв системтэй хэрхэн интеграцлагдсанаас хамаарч өөрчлөгдөнө гэж үздэг. Уг онол нь орчин үеийн хөгжлийн онолыг бий болгож, өнөөгийн хөгжиж буй бүс нутгууд, хөгжингүй бүс нутагт ч ижил төстэй нөхцөл байдал бий болгосон. Тиймээс ядуу буурай хөгжиж буй нутгуудад ядуурлаас ангижрахад туслах үүрэг нь хөрөнгө оруулалт, технологи дамжуулалт, дэлхийн зах зээлд илүү ойртох зэрэг янз бүрийн арга замаар хөгжлийн энэхүү түгээмэл зам дагуу хурдасгах явдал юм.

Системийн захад орших буурай орнуудын ядуурал нь дэлхийн эдийн засгийн системтэй бүрэн интеграцлагдах явцад тохиолддог хөгжлийн нэг шат гэж капиталистууд үздэг. Дэлхий дахины бизнесийн үйл ажиллагааг жигд нэг загварын үр ашигтай шуурхай болгоход колоничлол зайлшгүй гэж энэ онолынхон үздэг байна. Судлаач Тооч

(Tausch)Египетийн эдийн засагч Самир Аминагийн 1973-1997 оны бүтээлдсуурилан зах зээлийн капитализмын дараах гол шинж чанаруудыг жагсаасан:

1. Колоничлол болон гадаадынханы ноёрхлын довтолгооны үед хөдөө аж ахуй ба жижиг үйлдвэрлэлийн уналт, доройтлын ерөнхий шинж чанар тодорхойлогддог.

2. Хөгжиж байгаа орнуудын удирдлага уул уурхай, хөдөө аж ахуйд төвлөрсөн экспортын үйл ажиллагаа явуулах нь эдийн засгийн тогтворгүй байдлыг үүсгэдэг, зарим үйлдвэрлэлт бага цалингийн нөхцөлтэйгээр явагддагаас хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлдэггүй бөгөөд төлбөрийн хэрэгслэлийн тэгш бус солилцооны багцыг (гадаад худалдаа гэх мэт)бий болгодог гэж олон улсын мэргэжилтнүүд үздэг.

3. Эдгээр бүтэц нь яваандаа тухайн салбартаа гуравдахь түвшнийдалд ажилгүйдлийг хурдацтай нэмэгдүүлэн, нийгэм болон эдийн засгийн ерөнхий системд түрээсийн ач холбогдлыг нэмэгдүүлдэг.

4. Дэлхийн эдийн засгийн төвүүд дэх гэнэтийн өсөлтийн үед зах зээлийг хангах гадаадын хөрөнгө оруулагчдын буцаах экспортоос эргэлтийн хөрөнгийн санхүүгийн ужиг болсон алдагдал болон хомсдолтой бизнесийн мөчлөг нь ашиг авчирдаггүй.

5. Улс төр, нийгмийн харилцааны бүтцийн тэнцвэргүй байдал болон нийгмийн харилцаа дахь элементүүдийн хүчтэй дотоод холбоо нь хөрөнгө оруулагчдын ач холбогдлыг өсгөж, төр, нийгмийн давхаргад өр бий болгодог.

Хамаарлын онолыг баримтлагчид зах зээл дэх богино хугацааны өсөлтийг үл харгалзан, урт хугацааны өсөлтийг хадгалан тухайн орны эдийн засгийг тэнцвэргүй, санхүүгийн сөрөг урсгалтай дансны үлдэгдэлтэй байлгах хандлагатай байдаг. Циклийн хэлбэлзэл нь дунд болон урт хугацаанд эдийн засгийн өсөлт, нийгмийн хөгжилд чиглэсэн үндэсний хэмжээний харьцуулалт хийхэд гүн гүнзгий нөлөө үзүүлдэг. Урт удаан хугацааны өсөлтийн үр дүн нь урт хугацааны эдийн засгийн хямралын дараа богино хугацааны мөчлөгт түлхэц болж болох юм. Циклийн хугацаа нь чухал үүрэг гүйцэтгэдэг. Жиованни Аррииди дэлхийн хэмжээний хуримтлалын логик цаг хугацааны туршид өөрчлөгдөж, капитализмын логигоор зохицуулагддаг бөгөөд 1980-аад оноос өмнөх зохицуулалтын циклүүдээс ялгаатай нь санхүүгийн капиталын ноёрхол баталгааждаг⁹⁸ гэжээ.

Хамаарлын онол нь дэлхийн эдийн засгийн тогтолцоон дахь эдийн засгийн тэгш бус байдалд хийсэн Марксист дүгнэлтээс үүдэлтэй бөгөөд дэлхийн өмнөд хэсгийн буурай

⁹⁸Tausch, Arno (2003). "Social Cohesion, Sustainable Development and Turkey's Accession to the European Union: Implications from a Global Model". Alternatives: Turkish Journal of International Relations.

хөгжил нь дэлхийн хойд хэсгийн хөгжил дэвшлийн шууд үр дүн буюу урвуу хамаарал гэж үздэг. Энэ нь XIX зууны сүүл үед гарсан хагасколони орны онол юм. Дэлхийн зах зээлийн эдийн засаг дахь сул дорой гишүүдтэй байх явдал хамгийн чухал нь юм. Колоничлол дахь хамаарлын онолын марксист агуулга нь чөлөөт зах зээл бүхий капиталист эдийн засагтай харьцуулахад өдөр шөнө шиг ялгаатай. Өөрөөр хэлбэл, К.Марксын шинэ эдийн засгийн онолоор бол энэ нь өндөр хөгжилтэй, дунд, буурай гэж хуваагдсан эдийн засгийн мөлжлөгийн систем гэж тайлбарлагддаг.

Хараат бус байдлын онол хамаарлын онолын үзэл бодлыг үгүйсгэдэг бөгөөд хөгжиж буй орнууд бол зөвхөн хөгжингүй орнуудын ердийн хуулбар биш, харин өөрсдийн өвөрмөц шинж чанар, бүтцийг бий болгодог гэж үздэг. В.Арнольд хамаарлын онолыг хөгжиж буй орнуудад хэрэглээний нийгэм (..жинхэнэ өндөр мэдлэг боловсрол бол зээлээр хэрэглэгчдийн донтсон өнгө мөнгөний нийгэм буюу шинэ маягийн боолын нийгмийг байгуулах гэсэн тэдний туйлын хүсэл цаад зорилготой нь зөрчилдөж байдаг. ... Хүүтэй зээлийн өрөнд унасан, энэ бүхнийхээ цаад учрыг мэдэхгүй байгаа - сануулаад байхад ойлгодоггүй хүн сүрэг бол угтаа ямар ч эрх чөлөөгүй жинхэнэ боолууд билээ) бүрдүүлдэг хэмээн шүүмжилсэн.⁹⁹

Баялагийн үндэсний үзэл

Баялагийн үндэсний үзэл (Resource nationalism): бол өөрийн нутаг дэвсгэр дээрх байгалийн нөөц баялагт хяналт тавих зорилготой нийгмийн гишүүд болон төр засгийн үзэл хандлагыг илэрхийлсэн ойлголт юм. Өөрөөр хэлбэл байгалийн баялгаа өөрөө мэдэж шийдэх улс гүрнүүдийн сонирхол эрс нэмэгдэж байна. Энэ нь байгалийн баялаг боловсруулах гадаадын компаниудын оролцоог хатуу хянах, энэ салбар дахь төрийн өмчийн оролцоог нэмэгдүүлэх, хэрэв нөөцийн боловсруулалт заасан хугацаанд хийгдээгүй тохиолдолд уурхай болон цооногийг хураан авах, улсын болгох зэргээр илэрдэг. Үүнийг “use it or loose it” зарчим гэдэг¹⁰⁰.

Энэ утгаар үйлдвэрлэгч орнуудын баялагийн үндэсний үзлийн гурван өөр хандлага байдаг:

- ❖ Үйлдвэрлэгч орны баялагийн үндэсний үзэл (Үйлдвэрлэгч орнууд өөрийн байгалийн баялагийн салбартаа эдийн засгийн үйл ажиллагааны хяналтаа ихэсгэдэг)

⁹⁹В.Арнольд. Интереснопроамериканскую систему образования. <http://vivovoco.astronet.ru>

¹⁰⁰Д.Ганхуяг. Ресурсынационализмба Монгол.

- ❖ Хэрэглэгч орны баялагийн үндэсний үзэл (Хэрэглэгч орнууд бусад орнуудын байгалийн баялагт нэвтрэх боломжоо нэмэгдүүлэх эсвэл томоохон хяналт тогтоохийг эрэлхийлэх)
- ❖ Мөн баялагийн национализмын харьцангуй шинэ хэлбэр болох хөрөнгө оруулалтын төвлөрөл болсон улсууд болох газар нутаг нь байгалийн баялагийн орлогоос бий болсон хөрөнгийн сангаас хөрөнгө оруулалтын бий болгодог улсууд.

Баялагийн үндэсний үзлийн хамгийн тод жишээ болох Болива болон Венуселын газрын тос, хийн салбар дахь хагас националчлал, Бүгд найрамдах, ардчилсан Конго дахь уул уурхайн салбарын гэрээ хэлэлцээр, Шэлл ба Сахалин-Шээрэг өөрийн ноогдол хувийг албадан худалдах төслүүд гол хэвлэлүүдээр өргөн нийтлэгдсэн баялагийн үндсэрхэг үзлийн жишээ юм. Гэвч дэлхий даяар баялагийн үндэсний үзлийн гэж болохоор бодлогын санаачлага, арга хэрэгслийн олон жишээ бий. Харьцангуй өдөр тутмын үзэгдлүүд дэх эдгээр хязгаарлалтууд нь хандлага болон бодлогын хариу үйлдлийн үнэн бодит байдлыг тайлбарлахад хангалтгүй гэдэг нь мэдээж. Үйлдвэрлэгч орнуудын баялагийн үндэсний үзэл нь илүү өргөн хүрээтэй байдаг.

Баялагийн үндэсний үзлийг хэрэгжүүлэх арга зам, хамрах хүрээ, чиглэл нь хэрхэн ялгаатайг харуулсан зарим боломжит арга хэрэгслүүдийн товч тойм:

- ❖ Өмнөх байгалийн баялагийн гэрээнд дахин хэлцэл хийх болон цуцлалт (Бүгд найрамдах, ардчилсан Конго болон Гвиней хэсгээс харна уу)
- ❖ Засаглалын зарим бүтэц тогтолцоог хэрэгсэхгүй болгох(бүтээгдэхүүний хувь хүртэх гэрээний адил) нь үйлдвэрлэгч орнуудад тийм ч тааламжтай байдаггүй. (Орос, Казакстан болон Ирак дахь түгээмэл үзэл санааны адилаар)
- ❖ Улсын мэдэлд авах (Болива ба Венесуэлд дах шиг)
- ❖ Олон улсын газрын тосны компанийн бүтээгдэхүүнийг бүрмөсөн хориглох(Саудын Араб) байгалийн баялагын хамтарсан үйлдвэр дэх улсын ноогдолд улам бүр хатуу чанд шаардлага тавих(Казакстан, Алжир, Орос) Зохицуулалтын хяналт, урьдчилсан арилжааны эрх мэдлийг зөвшөөрөл болон байгалийн баялагийн салбар дахь эзэмшил (Казакстан шиг)
- ❖ Баялагийн өндөр үнэтэй үеүдэд байгалийн баялагийн олборлолтын компаниудад төлөх ёстой татварын хэмжээг нэмэгдүүлэх (Болива, Венусел)
- ❖ Дотоодын хатуу чанга, албадлагын зохицуулалт (Нигер болон бусад олон улсууд)
- ❖ Байгалийн баялагын бүтээгдэхүүний экспортын хориг, хязгаарлалтууд(Аргентины 2006 оны үхрийн махны экспортын хориг болон хоол хүнсний үнийн хурдтай

өсөлтэй холбоотойгоор Вьетнам, Энэтхэг, Египэт, Камбожын цагаан будааны экспорт дэх хоригийн адил)

- ❖ Энергийн аюулгүй байдал, хоол хүнс, үндэсний аюулгүй байдалтай холбогдох орон нутаг дахь байгалийн баялагийн тодорхой заагдсан хувь хэмжээний нөөцлөлт
- ❖ Гол салбарууд дахь дотоодын шалгуурууд (Номхон далайн арлуудын туназагасны салбар¹⁰¹-ын жишээг харна уу)
- ❖ Дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэх, орон нутгууд дахь нийгмийн хөрөнгө оруулалтын янз бүрийн төслүүдэд хөрөнгө оруулах, эсвэл үндэсний хэмжээнд хөрөнгө оруулалт хийх зэргээр хөрөнгө оруулагчдыг нийгмийн шууд зарцуулалт дахь хандивыг нэмэгдүүлэхэд зориулах шаардлагууд (Казакстан; Нигерт санал болгосны адил)

Хөгжингүй орнуудад ч баялагийн үндэсний үзэл хүчтэй байдаг бөгөөд тэд үүнийгээ төдийлөн ярьдаггүй, мэдээлдэггүй. Эдийн засаг, хүний эрхийн асуудал дээр төвлөн үйл ажиллагаа явуулдаг PUBLIC EYE гэдэг олон улсын байгууллагын мэдээлсэнээр байгалийн баялаг ашигласанаас авах роялтибуюу ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээг дараах хүснэгтээр харьцуулан үзэе.

Улс, орнууд	Роялти - ашигт малтмалын нөөц ашигласаны төлбөрийн хувь хэмжээ
Австрали	30%
Филиппин	30%
АНУ	30%
Канад	25%

¹⁰¹Туназагаснысалбар дахь баялагийн үндэсний үзэл. Resource nationalism in the pacific tuna sector. In the Pacific Islands, the late 1980s and early 1990s saw a shift towards “resource nationalism” in the Pacific tuna fishing industry, motivated by the unsatisfactory outcomes of negotiations between coastal states and fishing states with superior bargaining power and skills. The 1982 UN Convention on the Law of the Sea had established an “exclusive economic zone” (EEZ) of 200 miles, giving coastal states increased territorial control over large areas. Pacific Islands hoped to benefit economically by charging access fees to fishing nations outside their new EEZs. But legal rights did not translate readily into negotiating might and hopes were frustrated both by the superior negotiating position of most distant water fishing nations (notably Japan) and by the initial refusal of the United States to recognise the Pacific island states’ claims to tuna in the exclusive economic zones due to the delay in ratification of UNCLOS III and on the basis that tuna are a migratory species (Schurman, 1998).

ОХУ	20%
Казахстан	15%
Монгол	5%

Эх сурвалж: presentation by Andreas Missbach“RPUBLIC EYE“ NGO

Баялагийн үндэсний үзэл түүхий эдийн үнэ ханш өсөж буй үед илүү өргөждөг. Энэ үед нөөц баялгийн экспорт нь тухайн орны хүн ам, улс төрчдийн дунд гадныханд ашиглуулаад байгаа мэдрэмж төрдөгтэй холбоотой. Уул уурхайгаас үүдсэн экологийн болон бусад сөрөг үр дагаварууд энэ хандлагыг нэмэгдүүлдэг. Баялгийн үндэсний үзэл нь нэг талаар тухайн орны улс төрчдийн дунд нэр хүнд, легитим чанараа өсгөх арга хэрэгсэл болдог байна. Хэрэв чадвал, баялгаа өөрсдөө боловсруулж ашиглах нь илүү ашигтай.

Баялагийн үндэсний үзэл нь бас өөрийн гэсэн эрсдэлтэй талуудтай:

1. Тухайн орны хөгжил, дэвшилд шаардлагатай төсөл хөтөлбөрийг зогсоох, гацаах, хугацаа алдах үзэгдэл бий болох;
2. Тухайн улс бие дааж өөрөө баялагаа ашиглах хөрөнгө мөнгө, техник технологи, маркетинг менежмент, олон улсын нэр хүнд ба бизнесийн сүлжээнд холбогдоогүй болон хүний нөөцийн чадавхи бүрдээгүй байх;
3. Хариуцлагатай уул уурхай хөгжүүлэх орон нутгийн өөрийн удирдлагын механизмыг хөгжүүлж төлөвшүүлээгүй байх;

Африкийн улсуудын макро эдийн засаг ба баялагийн үндэсний үзлийн өсөлт

Африкийн улсуудын макро эдийн засгийн байдал:

- ❖ Эдийн засгийн өсөлт бага, харилцан адилгүй, хоорондоо их ялгаатай;
- ❖ Хүн амын хэт ядуурал, өндөр ажилгүйдэл ихэнх орнуудыг хамарсан;
- ❖ Олонх орнуудын эдийн засгийн суурь нь баялагийн нөөц ашиглалт;
- ❖ Эдийн засгийн төрөлжилт багатай, ихэнх улсууд амиа аргацаасан натураль хөдөө аж ахуйд суурилдаг;
- ❖ Улсуудын валютын нөөц, дотоодын хөрөнгө оруулалтын хувь бага, гадаад өрийн дарамт ихтэй;

Африк дахь гадаадын шууд хөрөнгө оруулалт нь голдуу газрын тос, баялаг уул уурхай руу явж, эдийн засгийг улам өрөнд оруулж, иргэдийнх нь амьжиргааны түвшинг хүндрүүлэх үзэгдэл бий болгож байдаг. Эдгээр ерөнхий шинжүүдэд хийсэн судалгаагаар ОУ-ын байгууллагууд Африк ойрын 20-иод жилд хүндрэлээс гарч чадахгүй гэж үздэг.

Сүүлийн 60-аад жилд неоколониализмын бодлогод хэлмэгдсэн Африкийн орнуудад 2009 оноос баялагийн үндэсний үзлийн хандлага хүчтэй давалгаалж эхэлсэн. Африк тивийн засгийн газрууд гадаадын компаниудыг шахаж гаргах шинэ арга замыг хайж байна. Тухайлбал:

Гана: Бүх уул уурхайн гэрээнүүдийг хянаж үзээд дахин авч хэлэлцэхээр болсноо зарласан. Энэ нь уул уурхайн компаниудад оногдуулах татварыг 25%-аас 35%-аар нэмэгдүүлж, ихээхэн хэмжээний ашиг олсон тохиолдолд 10%-ын гэнэтийн ашгийн татвар болон одоогийн байгаа нөөцийг ашигласны төлбөрт гэж 5%-ын татвар ноогдуулахаар төлөвлөсөн байна.¹⁰²

Гвинея: 2008 оны 12-р сараас Гвинеин засгийн газар уул уурхайн гэрээг хянан шалгаж эхэлсэн байна. Гвинейд 2008 оны 12-р сард Ерөнхийлөгч Ласло Конте нас барсны дараа цэргийнхэний удирдлага хүчтэй болжээ. Блүүмбергийн мэдээгээр бол, уул уурхайн салбарт авлигын улмаас үүссэн одоо байгаа бүх гэрээ хэлэлцээрүүдийг хянан засварлах, цуцлах зорилго тавьсан байна. Гвинеин гадаад валютын орлогын 80 хувийг Рио Тинто, Алкоа, ВНР Billiton, United Co Rusal, Бокси зэрэг гадаадын хөрөнгө оруулагчид оруулдаг байна.¹⁰³ Гвинеин засгийн газардэлхийн хамгийн том хөнгөн цагааны болон төмрийн хүдрийн ордуудыг эзэмшдэг уул уурхайн төслүүдэд 15%-ын хувьцаа эзэмшиж, цаашдаа 20%-ыг нь худалдаж авахаар зорьж ажиллаж байна.

Намибия: Шинээр эхэлж буй бүх уул уурхай олборлолтуудыг улсын эзэмшлийн компаниудад шилжүүлэхээр шийдсэн.

Өмнөд Африкийн БНУ: Уул уурхайн “супер ашиг”-т 50%-ын гэнэтийн ашиг болон хайгуулын лицензээ зарахад 50%-ын хөрөнгийн орлогийн албан татвар ногдуулдаг. Уул уурхайн компаниудын цагаан арьст эздийг 2014 он гэхэд багадаа 26%-ын хувьцааг хар арьст хувьцаа эзэмшигчдэд зарахыг шаардсан. Үүнийг Африкийн Үндэсний Конгресс 30% хүртэл өсгө гэж зөвлөсөн. Гэсэн хэдий ч харуудын эзэмшиж буй хувьцаа дөнгөж 9%-тай байгаа бөгөөд эдгээр хувьцааны ихэнхийг засгийн газрын зээлсэн мөнгөөр худалдаж авсан. Тиймээс хожим асуудал болж магадгүй гэж үзэж байна.

Замби: Засгийн газар нь 2008 онд уул уурхайн татварыг өмнөх 31.7 хувиас 47 хувь хүртэл өсгөсөн арга хэмжээний багцыг танилцуулжээ. Уул уурхайн компаниуд сөрөг хариу өгсөн бөгөөд уул уурхайн хөрөнгө босгоход хэцүү тул зарим төслийг түр зогсоосон байна. Засгийн газраас 2009 оны нэгдүгээр сард уул уурхайн компаниудын ажлын байрны бууралт, дэлхийн металлын үнийн уналт зэргээс шалтгаалж шинэ татварын талаар татгалзах шийдвэр гаргасан байна.

Ардчилсан Конго: 2007 онд Бүгд Найрамдах Ардчилсан Конго улсын засгийн газар уул уурхайн гэрээг дахин хянан шалгахүүрэгтэй хариуцлагын комиссыг байгуулж,

¹⁰² Resource Nationalism. A Horizon Scanning Research Paper by The Resources Demand and Supply Resource Nationalism Community of Interest. Published December 2014.

¹⁰³ Guinea announces review of mining contracts. <http://en.ce.cn/World/biz/200812/29/>

нийтдээ 61 уул уурхайн ашиглалтад гэрээний шалгалт хийсэн байна. 1998-2003 оны иргэний дайны үеэр холбогдох гэрээнүүдийн дийлэнх хэсгийг байгуулсан байдаг. Уг комисс 2007 оны 10 дугаар сард дээрх гэрээнүүдийг хянан шалгаж үзсэн. Тэдгээр гэрээний товхимлынх нь товч хураангуйг хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацсан бөгөөд анхандаа нийтэд мэдээлээгүй юм. Конго болон олон улсын иргэний нийгмийн байгууллагуудын дарамт шахалтын дараа засгийн газар нь 2008 оны 3-р сард яам хоорондын комиссын эцсийн тайланг нийтэлжээ. 2008 оны 2-р сард Өмнөд Африкт болсон уул уурхайн томоохон хурал дээр Конгогийн уурхайн дэд сайд нар нь зарим өөрчлөлтийг хийх шаардлагатай гэж зарласан. 2008 оны 12-р сард гэрээг дахин хэлэлцэж дууссаны дараа удалгүй хэлэлцээр дууссаны дараа зургаан компани хэлэлцээ хийхээс татгалзсан байна. Сайд нар нь эхний ээлжинд Quantum, Banro, Anglo Gold Ashanti, Gold Fields, Mwana Africa болон FreeportMcMoran зэрэг компаниудтай хийх хэлэлцээрийг 45 хоногийн хугацаатай сунгасан байна.¹⁰⁴

Конго улс болон ард иргэд нь үндэстэн дамнасан корпорациудын уул уурхайн ашгаас шударгаар хувь хүртэхгүй байгаа талаар гомдол гаргаж, олон улсын төрийн бус байгууллагуудыг “Конгод шудрага хувь” уриан дор эвсэн нэгдэхийг уриалж байна. ОУ-ын ТББ-ын тайлбар: Гэрээнд “ард иргэдэд хувь хүртээх тухай тусгагдаагүй” байна гэж үзсэн.¹⁰⁵ Үндэстэн дамнасан корпорациудын тайлбарт: гэрээ нэгэнт хийгдсэн, хүчинтэй байгаа, эргэж харах шаардлагагүй гэж үздэг. Харин гэрээ ид хийгдэж байх үед Конгод иргэний дайн дэгдэж байсан учраас гэрээнд олон нийт төдийлөн ач холбогдол өгч чадаагүйгээс гэрээ өрөөсгөл болсон гэж баялагийн үндэсний үзэлтнүүд үздэг байна.¹⁰⁶

Зимбабве: Засгийн газрын “нутагших” гэдэг бодлогын хүрээнд гадаадын компаниудыг орон нутгийнханд 51%-ыг өгөх, хэрэв зөвшөөрөхгүй бол Зимбабвегээс гарч явахыг шаардах болсон. Зимбабве улс Рио Тинто, Англо Платинум, Зимдлат гэдэг 3 том уул уурхайн компаниас цагаан алтны нөөц ашиглалтын төлбөрийг 10% хүртэл нэмэгдүүлсэн төлбөр шаардаж, боловсруулаагүй цагаан алтыг экспортлохыг хориглосон. Мөн 2 тэрбумаас багагүй доллараар боловсруулах үйлдвэр барихыг шаардсан байна. Зимбабве улсын эрх баригч улс төрчид нь Африкийн орнуудын дундаас илүү их радикал

¹⁰⁴Mining contract review in the Democratic Republic of Congo. <http://www.humansecuritygateway.info>

¹⁰⁵ Mining contract review in the Democratic Republic of Congo. <http://www.humansecuritygateway.info>

¹⁰⁶Halina Ward. Resource nationalism and sustainable development: a primer and key issues. 2009. Halina Ward is an independent analyst on Business and Sustainable Development. From 2001-2008 she was Director of the Business and Sustainable Development Programme at the International Institute for Environment and Development. Halina is a non-practising solicitor, with an LLB and an LLM from the University of London. She can be contacted at halina@halinaward.co.uk.

өөрчлөлтийг шаардсан учраас үндэстэн дамнасан корпорациудын зүгээс “бойкот” тавьсан нь сүүлийн 10-аад жил үргэлжилж, энэ орны үндэсний валютын уналт, эдийн засгийн дампуурлыг хөөргөдсөнөөр тус оронд улс төр, эдийн засгийн хямрал нүүрлэхэд бэлэн болсон байна.

Олон улсын байгууллагууд “...баялагын нийгэмчлэлийн тухай янз бүрийн санаачлага, удирдагчдын байр суурь, түүнийг идэвхжүүлэгч хүчин зүйлс нь нийгэм эдийн засгийн судалгаа шинжилгээний дүгнэлтүүдтэй авцалдахгүй байгаа нь зөрчил үүсгэж байна”¹⁰⁷ гэж тайлбарладаг.

Африк дахь нийгэм, эдийн засгийн хөгжлийг сайжруулахын тулд дараах зорилтуудыг тавьж байна. Үүнд:

1. Африкийн орнуудын үндэсний удирдагчид эдийн засгийн хөгжил болон олон улсын зохицуулалтад онцгой анхаарч байна;
2. Африкийн орнууд нийслэл барилга, санхүүжилт, хөдөө аж ахуй, байгаль орчин, зах зээл, эдийн засгийг төрөлжүүлэх, захиргаа, хүний нөөцийн чиглэлээр гадныхантай хамтран ажиллаж байна;
3. Төр засаглалын механизмыг оновчтой болгох, төрийн алба, иргэний нийгмийн чадавхийг сайжруулах шаардлага тулгамдаж байна;

Хятад - Африкийн харилцаа

2006 онд Өмнөд Африкийн Йоханнесбургт Хятад-Африкийн хамтын ажиллагааны чуулга уулзалт (FOCAC) болж, Хятадын удирдагч Си Жиньпин болон Африкийн 40 гаруй улсын удирдагчид оролцож Хятад-Африкийн харилцааны ирээдүйн дөрвөн хандлагыг тодорхойлжээ. Үүнд:¹⁰⁸

Үйлдвэржүүлэлт: БНХАУ-ын хөрөнгө оруулалт, барилга, Африкийн аж үйлдвэрийн парк шинэчлэлт, Африкийн 200,000 мэргэжилтэн сургаж туслах, БНХАУ-д Африкийн суралцагчдад 40,000 квот олгох.

Аюулгүй байдал, цэргийн хамтын ажиллагаа: Африкийн холбооны армиудад санхүүгийн болон цэргийн тусламж үзүүлэх, Хятад, Африкийн аюулгүй байдлын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх хүрээнд терроризмын эсрэг хамтран тэмцэх гэх мэт.

Хэвлэл мэдээллийн хамтын ажиллагаа, боловсролын солилцоо: Африкт таван соёлын төв барих, жил бүр Хятадад Африкийн 200 эрдэмтэд айлчлах, 500 Африк оюутнуудад санхүүжилт олгох, Африкийн 10000 тосгонд хиймэл дагуулын телевизийн

¹⁰⁷ Withdrawal from international arbitration as a tool of resource nationalism.

<http://www.brettonwoodsproject.org>

¹⁰⁸ Friedrich Ebert Stiftung. Workshop Paper On China And Africa Relations With Special Focus On Extractive Industries. 2009. Supported by: Friedrich Ebert Foundation

хөтөлбөр бий болгох, Кунзийн институт байгуулах (одоогоор нийтдээ 69 Кунзийн анги танхим зохион байгуулагджээ);

Байгаль орчныг хамгаалах: Хятад улс, зэрлэг ан амьтан ба ургамлын аймгийн ховордсон төрөл зүйлийг хамгаалах талаар хууль сахиулах чадавхийг бэхжүүлэхэд хамтран ажиллах хэлэлцээр хийжээ.

Ийнхүү Хятад постколониализм нэрийн дор Африкийн нөөц баялагийг “зөөлөн хүчний” бодлогоор дамжуулан эзэмших зорилго тавьж байна. Ө/х, Хятадын бодлого өмнөхөөс нэг шат ахисан аргаар колоничлох буюу баялагийг эзэмших явдал. Энэ нь барууныханд таалагдахгүй байгаа юм.

Монгол дахь шинэ колоничлолын шинжүүд

Байгалийн нөөц баялаг бол аль ч улс орны нийгэм-эдийн засгийн хүч чадлын салшгүй нэг эх сурвалж төдийгүй үндэсний аюулгүй байдлын тулгамдсан чухал асуудлуудын нэг мөн. Монгол улс байгалийн нөөц баялагийн хэмжээгээр дэлхийн улс орнуудын дотор дээгүүрт багтдаг хэдий ч түүнийг үр ашигтай ашиглаж нөхөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх тал дээр хоцрогдолтой орны тоонд хамрагддаг. Тиймээс Монгол улсын хөрөнгө санхүүгийн дутмаг чадавхи, техник технологийн хөгжлийн доогуур төвшин нь гадаадын хөрөнгө оруулалтын асуудалд үндэсний эрх ашиг, сонирхлоо хамгаалсан баялгийн үндэсний үзэл санаа тэргүүн зэргийн хэрэгцээ болж байгаа билээ. Монгол улс 2009 онд 3 тэрбум \$-ын өртэй байсан бол МАН ба АН-ын засаглал ноёрхсон сүүлийн 7 жилд буюу 2016 он гэхэд нийтдээ гадаад өр нийтдээ 23 тэрбум \$ болж 21 тэрбумаар нэмэгдсэн бол, 2017 оны байдлаар 25 тэрбум \$-ын өртэй байгаа бөгөөд цаашдаа 2020 оноос өмнө ОУВС-гийн 5,2 тэрбум \$-ын зээл энэ өрийг 30 тэрбум \$-оос их болгох нь тодорхой болсон. Жон Адамс: “Улс үндэстэнг эзлэн авч боолчлох хоёр зам байдаг. Эхний зам бол зэвсгээр, харин хоёр дахь зам бол өрөнд унагах арга юм” гэжээ.

Ийм неоколониализмд автсан төрүүдийг судлаачид неопатримон буюу түрээсийн төр (Neopatrimonialism & Rent state) хэмээн нэрлэдэг.

- ❖ **Неопатримон төр** нь (Neopatrimon state) эрх баригч бүлэг төрийг хувийн эзэмшил өмч (патримониум) мэт ашиглаж, нийгмийн баялагийг төрөл төрөгсөд, ах дүү, хамаатан садан, найз нөхөд, нутаг дов жалганыхан болон тойрон хүрээлэгсэддээ түлхүү хуваарилдаг тогтолцоо юм.
- ❖ **Түрээсийн төр** (Rent state) эдийн засаг нь байгалийн нөөц баялагт тулгуурласан, үйлдвэрлэл хөгжөөгүй, хүн амын багахан цөөн хэсэг баялагийн ихэнхийг эзэмшдэг, засгийн газрын гол орлого, төсөв бүрдүүлэх арга нь

баялагаа ашиглуулсаны түрээсээс бүрддэг, улс төр нь тэрхүү гадаадынханы өгдөг түрээсийн орлогоос хараат тогтолцоо юм.

- ❖ **Неопатримон дэглэмийн үндсэн шинж** нь нийтийн захиргаа, улс төрийн хүрээ нь бизнесийн салбар болон хувирдаг бөгөөд өөрөөр хэлбэл, эдийн засгийн нөөцийг олж авах арга хэрэгсэл нь улс төрийн эрх мэдэл болж хувирдаг.

Дээрх шинжүүд Монголын төр, засаглалд түгээмэл илэрч байгаа бөгөөд неоколониализм ба неопатримониализмын ашиг сонирхлын нэгдэл болон тэдгээрийн дотоодын субъектууд дараах байдлаар ажиглагдаж байна. Үүнд:

1. **Неоколониализмийн бодлогын уриа:** Эдийн засгийн өндөр өсөлт бий болно. ДНБ-ийг гаргахдаа гадаадын хөрөнгө оруулагчдын орлого, зарлагыг нэмж гаргадаг. (жилийн 17%-ийн өсөлт гэх мэт)“Аливаа орны эдийн засгийг өсөхөд нь тусалбал, тухайн орны эрх мэдлийн тогтолцооны дээд хэсэгт нь байдаг цөөн хүн л баяждаг. Харин тогтолцооны хамгийн доод хэсэгт байгаа хүмүүсийн хувь тавилан бүүр ч хэцүү болдог.”¹⁰⁹
2. **Олон улсын банк санхүүгийн байгууллагуудын итгэл хүлээх:** Их хэмжээний зээлийг баялагийн хэмжээнд баримжаалан олгох эрхийг өгдөг. (Дубайн гэрээ гэх мэт)- “Бүх зүйлүүдийг хоёр дахин, гурав дахин, бүр дөрөв дахин урьдчилан тооцоолсон байдаг.”¹¹⁰“Өрийг хэзээ ч төлж барахгүй гэдэг бол анхнаасаа төлөвлөж байсан тэр төлөвлөгөөний л нэг хэсэг юм.”¹¹¹
3. **Улсын өр ихсэх:** Сүүлийн 9 жилд Монгол улсын гадаад өр 22 тэрбум \$-оор нэмэгдэж 25 тэрбум \$-т хүрсэн. (Оюутолгойн ашгийг 2037 оноос хүртэхэд 34%-

¹⁰⁹ЖонПеркинс. Эдийнзасгийнхөлсний алуурчнынаминчлал. УБ., 2011. Тал 36

¹¹⁰ЖонПеркинс. Эдийнзасгийнхөлсний алуурчнынаминчлал: Дэлхийн банк, Олон улсын Валютгийн сангийн ажилладаг арга бол маш энгийн. Тэд эхлээд тухайн улс орныг худалдагдсан эрх баригчдаар нь дамжуулж төлж чадахааргүй том өрөнд аажмаар бодлоготойгоор унагадаг, дараа нь энэ өрийнхөө хүүг, зарим хэсгийг төлүүлэх мөн ирээдүйд улам илүү их ашиг олохын тулд дахиад зээлүүд өгч эхэлдэг. Энэ бүхний эцэст улс орнууд өөрийн орны байгалийн баялаг, эрчим хүч, усан хангамж, бүр боловсрол, эрүүл мэндийн систем, шүүх засаглал, тэтгэвэр даатгалын системээ хүртэл гадаадын компаниудад хэлсэн үнээр нь худалдахаас өөр аргагүй байдалд ордог. Питер Ж. Мерола. Эрин цагийн дуудлага. УБ., 2011. Тал 119

¹¹¹ЖонПеркинс. Эдийн засгийн алуурчны наминчлал. - Энэ бүхэн тус улсын хэдхэн эрх баригчид, тэдний гар хөлийг баяжуулах ба мэдээж ихэнхийг нь манай компаниуд завшдаг. Энэ улс орны ихэнх хүмүүс зээлийн энэ мөнгөөр юу хийснийг мэдрэх ч үгүй өнгөрдөг. Ингээд бүтэл бүтэн улс орон, жирийн хүмүүс асар их өрөнд унаад л үлддэг. Энэ өр нь тухайн улс орны хувьд асар их учир түүнийг төлж хэзээ ч барахгүй юм.

ийнхаа өрөөр ашиг авахгүй байх, эцэст нь өртэй хоцрох магадлалтай)“...байгалийн их нөөцтэй, ...орныг сонгож Дэлхийн банкны нэрээр, эсвэл түүний олон байгууллагуудын нэгний нэрээр том мөнгө зээлээр өгдөг. Үнэндээ энэ мөнгө хэзээ ч энэ улсад орж ирдэггүй бөгөөд харин манай хэдэн том компаниуд энэ улсад том дэд бүтэц үйлдвэр завод, боомтууд барих нэрээр энэ мөнгийг хувааж хүртдэг.”¹¹²

4. **Эрх баригчид нь неоколониализмын гар хөл болох:** Колоничлолд автагдсан улс орнуудын улс төрийн дэглэм ямар байх нь шинэ колоничлогчдод огт хамаагүй. Гол нь өрөөр дамжуулан улс төр, эдийн засаг нь хянагддаг байх ёстой. “Зээлдэгч орны удирдагчид заавал мөнгөнд дуртай байх ёстой. ...Авлигаар ажлаа зохицуулж, санасандаа хүрдэг тогтолцоо зам дээр нь гэнэт авлигад автагддаггүй удирдагч гараад ирвэл түүнийг зайлуулдаг.”¹¹³
5. **Үндэсний эрх ашиг гээгдэх:** Эрх баригчдын шийдвэр үндэсний эрх ашгаа байнга зөрчиж, “амиа хорлох” шинжтэй болсон. Төрийн бодлого, шийдвэрүүд улс, үндэстэнийхээ эрх ашгаас урвасан, гадаадынханыг хамгаалсан шинжтэй гарч эхэлсэн. (Каплагийн хэрэг, Шинэчлэлийн засгийг унагах, Оюу толгойн мөнгийг Монгол банкаар дамжуулахыг татгалзах гэх мэт)
6. **Неоколониализмийг дэмжигч нийгмийн бүлгүүд бий болох:** Улс төр, бизнес, ажиллах хүчний түвшинд неоколониализмийг хүчтэй дэмжигчид бий болсон. (Авлигад автсан улс төрчид, өөрсдийгөө баялаг бүтээгчид хэмээн нэрлэдэг туслан гүйцэтгэгч компаниуд, өндөр цалинтай цөөн ажиллах хүч нь неоколониализмийг дэмжсэн хүч болж, тэднийг хамгаалсан сурталчилгаа явуулдаг болсон. Тухайлбал, “хөрөнгө оруулагчдын итгэл”-ийг алдлаа гэх мэтээр)
7. **Төр нь иргэдийнхээ эрх ашгийг хамгаалдаггүй:** Уул уурхай, лицензтэй холбоотой эрх баригчид, шийдвэр гаргагчдад “авлигын” төлбөр, түрээсээ төлсөн гадаадын голдуу хүмүүст хууль үйлчилдэггүй бөгөөд тэдний хууль бус үйлдлийг хууль, хүчний байгууллагууд хамгаалдаг. Эх орондоо иргэд нь хоёрдугаар зэргийн хүн болж, гадаадынхан болон тэдэнтэй хуйвалдагсад нэгдүгээр зэргийн хүн болдог. Энэ нь гүнзгийрвэл, Иранд болсон А.Хомейнигийн удирдсан хувьсгал шиг байдалд хүргэх магадлалтай.¹¹⁴

¹¹² Питер Ж. Мерола. Эринцагийндуудлага. УБ., 2011. Тал 118

¹¹³ Жон Перкинс. Эдийн засгийн хөлсний алуурчны наминчлал. УБ., 2011. Тал 136-137

¹¹⁴ 1978-1979 оны Ираны лалын хувьсгалын уриа, шүүмжлэлийн нэг бай нь “Иран хүн нохой хоёр орохыг хориглоно” гэсэн байдаг.

8. **Гадаадад хямд ажиллах хүч болох, цагаачлах:** Жирийн иргэд эх орондоо амьдралаа дээшлүүлэх боломжгүй болж, гадаадад ажиллах хүчнээр явах, цагаачлах, тэндхийн иргэн болох, “хар”-аар байсан ч эргэж ирэхгүй байх хандлага ихэссэн.
9. **Үндэсний үзэлтэн, эх орончдыг гутаан доромжлох:** Улс, үндэстэнийхээ эрх ашгийг хамгаалахаар тэмцсэн эх орончдыг “намнаж” эхэлдэг. Өөрөөр хэлбэл улс, үндэстэнийхээ эрх ашгийг хамгаалж дуугарсан улс төрчид, иргэний хөдөлгөөнийг популистууд, гацаагчид хэмээн адлах, гутаан доромжлох, улс төрөөс арчиж хаях үзэгдэл ихсэж байна.
10. **Эдийн засгийн тусгаар тогтнол алдагдах:** Эдийн засгийн хувьд бие даасан ямар ч төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх чадваргүй болдог. Шинэ колоничлогчдоос хамааралтай эдийн засгийн хараат байдал үргэлжилж, эдийн засаг үл солонгорно. Өөрөөр хэлбэл, өр төлөлтийн асуудлууд болон уул уурхайгаас хараат эдийн засагт бусад өөр өсөлт хөгжлийн боломжууд хязгаарлагддаг байна.
11. **Неоколониализмийн үр дагавар, хариуцлагыг хүчирхэг гүрнүүд хүлээдэггүй**¹¹⁵ бөгөөд ихэнхдээ тухайн орны төр, засаглал нь чадваргүй, авлигад идэгдсэн, сул доройгоос болсон¹¹⁶ гэж тайлбарлагддаг. Өөрөөр хэлбэл, үндэстэн дамнасан корпорациудын тарьсан балаг эзэн орны удирдагчдад хамаагүй мэт боловч шаардлага гарвал корпорациудынхаа эрх ашгийг хамгаалдаг.

Дүгнэлт:

Бидэнд хөгжлийн аль замыг сонгох вэ? гэдэг асуудал тулгарч байна. Онолын хувьд бид биеэ даасан бодлого хэрэгжүүлэх бүрэн эрхтэй тусгаар тогтносон улс. Үүнд:

1. Неоколониализм: Энэ хандлага эхэлчихсэн. (Үргэлжилбэл, Африкийн замаар орох магадлалтай, гэхдээ тусгаар тогтнол хадгалагдана.)

¹¹⁵Питер Ж. Мерола. Эринцагийндуудлага. УБ., 2011. Тал 121...Тагнуулын төв газрынажилтан Кермит Рузвельтын санаачлагаар Хувийн зөвлөхүүдийг Дэлхийн банк, Олон улсын валютын сан зэрэг байгууллагаар дамжуулан илгээж байхаар болсон юм. Над шиг хувийн зөвлөх компаниудад ажилладаг зөвлөхүүдийг иймэрхүү ажилд шатан оролцуулж хэрэв ямар нэг зүйл дээр баригдвал Засгийн газрын хувьд ямар нэг үр дагаваргүй өнгөрөх юм.

¹¹⁶Самуэл Пол. Засгийн газрын үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналт: Иргэний нийгмийн санаачлагаас суралцах нь /Төрийн захиргаа ба Ардчилсан засаглал: Иргэддээ үйлчилдэг засгийн газар. УБ., 2008.

2. Постколониализм: Бас эхэлж байна. (Үүнийг дагаж Хятадын зөөлөн хүчний бодлого хэрэгжиснээр ирээдүйд үндэстэний хувьд уусах, магадгүй эдийн засгийн тусгаар тогтнол, бие даасан байдлаа алдах ч аюул байна. Өөрөөр хэлбэл эдийн засаг урд хөршөөс хэт хамааралтай болж байна.)
3. Үндэсний эрх ашгаа хамгаалах: Ийм улс төрчдийн нэгдэл, төр засагт бүрдээгүй байна. (Хэрэв ийм засаг байгуулж чадлаа ч олон улсын түвшинд бие дааж хөгжих, улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын чадвар хүрэхгүй “утопи” байх магадлалтай.)
4. ОУБ-ууд, Эвсэл холбоонуудад нэгдэх: Энэ хандлагыг хэрэгжүүлэх оролдлогууд бий. ОУ-ын хамтын нийгэмлэгүүдийн бодлоготой үндэсний эрх ашгаа хамгаалсан бодлогыг уялдуулах боломж бүрдэж болох юм. (Энэ нөхцөлд ямар ч тохиолдолд парламентын засаглалыг хадгалж байх шаардлагатай болно.)
5. Байнга төвийг сахих: Энэ хандлага бас анхаарлын төвд орж ирсэн. Энэ нь их гүрнүүдийн хүчний тэнцвэр, улс төр, эдийн засгийн сонирхлын тэнцвэртэй байдлаас хамаарах бөгөөд тэнцвэр алдагдсан үед боломжгүй. Өөрөөр хэлбэл, хоёр хөрш хүсэхгүй бол боломжгүй.
6. Өөрийн хүч, нөөцөд тулгуурлах: Байгалийн баялаггүй улс оронд гадны нөлөөлөл, сонирхол бага байх бөгөөд энэ нь бие даасан бодлого хэрэгжүүлэх бодит боломж бүрдүүлэх магадлал өндөр байдаг. Тиймээс баялагаас хэт хамааралтай бус, олон салбарт эдийн засгийг бүрдүүлэх шаардлагатай юм.

Abstract:

Neocolonialism is a policy of developed states which tends to recognize independence and sovereignty of any poor nations, then, it sets to control political, economic and even cultural sphere of those nations in order to provide gain for them. In other words, it is a modern implementation of a policy review its political framework, and issued him a favorable decision through the international relations level of developed countries to least developed countries, a colonial government in their economies. In theory, small poor countries can be independent, but they also are not protecting national interests through international free and real (liberal and realistic) a political and economic relations that phenomenon is neocolonialism.

Ном зүй:

1. Жозеф Е Стиглиц. Дэлхийчлэл ба түүний сэтгэлд эс нийцэх нь. УБ., 2007. Мөн судар ХХК
2. Жон Перкинс. Эдийн засгийн хөлсний алуурчны наминчлал. УБ., 2011.
3. Питер Ж. Мерола. Эрин цагийн дуудлага. УБ., 2011.

4. Самуэл Пол. Засгийн газрын үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналт: Иргэний нийгмийн санаачлагаас суралцах нь /Төрийн захиргаа ба Ардчилсан засаглал: Иргэддээ үйлчилдэг засгийн газар. УБ., 2008.
5. Halina Ward. Resource nationalism and sustainable development:a primer and key issues. March 2009.
6. Resource Nationalism. A Horizon Scanning Research Paper by The Resources Demand and Supply Resource Nationalism Community of Interest. Published December 2014.
7. Miria Pigato and Wenxia Tang. China and Africa:Expanding Economic Ties in an Evolving Global Context. March 2015.
8. Thomas Waelde, Renegotiating acquired rights in the oil and gas industries: Industry and political cyclesmeet the rule of law, Journal of World Energy Law and Business, 2008, Vol 1 Number 1,
9. Guinea announces review of mining contracts. <http://en.ce.cn/World/biz/200812/29/>
10. Mining contract review in the Democratic Republic of Congo. www.humansecuritygateway.info

ҮНДСЭН ХУУЛЬ ҮЕЭ ӨНГӨРӨӨН ӨӨРЧЛӨГДДӨГ, ХАРИН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ОРШИН ТОГТНОСООР БАЙДАГ

Н. Бурмаа

МУИС-н ОУХНУС

Нийтийн удирдлагын тэнхимийн эрхлэгч, профессор

Түлхүүр үг: хяналт, санхүүгийн хяналт, бие даасан хараат бус хяналт, иргэдийн эрх ашгийн төлөө, төрийн эрх мэдлийн засаглал хуваарилалт, засаглалын эрх мэдэлд хязгаарлалт хийх, хянах хэрэгсэл, харилцан хяналт, эрх мэдлийг хязгаарлах үнэ цэнэтэй хэрэгсэл, хяналт баэрх мэдэл нь харилцан тэнцвэрээ хадгалах хууль, хариуцлага ба хяналт, “хяналт үгүй бол хариуцлага байхгүй, хариуцлага байхгүй бол хяналт үгүй”, хяналтын систем хянах, хянагдах объект, субъект, хяналтын хүрээ, хяналтын үйл ажиллагаа, хамрагдах хугацаа, хяналтын үр дүн, үр дагавар зэрэг олонлогийн элемент, удирдлагын шийдвэр, үр дүн, үр ашиг, хэрэгжүүлэлт, үр дүн, үр нөлөө, ашигт ажиллагаабол удирдлагын шийдвэр, шийдвэрийн хэрэгжилт болно.

Үндсэн хууль үеэ өнгөрөөн өөрчлөгддөг, харин санхүүгийн хяналт оршин тогтносоор байдаг¹¹⁷ гэж эрдэмтэн судлаачид тодорхойлсон нь бие даасан хараат бус төрийн санхүүгийн хяналтын ач холбогдлыг илэрхийлнэ. Эрдэмтэн Фон Арним: Төрийн санхүүгийн хяналтын онол нь үндсэн хуулийн мөн чанарыг илэрхийлэгч иргэдийн эрх ашгийн төлөө үйлчилдэгтэй нягт холбоотой¹¹⁸ гэжээ. Төрийн хяналт төрийн эрх мэдлийн засаглал хуваарилалт, засаглалын эрх мэдэлд хязгаарлалт хийх, хянах хэрэгсэл юм.

Хяналт, харилцан хяналт бол эрх мэдлийг хязгаарлах үнэ цэнэтэй хэрэгсэл бөгөөд “Хяналтгүй эрх мэдэл нь түрэмгийлэл, дарангуйлсан төрийн механизмын системийг аяндаа бий болгодог”¹¹⁹. Эрдэмтэн судлаачид **хяналт** бол “эрх мэдлийг” хязгаарлах “эрх мэдэл” ба харин эрх мэдлийг эзэгнэн эзэмшигч буюу өмчлөгч биш гэж тайлбарласан нь хяналтыг эрх мэдэлтэй адилтгаж үзэж болохгүй гэсэн үг юм.

Хяналт баэрх мэдэл нь харилцан тэнцвэрээ хадгалах хуулинд захирагдана. Хариуцлага ба хяналт нь хамтдаа нэгэн шугаман хамааралд зэрэгцэн оршдог тул хаана шийдвэр гаргах эрх мэдэл байна? тэнд хариуцлага ба хяналт заавал байх ёстой. “Хяналт үгүй бол хариуцлага байхгүй, хариуцлага байхгүй бол хяналт үгүй” онолыг эрдэмтэд дэвшүүлж

¹¹⁷Degenhart, Christoph: Төрийн санхүүгийн хяналт. Германы төрийн эрх зүйн нийгэмлэг. (55) 1996, х. 192. герман хэлнээс орч.

¹¹⁸Hans-Herbert von Arnim: Ардчилсан нийгэм дэх төрийн санхүүгийн хяналт. Berlin 1989. х. 43. герман хэлнээс орч.

¹¹⁹Brunner, Georg: Герман улс дахь хяналт. Koeln. 1972. х. 35. герман хэлнээс орч.

“Хяналт” бол “Хариуцлага” гэдэг ухагдахууны хувьд эрдэмтэд санал нэгддэг. Ардчилсан нийгэмд хяналтыг дараахи ерөнхий 4 төрөлд ангилж үздэг. Үүнд: Парламентын хяналт, шүүхийн хяналт, төрийн санхүүгийн хяналт, олон нийтийн хяналт. Эдгээр хяналтууд системийн ерөнхий онолоор харилцан үйлчлэл бүхий элементүүдийн багцын хангалттай шинж чанаруудыг агуулан тэнцвэрт байдлаа хадгалахын зэрэгцээ оршин тогтнол, аюулгүй байдлаа хадгалах хуулинд захирагдана. Тодруулбал хяналтын систем нь гадаад дотоод орчин, эрх зүй болон бусад зайлшгүй шаардлагатай хүчин зүйлсийн нөхцлөөр хамгаалагдсан байх шаардлагатай.

Ардчилсан төртэй улс орнуудад парламентын хяналт чухал байр суурийг эзэлдэг. Парламентын гүйцэтгэх олон үүрэг функцүүдийн нэг нь хяналт. Парламент төрийн эрх барих дээд байгууллагын хувьд хууль тогтоох эрх мэдлийг хадгалах бөгөөд хууль эрх зүйн хяналт, төрийн үндсэн бодлогын шийдвэр, үүрэг даалгаврын биелэлтэд хяналт тавих, төрийн санхүү, зээл, татвар мөнгөний бодлого, улсын төсөв, улсын эдийн засгийн хөгжлийн явцад хяналт тавих үүргийг хүлээдэг. Германы эрдэмтэн судлаачид төрийн хяналтыг ардчилсан нийгмийн төрийн эрх мэдэл, засаглал хуваарилалтын зарчимтай холбон тайлбарладаг. Айхенбергер „төрийн хяналт бол хянаж буй болон хянагдаж буй төрийн үйл ажиллагаа” гэжээ¹²⁰. Төрийн хяналт ардчилал, ардчиллын үндсэн зарчмуудтай салшгүй уялдаатай. Хяналт нь ардчилал хөгжсөн нийгэмд хүндтэй байр суурийг эзлэн төрийн эрх мэдлийн хүчнүүдийн засаглал хуваарилалт, төрийн удирдлага, сайн засаглалд илүү ойр орших ажээ.

Төрийн хяналт бол төрийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн удирдлагын үйл ажиллагааг хянах, дахин хянах тасралтгүй үйл явц. Хяналтыг хууль тогтоох байгууллагын-парламентын, гүйцэтгэх засаглал-засгийн газрын хяналт (дотоод хяналт), шүүх засаглал-шүүхийн, олон нийтийн гэж ерөнхийлөн ангилахаас гадна хянах гэж байгаа объект, субъект, зорилго, зорилт, агуулга, хамрах хүрээ, хэлбэр, үйл ажиллагааны онцлог, оронзай болон цаг хугацаанаас хамааруулан нарийвчлан ангилдаг. Эдгээрээс дүгнэхэд хяналтыг түүний үйл ажиллагааны үүрэг, даалгавар, үйлчлэх хүчин зүйлийн нэгдлээс цогц системт үйл ажиллагаа болгон авч үздэгийг илтгэж байна. Хяналтын тухай ойлголтыг авч үзэхдээ үгийнх нь үүсэл гарлын хувьд мэтгэлцэх бус “үйл ажиллагаа” гэдэг утгаар нь бие биетэйгээ холбоотой удирдлагын үйл ажиллагааны багц „систем“ гэж үзвэл илүү

¹²⁰ Eichenberger, Kurt: Эрх мэдэл ба хяналт. Эмхэтгэсэн Andreas Kohl. Wien 1979, х. 32. герман хэлнээс орч.

зохистой. Системийн тухай ерөнхий онол нь юмс үзэгдэл, үйл ажиллагааг зөвхөн нэг талаас бус олон талаас авч судалдаг тул хяналт бол „систем“ мөн¹²¹.

Хяналт “систем” мөн тул системийн ерөнхий онолоор харилцан үйлчлэл бүхий элементүүдийн багцын хангалттай шинж чанаруудыг агуулан тэнцвэрт байдлаа хадгалахын зэрэгцээ оршин тогтнол¹²², аюулгүй байдлаа хадгалах хуулинд захирагдана. Тодруулбал: удирдлагын шийдвэр, санхүү, нөөц, гадаад, дотоод орчин, эрх зүй, мэдээллийн технологи, дотоод хяналтаар удирдлагын үйл ажиллагааны багц системийн бүтцийг бүрэлдүүлэн бусад зайлшгүй шаардлагатай дэд системээр бүтцээ өргөжүүлдэг. Систем, түүний дэд системүүд харилцан уялдаа бүхий хамаарлын олонлогоор¹²³ хамгаалагдсан байна. Рейнэр Пичас: хяналт бол “үйл ажиллагаа”-г илүү тодорхой болгодог тул “үйл ажиллагааны” өөрийнх нь бүтцийн элемент гэжээ¹²⁴. Хяналтыг бүрдүүлэгч олонлог болон элементүүдийн нэгдэл хяналтын дэд систем болох бөгөөд дараах байдлаар ангилан авч үзэж болно.

Хяналтыг бүрдүүлэгч олонлог болон элементүүдийн нэгдэл хяналтын дэд систем болно. Хяналтын үйл ажиллагааг дараах ерөнхий үе шатуудаар ангилснаар түүнийг бүрдүүлэгч олонлог болон элементүүдийн талаарх ойлголтыг тодорхой болгоно. Хяналт хийх үйл ажиллагааны ерөнхий үе шатууд: 1. бэлтгэл үе шат ба төлөвлөлт 2. Хяналт 3. Үр дүн 4. Үр нөлөө, дахин буюу эргэн хяналт (feedback) гэж ангилна.

Нэгдүгээр үе шат: бэлтгэл үе ба төлөвлөлт

- хяналтын үйл ажиллагаанд бэлтгэнэ
- хяналт хийх багийг бүрдүүлнэ
- хянах үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөлтийг хийнэ
- хяналтын эрсдэлийг тооцно
- хяналт хийх объектын онцлог, цаг хугацааны хүчин зүйл буюу хяналтын эхлэх, үргэлжлэх, дуусах хугацааг тооцно.

Хоёрдугаар үе шат: хяналт

- хяналтын үйл ажиллагаа

¹²¹ Бурмаа Нацагийн: Төрийн аудит. Диссертаци. Muenchen 2009, х. 7. герман хэлнээс орч.

¹²² Болдсайхан Б: Системийн аюулгүй байдлын асуудлууд. Улаанбаатар 2008, х.19.

¹²³ Олонлог нь дэд системийг бүрэлдүүлэгч хэд хэдэн (төгсгөлөг болон төгсгөлгүй) "юмс" тодорхой шинж чанараараа нэгдсэн нэгдлийг хэлнэ.

¹²⁴ Pitschas, Rainer: Захиргааны хариуцлага ба захиргааны үйл ажиллагааны бүтцийн ээдрээтэй асуудлуудыг захиргааны эрх зүйн үүднээс шийдвэрлэх нь. Muenchen 1990, х. 392. герман хэлнээс орч.

- хяналтын үйл ажиллагаа төлөвлөлтийн дагуу хийгдэж буй эсэхийг хяналтын үйл ажиллагааны туршид байнга хянана
- үйл ажиллагааны гүйцэтгэлийг хянана
- хяналттай холбогдон гарах эрсдэлийг байнга хянаж байх
- төлөвлөгөө, гүйцэтгэл, ирээдүйд хүрэх үр дүнд харьцуулалт хийнэ
- хяналт, шинжилгээний үр дүнг задлан шинжилж нэгтгэнэ

Гуравдугаар үе шат: үр дүн

- тайлан, тайлагнал
- зөвлөгөө

Дөрөвдүгээр үе шат: үр нөлөө, дахин буюу эргэн хяналт (feedback)

- үр нөлөө
- дахин буюу эргэн хяналт (feedback).

Тухайн үйл ажиллагааны дараагийн түвшинд эдгээр үе шатууд давтагдсанаар хяналтын системийн “орчил эргэлт” бий болно. Хяналтын “систем”-г шинжилснээр уг системийг үнэлэх боломж бүрдэнэ. Системийн үнэлгээ нь харилцан үйлчилгээ хангалттай ба хангалтгүй системийн үйлчлэлийн үр дүн /дэд систем/, түүний зорилт хоорондын зохицлоор тодорхойлогдоно. Хэрэв систем өгөгдсөн зорилгыг гүйцэтгэж байвал хангалттай, чадахгүй бол хангалтгүй гэж үзнэ¹²⁵. Системийн шинжилгээ хийхдээ уг системийг бүрдүүлэгч дэд системийн зохицолдоо зорилтын дагуу хангалттай уялдаж буйг системийн дотоод хяналтаар давхар хянана¹²⁶. Системийн давхар хяналтаар эрсдэлийн нөлөөллөөс хамгаалагдан системийн бүтцийн олонлог, элементүүдийн харилцан үйлчлэлийн нөлөөлөл хэвийн бол системийн үйлчлэлийг хангалттай гэж үзнэ. Хэрэв системийг бүрэлдүүлэгч олонлог, элементүүдийн уялдаа эрсдэлээс хамгаалагдах чадваргүй, уялдаа зохицолдоогүй бол уг “систем” зорилго, зорилтоо биелүүлж чадахгүйд хүрч “систем” үйлчилгээ доголдоно. “Систем”-н нөлөөллийн хэвийн үйл ажиллагааг хангах, учир шалтгааныг тодорхойлох, ил тод байлгах зорилгоор эхлэл, явц, үр дүн, эргэх холбооны хяналтын аналитик шинжилгээг хийх нь уг системийн оршин тогтнох, аюулгүй байдлаа хадгалахад чиглэнэ. Системийн онолын хуулийн үйлчлэх зүй тогтол хяналтын системийн зорилго, зорилтоо биелүүлэхэд үйлчилнэ. Кребс: төрийн санхүүгийн хяналт санхүү, төсөв, төрийн бүхий л нөөцийн ашиглалт, зарцуулалт, хөрөнгө оруулалттай нягт

¹²⁵ Болдсайхан Б: Системийн аюулгүй байдлын асуудлууд. Улаанбаатар 2008, х.99.

¹²⁶ Бурмаа Нацагийн: Төрийн аудит. Диссертаци. Muenchen 2009, х. 8. герман хэлнээс орч.

уялдаатай¹²⁷ гэжээ. Төрийн хяналтын систем эрх зүй, төрийн удирдлага, санхүү, төр иргэний нийгмийн харилцаанд чухал үүргийг гүйцэтгэдэг. Петер Ховат: “Хяналт бол хаана алдаа гарч байна, түүнийг хэрхэн засаж залруулах, алдаа давтагдаж буй талаар удирдлагыг мэдээллээр хангагч удирдлагын дэд систем. Төрийн удирдлагын түвшний хяналт бол удирдлагад зөвлөгөө өгөх үйлчилгээ”¹²⁸ гэжээ. Хяналтын үйл ажиллагаа удирдлагаас гарах болон гаргасан шийдвэр, шийдвэрийн үр дүн, хариуцлагын тогтолцоонд чиглэгдэж байдаг. Төрийн хяналт төрийн үйл ажиллагааг ил тод байлгахад чухал үүргийг гүйцэтгэнэ. Төрийн үйл ажиллагаа, төрийн хяналтын тайлагнал иргэдэд ил тод байх нь ардчилсан нийгмийн зарчим. Товч дүгнэвээс төрийн хяналт нь төрийн үйл ажиллагааг ил тод байлгах нийгмийн мөн чанарыг хадгалдаг онцлогтой. Орчин үеийн төрийн санхүүгийн хяналтын хүрээ “хил хязгааргүй” зарчмыг баримталдаг тул төрийн хяналт хил хязгааргүй тасралтгүй үргэлжлэх үйл ажиллагаа юм.

Төрөөс гарч буй бүхий л шийдвэр парламентын хяналттай байхаас гадна парламентад суудалтай намуудын давхар хяналтын дор байдаг. Ардчилал, нийгэм эдийн засгийн хөгжлийн өндөр түвшинд хүрсэн улс орнуудад “цөөнхийн бүлэглэлийн нам” парламентын хяналтад идэвхитэй байр сууринаас ханддаг. Парламентаас гарсан шийдвэрийг гүйцэтгэх засаглал хэрэгжүүлэх үүргийг хир үр дүнтэй биелүүлж байгааг эргэн хянах үүрэг нь парламентын хяналтын эргэх холбооны давтамжаар дахин хянагддаг уламжлалтай. Төрийн эрх мэдлийн засаглал хуваарилалтын түвшинд парламент нь хяналтын байгууллага харин засгийн газар хяналтын объект юм.

Парламентын хяналт нь улс төрийн хяналт тул парламентын засаглалтай орнуудын дэвшилттэй давуу тал бөгөөд улс төрийн, намуудын, иргэний болон ард түмний төлөөллийг агуулсан хяналтын нэгэн систем мөн. Парламентын гүйцэтгэх үндсэн үүргийн нэг бол улсын төсөвийг батлах, гүйцэтгэлд нь хяналт тавих.

Хяналтын ухагдахууныг тодорхойлоход хамгийн багаар тооцоход 2 элемент буюу хүчин зүйлс шаардагдах бөгөөд харьцуулагдах шинж чанарыг хадгалсан байна. Хяналт нь “байх ёстой” эд баялаг, нөөц¹²⁹ эсвэл хүчин зүйлсийг “жинхэнэ буюу одоо байгаа”, эсвэл “ирээдүйд бий болгохоор төлөвлөсөн” эд баялаг, нөөц, хүчин зүйлстэй харьцуулсан үр дүн

¹²⁷ Krebs, Walter: Төрийн шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь хяналтын үүрэг. Төрийн санхүү, парламент болон шүүхийн хяналтад эрх зүйн талаас оруулсан хувь нэмэр. Heidelberg 1984, х. 4. герман хэлнээс орч.

¹²⁸ Horvath, Peter: Хяналт шалгалт. 9 дэх хэвлэл. Muenchen 2003, х. 233. герман хэлнээс орч.

¹²⁹ Төрийн санхүүгийн хяналтын элемент нь төсөв, санхүү, хөрөнгө оруулалт зэрэг өргөн ухагдахууныг агуулдаг тул хураангуйлсан нэрээр эд баялаг, нөөц хэмээн нэрлэсэн болно.

юм. “Жинхэнэ буюу одоо байгаа”, “байх ёстой”, “ирээдүйд бий болгох” эд баялаг, нөөц хүчин зүйлсийн харьцуулалтын үр дүн уялдах, өнгөрсөн, одоо, ирээдүйн цаг хугацааны шинж чанарыг хадгалсан байдаг. Харьцуулалтын үр дүн зорилгодоо хэрхэн хүрэх, хүрсэн эсэх, илүү үр дүнд хүрэхийн тулд ямар оновчтой арга хэмжээ авч ажиллавал зохистой вэ? гэдгийг тодорхойлдог. Товчоор хэлбэл төлөвлөсөн ба гүйцэтгэсэн үйл ажиллагааг харьцуулан ирээдүйд хүрэх зорилтыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тодорхойлно гэсэн утгатай. Энэ утгаараа хяналт Р.Пичас-н¹³⁰ “байх ёстой” мөн “жинхэнэ буюу одоо байгаа” болон “ирээдүйд бий болгохоор төлөвлөсөн” үйл ажиллагааны энгийн харьцуулалтаас эхлэх бөгөөд хянагдаж байгаа объект, хяналтын хүрээнд шалтгаалан үйл ажиллагааны үе шатууд хүрээгээ тэлэх, нарийвчлах шаардлага бий болдог. Хяналтын хүрээг тэлэх, нарийвчлах шаардлага тодорхой бус хүчин зүйлсийн нөлөөтэй холбоотой. Хяналтын систем хянах, хянагдах объект, субъект, хяналтын хүрээ, хяналтын үйл ажиллагаа, хамрагдах хугацаа, хяналтын үр дүн, үр дагавар зэрэг олонлогийн элементийг агуулан¹³¹ удирдлагын шийдвэрийг оновчтой болгоход чиглэгдэнэ. Үр дүн бол удирдлагын гаргасан шийдвэр, түүний гүйцэтгэлээр хэмжигдэх үзүүлэлт, харин үр дүнд чиглэсэн хяналт нь жинхэнэ болсон үйлдэл болон урьдчилан төлөвлөгдсөн үйл ажиллагааны тодорхой мэдээ, мэдээллийн харьцуулалтад үндэслэгдэнэ. Үр дүнтэй байх нь зорилгоо биелүүлэх хэмжигдэхүүн, удирдлагын шийдвэрийг төлөвлөсөн зорилгод хүргэхэд хэрэгжүүлэх хүний нөөцийн ур чадвар, санаачилга зонхилох байр суурийг эзэлнэ. Харин “үр ашиг”-т чиглэсэн хяналт бол хүрсэн үр дүнг тавьсан зорилгод харьцуулснаар тодорхойлогдоно. Тодруулбал удирдлагын шийдвэрийн зорилго, “хэрэгжүүлэлт” ба “үр дүн”-д чиглэсэн хяналтуудын нэгдэл. Хяналтын үр нөлөөг өргөн утгаар нь шийдвэрийн үр дүнгийн илрэл гэж үзэж болно. Үр нөлөө нь үр ашиг хэмээх ойлголттой салшгүй холбоотой. Үр нөлөө бол удирдлагын шийдвэр, шийдвэрийн хэрэгжилт болно.

Хяналтын объект удирдлагын¹³² шийдвэр, шийдвэрийн хэрэгжилт, үр дүнгийн агуулгыг нэгэн зэрэг багтаадаг. Хяналтын судлах зүйл бол хяналтын объект, субъект, үйлдэл, дүрэм журам, систем, зохион байгуулалт, үр дүн, үр ашиг, үр нөлөө юм. Хяналтын эцсийн

¹³⁰ Pitschas, Rainer: Захиргааны хариуцлага ба захиргааны үйл ажиллагааны бүтцийн ээдрээтэй асуудлуудыг захиргааны эрх зүйн үүднээс шийдвэрлэх нь. Muenchen 1990, х. 391. герман хэлнээс орч.

¹³¹ Karehnke, Helmut: Хяналт бол үндсэн хуулийн эрх зүйн нэмэлт функц мөн. Төрийн төсөв сэтгүүл. (16) 1975, х. 146. герман хэлнээс орч.

¹³² Удирдлага ойлголтыг төр, төрийн бус байгууллага, бизнесийн байгууллагын аль ч хүрээнд авч үзэх боломжтой.

зорилго бол удирдлагын үйл ажиллагаа, түүний үр дүн, үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэх, удирдлагын шийдвэрийг оновчтой болгоход оршино. Rehm¹³³-н онолоор үр ашгийг ашигт ажиллагаагаар илэрхийлж дараах байдлаар томъёолдог:

$$AA=(B-Z):(R-Z)$$

AA -ашигт ажиллагаа

B- “байх ёстой” хүчин зүйл

R- “одоо байгаа” хүчин зүйл

Z-зорилго

Үйл ажиллагааны ашигт ажиллагааг тооцсоноор удирдлагын үйл ажиллагааг илүү үр дүнтэй болгох, цаг үеэ олсон оновчтой арга хэмжээ авах, хариуцлагыг өндөржүүлэх боломжийг бий болгоно. Орчин цагийн хяналтын судлах зүйл төр, бизнесийн байгууллагын хамтын үйл ажиллагааны “бүтээгдэхүүн” юм. Бүтээгдэхүүн, үйлчилгээний ашигт ажиллагааг нийт бүтээгдэхүүн, үйлчилгээ болон түүний нэр төрөл тус бүрээр тооцож болно. Бүтээгдэхүүн, үйлчилгээнд удирдлагын бодлого шийдвэр бүрэн хэмжээгээр хамрагдана. Эдгээр үзүүлэлтийг тухайн үйл ажиллагааны түвшин бүрт тооцож болох ба төрийн оновчтой бодлого шийдвэрийн үр дүн, үр ашиг эдийн засгийн утга агуулгаараа нэг хүнд ноогдох үндэсний орлогын өсөлтөөр тодорхойлогддог. Удирдлагын үйл ажиллагаа боловсронгуй болох тусам түүнийг хянах хяналтын арга, технологи, хүрээ илүү боловсронгуй болж удирдлагаас гарах болон гаргасан шийдвэрт шинжилгээ, дүгнэлт хийх, оновчтой болгох зөвлөгөө өгдгөөрөө удирдлага, хяналт, судалгааны үйл ажиллагаа салшгүй холбоотой. Удирдлага, хяналт, шинжлэх ухааны судалгааны үйл ажиллагаа шугаман хамааралтай. Хяналтад хамрагдах объект, субъект, зорилго, төрөл, цаг хугацаа, хүрээнээс хамаарч хяналтын төрлүүд нарийвчлан ангилагддаг тухай дээр дурдсан. Хяналтын үйл ажиллагаанд хяналтын объект чухал байр суурийг эзэлнэ. Хяналтын объект бүр онцлог шинжийг агуулсан байна. Юрген Вебер¹³⁴ хяналтын объектыг:

1. Төлөвлөсөн зорилго, зорилт биелэгдсэн
2. Хууль ёсны дагуу ажилласан
3. Удирдлагаас гарсан шийдвэрийн дагуу ажилласан эсэх
4. Дүрэм журмыг мөрдөж ажилласан эсэх зэрэг ерөнхий чиглэлээр ангилсан.

Эдгээр ерөнхий чиглэл тухайн хяналтын объектын үйл ажиллагаа, үр дүнгийн онцлогоос шалтгаалан хяналтын дараагийн үе шатны мөчлөг буюу цаашид боловсронгуй болгох

¹³³ Rehm, Hannes: Төрийн байгууллага дахь арвилан хэмнэлт ба үр ашигтай ажиллагаа. Төрийн удирдлага сэтгүүл. (13) 1980, х. 87. герман хэлнээс орч.

¹³⁴ Weber, Juergen: Хяналтын тухай ойлголт. Stuttgart 1994, х. 153. герман хэлнээс орч.

системт үйл ажиллагаанд шилждэг тул хяналт нь аливаа зорилго, зорилтдоо хүрэх үйл ажиллагааны алхмуудыг боловсронгуй оновчтой болгох тасралтгүй үйл ажиллагаа.

Хяналтын ангилал хяналтын системийг бүрдүүлэгч чухал элементүүдийн нэг. Хяналтын ангиллыг хэрхэн зөв сонгосноос хяналтын үйл ажиллагааны үр дүн шалтгаална. Хянан шалгагч нарын ур чадвар, хариуцлага зэрэг нь хяналтын үр дүнд нөлөөлөх шууд хүчин зүйл юм. Хяналтыг хууль эрх зүйн, санхүүгийн, үр дүнгийн, гүйцэтгэлийн хэмээн ерөнхийлөн ангилдаг. Эдгээр ерөнхий ангилал хяналтын төрөл бүрт өөр өөрийн онцлог шинжийг хадгалдаг. Тодруулбал санхүүгийн, шүүх засаглалын, парламентын, олон нийтийн хяналтад хяналтын хэлбэрүүд тодорхой бие даасан онцлогийг хадгална. Хяналтыг амжилттай хэрэгжүүлснээр удирдлагын үйл ажиллагааны (бэлтгэх-төлөвлөх, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх, хяналт-хариуцлага) ямар үе шатанд эрсдэл гарсан тухай үнэлэлт дүгнэлт өгч цаашид хэрхэн алдагдсан боломжоо нөхөх, илүү үр дүнтэй ажиллах боломжийг бүрдүүлэх арга замыг нээх ач холбогдолтой. Хяналтын үр дүн, дүгнэлтэд үндэслэн удирдлагын үйл ажиллагааг шуурхай, уян хатан, оновчтой төлөвлөсөн зорилтдоо хүрэх боломжийг олгоно. Хууль эрх зүйн хяналт хууль эрх зүйн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж буйг хянадаг бол санхүүгийн хяналт тухайн хяналтын объектын санхүүгийн үйл ажиллагаанд үндэслэдэг. Үр дүнгийн хяналт тухайн шалгагдаж байгаа “үйл ажиллагаа”-ны гүйцэтгэлийн үр дүнд шинжилгээ хийнэ. Үр ашгийн хяналт эдийн засгийн үр ашигтай ажиллан хамгийн бага зардлаар хамгийн их үр дүнд хүрэх эсвэл өгөгдсөн зардлаар хамгийн боломжит үр дүнд хүрсэн эсэхийг хэмждэг. Эдийн засгийн үр ашигтай ажиллах, бага зардал гаргах зэрэг нь олон боломжит сонголтуудаас хамгийн хямдыг сонгох биш харин хамгийн илүү оновчтойг сонгох сонголт мөн. Хяналтын объект, хэлбэр хяналтын системийн бүрэлдэхүүн хэсгүүд мөн. Хяналт бие биенээсээ хараат бус үйл ажиллагааны нэгдлээс бүрдэх ба түүнийг бүрдүүлэгч элементүүд шууд ба шууд бус хамааралтай эсвэл хамааралгүй байж болно. Энэхүү хамаарал, үл хамаарлын уялдаа нь гадаад, дотоод орчны зохицуулалт, нөөцийн хуваарилалт, мэдээлэл технологи, тоон ба чанарын үзүүлэлтүүдийн онцлогоор зохицуулагдана.

Төрийн хяналт хэдий чинээ хараат байна тэр хэмжээгээр ардчиллын ил тод, шударга зарчим алдагдаж, төрийн хяналтын механизмын үйлчлэх хүрээ суларч хариуцлагын систем доголддог зүй тогтолтой. Энэ зүй тогтолцооноос урьдчилан сэргийлж ардчилалын түүхэн туршлага бүхий улс орнууд төрийн санхүүгийн хяналт, төрийн санхүүгийн хяналтын дээд байгууллагын үйл ажиллагааг хараат бус байлгахыг эрхэмлэн иржээ. Тэрчлэн төрийн санхүүгийн хяналт бол 4 дэгч засаглал хэмээх онолыг эрдэмтэд дэвшүүлсэн. Үндсэн хуулиар хамгаалагдаагүйгээр төрийн санхүүгийн хяналтын үйл

ажиллагааг явуулах нь үндсэн хуулийн эрх зүйг зөрчиж буйгаа асуудал мөн¹³⁵ хэмээн ХБНГУ-н нэр хүнд бүхий эрдэмтэд үзэл бодлоо илэрхийлсэн нь олонтаа.

ХБНГУ, Австри Франц зэрэг Европын холбооны улсууд үндсэн хуулиндаа Төрийн санхүүгийн хяналтын дээд байгууллагын бие даасан хараат бус байдлыг баталгаажуулаад зогсохгүй энэ байгууллагын удирдлага буюу “Гишүүд”-г шүүгчтэй адил эрхтэйгээр хараат бус үйл ажиллагаа явуулахыг үндсэн хуулиндаа хуульчилсан.

Төрийн санхүүгийн хяналттай холбоотой гарч ирж буй бэрхшээлтэй асуудлуудыг дан ганц Төрийн санхүүгийн хяналтын дээд байгууллагын үйл ажиллагаатай шууд холбож үзэх нь учир дутагдалтай ба улс төр, хууль эрх зүй, эдийн засаг, нийгмийн асуудлуудын хүрээнд цогцоор нь авч үзэх нь зүйтэй.

Судалгаанаас үзэхэд: Монгол Улсад мөрдөгдөж буй хууль тогтоомжуудад үүрэг хариуцлага гэхээсээ эрх мэдлийг илүү түлхүү анхаарсан зохицуулалттай байдаг. (Тухайлбал тухайн байгууллага, ажилтан үйл ажиллагаагаа гүйцэтгэхдээ **дараахи эрхийг эдэлнэ, эсвэл дараахи бүрэн эрхтэй** гэсэн хуулийн заалтууд байдаг нь нийтлэг). Хуулийг боловсруулан, батлахдаа аль болох хүлээх үүрэг, хариуцлага руу түлхүү хуульчилж өгөх шаардлагатай. Одоогоор мөрдөгдөж буй төрийн санхүүгийн хяналттай холбоотой хууль тогтоомжуудын зарим заалтууд утга агуулгын хувьд давтагдсан, давхардсан, зарим зохицуулалтууд нэг хуульд байгаа заалтыг тэр чигээр нь үг бүрчлэн хуулж хэрэглэсэн байдал нилээд байна. Хариуцлага болон хяналтын тогтолцоог сайжруулах, боловсронгуй болгох үүднээс хуулийн утгын давтамжийг тухайн салбарын хуулийн онцлогт зохицуулан үүрэг, хариуцлага чиглэл рүү нарийвчлан боловсруулж байх нь зүйтэй.

Төрийн хяналтын систем нь төрийн эрх зүй, төрийн удирдлага, төрийн санхүү, төр иргэний нийгмийн харилцаанд томоохон байр суурийг эзэлдэг. Энэ ухагдахуунаас үндэслэн эрдэмтэд¹³⁶ хэд хэдэн төрлийн хяналтын нэгдсэн нөлөөний тухай онолыг хөндөж гаргаж ирсэн бөгөөд үүнийгээ ардчилсан төрийн эрх зүйн хэв шинж хэмээсэн нь сонгодог утгаараа төрөл бүрийн хяналтаар мэргэшсэн хяналтын байгууллагууд хяналтын нөлөөгөө нэгэн зорилгод нэгтгэнэ гэсэн ойлголт юм.

Иймд манай улсад төрийн санхүүгийн хяналтыг бусад хяналтын байгууллагуудтай хамтран гүйцэтгэн хяналтын байгууллагуудын мэдээллийн нэгдсэн сүлжээг төрийн хяналтын үйл ажиллагаанд ашиглах бүрэн боломж бий. Манай улсын хувьд Үндэсний

¹³⁵ Stern, Klaus: Холбооны ба муж улсуудын ТСХДБ-н үндсэн хуулийн эрх зүйн орчинд эзлэх байр суурь. Wolfgang Boening/Albert von Mutius нарын эмхтгэл. Ардчилсан нийгэм дэх төрийн санхүүгийн хяналт. Heidelberg 1990, х 19. герман хэлнээс орч

¹³⁶ Baeumlin, Richard: Засгийн газар ба захиргааны удирдлагыг Парламентаас хянах нь. Швецари улсын хуульчдын нийгэмлэг. 1966, х. 165-180. герман хэлнээс орч.

Аудитын Газар, Мэргэжлийн хяналтын газар, Авилгатай тэмцэх газар, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар зэрэг байгууллагууд төрийн хяналтын үйл ажиллагаандаа мэдээллийн нэгдсэн сүлжээг бий болгох, хамтран ажиллах уялдааг маш тодорхой хариуцлагын механизмын ялгаа заагийн үндсэн дээр бий болгох боломжтой. Ийнхүү ажиллахдаа эрдэм шинжилгээ судалгааны байгууллагууд, олон нийтийн хяналтын байгууллагуудтай хүчээ нэгтгэн ажилласнаар төрийн санхүүгийн хяналтыг чангатган авилгатай тэмцэх үйл ажиллагаанд үнэтэй хувь нэмрээ оруулна. Ийнхүү ажиллахдаа хууль эрх зүйн орчинг боловсронгуй оновчтой болгох асуудал зайлшгүй.

✓ Үүний үр дүнд төрийн хяналтын үйл ажиллагаанд эрх мэдэл-хяналт хариуцлагын зохицолдооны тэнцвэртэй байдлыг тодорхой хэмжээнд хүргэх боломж бий. Хяналтын байгууллагуудын ажиллах цаг хугацаа, төсвийн хөрөнгө хэмнэгдэхээс гадна авилгаас урьдчилан сэргийлэн төрийн хяналтад үнэтэй хувь нэмэр оруулах юм.

✓ Үндэсний аудитын газар хувийн хэвшлийн аудитынхантай хамтран ажиллах үйл ажиллагаагаа цаашид улам боловсронгуй болгох нь зүйтэй. Төрийн байгууллагуудын хувьд хувийн хэвшлийн үйл ажиллагаанаас суралцах зүйл их байгаа бөгөөд (Public Private Partnership) буюу төр ба хувийн хэвшлийн түншлэлийг жинхэнэ утгаар нь хэрэгжүүлэх шаардлагатай.

✓ Монгол Улсад төрийн санхүүгийн хяналтаас ангид үлдэх “хяналт хийгдэхгүй томоохон чөлөөт орон зай” бий. Төрийн санхүүгийн хяналтын үйл ажиллагаанд “хил хязгаар” байх ёсгүй бөгөөд хяналтын гадна буй чөлөөт орон зайг төрийн хяналтад хамруулах асуудлын талаар хуульчлах асуудал зайлшгүй тулгарч байна.

✓ ТСХДБ-н үнэ цэнэ гэдэг утгаараа Үндэсний аудитын газар нь төр, иргэн бүрийн өмнө онцгой үүрэг, хариуцлага хүлээсэн байгууллага тул энэ байгууллага нь оюунлаг, мэдлэгийн байгууллага байх ёстой. Иймд ҮАГ эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран ажиллах нь зүйтэй.

✓ ҮАГ-н ажиллагсдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх асуудал бол зөвхөн энэ байгууллагын үүрэг зорилт биш бөгөөд төрийн нэгдсэн бодлогын хэмжээнд онцгойлон авч үзэх ёстой чухал асуудлын нэг юм.

✓ Монгол Улсад төрийн хяналт, төрийн санхүүгийн хяналтын сэдвээр эрдэм шинжилгээний ажлууд маш цөөн. Иймд төрийн хяналтыг хөгжүүлэх боловсронгуй болгох үүднээс төр, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагууд энэ асуудлаар тодорхой арга хэмжээ авах шаардлагатай.

✓ Хувийн хэвшлээс уламжлалтай үүссэн төрийн бүтээмжийн тухай онол практикийн асуудлууд чухлаар тавигдаж эхэллээ. Бүтээмжгүй, үрэлгэн төр ард иргэдээ хэрхэн сайхан амьдралаар хангаж чадах билээ. Төрийн байгууллагын шийдвэр гаргах түвшний чухал

орон тоонд мэргэжлийн бус хүмүүс ажиллуулах асуудал түгээмэл үзэгдэл болжээ. Мэргэжлийн бус хүмүүс нарийн мэргэшил шаардсан үйл ажиллагаанд алдаа гаргаснаар төсвийн хөрөнгийг зүй бусаар зарцуулах, алдаа, алдагдал гаргах эрсдэл өндөрсөж төсвийн алдагдал үүсэх үндсэн нөхцөл болж байгаа нь аюултай юм. Тааруу бэлтгэгдсэн төрийн албан хаагч төрд нэмэлт ачаалал болж байдаг. ҮАГ төрийн бүтээмж, төрийн захиргааны байгууллагын үр ашиг, үр нөлөө, төрийн албан хаагчдын бүтээмжид гүйцэтгэлийн аудит хийн дүгнэлт хийх зайлшгүй шаардлагатай байна. Төрийн бүтээмж, төрийн үр ашигтай үйл ажиллагааны илрэл болсон хөрөнгө оруулалтын хэлбэр төрлөөс үл хамааран

-хөрөнгө оруулалтын өгөөжийн үр ашгийн аудит хийх

-улсын өр төлбөрийн аудит хийх

-зохион байгуулалтын аудит хийх тэр дундаа ЗГ-н бүтэц зохион байгуулалтад орон тоо, чиг үүрэг функцийн давхардалд аудит хийх

-төрийн байгууллагуудын үнэ цэнэ, үр өгөөж, бүтээмжид аудит хийх

-байгаль орчин түүнийг дахин сэргээх үйл ажиллагааны аудит хийх асуудлууд чухлаар тавигдаж байна.

Бас нэгэн чухал асуудал бол ТСХДБ-н эрсдлийн талаар дурьдахгүй өнгөрч болохгүй юм. МУ-д мөрдөж буй холбогдох хуулиудын заалтын дагуу санхүүгийн тайлан гаргах, аудитын дүгнэлт тайлан гаргах цаг хугацаа нь хэтэрхий шахуу тул энэхүү богино хугацаад бэлтгэгдсэн санхүүгийн тайлан мэдээллийн уялдаа, үнэн зөв, үндэслэлтэй байдалд цаг хугацааны дарамтаас үүсэн гарах эрсдлийн харицлагыг хэн, ямар байгууллага, эрх мэдлийн хүч хүлээх вэ? зэрэг эгзэгтэй асуудлууд бүрхэг.

-Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд хэн үнэлэлт дүгнэлт өгөх вэ?

-Төрийн аудиторуд үйл ажиллагаа хир чанартай гүйцэтгэж байна вэ?

-ҮАГ-тай холбоотой санал гомдлыг ямар байгууллага хүлээн авч шийдвэрлэх вэ?

зэрэг төрийн санхүүгийн хяналтын эрсдэлтэй холбоотой асуудлууд “Төрийн аудитын тухай” хуулинд нээлттэй үлдсэн.

ҮАГ улс төр, эдийн засаг, нийгэм, иргэдийн ашиг сонирхлын үүднээс зөвхөн хууль тогтоох байгууллага болох УИХ-д тайлагнаад зогсохгүй Засгийн газар, Шүүх засаглалын байгууллагуудад болон Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд тайлагнадаг байхаар хуульчилвал төрийн сан, төсвийн хөрөнгө, хөрөнгө оруулалтын үр ашиг төрийн байгууллагын бүтээмж түүнд тавих хяналт сайжрахаас гадна эрх мэдлийн хүчнүүдийн хоорондын харилцан хяналт бий болно. Монгол Улсын төрийн хяналт, төрийн санхүүгийн хяналтын үйл ажиллагааг боловсронгуй болгон хөгжүүлэх нь иргэн бүрийн сайн сайхны төлөө оруулах хувь нэмэр, үнэ цэнэтэй бодлого бодитой хэрэгжин монгол хүн монгол

төрийн бодлогод итгэх итгэх, хүндэтгэл нэмэгдэнэ. Итгэх нь сайн хэрэг харин хянах нь илүү сайн үйлс мөн.

Abstract

Die Entwicklung und Durchsetzung der Finanzkontrolle ist eng mit der Staatslehre, den Politik- und den Finanzwissenschaften verbunden. Der Rechnungshof übt keine unmittelbar staatliche Gewalt aus¹³⁷. Trotz einem seit langen Jahren geführten Meinungsstreit ist die genaue Zuordnung des BRH¹³⁸ zum Funktionsrahmen einer der Gewalten oder als selbstständige „Vierte Gewalt“ in Deutschland bis heute nicht eindeutig beantwortet worden. Obwohl es also keine vollständig ausformulierte und allgemeine akzeptierte Theorie gibt, die man auf den Rechnungshof anwenden kann, ist es die Aufgabe der Verfassungstheorie, die Ziele des Grundgesetzes, die Akteure und die Entscheidungsverfahren zusammenzufügen, ihr Wirken zu erklären und zu begründen, Probleme und drohende Fehlentwicklungen aufzuzeigen und zugleich die Richtung zu weisen, in der mögliche Verbesserungen zu suchen sind¹³⁹. Grundsätzlich ist aber die Verwirklichung der demokratischen Funktion der Finanzkontrolle an eine klare Trennung der Gewalten gebunden. Generell sollten die Prinzipien und Fundamentalstrukturen der öffentlichen Finanzkontrolle in der Verfassung verdeutlicht sein und gleichzeitig sollte die Struktur in verstärktem Maße sichtbar angeordnet sein¹⁴⁰. Dies gilt auch für die Mongolei. Auf diese Weise wird das ganze System der Finanzkontrolle verknüpft. Das Besondere des Finanzkontrollsystems soll darin bestehen, dass die verschiedenen und nicht miteinander verbundenen Kontrollinstitutionen miteinander in Zusammenhang gesetzt werden, damit die ORKB¹⁴¹ zum zentralen Bezugspunkt des Finanzkontrollsystems werden kann. Durch die Zusammenarbeit der externen und internen Finanzkontrollinstanzen können das Finanzkontrollsystem und die einzelnen Finanzkontrollmechanismen effektiver auf das gesamte staatliche Finanzgebaren einwirken. So können die spezifischen Kontrollfunktionen der ORKB in der Praxis ermöglicht werden. Dafür braucht der MSAO eine verfassungsrechtliche Verstärkung der gegenseitigen Kontrollbasis, das heißt, eine „Kontrolle der Kontrolle“. Die Rolle der Kontrolle in der Gewaltenteilung ist vielseitig und geht über die Finanzkontrolle hinaus. Wenn die MSAO¹⁴² eine Verstärkung der vielseitigen Kontrollfunktionen in der Realität bekommen könnte, würde die Finanzkontrolle in der Mongolei durch die MSAO im

¹³⁷ Vgl. *Degenhart*, Kontrolle der Verwaltung durch Rechnungshöfe, VVDStRL 55 (1996), 193.

¹³⁸ Bundesrechnungshof.

¹³⁹ *von Arnim*, in: von Arnim (Hrsg.), Finanzkontrolle im Wandel, 1989, S. 40.

¹⁴⁰ Vgl. *Tiemann*, Die staatliche Stellung der Finanzkontrolle des Bundes, 1974, S. 213.

¹⁴¹ Oberste Rechnungskontrollbehörde.

¹⁴² Mongolian State Audit Organization.

demokratischen Sinne realisiert. In der jetzigen Situation ist die Trennung zwischen Legislative und Exekutive nicht vollständig verwirklicht, darunter leidet die wechselseitige Kontrolle. Für die Realisierung und Verwirklichung der demokratischen Finanzkontrolle sollten deshalb in der Mongolei ebenso neue Formen der Machtausgleichung, die der jetzigen Transformationsphase angepasst sind, angestrebt werden. Verfassungstheoretisch sind für den Status der Rechnungshöfe fünf Elemente charakteristisch: Die Unabhängigkeit ihres Handelns, die Öffentlichkeit ihrer Wirkungsmacht, die Lückenlosigkeit des Kontrollauftrags, die Kontrolle der Rationalität des staatlichen Finanzgebarens und das Fehlen rechtlicher Sanktionsbefugnisse¹⁴³. Die Finanzkontrolle spielt eine konstruktive Rolle in den Beziehungen der Kontrolle zwischen Trägern der Gewaltenteilung.

Ном зүй

- Aisha Ghaus-Pasha: Засаглалд иргэний нийгмийн байгууллагуудын гүйцэтгэх үүрэг. Төрийн захиргаа ба ардчилсан засаглал. Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр. Монгол Улс 2008.
- Altmann Joern; Burmaa Natsag; Keydel Martin: Монгол улсын ТСХДБ-н үйл ажиллагаанд хийсэн дүгнэлт тайлан. ХБНГУ-н эдийн засаг, хамтын ажиллагааны хөгжлийн яам. Bonn 2007.
- Baeumlin, Richard: Засгийн газар ба захиргааны удирдлагыг Парламентаас хянах нь. Швейцарийн хуульчдын нийгэмлэг. 1966.
- Bajohr, Stefan: Санхүүгийн хяналтын ирээдүйн төлөв. Удирдлагын архив. 91 Боть. 2000.
- Blomeyer, Ina-Marie: Төрийн санхүүгийн хяналтын дээд байгууллага ба авилгалтай тэмцэх нь. Докторын ажил. Aachen 1999.
- Brunner, Georg: Герман улс дахь хяналт. Koeln 1972.
- Degenhart, Christoph: Төрийн санхүүгийн хяналт. Германы төрийн эрх зүйн нийгэмлэг. (55) 1996.
- Eichenberger, Kurt: Эрх мэдэл ба хяналт. Andreas Kohl-ийн эмхэтгэл 1979.
- Fuchs, Arthur: Хяналтын тухай мэдлэг буюу түүний нөлөө. Tuebingen 1966.
- GOPAC. Controlling corruption: A Parliamentarian's Handbook. 2005.
- Grupp, Klaus: ХБНГУ-н Төрийн санхүүгийн хяналтын дээд байгууллага. Diss. Berlin 1972.

¹⁴³ Vgl. *Schulze-Fielitz*, Kontrolle der Verwaltung durch die Rechnungshöfe, VVDStRL (55) 1996, 237.

- Hans-Herbert von Arnim: Ардчилсан нийгэм дэх төрийн санхүүгийн хяналт. Berlin 1989.
- Horvath, Peter: Хяналт шалгалт. 9 дэх хэвлэл. Muenchen 2003.
- Jakobs-Woltering, Peter: Төрийн санхүүгийн хяналтын дээд байгууллагын хүний нөөцийг хөгжүүлэх, мэргэшүүлэх бодлого. Докторын ажил. Frankfurt am Main 1993.
- Karehnke, Helmut: Хяналт бол үндсэн хуулийн эрх зүйн нэмэлт функц мөн. Төрийн төсөв сэтгүүл. (16).
- Klippstein, Gerhard: Санхүүгийн хяналтад тулгарсан зарим ээдрээтэй асуудлууд. Докторын ажил. Mannheim 1972.
- Korthals, Gernot: Төрийн санхүүгийн хяналтын нөлөөллийн ирээдүй. Төрийн алба сэтгүүл № 14. 2002.
- Kratzer, Monika: Төрийн албан дахь сургалт ба давтан сургалт. Докторын ажил. Baden-Baden 1996.
- Krebs, Walter: Төрийн шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь хяналтын үүрэг. Төрийн санхүү, парламент болон шүүхийн хяналтад эрх зүйн талаас оруулсан хувь нэмэр. Heidelberg 1984.
- Lax, Catherina: Монгол Улс Азийн стратегийн хүчний талбар болох нь. Baden-Baden 1995.
- Meun, Karl-Ulrich: Хяналт бол үндсэн хуулийн эрх зүйн зарчим мөн. 2 хэвлэл. Baden-Baden 1982.

АРДЧИЛАЛ БА БОЛОВСРОЛЫН ХАРИЛЦАН ХАМААРЛЫН АСУУДАЛ

С.Базарпүрэв

*МУИС-ийн Улс төр судлалын
тэнхимийн профессор*

Б.Насанбат

*МУИС-ийн Улс төр судлалын
тэнхимийн докторант*

Түлхүүр үг: Ардчилал, боловсрол, боловсролыг ардчилах, ардчиллыг хөгжүүлэх

Товч утга: “Ардчилал” хэмээх энэхүү ойлголтыг улс төр, философи, эрх зүй, ёс зүйн гээд олон талаас нь тайлбарлаж болно. Энэ удаад бид уг ойлголтыг боловсролын үйл ажиллагаанд хамааруулан тайлбарлахыг зорьж байна. Үүний тулд прагматизм, тэр дундаа Ж.Дьюигийн үзэл санаа, арга зүйг удирдлага болгов. Ж.Дьюи бол ардчилал ба боловсролын харилцан хамаарлыг анхлан тайлбарласан сэтгэгчийн нэг бөгөөд боловсролыг ардчилах, боловсрол дахь ардчиллын үүрэг, ач холбогдлын талаар өгүүлсэн олон бүтээл бичиж үлдээсэн судлаач юм.

Тэрээр өөрөө өөртөө бүрэн найдаж, өөрийгөө авч явж чаддаг, үүрэг хариуцлага хүлээж чаддаг, эрх чөлөөтэй, нийгмийн идэвхтэй гишүүн хэрэгтэй юу? үгүй юу? хэмээх асуултыг ардчилал, боловсролын аль алинтай нь холбогдох асуулт мөн тул судлаачид үүнийг анхаарах хэрэгтэй хэмээн үзжээ. Түүний тайлбараар ийм иргэн хүн нь нийгэмд хэрэгтэй тул тэдгээрийг өөрт нь бүрэн итгэл хүлээлгэж, өөрийнх нь бие даасан байдлыг хүндэтгэж, тохирсон үүрэг, хариуцлага оноож, оюун санааны болон үйлдлийн эрх чөлөө олгосон сургалтын үйл ажиллагаагаар бий болгож чадна гэж үзжээ. Эндээс л боловсрол ба ардчиллын харилцан хамаарал эхэлдэг. Энэ утгаар ардчилал ба боловсролын харилцан хамаарлын асуудал нь орчин үед сургуулийг байр тоног төхөөрөмжөөр хангах, багшаар хангах, мөнгө санхүүгээр дэмжих тухай асуудлуудаас дутахааргүй үнэ цэнэтэй.

Оршил: "Ардчиллын тухай сэдэв бол Ж.Дьюигийн хувьд хамгийн их судалсан, олон зохиолдоо авч үзсэн асуудал юм"¹⁴⁴. Энэ тухай профессор Ц.Гомбосүрэн "Ж.Дьюи

¹⁴⁴Ryan, A. John Dewey and the high tide of American liberalism. NY., 1995. p.181.

олонх америкчуудын ярьдаг, боддогт ойр байсан хоёр санааг соргоогоор ашигласан байна. Эдгээр нь ардчилал, шинжлэх ухаан хоёрын тухай юм. Тэрээр ардчилсан нийгмийн шинжлэх ухааны философи бий болгохыг зорьсон байна" гэсэнтэй санал нийлж байна. Өөрөөр хэлбэл, Ж.Дьюи нь "Ардчиллын практик туршлага, зарчим, загварыг хэрэглэх бололцоог хайж, насан туршдаа боловсролын системд тэдгээрийг суулгах арга механизмыг олохыг хичээж байжээ"¹⁴⁵.

Ж.Дьюи боловсрол ба ардчиллын холбоо хамаарал гүн бат бөгөөд боловсролын тусламжтайгаар хүн төрөлхтөн ардчиллыг цаашид хөгжүүлэх хэрэгцээ, шаардлагыг даван туулж чадна гэж үзжээ. Түүний энэхүү оролдлогыг Х.Дэвид зэрэг судлаачид ихэд үнэлэн "Тэрээр хүмүүнлэг ертөнцийг бодит байлгахыг эрмэлздэг дэлхийн иргэний санаа сэтгэлийн үүднээс ардчилал ба боловсролын асуудлыг ярьсан"¹⁴⁶ гэж тэмдэглэсэн буйтай бид ч санал нэг байна.

Үндсэн хэсэг: Ж.Дьюи боловсролын түүхэнд анализ хийж боловсрол дахь ардчилсан үзэл санаа Платон, Ж.Руссо, И.Г.Песталоцци нарын үзэл санаагаар дамжин өнөө үед ирсэн болохыг тайлбарласан. Эдгээр философичдын үзэл санаанд хувь хүнийг эрхэмлэн дээдлэх үзэл, төр улсын бодлогын цөм нь иргэдийн хэрэгцээ сонирхол мөн хэмээн үздэг билээ.

Ардчилал нь нийгмийн эрэлт хэрэгцээ, эмх цэгц, аюулгүй байдлыг хангаж чадах нь уу, үгүй юу? гэсэн эргэлзээ, шүүмжлэл хаа сайгүй байдаг. Улс орнуудад буй болсон улс төрийн ардчиллыг нураах өч төчнөөн учир шалтгаан ч бий. Эдгээр нь ардчиллыг парламент, сонгууль, намуудын тэмцэл төдийхнөөр хязгаарлан ойлгодог хүмүүстэй холбоотой байдаг. Тиймээс бид ардчилсан сэтгэлгээ, амьдралын ардчилсан хэв маяг болон үйл ажиллагаа нь хувь хүний хувьд чухал ач холбогдолтой байдаг гэдгийг авч үзэх хэрэгтэй. "Ардчиллын бүх асуудлыг дахин эргэцүүлж, түүний ач холбогдлыг тунгаахаас илүү чухал зүйл байхгүй болов уу"¹⁴⁷. Ардчилсан үзэл санаа өөрөө сэтгэлгээ ба үйл ажиллагааны хамтын оролцоог заавал шаардаж байдаг тул нийгмийн институтууд, түүний дотор боловсролтой шууд холбогддог. Өргөн утгаар харвал боловсролын салбарын хөгжил бол нийгмийн хөгжлийн (ардчилсан үзэл санааны) чухал бүрэлдэхүүн юм.

Орчин үед ардчиллыг боловсролын суурь зарчим төдийгүй үр дүнг хэмжих шалгуур, хэрэгжих улс төрийн нөхцөл нь болох эхлэлийг Ж.Дьюи өөрийн үзлээр

¹⁴⁵ Ж.Энхбаяр. Ж.Дьюигийн боловсролын философийн үзэл баримтлал. Философи, эрх зүйн боловсрол.УБ.,2010. 127 дахь тал.

¹⁴⁶Т.Hansen. Reading democracy and education. Albany: State university of New York.,2006.p.4

¹⁴⁷Д.Дьюи. Реконструкция в философии. Проблемы человека. Москва.,2003. с.180.

эхлүүлсэн юм. Түүний тодорхойлж байснаар хүнийг хүмүүжүүлэх арга барилууд дотроос хамгийн хүмүүнлэг зарчим нь ардчилсан хандлага юм. Энэ хандлагын үүднээс хувь хүний боловсрол нь чөлөөт сэтгэлгээ, бие даасан хандлага, эрх чөлөөт байдал, үүрэг, хариуцлагаар тодорхойлогддог. Тиймээс аливаа сургалтын үйл явц хэрхэн явагдаж байна, тэнд ардчилсан хандлага байна уу? үгүй юу? гэдэг нь боловсролд ач холбогдолтой байгаад зогсохгүй, бас эцсийн үр дүндээ тухайн нийгмийн утга холбогдолтой. Ардчилсан амьдралын хэв маягийг сонгосон нийгмийн бүх ашиг сонирхол, үйл ажиллагаанд боловсрол дахь ардчилсан хандлага нөлөөлдөг.

Ж.Дьюи нь амьдрал, үйл ажиллагааныхаа явцад ардчиллын талаар олон янзаар тодорхойлолт өгчээ. Тэдгээрийн дотроос дараах гурван утга илүү тод илэрхийлэгдсэн байдаг. Үүнд: Нэгдүгээрт, ардчилал бол хүнийг хүндэтгэн үзэх замаар нийгмийг удирдах нэг арга юм. Нийгмийг удирдана гэдэг бол үндсэндээ тусгаар тусгаар хүмүүсийг удирдана гэсэн үг билээ. Ардчилсан нийгэмд хүмүүсийг удирдахдаа өөрөөс нь зөвшөөрөл авалгүйгээр, ашиг сонирхол хэрэгцээ, шаардлагыг нь асуухгүйгээр тэднийг төлөөлж, нийгмийн асуудлыг шийдвэрлэх боломжгүй. Иргэдийнхээ тулгамдсан асуудлыг тэдний оролцоогүйгээр олж тогтоож, шийдвэрлэх чадвартай "удирдагч хүн" байх ч боломжгүй.

Энэ талаар тэрээр ийм нэгэн жишээг дурдсан байдаг. Нэгэн эмэгтэй надад ингэж хэлж байсан юм. Тэр эмэгтэй нэр алдартай төрийн зүтгэлтнээс: Хэрэв та Бурхан тэнгэр байсан бол ард олныхоо төлөө та юу хийх байсан бэ? гэж асууж гэнэ. Тэр хариуд нь: Таны асуултад шууд хариулах амаргүй л дээ. Юуны түрүүнд би иргэддээ хандаж тэдэнд юу хэрэгцээ шаардлагатай байгааг асууна, дараа нь түүнийг нь өгөхийг оролдох байсан гэж хариулжээ. Эмэгтэй: Би танаас чухам ийм л хариулт хүлээж байлаа гэж хэлэхэд, төрийн зүтгэлтэн: Бусдад юу хэрэгтэй вэ? гэдгийг сонирхдог, тэгээд түүнийг нь өгөхийг оролддог тийм хүмүүс бас байдаг юм гэжээ.

Дээрх жишээ бол тухайн хүнээс өөр хэн ч (бурхан байлаа ч) тэр хүнд хэрэгцээтэй байгаа зүйлийг бүрэн мэдэж тодорхойлж чаддаггүй бөгөөд хүн бол өөртөө юу хэрэгтэй байгааг бүрэн тодорхойлж чадах субъект мөн гэдгийг нотлон харуулж байна. Өөрөөр хэлбэл, Хүн хичнээн харанхуй мэдлэггүй байсан ч түүнд бусдаас илүү их мэддэг тийм зүйл заавал байдаг, аливаа хүн нь шинжлэх ухааны мэдлэггүй ч гэсэн өөрт тулгамдсан асуудлыг сайн мэддэг (эсвэл зарим асуудалд сул дорой гэдгээ мэддэг) юм аа гэдгийг харгалзан үзэх ёстойг чухалчилжээ. Ардчиллын талаарх түүний дээрх санаа боловсролд хэрхэн холбогдох вэ? Үүнийг бид боловсролын үйл ажиллагаанд суралцагчийн оролцоо, үзэл бодол, сонголтыг харгалзан үзэх нь чухал хэмээн ойлгож болно. Түүнчлэн хүн бүрийн хэрэгцээ, шаардлага, хүсэл эрмэлзлэлийг мэдэж чадах "оюун ухаан" байх боломжгүй тул багш болон боловсролын байгууллагын удирдах ажилтнууд аль болох

суралцагчийнхаа хэрэгцээ, сонирхлыг судлахад анхаарлаа хандуулах хэрэгтэй байдаг. Энэхүү судалгаандаа үндэслэн сургалтын хөтөлбөрийг санал болгох, тэрхүү хөтөлбөрөө хэрэгжүүлэх үйл явцдаа мөн л ардчиллын үнэт зүйлсийг хэрэгжүүлэх замаар нийгэмд хувь нэмрээ оруулж чадах иргэн хүнийг өөрийнх нь сонголт, үйл ажиллагаагаар төлөвшүүлэх учиртай юм.

Хоёрдугаарт, "Ардчилал нь нийгмийг удирдах арга төдийгүй бас хүмүүсийн амьдрах хэв маяг мөн"¹⁴⁸. Энэ нь юу гэсэн үг вэ? гэхээр бид цаашид ардчилсан үзэл санааг хэрэгжүүлж, амьдрал ахуйдаа мөрдсөнөөр л хамтын амьдралаа үргэлжлүүлж чадна гэсэн үг юм. Ардчилал нь амьдралын хэв маяг болохынхоо хувьд хүн бүрийн бусад хүмүүстэй харилцах харилцааг зохицуулахад шаардлагатай хэм хэмжээ, хувь хүний бүрэн дүүрэн хөгжихөд боломж, нийгмийн нийтлэг сайн сайханд хэрэгтэй үнэт зүйлийг бий болгодог. Харин улс төрийн эрх мэдлийн хариуцлага, бүх нийтийн сонгох эрх болон давтамжтай сонгууль зэрэг нь ардчиллын оршин тогтнох арга хэлбэр нь юм. Нөгөө талаас, ардчиллын үйл явц бол хүмүүсийн амьдрал юм. Сонгууль, олонхийн санал, эрх мэдлийн хуваарилалт зэрэг нь бидний эцсийн зорилго биш ч гэлээ нийгмийн сайн сайхны төлөө гэдэг утгаар нь үнэлж дүгнэх хэрэгтэй болдог.

Ардчиллыг амьдралынхаа хэв маяг болгохын тулд юу хийх вэ? гэхээр боловсролын салбарыг ардчилах замаар нийгмийг сайн сайхнаар урагшуулах явдал юм. "Боловсролыг ардчилах" гэдэг нь Ж.Дьюигийн философид боловсролын удирдлага, зохион байгуулалт, арга зүй, агуулгад ардчиллын үнэт зүйлсийг хэрэгжүүлэх, суралцагчийг бие даасан хүн гэж үзэх тухай асуудал юм. Энэ тухай тэрээр "Боловсролын салбарын тусламжтайгаар бид ардчиллыг төлөвшүүлэх, хөгжүүлэх тал дээр амжилт олж чадна"¹⁴⁹ хэмээн үзэж, энэ үзлээ Америкийн нийгмийн амьдралд хэрэгжүүлсэн байна.

Тэрээр ардчиллыг хүмүүсийн амьдрах хэв маяг хэмээн үзэхдээ "хувь хүний эрх чөлөөт байдал"-ыг чухалчилж үзжээ. Түүний философид үйл ажиллагааны эрх чөлөө, оюун санааны эрх чөлөө гэсэн хоёр утга агуулга бий. Шүтэх эс шүтэх эрх чөлөө, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөө, хэвлэлийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн байгууллагын эрх чөлөө зэрэг нь үйл ажиллагааны эрх чөлөө бөгөөд тэдгээр нь хуулиар баталгаажсан байх ёстой. Харин тэдгээр эрх чөлөөг хэрэгжүүлж, хөгжүүлэхэд нь шаардлагатай чөлөөлөгдсөн оюун ухааны ач холбогдлыг үнэлэхгүй байж болохгүй. Нөгөө талаас, хүний эдэлж болох олон эрх чөлөөний үндсэн эрх чөлөө бол оюун санааны эрх чөлөө билээ. Оюун санааны

¹⁴⁸ J. Dewey. Democracy and Education. New York: Free Press. 1916. p.93.

¹⁴⁹ J. Dewey. Democracy and Education. New York: Free Press. 1916. p.138-144.

эрх чөлөө гэдэгт тэрээр чөлөөтэй сэтгэн бодох, шүүмжилт сэтгэлгээ зэргийг багтаан үзсэн байдаг.

Түүний үзлээр, "Эрх чөлөөний ардчилсан үзэл нь хувь хүн бүр хүссэн зүйлээ хийхийг хэлэхгүй. Харин бусдын яг адил тийм эрх чөлөөг зөрчихгүй байхаар хязгаарлагдах юм. Хувь хүний чөлөөт үйлдэл оюун ухаангүй, бас ухамсарлагдсан итгэл үнэмшилгүй бол эрх чөлөөг тунхаглах нь эргэлт буцалтгүй төөрөгдөл, эмх замбараагүй байдалд хүргэдэг"¹⁵⁰. Тиймээс бид эрх чөлөөг төөрөгдөл, эмх замбараагүй байдалд ашиглахгүй тулд нэгдсэн ойлголтод хүрэх нь чухал. Энэ ойлголтыг тунхаглаж бус, үйлдүүлж өөрөөр хэлбэл, залуу үед боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагааны явцад нь ойлгуулах нь хамгийн үр ашигтай юм.

Ж.Дьюигийн үзлээр, ардчиллын үндсэн зарчим нь эрх чөлөө, тэгш эрх, ахан дүүгийн барилдлагатай юм. Түүний үзлээр, эрх чөлөө нь бие хүн өөрийгөө ухамсарлахуйн зайлшгүй нөхцөл юм. Гэхдээ энэ нь хүн бусад хүмүүстэй бодитой, олон талт холбоотой болсон нөхцөлд л хэрэгжинэ. Ийм учраас ахан дүүгийн барилдлагын ардчилсан зарчим гэдгийг Ж.Дьюи бие хүмүүсийн хамтын ажиллагаа гэсэн утгаар ойлгож ирсэн". Мөн тэрээр хүн бүр тэгш эрхтэй бөгөөд чухамдаа энэ бол хуулийн өмнө тэгш байх, өөрийгөө ухамсарлахуйн бололцооны тэгш байдал гэж үзсэн. Түүний хувьд тэгш эрх нь хүн ёсны болон ардчиллын туйлын зорилго юм.

“Эрх чөлөө нь хувь хүн бол хамгийн дээд бөгөөд цорын ганц эрхэмлэл гэсэн ёс зүйн үзэл санааны илэрхийлэл бөгөөд ардчилсан үзэл санаа нь эрх чөлөөг өөртөө багтаадаг”¹⁵¹. Хувь хүн бүрт хувийн эхлэл оршин байдаг, хүн бүр өөрийн хөгжилд тус болохуйц тийм сонголтыг өөрөө хийх ёстой. Хувь хүний нийгмийн санаачлагад хандах хандлага, нийгэм-соёлын харилцаан дахь түүний эрх чөлөөний хэр хэмжээ нь нийгмийг хэр зэрэг ардчилсны илэрхийлэл болдог. Энэ утгаар ардчилсан нийгэм нь бие хүний хөгжлийг хангаж чадна.

Эрх чөлөөний тухай, ардчиллыг төлөвшүүлэх тухай дээрх санаагаа хэрэгжүүлэхийн тулд тэрээр боловсролын салбарыг өөрчлөн сайжруулах асуудалд анхаарлаа хандуулжээ. Ж.Дьюи тухайн үеийн уламжлалт боловсролыг шүүн шинжилж, хэд хэдэн алдаа дутагдлыг илрүүлж, засч өөрчлөх боломжуудыг дэвшүүлэн тавьсан байдаг. Түүний үзлээр, боловсролын салбарт суралцагчид зөвхөн төр нийгмийг анх байгуулсан үндэслэгчдийн үзэл санаа, хандлага, эрмэлзэлтэй танилцах биш, харин өнөөгийн нөхцөл байдал дахь ардчилсан нийгмийн мөн чанар юу юм бэ? гэдгийг ойлгуулах тийм шинэчлэл

¹⁵⁰ Д.Дьюи. Реконструкция в философии. Проблемы человека. Москва.2003. с.176.

¹⁵¹ Д.Дьюи. Этика демократии. Полис. Москва.,1994. №3. с.30

хэрэгтэй байсан. Үүний тулд сургалтанд ардчилсан арга, хандлагуудыг нэвтрүүлэх, сургуулийн орчныг ардчилах, ардчиллын соёлд залуу үеэ сургахад онцгой анхаарах хэрэгтэй гэж үзжээ.

Өөрөөр хэлбэл, боловсрол дахь ардчилалтай холбогдуулан суралцагчдад юуг, яаж сурахаа сонгох эрх чөлөөг олгох нь ч гарцаагүй зүйл мөн. Суралцагч нь өөрийн сонирхол, хэрэгцээ, шаардлагын үүднээс боловсролын үйлчилгээ авах (арга, хэлбэрээ өөрөө сонгох) эрхтэй билээ. Хүн бүр чадлынхаа хэрээр боловсрол эзэмших эрхтэй. Гол нь туршлага солилцох энэ үйл ажиллагааны явцад суралцагч мэдлэгийг эрэл хайгуулын үр дүнд олж авах нь чухал. Туршлагаар олж авсан мэдлэг нь тухайн хүний өдөр тутмын амьдралд хэрэгжиж, зан чанарт нь хадгалагдаж байдаг. Тиймээс суралцагчийн сонирхлыг багш судалж, аль болох амьдралтай холбосон арга зүйгээр сургалтыг зохион байгуулах нь чухал болоод байна.

Гэхдээ Ж.Дьюи хязгааргүй эрх чөлөөг зөвшөөрөөгүй. Түүний үзлээр "эрх чөлөөтэй байна" гэдэг бол хязгаарыг устгана гэсэн үг биш. Хүүхэд сургалтын явцад эрх чөлөөтэй байж, хичээлийн явцад бие даасан судалгаа өрнүүлж, өөрчлөгдөн буй энэ нийгмийнхээ өөр өөр олон нөхцөлд шийдвэр гаргаж сурах чадварыг сургуулийн үйл ажиллагаанаас олж авах боломжтой байх ёстой. Өөрөөр хэлбэл "Хүүхдэд оюуны эрх чөлөө зайлшгүй хэрэгтэй, түүнийг олгох ёстой юм" хэмээн тэрээр үзсэн.

Ж.Дьюигийн хэлсэнчлэн хүүхдийн хүмүүжилд бие махбодын болон нийгмийн эрх чөлөө чухал. Өнөө үеийн зарим эцэг, эх эдгээр эрх чөлөөг хүүхэддээ хэтрүүлэн олгодог бол зарим нь хүүхдээ "сургах" нэрээр олон зүйлд дарж орхидог. Ингэхдээ хүүхдийнхээ сонирхол, авьяасыг харгалзан үзэхгүй бол хэдий олон төрлийн сургалт байгаад ч үр дүнд хүрэхгүй. Сонирхол, авьяасаас гадна тухайн хүүхэд суралцахуйн зорилгоо өөрөө шийдэх, өөрөөр хэлбэл тухайн нэг чиглэлээр суралцах гэж байгаа бол хүүхэд өөрөө шийдвэрт хүрэх нь чухал гэсэн үг. Энэ талаар Ж.Дьюи "Ардчилсан үзэл номлол, арга зүйг сургуулиудад хэрэгжүүлэхдээ нухацтай, хянуур, бас эрч хүчтэйгээр хандаж улс орны хүүхэд залуусыг эрх чөлөөний үзэл санаагаар хүмүүжүүлж, эрх чөлөөт нийгэмд бэлтгэх ёстой билээ"¹⁵² хэмээн тэмдэглэжээ.

Гуравдугаарт, Ардчилал нь эрх мэдлийг болон хууль тогтоох, удирдлагын хэрэгжилтийг удирдан зохицуулах гэдгээс илүү өргөн хүрээтэй ойлголт юм. "Ардчилал бол хувь хүний үнэт зүйл, ёс суртахууны эрхэм чанар юм. Ардчилал бол харилцан хүндэтгэх, тэвчин хүлцэх, хүлээн авч бас өгч чадах, бүрэн утгаар илэрхийлбэл туршлагаа

¹⁵²Д.Дьюи. Реконструкция в философии. Проблемы человека. Москва.2003. с.157.

харилцан солилцох цорын ганц боломжит (үр ашигтай) арга юм"¹⁵³. Ардчилал бол орчин үеийн ёс суртахууны харилцааны хэлбэр юм.

Энэ мэтээр ардчилал ба боловсролын холбоо хамаарал гүн гүнзгий бөгөөд нийгмийн хэрэгцээнээс үүдэлтэй болох нь ажиглагдаж байна. Энэ бүхнээс үзэхэд манай улсад боловсрол дахь ардчилсан үзэл, хандлагыг хөгжүүлэх нь чухал байна. Энэ нь зөвхөн суралцагчийн эрхийн асуудал биш бөгөөд илүү гүн харвал (Ж.Дьюигийн тодорхойлсноор) "суралцагч энэ эрхээ эдлэх замаар улс орноо хөгжүүлэх үүрэг хүлээж байдаг юм". Энэ тухай Ж.Дьюи, боловсрол дахь ардчилсан үзэл, хандлагыг нэмэгдүүлэх нь "Ардчилсан нийгмийн иргэн, хувь хүн гэдэг утгаараа бид чухам юу хүсэж байна, бидэнд ямар асуудал байна вэ? гэдгийг өөрсдөө эргэцүүлэн бодох үүрэгтэй болгож байдаг" гэжээ.

Ж.Дьюи ардчиллын талаар бас нэгэн бодууштай санаа дэвшүүлсэн нь ардчиллыг ойлгох бидний буруу ойлголтын тухай юм. Тэрээр "Бид ардчиллыг хэрэглэхэд зориулагдсан учраас аль хэдийн байгуулагдчихсан гэж бодоод сурчихжээ. Ардчиллыг ямар нэгэн тийм тогтвортой зүйл бөгөөд хэн нэгнээс өвлөгдөн уламжлагддаг мэтээр ойлгож байна. Угтаа үе үеийн хүн ард ардчиллыг үргэлж өөрсдөө бүтээж байх учиртай" гэжээ. Энэ нь манай улсын өнөөгийн байдлыг хэлсэн гэлтэй. Монголчууд бид ардчилсан хөгжлийн замаар замнаад 30-аад жил болж байгаа боловч ардчиллыг төлөвшүүлэх, боловсролыг ардчилах тал дээр анхаарч ажиллах шаардлагатай байна. Учир нь ардчилал мөн чанарынхаа хувьд хүнээс хүнд, үеэс үед уламжлагддаг зүйл биш бөгөөд харин тухайн нийгэмд амьдарч байгаа хүмүүсийн хэрэгцээ, асуудал, нийгмийн амьдралын нөхцөл байдлаас шалтгаалан ардчиллыг үргэлж шинээр бүтээж байх учиртай билээ.

Ж.Дьюигийн хэлсэнчлэн "Бидэнд агуу их үнэт өв, уламжлал үлдсэн байлаа ч тэдгээр уламжлалын үр шимийг бид амсахын тулд өөрсдөө идэвх чармайлт гаргах ёстой юм". Ардчилал нь яг энэ үед амьдарч буй хүмүүсийн идэвхтэй үйл ажиллагааны тусламжтайгаар орчин үеийн нийгмийн харилцаанд нэвтрэн орох боломжтой. Хүн бүрт оюун ухаан адил түвшинд заяадаггүй ч ардчилсан ертөнцийг үзэх үзлийг илүү ерөнхий утгаар нь авч үзэх юм бол ардчилал бүх хүмүүсийн оролцоогоор бүтсэн хамтын оюун ухааны бүтээгдэхүүн бөгөөд хүн бүр өөрийн гэсэн хувь нэмрээ оруулах бололцоотой. Энэхүү хувь нэмрийг зөвхөн хувь хүний оролцоогоор нь л үнэлж болох юм. Авторитар үзэлтнүүд хувь хүний нийгэмд оруулах хувь нэмрийг ямар нэг бэлэн зарчмын шалгуураар (нийгмийн гарал, арьс өнгө, санхүүгийн байдал, нийгэмд эзлэх байр суурь, эрэмбэ, нийгмийн давхраажилт зэргээр) үнэлдэг бол ардчилсан нийгэмд ийм зүйл байдаггүй.

¹⁵³Д.Дьюи. Реконструкция в философии. Проблемы человека. Москва.2003. с.165.

Дүгнэлт: Ардчилал бол ерөөс амархан хүлээгээд авчихдаг, бас амархан дагаад явж болдог тийм зам мөр биш юм. Өнөөгийн нийгэм дэх нарийн нөхцөл байдал дээр авч үзэх юм бол энэ зам мөр бол хамгийн амаргүй нь юм. Ардчилсан хөгжлийн замаар иргэддээ илүү чанартай амьдралыг бий болгосон улс орнууд нь бидэнд энэ арга зам үр дүнтэй байж болдог юм аа гэдгийг харуулдаг. Гэсэн хэдий ч бид сохроор биш, ухаалгаар тэдгээр улсуудаас суралцах хэрэгтэй. Монголын ардчиллыг цааш төлөвшүүлэхийн тулд бид боловсрол дахь ардчиллыг хөгжүүлэх өөрөөр хэлбэл, боловсролыг ардчилах замаар нийгэмдээ хувь нэмрээ оруулж чадах иргэдийг бэлтгэмээр байна. Ардчиллын үнэт зүйлс болох эрх чөлөө, тэгш байдал, шударга ёс, хувь хүний эрхэм чанар, хамтын хариуцлага, зөвшилцөл зэргийг багш нар хичээл заах арга барилдаа нэвтрүүлснээр боловсролын шинэчлэл илүү үр ашигтай байх болно.

Abstract: All human societies, past and present, have had a vested interest in education; and some wits have claimed that teaching (at its best an educational activity) is the second oldest profession. This article provides on the intimate relationship between democracy and education. In a democracy, education is given primacy, for it is pre-requisite for the survival and success of the former. Similarly, education fosters a democratic temper in the minds of people. Democratic values like liberty, equality, fraternity justice, dignity of individual, co-operation, sharing of responsibility etc. are applied to education to make it more effective, meaningful, relevant and useful...If democracy is about freedom of choice, equity and justice, then education is a precondition for democracy.

Ном зүй

1. A.Ryan. John Dewey and the high tide of American liberalism. NY., 1995.
2. Ж.Энхбаяр. Ж.Дьюигийн боловсролын философийн үзэл баримтлал. Философи, эрх зүйн
3. боловсрол. 2010.
4. T.Hansen. Reading democracy and education. Albany: State university of New York.2006.
5. Д.Дьюи. Реконструкция в философии. Проблемы человека. Москва.2003.
6. Д.Дьюи. Этика демократии. Полис. Москва.,1994. №3.
7. J. Dewey. Democracy and Education. New York: Free Press.1916.

ШУУД АРДЧИЛЛЫН ХЭЛБЭРҮҮД: ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Д. Бумдарь

*МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар,
Улс төр судлалын тэнхимийн дэд профессор, Доктор*

С. Оюунбилэг

*МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар,
Улс төр судлалын тэнхимийн докторант*

Түлхүүр үг: *шууд ардчилал, referendum, plebiscite, popular vote, initiative, recall*

Оршил

Орчин үед системийн хямрал нь эдийн засаг, улс төрийн томоохон хямралаас үүдэлтэйгээр бий болж байна. Хямрал хэдий чинээ том байна төдий чинээ нийгэмд үзүүлэх нөлөөлөл нь өргөн хүрээтэй явагддаг. Тухайлбал 2008 оны Америкийн арилжааны банк дампуурч “Lihman shock” болоход нэг улсын хэмжээнд бус дэлхийг хамарсан эдийн засгийн хямралыг үүсгэсэн. Эдийн засгийн хямрал нь улс төрийн тогтворгүй байдлыг бий болгох үндсэн нөхцөл болох талтай. Учир нь ажилгүйдэл, мөнгөний уналт зэрэг нь иргэдийн амьжиргааг доошлуулж засаглалд итгэл үзүүлэх байдал нь сулардаг.

Хэрвээ энэхүү байдал даамжирваас дахин сонгууль явуулахыг шаардах зэрэг улс төрийн тогтворгүй байдал уруу шилжих аюултай. Нөгөө талаас нөхцөл байдлыг сайжруулахыг зорьсон улс төрийн шийдвэрүүд эдийн засгийн хямралыг улам даамжруулах тал ч бий. Тиймээс системийн хямрал удаан үргэлжлэх аваас нийгмийн зүгээс хариуцлага шаардаж эхэлдэг. Тухайлбал шинэ тогтолцоо, реформ, бүтцийн өөрчлөлт зэргийг нийгэм хүсэж хүчтэй шахалтууд бий болдог. Манай улсын хувьд ардчилсан шилжилт хийгээд 27 жил болж байгаа хэдий ч ардчиллыг төлөвшүүлэх үйл явц хямралд орсон хэмээн үзэж болох талтай. Тогтолцооны хямрал нь төрд итгэх итгэл сулрах, сонгуулийн үр дүнг шударга бус хэмээн үгүйсгэх, авилгалын төсөөллийн индекс өсөх, нийгэм, эдийн засгийн зогсонги байдал зэргээр илрэн гарч байгаа билээ.

Олон улс орнуудад тогтолцооны хямралыг Шууд ардчиллын зарчмаар шийдвэрлэж ирсэн байдаг. Манай улсын хувьд шууд ардчилал хэрэгжүүлэх боломж эрх зүйн хүрээнд хэрхэн зохицуулагдсан байгааг харьцуулан судлахыг зорьсон болно.

Шууд ардчилал

Шууд ардчилал нь маш энгийнээр тодорхойлбол иргэд ямар нэгэн төлөөлөлгүйгээр санал, шийдвэрээ өөрсдөө гаргах үйл явц юм. Орчин үед шууд ардчиллыг төлөөллийн

ардчиллыг бэхжүүлэх замаар орон нутаг, хотын хэмжээний бодлого боловсруулах түвшинд хослуулан хэрэгжүүлж буй улс орнууд олон байдаг. Тухайлбал Швед, Швейцарь, АНУ, Итали, Япон зэрэг улс орнууд шууд ардчиллыг хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалттай байдаг.

Шууд ардчилал нь ардчиллын анхны хэлбэр хэмээн үзэх хандлага түгээмэл байдаг. Учир нь Эртний Афинд зөвхөн хотын иргэн төрийн бодлогод шууд оролцон саналаа илэрхийлж шийдвэр гаргадаг байсан. Үүнээс үүдэлтэйгээр 18 дугаар зуунд Ж.Ж. Руссо (Jan Jacques Rousseau 1712-1778) шууд ардчилал нь туйлын үнэн ардчилал хэмээн дүгнэн ард түмний төлөөллийг эсэргүүцэж байв. Ж.Ж. Руссо ард түмэн хэзээ ч бусдаар төлөөлөхгүй, депататууд ард түмний зарц бөгөөд эцсийн шийдвэрийг ард түмэн өөрсдөө гаргана хэмээн “*Нийгмийн гэрээг буюу улс төрийн эрхийн зарчмийн тухай*”¹⁵⁴ бүтээлдээ дурдсан байдаг.

Шууд ардчиллын давуу тал нь сонгуулийн эрх бүхий иргэд бүгд оролцон нээлттэйгээр хэлэлцэн, тэгш эрхийн зарчмын дагуу иргэдийн бодол санаа шийдвэрт шууд тусгалаа олон гаргасан шийдвэрийн хүчин төгөлдөр байдал өндөр байдагт оршино.

Харин сул тал нь иргэдийн нэг дор цуглуулах хөрөнгө хүч, санхүүгийн хүндрэл, мэргэжлийн чадвар шаардсан асуудлыг ойлгохгүй байх, сэтгэлийн хөөрлөөр нийгэмд популизмыг үүсгэх зэрэг сөрөг талтай юм.

Шууд ардчилал нь бүх нийтийн санал хураалт хэлбэрээр түгээмэл хэрэглэгддэг байдлыг дараах хүснэгтээр харуулав.(Хүснэгт.1)

Бүх нийтийн санал хураалтын зориулалт.Хүснэгт.1

Хуулийн дагуух бүх нийтийн санал хураалт	ҮХ-н референдум	ҮХ-ийн өөрчлөлт, нэмэлттэй холбоотой асуудлаар
	Аливаа хуультай холбоотой референдум	Хууль, хуулийн заалт хүчингүй болгох, өөрчлөхтэй холбоотой асуудлаар
	Олон улсын гэрээтэй холбоотой референдум	Олон улсын гэрээг зөвшөөрөх, элсэн орох асуудлаар
Санхүү, төсөвтэй холбоотой бүх нийтийн санал асуулга		Төсөв, санхүүгийн бодлоготой холбоотой асуудлаар
Онц тусгай асуудлаар бүх нийтийн санал асуулга		Засаглал, санхүүтэй холбоотой асуудлаас бусад тохиолдолд
Ямар нэгэн албан тушаалтан, хүнд зориулсан бүх нийтийн санал асуулга		Улс төрийн албан тушаалтан, түүнтэй холбогдох асуудлаар

¹⁵⁴桑原武夫・前川貞次郎訳（1954年）岩波文庫133ページ。

Орчин үед улс орнууд шууд ардчиллыг дараах хэлбэрүүдээр хэрэгжүүлж байна.

Үүнд:

- ✧ *бүх нийтийн санал асуулга (referendum)*
- ✧ *олон нийтийн санал, асуулга-тодорхой асуудалд чиглэсэн (prebisite)*
- ✧ *бүх нийтийн санал, асуулга-хүлээн зөвшөөрөхгүй асуудалд (popular vote)*
- ✧ *олон нийтийн санал, санаачилга (initiative)*
- ✧ *эргүүлэн татах (recall)* ¹⁵⁵

Бүх нийтийн санал асуулга (referendum):

Энэ бол сонгуулийн эрх бүхий сонгогчдын санал хураалт юм. Үр дүн нь төрийн болон нутгийн удирдлагын шийдвэр гаргахад нөлөөлдөг. Бүх нийтийн санал асуулгаар гарсан шийдвэр нь хуулийн хүчинтэй байна. Парламентад тодорхой түвшинд хэлэлцсэн, батлагдах шатандаа явж буй асуудлаар ч хүчин төгөлдөр хэрэгжих боломжтой эсэх дээр бүх нийтээс санал асуулга явуулахад мөн хэрэглэж болно. Зарим тохиолдолд засгийн газрын шийдвэр, парламентын баталсан хуулиудаас ч илүү нөлөөтэй байна. Референдумын үр дүнд гаргасан шийдвэрийг хүчингүй болгох боломжгүй байдаг. Референдум явуулахын тулд урьдчилсан бэлтгэл сайн хийх ёстой. Тухайлбал Үндсэн Хуулийн өөрчлөлттэй холбоотой асуудлыг иргэдэд маш сайн тайлбарлаж, таниулсаны үндсэн дээр санал асуулга явуулах хэрэгтэй.

Швейцарь улс шууд ардчиллыг 1368 оноос хойш хамгийн хүчтэй хөгжүүлж чадсан байдаг. Гэхдээ судлаачид Швейцарийн ардчиллыг “Halbdirekte Demokratie” эсвэл “hybrid democracy” буюу хагас шууд ардчилал хэмээн үздэг. 1848 оны Үндсэн хууль нь хагас шууд ардчиллыг хэрэгжүүлэх үндэс нь болсон. Гол онцлог нь:

- Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт хийхэд бүх нийтийн санал, санаачлагыг хүлээн авдаг
- НҮБ гэх мэт томоохон олон улсын засгын газар хоорондын байгууллагад элсэн ороход бүх нийтийн санал асуулга хийхийг иргэддээ үүрэг болгосон байдаг
- Бусад хуулийн нэмэлт өөрчлөлт, улсын төсөв, зардалд хориг тавих зэрэг олон асуудлаар сонгуулийн эрх бүхий иргэд хүсэлт гаргах аваас бүх нийтийн санал асуулгыг явуулдаг
- Бүх нийтийн санал асуулга ихэвчлэн орон нутгийн түвшинд хэрэгждэг зэргийг дурдаж болно.

¹⁵⁵衆議院憲法調査会事務局

(2006年)最高法規としての憲法のあり方に関する調査小委員会16ページ。

Өнөөдрийг хүртэл улс орнуудад хэрэгжсэн бүх нийтийн санал асуулга 800 удаа хийгдсэн байдгаас 414 нь Швейцарь улсад явагдсан байх жишээтэй. Энэхүү системийг Швейцарийн хувьд иргэд, төлөөллийн танхим хоорондын ойлголцол, хүлээн зөвшөөрөлт явагдах хамгийн чухал тогтолцоо хэмээн үздэг. Тийм ч учраас хууль тогтоох байгууллагаас санаачлан боловсруулж буй хуулийн хүчин төгөлдөр байх эсэх нь ард иргэдийн санал хураалтын үр дүнгээр илрэх ёстой байдаг. Швейцарьт бүх нийтийн санал асуулга хэрхэн зохицуулагдсан байгааг дараах хүснэгтээс харч болно.(Хүснэгт.2)

Үүрэгжүүлсэн референдум.Хүснэгт.2

Бүх нийтийн санал асуулга явуулах асуудлууд	Санал хураалт зохион байгуулагдах үе шат
Үндсэн хуулийн өөрчлөлт	1. Парламентаас зарлиг гарах
Олон улсын байгууллагад элсэн орох, аюулгүй байдлыг асуудал	2. Засгийн газраас бүх нийтийн санал хураалт хийгдэх өдөр, мэдээлэл тараах
Жилийн дараа хүчин төгөлдөр хэрэгжиж эхлэх холбооны хууль, захирамж	3. Санал хураалт сонгох эрх бүхий иргэдийн 50 дээш хувийн саналаар хүчин төгөлдөр болох

Мөн иргэд болон иргэний нийгмийн байгууллагын зүгээс бүх нийтийн санал асуулгыг хийж болдог. Тухайлбал,

- Холбооны гэрээнд санал өгөх
- Хүчингүй болгох болгохгүй
- ОУ-н байгууллагад нэгдэх
- Гэрээг хэрэгжүүлэхэд хэрэгтэй хуулийн асуудлаар зэрэг байж болно.

Олон нийтийн санал, асуулга-тодорхой асуудалд чиглэсэн (prebiscite)

Сонгуулийн эрх бүхий сонгогчид оролцон санал хураалт явуулах үйл явц. Энэ тохиолдолд улс орны хөгжил, нутаг дэвсгэрийн асуудал, олон улсын болон бие хүнтэй холбоотой хамгийн чухал асуудлаар санал хураалт явуулдаг. Бие хүн гэдэг нь тухайлбал ерөнхийлөгчийн сонгуульд зөвхөн нэг хүнийг сонгох г.м. Тодруулж хэлбэл энэ нэр томъёонд албан ёсны ойлголт, тодорхойлолт байхгүй. Сонгогчдод нэг л хүнийг сонгох нөхцөлтэй сонгуулийг Египетэд Референдум, Палистанд Пелибистит гэж нэрлэх тохиолдол байдаг. Ихэвчлэн авторитар хэлбэрийн дэглэмийн үед хэрэглэдэг.

Тухайлбал 1962 онд Франц улсын ерөнхийлөгч Д.Голь ерөнхийлөгчийн сонгуулийг бүх нийтээрээ сонгодог болгож хуулийн өөрчлөлт хийхийн тулд пелибистит явуулсан

байдаг. Францын Үндсэн хуулийн дагуу бол Засгийн газар, парламентын гишүүд хуулийн өөрчлөлтийг санал болгосныг үндэслэн хоёр танхимаар оруулна. Тухайн асуудлаар хоёр танхимын гишүүдийн 50-иас дээш хувийн санал авсан тохиолдолд бүх нийтийн санал хураалтыг явуулж, нийт сонгох эрх бүхий иргэдийн 70-аас дээш хувь зөвшөөрсөн тохиолдолд энэхүү өөрчлөлт албан ёсоор дэмжигдэх ёстой байсан. Харин Д. Голь Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт хийх замаар бүх нийтийн санал асуулга явуулах 11 дүгээр зүйлийг үндэслэн санал асуулга явуулсан байдаг. Францын түүхэнд пелибиститийг ерөнхийлөгч Д. Голиос өмнө Напелион төрийн эрхэнд гарч эзэнт хаант засаглалыг дахин сэргээхдээ анх хэрэгжүүлж байсан түүхтэй. Францын анхны Үндсэн хууль 1791 онд батлагдан гарсан хэдий ч 1793 онд Үндэсний асамблей “бүх ард иргэдийн хүлээн зөвшөөрсөн Үндсэн хуулиас өөр Үндсэн хууль орших ёсгүй” хэмээн тунхагласан учир анх удаа Бүх нийтийн санал асуулга хэрэгжсэн байдаг.

Бүх нийтийн татгалзсан санал-хүлээн зөвшөөрөхгүй асуудалд (popular vote)

Энэ тохиолдолд ихэвчлэн парламентад хэлэлцэгдээд шийдэлд хүрээгүй асуудлыг ард түмний санал асуулга хэлбэрээр явуулдаг. Гарах үр дүн нь ихэвчлэн дэмжигдэхгүй эсрэг гардаг. Санал асуулгын үр дүнг парламент хүлээн авах ёстой байдаг.

Олон нийтийн санал, санаачилга (initiative)

Энэ тохиолдолд ихэвчлэн ард түмний хүсэл, санаачлагаас үүдэлтэй. Олон нийтийн санал, санаачилга нь тодорхой тооны сонгох эрх бүхий иргэдийн зүгээс гаргах боломжтой байдаг. Энэхүү санаачилга нь бүх нийтийн санал асуулга, эсвэл шууд парламентын хэлэлцүүлгээр орох гэсэн хоёр зохицуулалтын хүрээнд явагддаг. Тухайлбал хуулийн зөрчилтэй заалтад санал оруулах г.м.

Швейцарь улсад бүх нийтийн санал санаачилга хэрхэн хэрэгждэг болохыг дараах хүснэгтээс харж болно.(Хүснэгт.3)

Хүснэгт.3

Санаачлах асуудлууд	Хэрэгжих байдал
Үндсэн хуулийн реформ	<ul style="list-style-type: none"> ① Иргэний санаачилга ② Холбооны засгийн газар хянах ③ 18 сарын дотор сонгох эрх бүхий 100,000 иргэдийн санал, санаачлага ④ Бүх нийтийн санал асуулгаар 50-аас дээш хувь дэмжигдсэн байх ⑤ Парламентыг тараах, дахин сонгууль явагдах ⑥ Шинэ парламент дахин төсөл оруулах

	<p>⑦ Холбоо, мужын сонгох эрх бүхий бүх иргэдийн 50-аас дээш хувийн дэмжлэг авах, хүчин төгөлдөр болох</p> <p>※ 1935 онд ④ хүртэл үргэлжилсэн байдаг.</p>
Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт	<p>①~③ хүртэл дээрхтэй ижил шат дараалалтай. Гэхдээ парламент хуулийн төслийн утга агуулга ямар нэгэн байдлаар зөрөх аваас хүчингүй болгох эрхтэй.</p>
Ерөнхий саналын формат	<p>④ парламент саналыг дэмжвэл → ⑦ хэрэгжих боломжтой</p> <p>⑤ парламент дэмжээгүй тохиолдолд бүх нийтийн санал асуулга</p> <p>⑥ Бүх нийтийн санал асуулгаар 50-аас дээш хувь дэмжигдсэн байх</p> <p>⑦ Парламент дэмжигдсэн саналыг хуулийн төсөл болгож оруулж ирэх</p> <p>⑧ Холбоо, мужын сонгох эрх бүхий бүх иргэдийн 50-аас дээш хувийн дэмжлэг авах, хүчин төгөлдөр болох</p>
Бэлэн болсон хуулийн төсөл	<p>④ парламент саналыг дэмжвэл → ⑥ хэрэгжих боломжтой</p> <p>⑤ парламент дэмжээгүй тохиолдолд татгалзах, дахин шинэ төсөл оруулж ирэх. Ингэхдээ иргэдийн санаачилсан төслийг хэрэгсэхгүй болгосон.</p> <p>⑥ Холбоо, мужийн сонгох эрх бүхий бүх иргэдийн 50-аас дээш хувийн дэмжлэг авах, хүчин төгөлдөр болох</p>

Эргүүлэн татах (recall)

Тухайн албан тушаалын бүрэн эрхийн хугацаа дуусаагүй байсан ч хариуцлага тооцон эргүүлэн татах үйл явц юм. Энэхүү санаачлага нь тодорхой тооны сонгох эрх бүхий иргэдийн зүгээс гарч бүх нийтийн санал асуулга болдог. Олон улсад ихэвчлэн орон нутаг, мужийн түвшинд түгээмэл хэрэглэгдэх хуулийн зохицуулалт хийгдсэн байдаг. Эргүүлэн татах эрх үйлчлэх албан тушаал нь сонгуулиар сонгогдсон улс төрийн албан тушаалтан, төрийн албаны томилгоо хийгддэг улс төрийн албан тушаалтан байна.

Тухайлбал АНУ-д энэхүү зохицуулалтыг дараах байдлаар хийсэн байдаг. 1776 онд АНУ тусгаар тогнолоо зарласны дараа 1780 онд анх удаа бүх нийтийн санал асуулга хэрэгжсэн түүхтэй. Улмаар Прогрессив хөдөлгөөний үр дүнд эмэгтэйчүүдийн сонгуульд оролцох эрх, сенатын гишүүд бүх нийтийн сонгуулиар сонгогдох, сонгуулийн сунгаа, бүх нийтийн санал асуулга, албан тушаалтанг эргүүлэх татах гэсэн таван зүйлээр Үндсэн хуулинд нэмэлт өөрчлөлт оруулсан байдаг. Үүний үр дүнд шууд ардчиллын зарчмууд бүрэн хэрэгжих боломжтой болсон. Америкт шууд ардчилал хэрхэн хэрэгждэг болохыг дараах хүснэгтээс харч болно. (Хүснэгт. 4)

Хүснэгт. 4

Бүх нийтийн шууд санал санаачлага		Тодорхой тооны сонгох эрх бүхий иргэдийн зүгээс санаачлан мужын хурлаар хянагдахгүй шууд бүх нийтийн санал асуулга хийгдэх
Төлөөллийн санал, санаачлага		—Тодорхой тооны сонгох эрх бүхий иргэдийн зүгээс санаачлан мужын хурлаар хэлэлцэгдэх —Тодорхой хугацаа өнгөрсөн боловч мужын хурлаар уг асуудлыг хүлээн авч хэлэлцэхгүй аваас шууд иргэдийн санал асуулгыг хэрэгжүүлэх
Бүх нийтийн санал асуулга	Иргэдийн зүгээс	—Тодорхой тооны сонгох эрх бүхий иргэдийн зүгээс санаачлан мужын хурлаар хэлэлцүүлэн хуулийн өөрчлөлтийг хийх
	Парламент -ын зүгээс	Парламент санаачлан иргэдийн санал асуулга явуулах
Үүрэгжүүлсэн бүх нийтийн санал асуулга		Мужуудын Үндсэн хууль, иргэдийн оролцоотой харилцан адилгүй шийдэгдэх асуудал. Үндсэн хуулийн өөрчлөлт, төсөв, татварыг нэмэх талаар, өөрчлөх талаар муж болгон явуулах
<i>Эргүүлэн татах</i>		—Тодорхой тооны сонгох эрх бүхий иргэдийн зүгээс санаачлан сонгуулиар сонгогдон гарч ирсэн албан тушаалтанг эргүүлэн татах санал асуулга

Бүх нийтийн санал асуулга нь заавал санал хураалтаар биш, нийт иргэдийн санаа бодлыг асуух хэлбэр хэмээн үзэж болно. Энэхүү хэлбэрийн санал асуулгыг иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгсэлийг ашиглан хэрэгжүүлж болно.

Бүх нийтийн санал асуулгаар албан ёсны шийдвэр гарахгүй, зөвхөн иргэдийн санаа бодлыг тандах үйл явц хэмээн үзвэл төлөөллийн ардчиллын шийдвэр гаргах үйл явцад дэмжлэг үзүүлэх шууд ардчиллын чухал хэлбэр юм. Тодорхой шийдвэр гаргадаггүй бүх санал хураалтыг зөвлөх референдум хэмээн нэрлэдэг.

Нийт ард түмний санал асуулгад сонгох эрх бүхий иргэд оролцох ёстой байдаг. Зарчмын хувьд энэ нь төлөөллийн ардчиллаас давуу талтай. Референдум бол ард түмэнд санаа бодлоо шууд илэрхийлэх боломж олгодог. Гэхдээ референдумын ач холбогдолыг хэтрүүлж үнэлж хэрхэвч болохгүй. Яагаад гэвэл бүх нийтийн санал асуулгаар гаргаж тавьж байгаа асуудал нь энгийн сонгогч тэр болгон нарийн ойлгох боломжгүй байх тал бий. Нөгөө талаар жирийн сонгогч бол аливаа саналын шийдвэрийн улс төрийн үр дагаварыг тооцоолоход бэрх байдаг.

Шууд ардчилал сайн хөгжсөн зарим улсуудад ямар хэлбэрээр хийгддэг болохыг дараах хүснэгтээс харч болно.(Хүснэгт. 5)

Хүснэгт.5

Улсын нэр	Асуудал	Иргэний үүрэг	Хаанаас явуулж болох	Шийдвэрт нөлөөлөх
<i>Англи</i>	Улс төрийн шийдвэр	Сайн дураар, иргэдийн зүгээс санаачлах	Парламентаас	Зөвлөлдөх
<i>Итали</i>	1.Хуулийн заалт хүчингүй болгох: - Татвар - Төсөв - Хүнд ял хөнгөвчлөх	Сайн дураар	1.Сонгуулийн насны 500,000 хүн 2.Таван мужийн хурлаас	Хүчинтэй саналын ½ ба түүнээс дээш зөвшөөрбөл хүчин төгөлдөр
	2.Үндсэн хуулийн өөрчлөлт	Сайн дураар	1.Парламентын танхим тус бүрээс 1/5 1.Сонгуулийн насны 500000 хүн 2.Таван мужийн хурлаас	Хүчинтэй саналын ½ ба түүнээс дээш санал авахад өөрчлөлт хийнэ

<i>Швед</i>	1.Улс төрийн чухал бодлого	Сайн дураар	Парламентаас	Зөвшилцдөг
	2.Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөл	Сайн дураар	Танхимын 1/3хүсэлт гаргах	Хүчинтэй санал 50%-с дээш байх мөн энэ саналын тоо парламентын 50%-с дээш дэмжсэн тохиолдолд
<i>Дани</i>	Тусгай хууль (ОУ-н байгууллага руу өөрийн эрх мэдлээ шилжүүлэх, сонгуулийн санал өгөх нас өөрчлөх)	Үүрэг	Танхимын 1/3 хүсэлт гаргах	Санал өгсөн иргэдийн 50%-с дээш нь эсрэг байх мөн сонгууль өгөх иргэдийн 30%-с дээш нь эсрэг санал өгсөн байх
	Үүнээс бусад хуулинд	Сайн дураар	Танхимын 1/3 хүсэлт гаргах	Санал өгсөн иргэдийн 50%-с дээш нь эсрэг байх мөн сонгууль өгөх иргэдийн 30%-с дээш нь эсрэг санал өгсөн байх
	Үндсэн хуулийн өөрчлөлт	Үүрэг	Танхимын 1/3 хүсэлт гаргах	Санал өгсөн иргэдийн 50%-с дээш нь эсрэг байх мөн сонгууль өгөх иргэдийн 30%-с дээш нь эсрэг санал өгсөн байх
<i>Франц</i>	ЭЗ,УТ-н бодлого,төрийн албан хаагчид хамаарал бүхий хуулиуд	Сайн дураар	Ерөнхийлөгч зөвшөөрсөн нөхцөлд ЗГ, хоёр танхим хамтарч	Хүчинтэй саналын 50%-с дээш нь дэмжсэн нөхцөлд

Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт	Үүрэг	Парламентаас	Хүчинтэй саналын 50%-с дээш нь дэмжсэн нөхцөлд
Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт			Хүчинтэй саналын 50%-с дээш нь дэмжсэн нөхцөлд

Манай улсын хувьд 1945 оны 10 сарын 20-нд Бүх нийтийн санал асуулга явуулан тусгаар тогтнолоо бататгаж байсан түүхтэй. 1992 оны Ардчилсан шинэ Үндсэн хуулийн гуравдугаар зүйлд: Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ хэмээн заасан байдаг.

1995 онд батлагдсан Бүх нийтийн санал асуулгын тухай хуулиар бүх нийтийн санал асуулга, санал санаачлагыг хэрэгжүүлж болох эрх зүйн зохицуулалт анх удаа хийгдсэн. Энэхүү хуулийг 2016 онд шинэчлэн найруулан “Ард нийтийн санал асуулгын тухай” хууль болгон баталсан. Бүх нийтийн санал асуулга явуулах боломжийг хуульчилж өгсөн байдаг ч манай улсад огт хэрэгжихгүй байгаа нь учир дутагдалтай.

Энэ нь уг хуулийн “5.1.Ард нийтийн санал асуулга явуулахыг Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны нэгээс доошгүй нь санаачлах эрхтэй”¹⁵⁶ хэмээн заасан байдагтай шууд холбоотой хэмээн үзэж болно.

Үндэсний язгуур эрх ашиг, аюулгүй байдал, Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлттэй холбоотой асуудлаар шууд ардчиллын зарчмаар бүх нийтийн санал асуулга явуулах нь Монгол улсын Үндсэн хуулийн гуравдугаар заалтыг хангах нэг том боломж билээ.

Ном зүй

- Монгол улсын Үндсэн хууль, 1992 он.
- Ард нийтийн санал асуулгын тухай хууль, 2016 он.
- Шууд ардчилал- Иргэдийн оролцоо” Бодлогын баримт бичгийн эмхтгэл, 2008 он.
- 阿部照哉・畑博行編『世界の憲法集〔第二版〕』（1998年）有信堂
- 生田希保美・越野誠一『アメリカの直接参加・住民投票』（1987年）自治体研究社
- 小林武『現代スイス憲法』（1989年）法律文化社
- 辻村みよ子「レフェレンダムと議会の役割」『ジュリスト1022号』（1993

¹⁵⁶<http://www.legalinfo.mn/law/details/11704>

年) 有斐閣

- 中村義孝編訳『フランス憲法史集成』(2003年) 法律文化社

ИРГЭДИЙН УЛС ТӨРИЙН ҮЗЭЛ СУРТАЛЫН ТАРХАЛТЫГ УЛС ТӨРИЙН ГАЗАРЗҮЙН ҮҮДНЭЭС ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА

Д.Оюунчимэг

*МУИС-ийн ШУС-ийн НУ-ны салбарын
Улс төр судлалын тэнхимийн ахлах багш*

Г.Цогтдэлгэр

*МУИС-ийн ШУС-ийн БУ-ны салбарын Газарзүйн
тэнхимийн докторант*

ТҮЛХҮҮР ҮГ: “Улс төрийн газарзүй”, “Улс төрийн орон зай, тархалт”, “Улс төрийн үзэл суртал, үзэл баримтлал”,

ОРШИЛ

Газарзүйн шинжлэх ухааны судалгаанд аливаа нийгмийн болон байгалийн юмс үзэгдлийн орон зайн шинжилгээ, хүн ам ба бүс нутаг хоорондын хамаарал зэрэг дэлхий дээр болж буй бүхий л үйл явц багтдаг. Манай улсад байгалийн үзэгдэл үйл явцыг тусгай аргачлалын дагуу орон зайн хил хязгаарын хүрээнд судалсан байдаг боловч нийгмийн үйл явцыг орон зайн хувьд тусгайлан судлагдаагүй байна.

Нийгмийн шинжлэх ухааны хүрээнд улс төрийн нам хүчний байршил, үйл ажиллагааны хүрээ, сонгуулийн үйл явц, засгийн газрын бодлого хөтөлбөрийн хэрэгжилт, шашин, соёлын тархалт зэргийг орон зайн хувьд хил хязгаар тогтоож нарийвчлан үзэх нь улс төрийн газарзүйн судалгааны чиглэл юм. Улс төрийн газарзүйн чиглэлээр АНУ болон Европын Их сургуулиудын эрдэмтэн, судлаачдын дунд улс төрийн орон зайн шинжилгээсудалгааны ажил олонтоо хийгдэж байна.

Сүүлийн зуун жилд улс төрийн үзэл суртлын асуудал нийгэм, улс төр, эдийн засагт ихээр хөндөгдөж ирсэн. Улс төрийн үзэл суртлын талаар эрдэмтэн мэргэд олон янзаар тодорхойлсон байдаг. Жишээ нь М.Вебер “шинжлэх ухаан дахь шинжлэх ухааны бус хандлага” хэмээн үзсэн байдаг. Өөрөөр хэлбэл, үзэл суртал нь шинжлэх ухаанаар нотлогдоогүй, батлагдаагүй мөрөөдлийн шинжтэй итгэл үнэмшлийн систем байж болох бөгөөд үл гүйцэлдэх шинжийг агуулж байдаг.¹⁵⁷ Нэг талаас үзэл суртал нь оршин үйлчилж байдаг боловч **нөгөө талаас идеалист ойлголт юм.**

¹⁵⁷Ц.Ганболд, Ц.Батболд “Политологи” эрдэм шинжилгээний бичиг, 22-р хуудас

Иймээс улс төрийн үзэл суртал нь нэг талаас шинжлэх ухааны үндэстэй, системтэй мэдлэг, онол агуулдаг ч нөгөө талаас нийгмийн тодорхой бүлгийн эрх ашгийн өнцгөөс түүнийгээ тайлбарладаг шинжлэх ухаан ч бус хандлага агуулдаг учраас түүнийг шинжлэх ухаан гэж үзэх боломжгүй юм.

Улс төрийн газарзүйн үүднээс авч үзвэл улс төрийн үзэл суртал нийгэмд ямар нэг хэмжээгээр оршин байгаа бол “хаана” гэсэн орон зайн ойлголт гарч ирж байна. Улс төрийн газарзүйн онолын суурийг нийгэм эдийн засгийн газарзүйн онол болох “тархцын онол”-ыг суурь болгон авч үзлээ. Тархцын онолоор аливаа нэг шинэ техник технологи, үзэгдэл үйл явц нийгэмд нэвтрэхдээ тодорхой нэг газар нутгаас хүрээгээ тэлж бүс нутгийн хэмжээнд улс орны хэмжээнд тархаж болно гэж үздэг. Улс төрийн газарзүйн суурь онолын нэг болох тархцын онолыг голлон баримталж, улс төрийн үзэл суртал оршин үйлчилж байгааг батлахыг зорьлоо.

1990 оноос өмнө улс төрийн нэг нам, нэг үзэл сурталтай байсан бол 1990 оноос олон нам , олон ургалч үзэл төлөвшиж эхэлсэн. Олон ургалч үзлийг иргэд шууд сонгож авахаас илүүтэйгээр аливаа нийгмийн хувьсал, өөрчлөлт олон жилийн хугацаанд хуримтлагдан бүрэлддэг байна. Улс төрийн үзэл суртал нь нийгмийн шаардлагаар бүрэлдэн буй болж, хувьсан өөрчлөгдөж, хөгжиж, илүү боловсронгуй болж ирсэн. Нэг талаас тухайн улс төрийн нам хүчний үзэл баримтлал боловч нөгөө талаас нийгэм дэх хэрэгцээ, шаардлага дээр үндэслэн оршиж байдаг. Тиймээс иргэд, сонгогч олон түмэн улс төрийн үзэл баримтлалтай байгаа эсэх, мөн иргэдийн улс төрийн үзэл баримтлалтай болоход ямар хүчин зүйл нөлөөлж буй талаар тодруулан судлах юм. Иргэдийн улс төрийн үзэл баримтлал төлөвшихөд боловсролын төвшин, эдийн засгийн байдал, хүйсийн байдал, насны онцлог, гарал угсаа, ажил мэргэжил зэрэг хүчин зүйлс хэрхэн нөлөөлж буйг тогтоож, тухайн үзэл баримтлалын дэмжигч нарын орон зайн хүрээг тодорхойлж болох юм. Улс төрийн үзэл баримтлалуудаас хамгийн нийтлэг, томоохон урсгал болох либерал, консерватив, социал-демократ, үндэсний үзэл зэргийг сонгож авч судалсан.

Либерал үзлийг Ш.Монтескье, Т.Гоббс, А.Смит, Т.Жефферсон, Ж.С.Милль зэрэг судлаачид үндэслэсэн. Тэдгээр эрдэмтдийн үзэж буйгаар хувийн өмч, хүний эрх, эрх чөлөө зэрэг нь либерал үзлийн тулгуур зарчим юм. Либерал үзэл нь бие хүнийн үнэт зүйлс дээр тулгуурлаж, түүний бие даасан байдлыг эрхэмлэдэг. Уг үзэл нь язгуур эрх ашиг болох амьд явах, өмчтэй байх зэрэг эрхийг дээдэлдэг. Либерал үзэл нь шатлан захирах ёс, угсаа залгамжлан хаанчлах үйл явцыг халж, иргэдийн оролцоонд тулгуурлаж гарч ирсэн. Худалдаа наймаа ихээр хөгжсөн, нийгмийн харилцаа хурдацтай өөрчлөгдөж буй, уламжлалт харилцаа алдагдаж буй нийгэмд түлхүү хөгждөг байна. Хөгжлийн шатандаа либерал, неолибериал, либеритари зэргээр хувьсан

өөрчлөгдөж, хөгжиж иржээ. Эдгээр нь гарал үүслийн хувьд ижил боловч засаглалын төвшинд хэрэгжүүлэх аргачлал нь харилцан адилгүй байна. Консерватив үзлийг Английн эрдэмтэн Эдмунд Берк, Францын нийгэм судлаач Жозеф де Местр, Луй Бональд нар гүнзгийрүүлэн судалж дараах үзэл баримтлалыг тодорхойлсон. Нийгэм эмх журам, тогтвортой байдал, уламжлалаа хадгалан хөгжих ёстой бөгөөд нийгмийн эрс өөрчлөлт сөрөг үр дагаварт хүргэнэ хэмээн үздэг. Консерватив үзэл баримтлал нь тухайн улс үндэстний үнэт зүйл, ёс заншил хадгалагдан үлдэж буй нийгэмд илүү давамгайлах хандлагатай байдаг. Шийдвэр гаргахдаа ёс суртахуун, зан заншил, шашин шүтлэгийг харгалзаж үзэх хэрэгтэй гэсэн байр суурьтай бөгөөд хөгжлийн шатандаа консерватив болон неоконсерватив гэсэн чиглэлтэй болсон.

Социал-демократ үзлийг Э.Бернштейн, К.Каутский зэрэг эрдэмтэд судалж, боловсронгуй болгосон байна. Энэхүү үзэл суртал нь анги давхаргуудад харилцан адилгүй төрийн зохицуулалт хийх, нийгмийн хангамж, боловсрол, эрүүл мэнд зэрэгт түлхүү анхаарал тавьдаг бол харин үндэсний үзэл бол тодорхой нутаг дэвсгэрт оршин сууж байгаа иргэдийн соёл, зан заншил, үндэсний эрх ашгийг дээдлэх үзэл юм. Үндэсний үзэл нь үндэстэн, угсаатны онцлог, дархлаагаа хадгалах эрмэлзлэл, үзэл баримтлалаар ялгардаг. Үндэсний үзэл түүхэн хөгжлийн явцдаа хэд хэдэн урсгал чиглэлээр хөгжиж ирсэн. Иргэний үндэсний үзэл нь нийт ард түмний гарал үүсэл, өөрийн оршин буй нутаг дэвсгэр, соёл, зан заншлыг эрхэмлэн дээдэлдэг орно. Судалгааны ажлын хүрээнд иргэдийн улс төрийн үзэл суртал төлөвшихөд тодорхой тойрог бүхий нутаг дэвсгэрт үүсдэг төдийгүй тухайн үзэл сурталын тархалтын орон зайг хэмжиж болно хэмээн таамаглал дэвшүүлж судалсан. Иргэдийн улс төрийн үзэл суртал, үзэл баримтлал, үнэт зүйлс хандлагыг тодорхойлохдоо “либерал”, “консерватив”, социал-демократ” зэрэг голлох үзэл суртлуудыг авч үзсэн бөгөөд тэдгээрийг дотор нь либерал, неолиберал, либеритари гэгчлэн задлалгүйгээр суурь үзэл баримтлалаар нь либерал үзэлтэй хэмээн авч үзсэн. Үүндээ үндэслэн орон зайн дүн шинжилгээг, иргэдийн улс төрийн талаарх ойлголт, үзэл баримтлал, үнэт зүйлс, чиг хандлага хийгээд түүний газарзүйн байршил, тархацын харилцан уялдаа, зүй тогтлын талаар дэлгэрүүлэн судаллаа.

1.Арга зүй: Энэхүү судалгаа нь иргэдийн улс төрийн үзэл баримтлал нь нийгэм, эдийн засаг, газарзүй хүчин зүйлсээс хамаарч буйг тодорхойлох зорилгоор хийгдсэн. Одоогийн байдлаар иргэдийн үзэл баримтлалын талаархи мэдээлэл төр, захиргааны байгууллагууд, нам, улс төрийн хүчнүүдэд тойм байдлаар байх боловч иргэн нэг бүрийн үзэл баримтлал, түүний өөрчлөлтийн талаархи мэдээлэл үндсэндээ байдаггүй. Тиймээс мэдээ, мэдээллийг цуглуулахын тулд социологийн судалгааны арга, аргачлалыг ашигласан. Аливаа судалгааны ажил амжилттай болох үндэс нь судалгааны зорилго

зорилтод нийцсэн судалгааны арга зүйгээ зөв тодорхойлоход оршино.¹⁵⁸ Тиймээс төлөөлөх чадвар бүхий олон тооны респондентыг хамарсан, мэдээллийг үнэн зөв хариулах боломжтой, шалгах аргачлалыг тусгасан судалгааны арга бол асуулгын арга юм. Тус судалгаанд бичгийн буюу анкетын аргыг ашигласан. Брайманы/1989/ тодорхойлолтоор асуулгын судалгаа гэдэг нь хэд хэдэн хувьсагчийн тухайд тоогоор илэрхийлж болох мэдээллийг системтэй цуглуулахын тулд хэд хэдэн нэгжээс ихэвчлэн цаг хугацааны тодорхой нэг мөчид мэдээлэл цуглуулан авч дараа нь уялдаа хамаарлын зүй тогтлыг шинжлэх явдал юм.¹⁵⁹ Анкетын арга гэдэг бол судлах асуудал, судалгааны зорилгоос хамаарч нийгмийн үзэгдэл, үйл явцын тоо чанар, шалтгаан үр дагаврын холбоо, учир холбогдол, онцлогийг нээн илрүүлэхэд чиглэгдсэн тодорхой агуулга, бүтэц, зохион байгуулалт, дарааллаар урьдчилан бэлтгэж хэвлэсэн асуулт хариултын цогц юм.¹⁶⁰ Анкетын загварыг үндсэн хоёр хэсгээс бүрдүүлсэн. Нэгдүгээр хэсэг нь хувь хүний мэдээллийн хэсэг буюу боловсрол, нас, хүйс, яс үндэс, өрхийн орлого, улс төрийн намын гишүүнчлэл, сонгуульд санал өгсөн байдал зэргийг оруулсан арван таван асуултаас бүрдсэн бол хоёрдугаар хэсэг нь улс төрийн үзэл баримтлалыг тодорхойлох асуулт бөгөөд либериал, консерватив, социал-демократ, үндэсний үзэл зэрэг үзэл баримтлалыг тодруулахуйц хорин таван асуултаас бүрдсэн. Иргэдийн улс төрийн үзэл баримтлал төлөвшихөд нөлөөлж буй хүчин зүйлсийг Корреляцын шинжилгээ ашиглан тодорхойллоо. Корреляцын шинжилгээг корреляцын коэффициентоор тодорхойлсон болно.

Нийт эх олонлогоос бүгдээс нь судалгаа авах нь цаг хугацаа, зардлын хувьд маш өндөр тул нийт эх олонлогоос авсан хэмжээний ижил үнэн зөв дүн гаргах стратеги нь түүвэрлэх явдал юм. Судалгааны талбайд эх олонлог буюу 20125 сонгуулийн насны хүн амаас 99%-ийн магадлалаас $\pm 6\%$ -иар тооцоолж нийт 480 респондентыг сонгож авсан. Тухайн судалгааны үнэмшил хамгийн багадаа 93%-ийн магадлалтай буюу түүнээс дээш хувь гэсэн үнэлгээтэй байна.

Энэхүү судалгааны талбараар Сүхбаатар дүүргийн 60-р тойргийг сонгож авсан. Судалгааны талбайн хувьд тус дүүргийн 7, 8, 9, 10-р хороод буюу нийт дөрвөн хороог хамруулсан. Судалгаанд нийт 480 иргэн оролцсон бөгөөд алдааны магадлалыг 99%-иар тогтоосон. Нийт авсан судалгааны алдааны магадлал 93%-тай байсан.

¹⁵⁸McDaneil C. and Gates R. (2012). *Marketing Research Essentials*, 8th Edition, South-Western College Publishing

¹⁵⁹Колин Робсон. “Бодит ертөнцийг судлахуй.” Нийгмийн ухаан болон мэргэжлийн судлаачдад зориулсан гарыг авлага. УБ., 2006

¹⁶⁰Шинжлэх ухааны академи философи, социологи, эрхийн хүрээлэн. “Социологийн судалгааны аргазүй, аргачлал” УБ., 2008

2. *Үр дүн*: Судалгааны ажлын хүрээнд сонгуулийн нэг тойргийг сонгож авахдаа орон сууц, гэр хорооллын суурьшлын бүсийн аль алиныг хамарсан нутаг дэвсгэрийг сонгосон. Тухайн шалгуурт тэнцсэн Сүхбаатар дүүргийн 7-р хороо, 8-р хороо, 9-р хороо, 10-р хороод судалгаанд хамрагдаж байна. 60-р тойрог дахь 8-р хорооны хамрах газар нутаг нь урд талаараа Багшийн их сургууль, баруун талаараа соёлын төв өргөө, шангрила, хүүхдийн номын ордон, уран зургийн галерей зэрэг үйлчилгээний газрууд байрласан. Хорооны төв хэсгээр 1970-1980 оны хооронд баригдсан орон сууцтай, хүрээлсэн байдалтай шинэ баригдсан /2000 оноос хойш/ орон сууцтай. Тус тойргийн 7-р хороо нь баруун талаараа үйлчилгээний газруудтай. Үүнд: Номин дэлгүүр, Шатахуун түгээх газар, Ардчиллын ордон зэрэг газруудтай бол хорооны зүүн хойд хэсэгт 1980-1990 оны хооронд баригдсан угсармал 9-н давхар орон сууцнууд байрласан. Зүүн урд хэсэгт шинэ баригдсан /2000 оноос хойш/ орон сууцтай. Харин 10-р хорооны орон зайн төлөвийг үзвэл зүүн талаараа худалдаа үйлчилгээний газар болох 100-н айлын худалдааны төв орж байгаа бол урд болон төв хэсгээр 1970-1980 оны хооронд баригдсан орон сууцтай. Баруун хойд хэсгээрээ шинээр баригдсан /2000 оноос хойш/ орон сууц төвлөрч байна. (Зураг дээрээс харна уу.) Тус тойргийн 9-р хорооны орон зайн төлөв: нийт нутаг дэвсгэрийн 90% гаруй хувийг гэр хорооллын бүс эзэлж байна. Зүүн урд хэсгээр төв зам дагуу шинэ орон сууцууд баригдсан байна. Улсын их хурлын 60-р тойргийн төлөв нь 8-р хороонд Худалдаа үйлчилгээний томоохон төвтэй. 7-р хороо, 8-р хороо, 10-р хороодод орон сууцны бүс төвлөрсөн байгаа бол 9-р хороонд гэр хороолол төвлөрсөн байна.

Либерал үзэл баримтлалтай иргэдийн орон зайн шинжилгээ:

Судалгааны талбайн нийт иргэдийн үзэл баримтлал, тухайн үзэл баримтлал харилцан ямар хүчин зүйлээс хамаарч байхыг тодорхойлсон. Либерал үзэл баримтлалтай иргэдийг хувийн өмчтэй байх, хууль эрх зүйг дээдлэх, эдийн засагт төрийн оролцоог хүлээн зөвшөөрөх, нийгэмд төр хэрхэн нөлөөлөх зэрэг асуулгаар тодорхойлсон. Нийт судалгаанд оролцогчдын 230 нь либерал үзэлтэй хэмээн тодорхойлогдсон бөгөөд тухайн үзэлд насны байдал, хүйс, боловсролын төвшин, ажил эрхлэлт, цалин /өрхийн орлого/ зэргээр олон хүчин зүйлд корреляцын коэффициентоор тодорхойлсон. Насны байдал нь эерэг буюу сул хамааралтай $r=0.16$ гарсан бол хүйсний байдал $r=-0.16$, боловсролын байдал $r=-0.092$, ажил эрхлэлтийн байдал $r=-0.1$ цалин буюу орлогын хэмжээ /орлого/ байдал $r=0.07$, яс үндэсний байдал $r=-0.02$ гарсан байна. Хүснэгт 2-оос үзнэ үү. Үүнээс үзэхэд либерал үзэл төлөвшихөд хүйс, боловсрол, ажил, яс үндэс хамаардаггүй байна. Харин насны болон орлогын хэмжээ хамааралтай байгааг харж болно. Тиймээс хэдий насны, ямар хэмжээний орлоготой хүнд дээрх үзэл хамааралтай байгааг нэг хувьсагчийн шинжилгээгээр тодорхойлвол:

Хүснэгт 1 Либерал үзэлтэй иргэдийн корреляцын коэффициент

	Нас	Хүйс	Боловсрол	Ажил	Цалин	Ястан	Үзэл
Нас Pearson Correlation	1	-.181**	-.061	-.144*	.016	-.085	.269*
N	230	230	230	230	230	230	230
Хүйс Pearson Correlation	-.181**	1	.053	.171**	-.183**	.046	-.147*
N	230	230	230	230	230	230	230
Боловсрол Pearson Correlation	-.061	.053	1	.102	-.309**	-.054	-.026
N	230	230	230	230	230	230	230
Ажил Pearson Correlation	-.144*	.171**	.102	1	-.234**	-.030	-.092
N	230	230	230	230	230	230	230
Цалин Pearson Correlation	.016	-.183**	-.309**	-.234**	1	.068	.100
N	230	230	230	230	230	230	230
Ястан Pearson Correlation	-.085	.046	-.054	-.030	.068	1	-.036
N	230	230	230	230	230	230	230
Үзэл Pearson Correlation	.269**	-.147*	-.026	-.092	.100	-.036	1
N	230	230	230	230	230	230	230

Гистограмм нь нэг хувьсагчийн тасралтгүй утгыг агуулж тухайн утгаар график хэлбэрт дүрслэгдэнэ. Либерал үзэл нь 20-30 насны иргэд хамгийн их утгыг агуулж байгаа бол 30-45 насны иргэдэд жигд утга, 45-аас дээш насныханд буурсан үзүүлэлттэй байна. График 1 дээрээс харна уу. Либерал үзэл баримтлалтай иргэд болон цалингийн хэмжээ хоорондын корреляцын коэффициент $r=1$ утгатай. Нийт либерал үзэл баримтлалтай иргэдийн цалин хөлсний хэмжээг авч үзвэл: 1 гэсэн утгыг 200,000 ₮-өөс доош орлоготой, 2 гэсэн утга нь 200 мянгаас 400 мянгын орлоготой иргэд, 3 гэсэн утга нь 400 мянгаас 600 мянгын орлоготой иргэд, 4 гэсэн утга нь 600 мянгаас 800 мянгын орлоготой иргэд, 5 гэсэн утга нь 800 мянгаас 1 саяын орлоготой иргэд, 6 гэсэн утга нь 1 саяас дээш орлоготой иргэд орно. Нийт либерал үзэлтэй иргэдийн дийлэнх хувь нь 500 мянган төгрөгөөс дээш орлоготой иргэд орсон бөгөөд 1 саяас дээш орлоготой иргэдэд либерал үзэл илүүтэй ажиглагдаж байна. Доорх графикаас харна уу.






График1 Либерал үзэлтэй иргэдийн насны гистограмм
(Эх сурвалж: Зохиогч)

График2 Либерал үзэлтэй иргэдийн орлогын хэмжээний гистограмм
(Эх сурвалж: Зохиогч)

Их

хурлын сонгуулийн 60-р тойргийн либерал үзэлтэй иргэдийн орон зайн төлөвийг тодорхойлвол: хамгийн их утгыг 8-р хорооны хуучны орон сууц болох 1990 оноос өмнө баригдсан 45, 46, 47, 48-р байрнууд болон 2000 оны үе баригдсан 25-1-р байр, 14-2-р байруудад нягтшил ихтэй байна. 10-р хорооны хойд хэсгээр өндөр нягтшилтай хэсэгт хойд хэсэгт байрлах 43-р байр, 130-р байрнуудад болон урд хэсэгт 1990 оноос өмнө баригдсан 19-р байр, 20-р байр, 1-р байр, 45-р байруудад өндөр гарсан. Харин 9-р хороо болох гэр хорооллын бүсэд хамгийн бага утгыг агуулсан бөгөөд урд хэсэгт байрласан нягтшил нь шинээр баригдсан орон сууц орно. Харин 7-р хороонд нягтшил ихтэй томоохон хоёр төв байна. Тус нутаг дэвсгэр нь 11-р хороололд хамаарагдах бөгөөд 1990 оноос өмнө баригдсан 4, 5, 6, 7, 8, 9-р байрууд орж байна. Либерал үзэл нь орон сууцны бүсүүдэд хамгийн өндөр утгыг агуулж байгаа бол гэр хорооллын бүсэд хамгийн бага утгатай байна. (Доорх зурагнаас үзнэ үү.)



Консерватив үзэл баримтлалтай иргэдийн орон зайн шинжилгээ

Зураг 1 Либерал үзэлтэй иргэдийн hot-spot шинжилгээ
(Эх сурвалж: Зохиогч)

Консерватив үзэл нь

эмх журам, тогтвортой байдал, уламжлалт хэв маягийг хадгалж үлдээх хандлагатай. Үзэл бодлын хувьд хувирамтгай бус, аливаа ажлыг шат дараалалтай хийдэг. Энэ үзэл нийгэм, эдийн засгийн асуудалд ихээхэн анхаарал хандуулдаг хүмүүсийн үр нөлөөгөөр 1970-аад оноос идэвхжиж эхэлсэн. Нийт судалгаанд оролцогчдын 89 нь консерватив байр суурьтай иргэд байсан. Эдгээрийн нас, хүйс, боловсрол, ажил, цалин, яс үндэсний хувьд хамаарлыг тогтоосон болно. Үүнд: Насны байдал $r=0,24$, хүйсний байдал $r=-0,09$, боловсролын төвшин $r=0,1$, ажил эрхлэлтийн байдал $r=0,08$, цалин /орлого/ байдал $r=-0,08$, яс үндэсний байдал $r=0,004$ хамааралтай гарсан. (Хүснэгт 3 дээрээс үзнэ үү.) Хүснэгтээс үзэхэд хүйс, ажил эрхлэлт, цалин хөлс, яс үндэсний байдалд хамааралгүй. Харин нас, боловсролын төвшинд эерэг гарч байгаа нь цаашид хэдэн насны, ямар боловсролын төвшинтэй иргэд энэхүү үзэлд хамаарагдаж буйг тодорхойлох шаардлагатайг харуулж байна.


Хүснэгт 2 Консерватив үзэлтэй иргэдийн корреляцын коэффициент
(Эх сурвалж: Зохиогч)

	Нас	Хүйс	Боловсрол	Ажил	Цалин	Ястан	Үзэл
Нас Pearson Correlation	1	-.217*	.105	-.219*	.015	.098	.137
N	89	89	89	89	89	89	89
Хүйс Pearson Correlation	-.217*	1	-.036	.047	.049	-.044	-.220*
N	89	89	89	89	89	89	89
Боловсрол Pearson Correlation	.105	-.036	1	-.060	-.077	-.053	.103
N	89	89	89	89	89	89	89
Ажил Pearson Correlation	-.219*	.047	-.060	1	-.275**	.109	-.264*
N	89	89	89	89	89	89	89
Цалин Pearson Correlation	.015	.049	-.077	-.275**	1	-.150	-.105
N	89	89	89	89	89	89	89
Ястан Pearson Correlation	.098	-.044	-.053	.109	-.150	1	-.086
N	89	89	89	89	89	89	89
Үзэл Pearson Correlation	.137	-.220*	.103	-.264*	-.105	-.086	1
N	89	89	89	89	89	89	89

Хоёр хувьсагч гистограмм шинжилгээ

Консерватив үзэлтэй иргэдийн хамаарлыг тогтооход насны байдал, боловсролын төвшинд хамааралтай утга гарсан тул түүнийг авч хэрэглэсэн. Гистограмм шинжилгээ ашиглан хэдий насны хүн голлож байгааг тодорхойлоход: Дээд боловсролтой иргэдийн 20-40 насны иргэд өсөлттэй, 50-60 насны иргэдийн хувьд мөн тогтмол өсөлтийг үзүүлж байна. Бүрэн дунд боловсролтой 18-19 насны иргэдэд өндөр байгаа ч үзэл бодол нь төлөвших үе дээр байгаа тул тогтсон үзэл баримтлалтай гэж үзэх боломжгүй юм. Консерватив үзэл баримтлалтай иргэдэд боловсролын төвшин ихсэх тусам тайван замаар

өөрчлөлтийг хийх, соёл уламжлалыг харгалзан үзэх байр суурьтай болж байна. (График 3 дээрээс харна уу.)




Консерватив
үзэл
баримтлалтай

нийт 89 иргэдийн

тархалтыг авч үзвэл:

8-р хорооны консерватив үзэл баримтлалтай хүмүүс гурван хэсэгт тархсан бөгөөд хуучны 45-р байр болон 48-р байранд, мөн 25-1-р байр болон 14-2-р байруудад байна. 7-р хороонд хамгийн их буюу 4, 5, 6, 7, 8, 9-р байруудад өндөр нягтшилтай байна. Эдгээр байрууд нь 1990 оноос өмнө баригдсан угсармал орон сууцууд юм. Харин 9-р хорооны орон сууцанд нягтшилтын хувь бага зэрэг гарсан бол 10-р хороонд байрлах хуучны болон шинэ орон сууцанд жигд тархсан нь ажиглагдаж байна. Консерватив үзэл баримтлалтай иргэд орон сууцны бүсүүдэд илүүтэй ажиглагдаж байгаа бол гэр хорооллын бүсэд харьцангуй бага утгатай байна.



Зураг 2 Консерватив үзэлтэй иргэдийн hot-spot шинжилгээ (Эх сурвалж: Зохиогч)

Социал-демократ үзэлтэй иргэдийн орон зайн шинжилгээ

Социал-демократ үзэл нь аливаа асуудлыг тайван замаар шийдэхийг эрмэлздэг бөгөөд үзэл баримтлалын хувьд асуудалд хүмүүнлэг байр сууринаас ханддаг. Улс төрийн байр суурь нь парламентын засаглалыг дэмжин, улс орны эв нэгдлийг сахих зорилготой, марксист үзэл суртлыг шүүмжлэн гарч ирсэн. Энэхүү судалгаанд 378 респондент өөрийн байр суурийг социал-демократ үзэлтэй гэж тодорхойлсон. Тухайн үзэл нь нас, хүйс, боловсролын төвшин, ажил эрхлэлтийн байдал, цалин хөлс, үндэс угсаа зэрэгт хамаарлыг тогтооход, насны хувьд хамаарлын коэффициент $r=0,14$ байна.

		Нас	Хүйс	Боловсрол	Ажил	Цалин	Ястан	Үзэл
Нас	Pearson Correlation	1	-.056	.112*	-.131**	.004	-.098*	.149**
	N	378	378	378	378	378	378	378
Хүйс	Pearson Correlation	-.056	1	-.015	.101*	-.093	.016	-.030
	N	378	378	378	378	378	378	378
Боловсрол	Pearson Correlation	.112*	-.015	1	.133**	-.317**	-.009	.008

N		378	378	378	378	378	378	378
Ажил	Pearson	-.131**	.101*	.133**	1	-.212**	.031	-.022
	Correlation							
N		378	378	378	378	378	378	378
Цалин	Pearson	.004	-.093	-.317**	-.212**	1	-.076	-.015
	Correlation							
N		378	378	378	378	378	378	378
Ястан	Pearson	-.098*	.016	-.009	.031	-.076	1	-.033
	Correlation							
N		378	378	378	378	378	378	378
Үзэл	Pearson	.149**	-.030	.008	-.022	-.015	-.033	1
	Correlation							
N		378	378	378	378	378	378	378

Хүснэгт 4 Социал-демократ үзэлтэй иргэдийн корреляцын коэффициент (Эх сурвалж: Зохиогч)

Нэг хувьсагчийн гистограмм шинжилгээ:

Социал-демократ үзэлтэй иргэдийн насны бүтцийг авч үзвэл: 20-28 насны иргэд хамгийн өндөр хувийг эзэлж байгаа бол 20-40 насны иргэд дийлэнх хувийг эзэлж байна. Мөн түүнчлэн Монгол улсын насны суваргын дагуу байрласан байгаа нь нийт иргэдийн аль ч насныхны дунд асуудалд социал-демократ байр сууринаас хандах хандлага оршиж байдгийг харуулж байна.





График 4 Социал-демократ үзэлтэй иргэдийн насны гистограмм (Эх сурвалж: Зохиогч)

Судалгаанд оролцсон социал-демократ үзэл баримтлалтай респондентуудын орон зайн тархалтыг авч үзвэл. 8-р хорооны 45-р байр, 46-р байр, 47-р байр, 25-1-р байр, 14-2-р байруудад нягтшил ихтэй байна. 7-р хорооны 1990 оноос өмнө баригдсан орон сууц болох 4-р байр, 5-р байр, 6-р байр, 7-р байр, 8-р байр, 9-р байруудад нягтшил хамгийн ихтэй нутаг дэвсгэр байна. 10-р хорооны хойд хэсэгт байрлах 1990-оноос хойш баригдсан 43-р байр, 130-р байранд нягтшил ихтэй байгаа бол хорооны урд хэсэгт байрлах 18-р байр, 19-р байр, 20-р байруудад нягтшил харьцангуй багатай харагдаж байна. 9-р хорооны нутаг дэвсгэрт социал-демократ үзэл баримтлалтай иргэд жигд тархсан байгааг харж болно.



Зураг 3 Социал-демократ үзэлтэй иргэдийн hot-spot шинжилгээ (Эх сурвалж: Зохиогч)

Дүгнэлт: Энэхүү судалгаа нь эмпирик хандлагаар хийгдсэн бөгөөд арга, аргазүйн хувьд асуулга (анкет) судалгаа авч, түүврийн кластерын аргачлалыг ашигласан. Асуулга судалгааг 480 иргэдээс авсан нь түүврийн хэмжээг тогтоох тооцооллоор 99%-ийн магадлалаар $\pm 6\%$ -ийн үнэмшилтэй тооцоолсон. Судалгааны ажил нь нийт эх олонлогийн хамгийн багадаа 93% байхаар тооцсон. Судалгаанд хамрагдсан нийт иргэдийн нийгэм, эдийн засгийн мэдээлэл болон иргэдийн үзэл баримтлалыг тодорхойлж, тухайн иргэдийн үзэл баримтлалд тодорхой хамаарал байгааг олон хүчин зүйлт корреляцын коэффициентоор тодорхойлсон. Улс төрийн голлох үзэл баримтлал болох либерал, социал-демократ үзэл нь иргэдийн насны хувьд $r=0.16$ –ийн хамааралтай ба эдгээр иргэдийн медиан нь 36,2 байгаа нь төлөвшсөн насны иргэд юм. Консерватив үзэлтэй иргэд насны хувьд $r=0.2$ -ийг, боловсролын төвшин $r=0.14$ - хамааралтай байгаа нь боловсролын төвшин ихсэх тусам, мөн нас тогтсон үед консерватив байр суурь нэмэгддэг зүй тогтол ажиглагдаж байна. Судалгаа хийгдсэн нутаг дэвсгэрт иргэдийн нийгэмдээ хандах хандлага, амьдралын нөхцөл боломж, ажил эрхлэлтийн байдал, боловсролын төвшин зэргээс хамаарч тодорхой ялгаатайгаар либерал, консерватив, социал демократ үзлүүдэд

хуваагдаж байна. Тухайлбал, 1980-1990 оны хооронд баригдсан орон сууцанд гэхэд социал демократ, консерватив үзэлтэй иргэд түлхүү амьдарч байхад харин либерал үзэлтэй иргэдийн дийлэнх нь 2000 оноос хойш баригдсан орон сууцанд амьдарч байгаа нь анхаарал татаж байна. Мөн социал демократ үзэлтэй иргэд гэр хорооллын бүсэд илүү давамгайл байгаа нь судалгааны дүнгээс харагдаж байна. Энэ шинжүүд нь анх дэвшүүлсэн таамаглалтай нийцэж байна. Энэхүү судалгаагаар Сүхбаатар дүүргийн 7, 8, 9, 10-р хороог сонгон авч иргэдийн улс төрийн үзэл баримтлалын төлөв байдал, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийн корреляцийн хамаарлыг тогтоож “орон зайн дүн шинжилгээ” хийсэн нь улс төрийн үзэл баримтлалын төвлөрөл, саармагжилт, орчны нэгдмэл шинжийг оновчтой тооцоолох аргачлал болсон. Судалгааны энэхүү арга, аргачлалаар, тухайлбал улс орны хэмжээнд болон нийслэл хотод тулгамдаж буй олон асуудлуудын зураглал-гарцыг тодорхойлох аваас үр дүнгээ өгнө.

ABSTRACT

Peoples political ideology is determined by study of political geography theory and methodology. Therefore, the people's political ideology is described all over the country and region by the cartography approach. The aim of this research work is to determine the micro environmental situations and impact factors using the hot-spot analysis. In addition, I considered the size of research area as an electoral district and gathered information from 480 respondents. I chose the respondents by cluster collection approach using questionnaire method and considered the level of collection as 99% probability and respondents as ± 6 interval. This research is significant to determine the political attitude of the citizens, define the spatial dependence and evaluate the spatial situations of the political parties. I determined the spatial situations by studying the political attitude of the citizens using hot-spot analysis. This research work is the basic study which will be carried out at micro level of Peoples political ideology study.

Ашигласан ном, материал

- McDaneil C. and Gates R. (2012). Marketing Research Essentials, 8th Edition, South-Western College Publishing
- Agnew, J.A. (2002) “Making Political Geography. London: Arnold.”
- Florian Stoffel, Halldor Janetzko, Florain Mansmann., (2012) “Proportions in Categorical and Geographic Data: Visualizing the Results of Political Elections”

Ц.Ганболд, Ц.Батболд “Политологи”эрдэм шинжилгээний бичиг, 22-р хуудас
Ном, сурах бичиг:

- Pattison, W.D. (1990). "Four Traditions of Geography" Journal of Geography: pp. 202-6. Reprint of a 1964 article.
- Колин Робсон. (2006)“Бодит ертөнцийг судлахуй.” Нийгмийн ухаан болон мэргэжлийн судлаачдад зориулсан гарын авлага. УБ.,
- Шинжлэх ухааны академи философи, социологи, эрхийн хүрээлэн. Ц.Баатартогтох “Социологийн судалгааны аргазүй, аргачлал” УБ., 2008
- (2012) “Нийгмийн шинжлэх ухааны судалгааны аргазүй”. УБ., хуудас 124
- Б.Долгор, Я.Төгөлдөр, Б.Энхамгалан, Д.Одмаа Ш.Эвсанаа. (2010) “Улс төр судлал”.УБ., хуудас 59
- Колосов. В.А. (1995) Политическая география сегодня. М. стр 12
- М.Баянтөр, В.Батцэнгэл, Н.Одхүү (2012) “Улс төрийн газарзүй” УБ. хот
- Barney Warf and Jonathan Leib (2011) “Revitalizing Electoral Geography” USA.
- Д.Даш, Н.Мандах, (2011). “Газарзүйн шинжлэх ухааны хөгжлийн түүх” ху.583
- УТБА. (1995) Лекцийн эмхтгэл 2-р дэвтэр. УБ.,

Программ хангамж:

- ESRI, (2012), “ArcGIS”, Redlands, CA, хувилбар 10.1.
- Microsoft, (2010), “Office 2010”, Redmond, Washington .
- IMB, (2015), “SPSS statistics 23”

УЛС ТӨРЧИЙН ИМИЖЭЭ БҮРДҮҮЛЭХ ТЕХНОЛОГИ БА УЛС ТӨРИЙН МЭРГЭЖЛИЙН ОНЦЛОГ

У.БАТЦЭРЭН

Доктор(Ph.D)

Удирдлагын Академи. Төрийн алба, удирдлагын сургууль.

Сургалтын менежер,

Шинжлэх Ухааны Академи. Философийн хүрээлэн.

Улс төр, эрх зүйн салбар. Эрдэм шинжилгээний дэд ажилтан

Ү.БАТБАЯР

Удирдлагын академи. Удирдахуйн ухааны сургууль.

Магистрант

Түлхүүр үгс:Имиж, улс төрч, нэр дэвшигч, сонгуулийн кампани, улс төрийн имижейкер, улс төрийн зөвлөх, улс төрийн технологич, улс төрийн соёл, улс төрийн ёс суртахуун.

Товч утга: Улс төрчийнимижбүрдүүлэх технологи нь тусгай мэргэжлийн улс төрийн ажилтан нарийн хийдэг ажил билээ. Өөрөөр хэлбэл, улс төрийн имижейкер тэргүүтэй улс төрийн мэргэжилтэн нар сонгуульд нэр дэвшигч болон улс төрч нарийн имижийг цаг ямагт бүрдүүлж байдаг. Улс төрийн имижейкер нь улс төрийн субьектийн имижийг бүрдүүлэхдээ улс төрчийн хувийн соёл, зан чанар, ёс суртахуун зэрэг хүчин зүйлийг судлан ажилдаг.

Улс төрчийн соёл, ёс суртахуун зэргээс түүний улс төрийн имиж бүрэлдэх үйл явц ихээхэн шалтгаалдаг. Энэхүү өгүүллээ ШУА-ийн ФХ-ийн Улс төр, эрх зүйн салбарын суурь судалгааны төслийн хүрээнд онцлон онол, практик талаас нь судлан үзэхийг зорив.

Улс төрчийн имижийг бүрдүүлэхдээ түүнд тохирсон зохистой арга, технологийг бий болгох нь улс төрийн мэргэжилтэн нарын хийж хэрэгжүүлэх үндсэн ажил юм. Өөрөөр хэлбэл, улс төрчийн имиж бүрдүүлэх үйл явц нь олон шатлалт бүхий нарийн нийлмэл, төвөгтэй үйл явц юм. 2008 оноос хойших Улсын Их Хурал болон Ерөнхийлөгчийн сонгуулиудад дүн шинжилгээ хийж үзэхэд нэр дэвшигчдийн имижийг бүрдүүлэхдээ улс төрийн мэргэжилтэн нар дараах үндсэн хоёр алхмыг хийж хэрэгжүүлж байна. Үүнд: Нэгдүгээрт: сонгуулийн кампанит ажлын үед олон нийтийн санаа бодол, өрсөлдөгч нам, нэр дэвшигчийг тандан судлах; цуглуулсан мэдээлэлд боловсруулалт хийж, сонгуульд

өрсөлдөж буй нэр дэвшигчийн давуу ба сул талыг тодорхойлох; сонгуулийн кампанийн бодлого, төлөвлөгөө, үйл ажиллагааг хэрхэн удирдан явуулах арга замыг боловсруулах; зорилтот бүлгийг тодорхойлох, тулгамдсан асуудал, сонгуулийн зорилго, уриа боловсруулах. Хоёрдугаарт: сонгуулийн кампанийн технологийг хэрэгжүүлэх үндсэн субъектийг сонгож бүрдүүлэх (сонгуулийн кампанийг зохион байгуулах баг), тэдгээрийн чиг үүргийн хуваарилалт; үйл ажиллагааны нэгдсэн график-төлөвлөгөөг хийж, хэрэгжүүлэх; хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээ, чиглэлийг тодорхойлж, зураглалыг хийх; зорилго, зорилтыг хэрэгжүүлэх; улс төрийн болон сонгогчдын нийгэм-сэтгэл зүйн шинж байдал, өрсөлдөгч талын аргыг тандан судлах; цагийн байдлын үнэлгээ, шийдэл; нэр дэвшигчийн хувийн соёл, үйл байдлын имижийг бүрдүүлэх; мэдээлэл-сурталчилгааны үйл ажиллагаа; гэнэтийн цохилт үзүүлэх төлөвлөгөө боловсруулах; үйл явцад хяналт-шинжилгээ хийх; үр дүнг тооцох зэрэг ажлыг хийж хэрэгжүүлж байна.

Улс төрч (нэр дэвшигч)-ийн имижийг бүрдүүлэх үйл явц нь сонгуулийн кампанийн удирдлага, зохион байгуулалттай холбоо бүхий олон талт, чанд нарийн дэс дараалал бүхий олон шатлалт үйл ажиллагаа явц байдаг.

Сонгуулийн кампанийн явц дахь улс төрчийн имиж бүрдүүлэх үйл явц нь сонгуулийн кампанийн технологийг гардан хэрэгжүүлэгч тодорхой үүрэг бүхий субъектүүдийн идэвхтэй үйл ажиллагаанаас ихээхэн хамаардаг. Манай улсын хувьд сонгуулийн кампанийг удирдан зохицуулагч субъект нь хэв шинжээрээ дараах онцлог, байдалтай байна. Үүнд:

- Сонгуулийн кампанийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, сонгуулийн штабын үйл ажиллагааны олон чиглэлийг хооронд нь нэгтгэн зохицуулах, өдөр тутмын үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх, нөхцөл байдалтай уялдуулан сонгуулийн үйл ажиллагаатай холбогдох нэмэлт өөрчлөлт оруулах үүрэгтэй нэр дэвшигчийн сонгуулийн штабын **ерөнхий менежер, улс төрийн мэргэжилтэн**;
- Нэр дэвшигчийн сонгуулийн кампанийн бодлого, шийдвэр гаргах, нэр дэвшигчийн сонгуулийн штабыг үйл ажиллагааг бүхэлд нь удирдлага, зохион байгуулалтаар хангах, хүний нөөц, санхүү, хангамжийн асуудлыг зохицуулах үүрэгтэй **штабын удирдагч**;
- Сонгуулийн кампанийн санхүүгийн асуудал хариуцсан **санхүүгийн менежер**;
- Нэр дэвшигчийн сонгуулийн штабын дотоод үйл ажиллагааг зохицуулагч **оффис менежер**;

- Нэр дэвшигчийн сонгуулийн штабаас сонгуулийн тойрогт хэрэгжүүлэх бүх арга хэмжээг газар дээр нь зохион байгуулах, тойргийн сонгогчидтой хийх уулзалт, хурал цуглаан болон ганцаарчилсан арга хэмжээ хариуцсан зохион байгуулагч **менежер**;
- Нэр дэвшигчийн ажлын график, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй хяналт-төлөвлөлтийн **менежер**;
- Нэр дэвшигчийн ухуулга сурталчилгааны материалыг сонгуулийн тойрогт байршуулах асуудлыг хариуцсан **менежер**;
- Нэр дэвшигчийн ухуулга сурталчилгааны материалын эх зохиогч **дизайн мэргэжилтэн**;
- Нэрдэвшигчийн сурталчилгааны материал тараах, сонгогчдын дунд сурталчилгаа явуулах, сонгогчдын дунд ажиллах ухуулагч; ухуулга, сурталчилгааны ажилд тойргийн сонгогчдоос татан оролцуулах үүрэгтэй **сайн дурын баг** зэрэг багтдаг.

Нэр дэвшигчийн имиж бүрдүүлэх багт дээрх мэргэжилтэнүүдээс гадна улс төрийн мэргэжлийн дараах мэргэжилтэнүүд ажиллаж багийг нь удирдаж байдаг билээ. Үүнд:

- Нийт сонгогчдод хүргэх нэр дэвшигчийн сонгуулийн дүр төрх, имижийг боловсруулах ажлыг хариуцан, багийг ахлах **улс төрийн имижмейкер**;
- Нэр дэвшигчийн сонгуулийн кампанийг илүү үр дүнтэй зохион байгуулах талаар санал, дүгнэлт гаргах үүрэгтэй **улс төрийн зөвлөх, технологич**;
- Олон нийтийн харилцаа, хэвлэл мэдээллийн асуудал хариуцсан **PR мэргэжилтэн**;
- Олон нийтийн санаа бодол, нэр дэвшигчийн рейтинг судлах **социологийн шинжээч**;
- Нэр дэвшигчийн уриа, хэлэх үг, сурталчилгааны бичмэл эх зохиох **спичрайтер**;

Сонгуулийн кампанийн технологийг хэрэгжүүлэгч дээр онцолсон субъектүүд нь тус тусын ажил үүргээрээ дамжуулан сонгуульд нэр дэвшигч улс төрчийн имиж бүрдүүлэлтэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Тэдгээр нь сонгуулийн кампанийн технологи хийгээд нэр дэвшигчийн имижийг бүрдүүлэхдээ дасан зохицох; зохицуулах; өөрийгөө хадгалах; сэлбэлт, өөрчлөлт хийх; мэдээллийн харилцаа тогтоох; удирдах; сонгуулийн кампанийн үеийн сонирхлыг илрүүлэх, нэгтгэх, гэх зэрэг үндсэн чиг үүргийг харилцан хамааралт байдлаар хэрэгжүүлдэг.

Аливаа орны сонгогчдыг *ард түмэн, сонгогч, иргэн* гэсэн гурван хэсэгт хуваах нь нийтлэг байдаг. Хэний ч телее саналаа өгсөн эхний хэсэг (*ардтүмэн*)-т ялгаагүй. Хоёр дахь хэсэг (*сонгогч*)-т хамаарах хүмүүс санал хураах байранд ирэхдээ сонголтоо хэдийнээ хийчихсэн байдаг ч дэмжиж буй нэр дэвшигчийнхээ гадаад өнгө төрх, гарал үүслийг ихэд сонирхдог байна. Харин гурав дахь хэсэгбуюу *иргэд* нь нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөр, ажил хэргийн хийгээд улс төрийн нэр хүндийг нь харьцуулан үзэжхэний телее санал өгөхөө шийддэг. Тэдний санаа бодлыг ямар ч ухуулга, ямар ч сонгуулийн кампанит ажил, арга хэмжээ өөрчилж чаддаггүй. Ардчилал хөгжихийн хирээр энэ хэсэгт хамаарагдах хүмүүсийн тоо нэмэгдэж байна.

Нэгэн зүйлийг тодруулахад **улс төрч** бол улс төрийн мэргэжилтэн юм. Өөрөөр хэлбэл, улс төрч нь нийгэмд чухал байр суурьтай мэргэжил юм. Хүн төрөлхтний хамгийн эртний ажлын нэг гэж тооцогддог энэхүү мэргэжил сайнаасаа илүү муу нэрийг олонтаа дагуулдаг, дагуулж байгаа нь өнөөгийн нийгэмд олон нийтэд илт харагдаж байна. Ямартай ч орчин үеийн олон талт, улам бүр нарийсан чамбайрч буй нийгэм нь хөдөлмөрийн олон янзын хуваарийг шаардах болсон нь улс төрийн салбарт ч үйлчлэх болжээ. Өдгөө улс төрч гэдэг нь тун ерөнхий шинжтэй төдийгүй улс төрийн талбарт ажиллаж буй цор ганц мэргэшсэн этгээд биш гэдэг нь хэн бүхэнд ойлгомжтой.

Улс төр бол багийн тоглолт. Тэр тусмаа улам бүр нарийн төвөгтэй болж буй нийгэм, улс төрийн харилцаанд улс төрийн нарийн мэргэжилтэй нөхдөөр багаа бүрдүүлсэн тэрхүү улс төрч л амжилт олж, түүнийгээ бататгаж чадна. Орчин цагийн улс төрийн үйл ажиллагаанд улс төрчидтэй цуг, гэхдээ гол төлөв хөшигний ард үлддэг билээ. Тухайлбал, улс төрийн имижмейкер, зөвлөх, технологич, PR-ийн мэргэжилтэн нар юм. Өнөө үед улс төрийн бодит нөхцөл байдлыг тэдгээрээс салангид авч үзэх боломжгүй болжээ.

Дээрх ажил мэргэжлүүдийг их дээд сургуульд тухайлан бэлтгэдэггүй бөгөөд мэргэжлийн талаар гарын авлагууд дээр дурьдсан байх нь тун ховор юм. Гэхдээ улс төр нь мэргэжлийн үйл ажиллагааны хүрээ болон хувирч, улс төрч гэдэг нь ажил үүргээсээ хамааран мэргэшсэн этгээд гэж тооцогдох явдал улам бүр өргөжиж байна. Энэхүү мэргэжилийн үйл явц нь урт хугацааны, олон хүчин зүйл, нөхцлөөс хамаардаг. Юуны түүрүүнд энэ нь практикаар олж авдаг мэргэжил бөгөөд ялангуяа “улс төрч”-ийг үүнд тооцож болно. Гэхдээ үйл явц бүр эхнээсээ аваад цогц байдлаар тодорхойлогдож эхлэх нь бий. Үүний нотолгоо нь улс төрч өөрийн дэргэд улс төрийн зөвлөх, технологич, имижмейкер гэх мэргэжилтнүүдийг багтаасан “баг”-ийг бүрдүүлэхээс ажил нь эхэлдэг. Улс төрийн имижмейкер, зөвлөх, технологич гэсэн улс төрийн мэргэжлийн талаар товч тайлбар хийв.

Улс төрийн имижемейкер. Өөрийн үйлчлүүлэгчдийн нэр хүнд, имижийг засч зохицуулдаг мэргэжилтэн.Имижемейкер гэдэг бол улс төрийн, нийгмийн зүтгэлтнүүд олон түмний сэтгэлийг татах, нэр хүнд олж авахад дөхөм үзүүлэх тодорхой дүр төрхийг бий болгох улс төрийн мэргэжилтэн юм.Улс төрийн өрсөлдөөний ертөнцөд улс төрчид бие биенээсээ илүү харагдахыг эрмэлзэж байдаг. Өөрөөр хэлбэл, сонгуулийн нэг тойрогт нэг л ялагч байх бөгөөд харин түүний төлөө хэд хэдэн нэр дэвшигчид өрсөлдөх болдог.“Өөрийнхөө улс төрчийг сэтгэл татам” байлгах нь имижемейкерийн гол зорилго юм.

Орчин үед улс төрийн менежмент явуулах, имиж бүтээх нь өөрийн дэг жаяг, технологи ба улс төр, зах зээлийн өвөрмөц үйл явц юм. Улс төрийн кампанит ажлыг зохион байгуулах тусгай агентлагийг1950-иад онд АНУ-д анхлан бий болгосон байдаг. Улмаар өнөө үед дэлхий нийтэд мэдээллийн коммуникацын хэрэгсэл эрчимтэй хөгжсөн бөгөөд түүнийг дагаад дээрх байгууллагууд сонгуулийн стратеги ба тактикийг хүчтэй явуулан, сонгуульд нэр дэвшигчийг өрсөлдөх чадвартай дүр төрх, имижийг олон нийтийн санаанд нийцүүлэхийн төлөө ажиллаж байна. Улс төрч нь жирийн хүнийг бодвол илүү эрх мэдэлтэй, хүчирхэг, түрэмгий байх ёстой гэдэг. Харин тэвдүү, хийрхүү үйлдэл гаргаж болохгүй. Ялангуяа хямралын нөхцөл өрнөсөн улс орны лидер хүн ард түмэн, сонгогчдод тайван, итгэлтэй шинжийг төрүүлэх хэрэгтэй. Энэ утгаар нь авч үзвэл улс төрч өнөөгийн цаг үеийнх биш, харин ирээдүйн бэлгэ тэмдэг болох ёстой юм.

Имижемейкер бол улс төрчийн имиж бүрдүүлэгч төдийгүй сонгогчдыг судлах, тэдний улс төрийн боловсролд нөлөөлөх, тухайн тойрог, орон нутгийн хэмжээнд судалгаа явуулж сонгогчдын хүсэл эрмэлзэл, юуг хүсэн хүлээж байгааг судалж байдаг. Мөн өөрийн нэр дэвшигчийн өрсөлдөх тойргийг зөв оновчтой сонгохоос имижемейкерийн ажил эхэлнэ гэж үзэж болно. Өрсөлдөх тойргийг зөв тодорхойлох нь цаашид нэр дэвшигчийн имижийг бүрдүүлэх, хувийн чанарыг нээн харуулах, тойргийн сонгогчидтой хэрхэн ажиллах талаар арга барил, тактикаа сонгоход дөхөм болдог. Өрсөлдөх тойргийг сонгохдоо тойргийн хүн амын тоо, сүүлийн сонгуульд оролцсон ирц, сонгуулийн үр дүн, өрсөлдөгчдийн рейтингийн талаархи социологийн судалгааны үр дүн, тойргийн томоохон байгууллага, аж ахуйн нэгж, банк, даатгалын компани, тэдний удирдагчдын сонирхол, сонгогчдын орлого, нийгмийн бүтэц, сонирхол зэргийгтуршлагатай имижемейкерүүд харгалзан үзэж имиж бүрдүүлэх кампанит ажилдаа ашиглаж амжилтад хүрэх нь бий.

Улс төрийн имижмейкер нь сонгуулийн кампанийг зохион байгуулах технологийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор нэр дэвшигч буюу улс төрчийн имижийг дараах үе шаттайгаар бүрдүүлэн ажиллаж байна.¹⁶¹

Эхлэлийн үе шат. Энэ үед нэр дэвшигчийг тодруулах, бүртгүүлэх; сонгуулийн кампанийн төв штаб, сонгуулийн кампанийг гардан явуулах удирдах болон гүйцэтгэгч багийг бүрдүүлэх; тойргийн оношлогоо буюу мэдээлэл бүрдүүлэх, дүн шинжилгээ хийх; сонгуулийн кампанит ажлын бүрэн нөөцийг тодорхойлох; зорилгоо тодорхойлж, бодлогоо төлөвлөх; сонгогчдын бүтцийн анализ, зорилгот бүлгийн тухай тодорхойлолт; урьдчилсан сонгуулийн мөрийн хөтөлбөрийг боловсруулах; сонгуулийн кампанит ажлын үзэл баримтлалыг боловсруулах зэрэг тодорхой үйл ажиллагааг дэс дараатай хэрэгжүүлэх хэрэгтэй.

Дүнд үе шат. Энэ үед сонгуулийн кампанийн бодлого, үйл ажиллагаа ба шуурхай үйлдлийн төлөвлөгөөг боловсруулах; сонгуулийн кампанит ажлын технологийн хэрэгжилтийн ажлын төлөвлөгөө, графикийг хийх; намын болон нэр дэвшигчийн имижийг бүрдүүлэх; кампанит ажлын санхүүгийн төлөвлөгөөг зохиох, төсвийн хуваарилалт хийх; реклам сурталчилгааны хэлбэрийг сонгож хэрэгжүүлэх; зохицуулалтын тусгай нэмэлт хөтөлбөр боловсруулах; кампанит ажлын төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавих; нэр дэвшигчийн хэлж ярих зүйлийг боловсруулж, редакцхийх; сонгуулийн өдөр тутмын ажил зэрэг үйл ажиллагааны төрлийг багтааж болно.

Төгсгөл үе шат. Энэ үед өөрсдийн нөөц боломжийн зарцуулалт, үр дүнг дахин тооцож, реклам сурталчилгааны хамгийн оргил арга ажиллагааг хэрэгжүүлж, өрсөлдөгчийнхөө эсрэг том цохилт өгөх төлөвлөгөөг хэрэгжүүлэх замаар сонгуулийн кампаниа дуусгахаас гадна сонгуулийн кампанийн технологийн хэрэгжилтийн үр дүнг тооцон, ялалт, ялагдлын аль алинаас алдаа, оноогоо олж харж, нэгтгэн дүгнэх, үйл ажиллагааны үр дүнгийн талаар мэдээлэл цуглуулах, тэрхүү мэдээллийг үнэлж дүгнэх, санхүүгийн төсвийн зарцуулалтын үр дүнг тооцох, сонгуулийн үр дүнг олон түмэнд мэдээлэх, сонгуулийн үр дүнгээс туршлага сургамж авах, дараа дараагийн сонгуулийн кампанийг явуулахад тус дөхөм болох мэдээллийн санг бүрдүүлж, архивлах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байна.

Имижмейкер нь нэр дэвшигчийг сонгогчдод таниулах гол зүйл бол нэр дэвшигчийн улс төрийн үзэл бодол, байр суурийг тайлбарлан ойлгуулах явдал юм. Нэр дэвшигчийн ертөнцийг үзэх үзэл, улс төрийн нөхцөл байдалд хандах хандлага, нийгмийн тулгамдсан

¹⁶¹У.Батцэрэн. “Улс төрийн лидерийн имиж бүрдүүлэлтэд хэвлэл мэдээллийн хэрэгслийн гүйцэтгэх үүрэг”. Диссертаци. УБ., 2017. 56 дахь тал.

асуудлын талаархи ойлголт, сэтгэлгээний хэв маяг энэ бүхэн сонголт хийхэд нөлөөлдөг чухал хүчин зүйл байдаг.

Улс төрчдийн дотор имижмейкерүүд юу хийдэг талаар нилээд сонирхолтой төөрөгдөл байдаг. Энэ төөрөгдлийг зарим мэргэжилтнүүд ашиглах нь бий. Тэдний зарим нь өөрсдийгөө имижмейкер гэж танилцуулаад улс төрчдөд зангиагаа солих, үсээ янзлах талаар зөвлөлгөө өгч байдаг. Гадаад дүр төрхийг өөрчлөх нь зөв боловч энэ нь имиж бүрдүүлэхэд туслах үүргийг л гүйцэтгэдэг.

Улс төрийн зөвлөх. Улс төрийн зөвлөх буюу консультантын зорилгод ирээдүйн улс төрийн болзошгүй үйл явдлыг таамаглах, сонгогчдын дунд төсөл хэрэгжүүлэх, түүний улс төрийн “үүр” нь болох учиртай мэргэжлийн хүрээлээ бүрдүүлэх ажиллагаа багтдаг.

Имижмейкерээс ялгаатай нь тэр шоу зохиодоггүй буюу улс төрчийн гадаад байдал, театрын тоглолтод анхаарал хандуулдаггүй. Улс төрчийн зөвлөгч нь өөр өөр бодит илрэл болох бүдүүвч, хийсвэр үзэл санаа, төсөлтэй ажилладаг нэгэн бөгөөд улс төрийн субъектийн үйл байдлын зохист үзэл баримтлалтай тэдгээрийг нийлэгжүүлэх ажлыг гүйцэтгэж байдаг ажээ. Энэхүү үйл ажиллагааны утга учир нь улс төрчийн дотоод үзэл бодлыг гадаад илрэлтэй нь хоршуулан нэгтгэхэд оршино. Гэхдээ түүний хамгийн гол зорилго бол улс төрийн шинэ орон зайг төлөвшүүлэх, цогцлоох, цаашлаад улс төрчийн мэргэжлийн чадварыг дээд зэргээр эзэмшсэн хүмүүсийн хүрээлэлд улс төрийн үйл ажиллагааны нөхцөлд зохицон нийцэж буйг тодорхойлох, харуулах явдал юм.

Улс төрийн зөвлөхийн үйл ажиллагаанд ирээдүйг таамаглах үй явц зайлшгүй ордог. Учир нь тухайн цаг үедээ огт төсөөлөгдөхөөргүй ч хэтийн төлөвтөө өрнөж болох улс төрийн үйл явдлыг таамаглах шаардлага байнга гардаг. Мэдээж, өнөөдөр хэн нэг улс төрч гудамжинд “лааз өшиглөж”, эсвэл “төр засгийг гал тогооноосоо удирдан залж” буй тухай сэдэв “моодонд” орж болно. Гэхдээ улс төрийн зөвлөх үүнээс ангид оршиж, мэргэшсэн улс төрчдийн давхаргаас бүрдсэн тэрхүү орчныг сайн мэдэж, хөвж чаддаг байх шаардлагатай. Тэрхүү орчин бол удирдлага ба менежментийн хүрээ гэдгийг юун түрүүн ухамсарлах хэрэгтэй.

Улс төрч нь улс төрийн бодит талбарыг бүрдүүлж байдаг хувь хүмүүсийн хоорондын харилцааны төрөлх орчинд л оршин тогтнож байдаг юм. Шаардлагатай оношилгоо дүгнэлтийн багц арга хэрэгслийг ашигладаг бусад мэргэжлүүдээс ялгагдах онцлог нь улс төрч хүн өөрийн мэргэжлийн дадал туршлагыг хөгжүүлэхийн тулд боломжит хандлагыг туршин үзэх бололцоотой байдаг. Улмаар тэдгээр хандлагууд цаашдаа улам боловсронгуй болох байдлаар явагддаг болохыг хэлэх нь зүйтэй.

Улс төрийн технологич. Улс төрийн технологич нь багийн бусад гишүүдийн боловсруулсан онолын бүдүүвч, хийсвэр сэтгэлгээний санаа оноог нь бодит амьдралд

буулган хэрэгжүүлэх асуудлыг эрхэлдэг улс төрийн мэргэжилтэн юм. Тэр тухайн улс төрийн нөхцөл байдалд хамгийн үр нөлөөтэй гэсэн арга, технологийг задлан гаргах чадвартай байх ёстой. Чухамдаа улс төрийн технологич гэдэг нь олон түмний ухамсрыг далд байдлаар удирдан чиглүүлэх, сонгогчдын сэтгэл санааг урхидах чадварыг эзэмшсэн нэгэн юм.

Мэргэшсэн шинжээч гэж үнэлэгдэхийн тулд тэрхүү этгээд нийгмийн сэтгэл зүй, улс төр, социологи, зар сурталчилгааны сэтгэл зүйн мэдлэгтэй, стандарт бус бүтээлч сэтгэлгээтэй, утга зохиол, урлагийн нарийн мэдрэмжтэй байх гэсэн нэлээн өндөр болзол нөхцөлийг хангах шаардлагатай болдог.

НОМ ЗҮЙ:

1. А.В.Пониделко, А.В.Лукашев. “Черный PR как способ овладения властью или бомба для имиджмейкера”. СП., 2000.
2. Монгол Улсын Их Сургууль. “Политлоги”. Эрдэм шинжилгээний бичиг. №15. (476). УБ., 2017.
3. Удирдлагын академи. “Удирдахуйн онол, практикийн асуудлууд”. Эрдэм шинжилгээний бичиг. №1. (17). УБ., 2017.
4. У.Батцэрэн. “Улс төрийн имиж бүрдүүлэлт ба манипуляци”. УБ., 2006.
5. У.Батцэрэн. “Улс төрийн лидерийн имиж бүрдүүлэлтэд хэвлэл мэдээллийн хэрэгслийн гүйцэтгэх үүрэг”. Диссертаци. УБ., 2017.
6. Философийн хүрээлэн. “Философи эрхийн судлал”. Эрдэм шинжилгээний бичиг. Боть №32. УБ., 2017.

МОНГОЛЫН НИЙГМИЙН ДҮР ТӨРХ

Ц.Өлзийжаргал

*БНХАУ, Шаньдун их сургууль, Улс төр судлал, нийтийн удирдлагын
сургуулийн докторант*

Ч.Өлзийсайхан

МУИС, Улс төр судлалын тэнхимийнбагш, доктор, дэд профессор

Хураангуй: Монгол улсад өрнөсөн улс төрийн өөрчлөлт нь олон талтай, маш нарийн төвөгтэй үйл явц байсан бөгөөдхувь хүний үзэл бодол, итгэл үнэмшил, эрх, эрх чөлөөнөөс эхлээд засаг төрийн бүтэц зохион байгуулалтыг хүртэл хамарсан өргөн хүрээтэй үйл явц болон өрнөсөн. Энэ өгүүлэлд улс төрийн өөрчлөлт нь гэр бүл, нийгэм, улс төрийн хүрээнд явагдаж ямар үр дүн гарч байгаа тухай өгүүлэх болно.

Түлхүүр үгс: ардчилал, тэгшитгэл, ядуурал, гэр бүл салалт, нийгмийн давхраажил, авлига, иргэний нийгмийн байгуулал, хууль, хяналтын тогтолцоо

XX зуун бол дэлхий дахинд өргөн хүрээтэй өөрчлөлт өрнөсөн зуун байсан бөгөөд хамгийн гол үйл явц бол улс төрийн хүрээний өөрчлөлтүүд хаа сайгүй өрнөсөн явдал юм. Монгол улсад өрнөсөн улс төрийн өөрчлөлт нь олон талтай, төвөгтэй үйл явц байсан бөгөөд хувь хүний үзэл бодол, итгэл үнэмшил, эрх, эрх чөлөөнөөс эхлээд засаг төрийн бүтэц зохион байгуулалтыг хүртэл хамарсан. Нийгэм улс төрийн бүх талыг хамарсан энэ өөрчлөлтийн нэг үр дүн нь улс төрийн шинжлэх ухааныг ч өөр өнгө аястайгаар өөрчилсөн. Улс төрийн шинжлэх ухааныг зөвхөн ардчилал шинэчлэлтэй холбоотой хөгжсөн гэж өрөөсгөл ойлгож болохгүй. Аристотель Платоноос авахуулаад дундад зуун, сэргэн мандалт, соён гэгээрэл, аж үйлдвэрийн хувьсгал, социализм, өөрчлөн байгуулалт гээд өөрчлөлт шинэчлэлтийн давалгаа бүрт улс төрийн шинжлэх ухаан цаг үеийн тусгал болон өөр өөр өнгө аястайгаар хөгжиж байсан билээ. 1990 оноос хойшхи улс төрийн шинжлэх ухааны хөгжил, өөрчлөлт, үнэт зүйлсийг туйлын үнэн гэж үзэх нь эргэлзээтэй, харин энэ цаг үеийн онцлогийг тусгасан байгаа болов уу гэж үзэх нь илүү зохистой. Учир нь дэлхийн улс орнуудад ардчиллыг хүлээж авах байдал өөр өөр, ардчилсан элементийг өнгөц харахад бүрэн агуулсан мэт байгаа улс орнуудын нийгмийн харилцаанд ч үр дүн ихээхэн өөр өөр байгаа байдал нь үүнд дүн шинжилгээ хийх боломжийг л илүү түлхүү тавьж байна гэж үзэж болох юм. Цаг үе бүхэнд ноёрхон буй үзэл суртал нь өөр өөрийн улс төрийн тогтолцоо, системийн аюулгүй байдлаа хамгаалсан шинжтэй байдаг нь үнэн юм.

Төрийн засаглалын хэлбэр, үндсэн хуулийн тогтвортой шинж, хуулийн мөн чанар нь хэний эрх ашиг, сонирхлыг илэрхийлж байна вэ гэдэгт эрдэмтэн судлаачид, эртний

нэрт сэтгэгчид нар ач холбогдол өгөн судласан байдаг. Тухайлбал, Сократ төр, засаглалын хэлбэрийг хэв маягчлан үзэхдээ хаант засаг, дарангуй засаг, язгууртны засаг, баячуудын засаг, олон түмний засаг¹⁶² гэж ялган үзсэн байдаг. Мөн төр нийгмийн хэвийн оршин тогтнож, үйл ажиллагаагаа явуулах гол нөхцөл нь хууль бөгөөд ухаалаг шудрага хууль тогтож ноёрхсон нөхцөлд иргэдийн улс төрийн эрх чөлөө хэрэгжих боломжийг бий болгодог гэж үзжээ.

Сократ олон түмний засаглал буюу ардчиллыг онолын хувьд шүүмжлэлтэй хандаж байснаас гадна түүний шавь Платон “Төр” хэмээх зохиолдоо төр, төрийн засаглалын таван янзын хэлбэрийг гарган тавьж, тэдгээрийг хооронд нь харьцуулан шинжилсэн байдаг. Энэ нь *нэгд*, аристократ /язгууртны/, *хоёрт*, тимократ, *гуравт*, олигархи, *дөрөвт*, демократ, *тавд*, тиран төрийн хэлбэр юм. Платон тэдгээрийн тус бүрийн онцлогийг нь шинжлэн үзээд *тимократ* төр бол эд баялаг, нэр төрт хэт шунасан, олз ашиг, дайн байлдааныг гол үйл ажиллагаагаа болгогсодын төрийн засаглалын хэлбэр юм. *Олигархи* хэлбэр нь эд хөрөнгөн дээр тогтсон, засаглалын эрх мэдлийг цөөнх болсон баячууд барьж удирдсан, ядуус нь засаглалд оролцдоггүй төрийн байгуулал юм. Тимократ төрийн үед алт, эд баялаг хувь хүмүүсийн гарт орж хуримтлагдах нь энэ төрийг мөхөлд хүргэж баячуудын засаг тогтоход хүргэнэ. Энэ үед баячууд төрийн хуулийг дур зоргоор ойлгон хэрэглэж, эд баялагт шунан, сайн үйлийг умартан эд баялаг ба баячууд нийгэмд илүү их үнэ цэнэтэй, хүндтэй болно. Засгийн эрх мэдлийг зэр зэвсэг, айлган сүрдүүлэх, хүчирхийлэлийн аргаар барина. Ийм нөхцөлд нийгэм тогтворгүй болж, баян, ядуугийн хооронд тэмцэл гарч эцэсдээ хорсож, хилэгнэсэн ард олон өөрийн засаглалыг тогтооно. Энэ засаглал бол *демократ* төрийн хэлбэр юм. Энэ үед нийгэмд түгээмэл эрх чөлөө ноёрхож, дээдэс, доодос ялгаагүй адилхан эрх мэдэлтэй болж, бүх зүйлийг *тэгшитгэнэ*. Эрх чөлөө нь хэн, юу дуртайгаа хийх бололцоог олгох ба үүний уршгаар эрх чөлөөний хэм хэмжээ алдагдаж, нийгэмд эмх замбараагүй, засаг захиргаагүй байдал газар авна, хязгааргүй эрх чөлөө нь нийгмийг хямраана. Засгийн эрхэнд жинхэнэ шудрага хүн, мэдлэг, чадвартай хүмүүс бус харин тохиолдлоор гарч ирнэ. Тэд үнэнч шудрага, ажил хэрэгч хүмүүсийг элдвээр шахан хавчиж, бялдууч, хоёр нүүртэнгүүдээр өөрсдийгөө хүрээлүүлнэ. Тэдгээр нь хамтран эрх чөлөө, шударга ёсны зарчмыг уландаа гишгэнэ. Үүний улмаас олон түмэн албан тушаалтнуудаа шудрага ёс, эрх чөлөөг завхруулсан хэмээн хатуу шийтгэнэ. Нийгэм тэнцвэрээ алдаж, төрийн тулгуур сулран демократ төр тиран төр буюу хэрцгий

¹⁶²Д.Болд-Эрдэнэ. “Улс төрийн онолын сонгодог болон орчин үеийн эх сурвалж” Шинэ толь №51, УБ., 2005/2, 10 дахь тал

дарангуйллын төрд байр сууриа тавьж энэ мэтээр нэгээс нөгөөдөө шилжиж, битүү орчлыг үүсгэдэг¹⁶³ гэж тэрээр дүгнэн хэлсэн байна.

Эртний сэтгэгчдийн нийгмийн удирдлагыг хэлбэрүүдийг ажиглан дүгнэсэн байдал өнөөгийн нийгмийн өөрчлөлтийн үед ч ач холбогдлоо алдаагүй хэвээр л байна. Харин үүссэн нөхцөл байдлаас гарах арга зам, учир шалтгааныг онолын хувьд тайлбарласантайлбарууд илүү олон хувилбартай, илүү нарийвчилсан шинжтэй болжээ.

Улс төр судлаачид, нийгэм судлаачдын дунд өнөөгийн монголын нийгэм эдийн засгийн байдлыг шилжилтийн үедээ яваа гэх хандлага ихээхэн түгээмэл байдаг. Харин асуудлыг ингэж үзэх нь явцгүй болох нь бодит байдлаар батлагдаж байна. Бүхэл бүтэн гурван арван жилийг дамнасан шилжилт гэж байх нь утгагүй. Үүний нөгөө талд чухам ямар зүйл дээр алдсан учраас энэхүү “шилжилт” гэх үеээсээ гарч чадахгүй байна вэ, үүнээс гарах цаг хугацаа хэдий хүртэл үргэлжлэх юм бэ гэдгийн учрыг олохыг хичээхгүй, үхээнц хандах нь улс төрийн шинжлэх ухааныг судалж буй хүмүүсийн хувьд дэндүү арчаагүй ноомой хэрэг болох билээ. Үүссэн нөхцөл байдалд сэтгэл зовинон асуудлаас гарах арга замд хувь нэмрээ оруулж буй улс төрийг сонирхон судлагч, судлаач, эрдэмтдийн бүтээлүүдэд гарч байгаа санааг тоймлон үзүүлэхийг зорилоо.

ГЭР БҮЛИЙН ОРЧИНД

Аристотель “Улс төр” хэмээх зохиолдоо “улс төрийн системийг бүрдүүлэгч үндсэн элемент нь хүн, анхдагч цөм нь гэр бүл юм¹⁶⁴” гэж онцгойлон тэмдэглэсэн байдаг. Шилжилтийн үед ихэнх үйлдвэрийн газрууд зогсонги байдалд орсонтой холбоотой ажилгүйчүүдийн тоо эрс нэмэгдэж нэг хэсэг нь гадаадын хөдөлмөрийн зах зээлд хөлсний ажилчид болж зарим нь ажилгүйчүүдийн эгнээнд орсон. Төр засгийн зүгээс улс төрийн эдийн засгийн бодлого дээр алдаа гаргасны үр дагавар болж улс орны хэмжээгээр үйлдвэржилт явагдаж чадсангүй, ингэснээр ажилтай орлоготой байсан олон мянган иргэд ажилгүй болж, нийгэмд янз бүрийн сөрөг үр дагаварууд бий болсон.

Энэ талаар монголын нэрт социологич Х.Гүндсамбуу “Монголын нийгмийн даврхаажил: хөгжил, хандлага (XX зуун)” сэдэвт бүтээлдээ; “Ардчилал зах зээлийн нөлөөгөөр олон түмний сэдэл, үнэт зүйлс, үнэлэмж, баримжааллын аль алинд өөрчлөлт гарлаа. Айл гэр, хань ижил, үр хүүхдээс авахуулаад ариун цагаан хөдөлмөр, хүний мөс, хүнлэг шинж, ажил төрөл, албан тушаал зэргийн сэдэл, үнэт зүйлсэд өөрчлөлт гарч, урьд нь ярих битгий төсөөлөх нь үгүй байсан зүйл өнөөдөр гайхал төрүүлэхээ болилоо. Хээл

¹⁶³Д.Болд-Эрдэнэ. “Улс төрийн онолын сонгодог болон орчин үеийн эх сурвалж” Шинэ толь №51, хууд. 14. УБ., 2005/2

¹⁶⁴Мөн тэнд. 20 дахь тал

хахууль, хулгай зэлгий, гэмт хэрэг ажилгүйдэл, ядуурал, хэсүүчлэл, ужид цэнгэл зэргийг энд дурьдахад хангалттай¹⁶⁵ хэмээн өгүүлсэн байдаг. Монголчууд бид гэр бүл төлөвлөлт гэрлэлтийн талаар түүхэн уламжлалтай ард түмэн. Өндгөн сүй тавих, гэрлэх, өрх тусгаарлах, аж төрөхдөө нарийн чанд дэг горимтой явсан ард түмэн. Ардчиллын он жилүүдэд энэ уламжлал улам бүр алдагдсаар байна.

Улаанбаатар хотод сүүлийн 10 жилд гэрлэлтийн тоо буурсан үзүүлэлттэй гарч 2006 онд нийслэлд 16,267 өрх голомт тусгаарлаж, гэрлэлтээ батлуулсан бол 2015 онд энэ тоо 8,263 өрх болж, даруй хоёр дахин буурчээ. 2006 онд нийслэл дэх гэр бүл салалтын тоо жилд 1,064 байсан бол 2015 оны байдлаар 2,215 болж мөн адил хоёр дахин өсчээ. Сүүлийн гурван жилээс (2013,2014, 2015) харахад гэр бүл салалтын тоо жилд тогтмол 200-гаар нэмэгдсэн байна.

Аль ч нийгэмд хүмүүсийн эзлэх байр суурь, гүйцэтгэх үүрэг, давхраажлын “тодорхойлогдох муж” нь нэг бол төрөлх гэр бүлээс эсхүл гэрлэлтээс, мөн хоёулангаас нь үлэмжхэн хамааралтай. Зарим нэг хүн хэний гэрт мэндэлснээсээ, зарим нь хэнтэй гэрлэснээсээ, хэнтэй ураг худ болсноосоо хамааран, давхраажлын шатаар өгсөж, урууддаг. Ялангуяа эмэгтэйчүүдийн хувь заяанд гэрлэлт онцгой учир холбогдолтой¹⁶⁶. Гэр бүлийн бүтцийн өнөөгийн байдлыг Үндэсний статистикийн хорооны хүн ам зүйн мэдээллийн сан дахь 1993, 2000, 2010, 2015 онуудын хүн амын тооллогын материалд тулгуурлангаргасан судалгаанд аймаг, нийслэлийн нийт өрхийн дотор эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн эзлэх хувийн дундаж 1993 онд 7,5%, 2000 онд 15,8%, 2010 онд 18,9%, 2015 онд 23,2% болж өссөн байна¹⁶⁷. Гэр бүл салалтын хохирогч нь хүүхэд, эмэгтэйчүүд байдаг. Үүнээс үүдэн хүүхэд, эмэгтэйчүүд гэр бүлийн хүчирхийллийн бай болсоор байна. Сүүлийн жилүүдэд өсвөр насны хүүхэд, залуучуудын дунд бэлгийн цөөнх, биеэ үнэлэгчид, архи, тамхи, мансууруулах бодист донтож байгаа нь гэр бүл салалтаас үүссэн үр дүн гэж дүгнэн хэлж болно.

Мөн гэр бүл салалтын шалтгааныг ядуурал их байгаатай холбон тайлбарладаг. 2006-2009 оны гэр бүл салалтын тоог улс төрийн намуудын сонгуулийн амлалт, нийгмийн халамжийн бодлогыг хэт их хавтгайруулсантай холбоотойгоор хэврэг гэр бүлүүдийг зохиомлоор бий болгосон явдалтай холбоотой гэж үзэх явдал бий. (“Шинэ, Залуу гэр бүлд

¹⁶⁵Х.Гүндсамбуу. “Монголын нийгмийн давхраажил: хөгжил, хандлага (XX зуун)” УБ., 2002, хууд. 47

¹⁶⁶Мөн тэнд. хууд. 51

¹⁶⁷Ж.Батсуурь, Э.Энхмаа. “Монгол улсын хүн ам зүйн аюулгүй байдалд тулгамдаж буй зарим асуудал”. Стратегийн судалгаа. УБ., №76, (4/2016) хууд. 70

үзүүлэх мөнгөн тусламжийн 500,000 төгрөг¹⁶⁸”, “Хүний хөгжил сангийн Эх орны хишиг-1,500,000 төгрөг¹⁶⁹ гэх мэт).

Гэр бүл салалт их байгаа нь ганцхан амьдралын тарчиг ядуу хэсэгт байдаг үзэгдэл биш болжээ. Төрөөс төрсөн тэр бумтангуудын дунд ч энэ үзэгдэл газар авч тэд “үрээ танихгүй өнөр, үрээгээ танихгүй баян” болсон байгааг нуух юун. Улс орны оршин тогтнох, улсын аюулгүй байдал баталгаатай байх эсэхэд иргэн хүн бүрийн оролцоо чухал үүрэг гүйцэтгэдэг. Хүний эрх, эрх чөлөөг бид гэр бүл салж нийлэх эсхүл дур зоргоороо юу хүссэнээ хийж байгаагаа ардчиллаар өгсөн эрх чөлөөгөө эдлэж байна гэж ойлгох нь буруу бөгөөд энэ нийгмийн нэгж дээр ажиглагдаж байгаа гажуудал, сөрөг нөлөөлөл нь улс орны эрх ашгийн асуудлыг хөндөж байдаг тул иргэн бүрийн хүлээх үүрэг дээр анхаарах ёстой юм.

НИЙГМИЙН ОРЧИНД

Ардчилал монголын ард түмний мөрөөдөл байсан, харин бодит зүйл болсон эсэх нь ихээхэн эргэлзээтэй. Манай нийгэмд бүтэцийн ихээхэн өөрчлөлт гарч байна. Ядуурал, ажилгүйдэл ихэсч байгаагаас, гэмт хэрэг өсч, эрүүгийн нөхцөл байдал хүндэрч нийгмийн зүгээсхатуу гарыг санагалзах болсоор байна. Монголын нийгэм 1990-ээд оны үеийн хүмүүсийн хүсч мөрөөдөж байсан нийгмийн олонхи нь дундаж амьдралтай болсонгүй харин өвөрмөц, гажигтай, ядуучууд олонхи болсон байдлаар давхраажих хандлага ажиглагдаж байна. Сүүлийн үеийн судалгаагаар ядуурлын түвшин 30%-ийг давж гарч байна. “Ядуурлын учир шалтгаан бусдаас, гадныханаас бус, чухамхүү биднээс, монголын нийгмийн өнөөгийн нөхцөл байдлаас л өмнөтгөл, үүдэлтэй¹⁷⁰”.

Хөдөө, орон нутагт ажлын байр бий болохгүй, ажилгүй иргэдийн мэргэжлийн ур чадвар ажлын байрны шаардлагыг хангахгүй, зарим ажлын байр нь ядуурлаас ангижрах

¹⁶⁸2006 оны тавдугаар сард хүнамын өсөлт, хөгжлийг дэмжих зорилгоор УИХ-аас “Хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай хууль”-ийг батлан гаргаж амьжиргааны түвшин, өрхийн эмзэг байдлыг харгалзалгүйгээр нийтлэг олгогдох мөнгөн тэтгэмж, тусламжийг бий болгосон.

¹⁶⁹Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт “Стратегийн болон томоохон ордог газраас олсон орлогоос иргэн бүрт 1.5 сая төгрөг хүртээх эрх зүйн орчин болон санхүүгийн эхүүсвэрийг бүрдүүлж хэрэгжүүлнэ.” гэж заасны дагуу Монгол Улсын Их Хурал Хүний хөгжил сангийн тухай хуулийг 2009 оны 11 дүгээр сард баталсан. Хүний хөгжил сангаас 2010 онд эхний ээлжинд 70.000, иргэний шинэчилсэн бүртгэлд хамрагдсан иргэдэд 50.000 төгрөгийг олгож эхэлсэн.

¹⁷⁰Х.Гүндсамбуу. “Монголын нийгмийн давхраажил: хөгжил, хандлага (XX зуун)” УБ., 2002, 39 дэх тал

хэмжээний цалин хөлстэй биш байгаа нь үүнд нөлөөлж байна. Дээрх нөхцөл байдалтай уялдуулан ажлын байрыг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулхын тулд НҮБ, Дэлхийн банк, Зүүн Ази Номхон далайн бүс нутгийн, гадаад, дотоодын төсөл хөтөлбөрүүдийн хүрээнд нилээд хөрөнгө зарж олон арга хэмжээ авч байгаа ч үр дүнгээ өгөхгүй байна. Энэ нь магадгүй энэхүү зарцуулж байгаа хөрөнгө нь улс орны хөгжил, нийгмийн сайн сайхан байдлыг хангах чиглэлд зарцуулагдаж чадахгүй байгаа, янз бүрийн зээл тусламж авах, төсөл хэрэгжүүлэхдээ алсыг харсан ухаалаг шийдвэр гаргах тогтолцоо бүрдэж өгөөгүйтэй холбоотой байх магадлал ихтэй юм.

Монголчууд бид үе үеийн турш тэгштгэсэн нийгэмд амьдарсаа риржээ. Олон үеийн туршид баялаг нь бараг ганц мал аж ахуй байлаа. Ийм нөхцөлд хэн ч хэдэн үеэрээ баян эсвэл хоосон байх бололцоогүй. Учир нь цас зуд ган ганчиг “үйлдвэрлэгч” байгаль өөрөө нүүдэлчний нийгмийг тэгштгэдэг байв. Иймээс ч “баян хүн нэг зуданд” гэсэн хүн болгоны мэдэх үг бий. Социализмын үед нийгмийн гишүүдийг тэгштгэгч нь нам засаг байлаа. “Бүх юмыг улс хариуцна¹⁷¹” гэсэн сэтгэлгээ одоо хэр нь бидэнд байсаар байна.

Ядуурлын тухай бидний ойлголт буруу, ядууралтай тэмцэхээр сонгосон араг зам ч буруу байж болох юм гэж эргэж харах хэрэгтэй болжээ. Ядуурал нь нийгмийн болон хувь хүний гэсэн хоёр хүчин зүйлээс шалтгаалж болно. Ядуурлын энэ учир шалтгааныг харгалзан үзэж залруулахын тулд АНУ гэхэд 20 гаруй жил анхааралдаа авч ажиллаж байж тодорхой үр дүнд хүрсэн байдаг. Төр засгийн зүгээс иргэддээ орлогын хамгийн доод хэмжээг баталгаажуулсан бодлогын зохицуулалт нь хүмүүсийн ядуурлын байдлаас гарахад дөхөм үзүүлж чадахгүй байж болно. Мөн хувь хүмүүсийн өөрсдийнх нь онцлогоос хамаарсан шинжтэй ядуурал байж болох юм. АНУ-ын эрдэмтэн Роберт Ректор өөрийн судалгаандаа хувь хүнээс хамаарсан ядуурлыг дараах байдлаар тодорхойлжээ. “Араншлын ядуурал нь арчаагүй байдал, ажлын ёс зүйн доройтол, мэдэж сурах тэмүүллийн хомсдол, үр хүүхдээ асран хүмүүжүүлэх хүсэлгүй буюу чадваргүй байдал, гэмт хэрэг, архины дон гэх мэт нийгмийн патологуудын (гажигуудын) багц юм” гэжээ. Цааш нь тэрээр “асуудал мөнгө хөрөнгөний хүрээнээс хэдийнээ хальж, нийгмийн асуудал болон хүндэрч байгаа юм. Хүн эдийн ядууралд хэт удаан оршивоос аяндаа араншлын ядууралд шилждэг жамтай¹⁷².

¹⁷¹Б.Баабар. “Биднийг хэн тэжээдэг вэ?” <http://www.baabar.mn>

¹⁷²“Ядуурлын хоёр нүүр” <http://tribunemongolica.blogspot.co.uk>

Аль ч учир шалтгаанаас байсан гэсэн Монгол Улс нэгэнт тулж ирсэн энэ ядуурал гэх үзэгдлээс хэрхэн салах вэ? Английн зохиолч Жорж Оруэлл¹⁷³ийн “Амьтны хүрээлэн” зохиолд аль ч нийгмийн үед эрдэм боловсролгүй ард түмэн хэрхэн дарлал мөлжлөгт өртдөгийг ёгт үлгэрээр дүрслэн үзүүлсэн байдаг. Иргэд улс төрийн боловсролтойболсноор улс төрийн эрхээ зөв эдлэж, ирээдүй хойчийнхоо төлөө зөв ухаалаг шийдвэр гаргах, улс эх орон нийгмийн хөгжлийн төлөө хоёргүй сэтгэлээр ажиллах “*жинхэнэ улс төрч*”-ийг бий болгож, төлөвшүүлэхэд хувь нэмэрээ оруулдаг. Хүн төрөлхтөний хөгжлийн аль ч үед нийгмийн иргэн бүр их бага ямар нэг хэмжээгээр оролцож байж маргаашаа бүтээдэгтэдгийг иргэн бүр санаж асуудалд хандах нь ядуурлаас гарах арга зам байж болох юм.

УЛС ТӨРИЙН ОРЧИНД

Монголын улс төр, нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, шинэтгэлийн явцад ардчилсан төр, засгийн тогтолцоо бүрэлдэх, дэлхий дахинд Монгол улсын нэр хүнд дээшлэх, бүхэлдээ чөлөөт ардчилсан нийгмийн тогтолцооны дүр төрхөд шилжих, хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, гадаад харилцаа өргөжих зэрэг олон сайн үр дагаварууд¹⁷⁴ бий болсон. Улс орны хөгжил, баялагийн эдийн засгийн үр ашгийг ард түмэн нийтээрээ хүртэж чаддаг байх нь урт хугацааны, тогтвортой хөгжлийн шинж чанар юм. Сүүлийн жилүүдэд улс төрд клиентелизм¹⁷⁵ эдийн засгийн элитүүд, бизнесменүүд давамгайлах болсноор явцуу эрх ашигт барьцаалагдаж, наймааны бүлэглэлийн сэтгэхгүй тогтож авлига ихэссээр байна. Үүнийг дараах судалгааны үр дүнгээс харж болно. “Транспаренси Интернейшнл” ТББ-ын 2014 онд нийтэлсэн авлигын үзүүлэлтийн индексийн үзүүлэлтэнд нийт 177 орон

¹⁷³Жорж Оруэлл (1903-1950) буюу Английн зохиолч Эрик Артур Блэр орчин цагийн улс төрийн романы эцэг Энэтхэгийн Бенгалд төрсөн. Тэрээр 1928-1929 онд Парист амьдарч байхдаа зохиол бичиж эхэлжээ.

¹⁷⁴Ч.Өлзийсайхан. “Монгол дахь ардчилсан шилжилтийн үеийн улс төрийн элитүүдийн төлөвшил” УБ., 2012. Хууд. 163

¹⁷⁵Клиентелизм нь хоёр болон олон хүнийг хамарсан найз нөхөд, хамаатан садангийн онцгой харилцаа, холбоо бөгөөд голдуу тодорхой зорилгод чиглэсэн байх ба нийгэм, эдийн засгийн (эсвэл улс төрийн) хувьд дээгүүр зиндааны нэг этгээд (патрон, ивээн тэтгэгч) нь доогуур зиндааны нөгөөдөө (клиент, дэмжигч) өөрийн нэр нөлөө, боломж бололцоог ашиглан хангамж, хамгаалалт үзүүлж байхад клиент нь мөн хариуд нь ивээн тэтгэгчдээ өөрийн биеэр үйлчлэх зэргээр ерөнхий дэмжлэг, туслалцаа үзүүлдэг үзэгдэл юм. Тэтгэгч, дэмжигчдийн холбоо нь олон хүнийг хамарч, тэдгээр нь хэд хэдэн шат дамжлага үүсгэж, улмаар нэгэн пирамид болж “нийгмийн солилцооны сүлжээг” улмаар “нийгмийн солилцооны авилгалыг” бий болгодог. Михаил Клима. “Тоталитар дэглэмээс гажуудсан ардчилал руу” УБ., 2017 хууд. 7

хамрагдсанаас Монгол улс 80-р байрт жагсчээ. Монголын иргэд ч энэ асуудлыг олонтаа хөндөн, өргөн хэлэлцүүлэг явуулсаар ирсэн. Улс төрийн хүрээнд ч авилга Монгол улсын цаашдын хөгжлийг хойш нь татах аюултайг онцлон авч үзэж, авилгатай тэмцэх хууль тогтоомж батлан, зохих хяналтын байгууллагуудыг бий болгосон. Гэвч ил болсон авлигын хэргүүдийг эрүүгийн хуулийн дагуу хатуу шийтгэх тогтолцоо бүрдээгүй байгаа бөгөөд авлигын хэргийг олон нийтэд ил гаргах нь улс төрчдийн харилцан нэг нэгнээ шантаажлах нэг хэлбэр болж байна. Өөрийн зорилгодоо үнэнч зогсох чадвартай иргэний нийгмийн байгууллагууд болон шүүмжлэлт байдлаар хандах, хараат бус хэвлэл мэдээлэл Монгол улсад үгүйлэгдэж байна¹⁷⁶. Үүний тулд улс төрийн тогтолцоогоо боловсронгуй болгож хэд хэдэн шинэчлэлүүдийг хийх шаардлагатай тулгарч байна хэмээн судлаачид үзэж байна. Олон улсын хэмжээнд ч гэсэн улс төрийн тогтолцоо нь хөгжих эсвэл уруудах хамгийн гол учир шалтгаан болж буй талаар ихээхэн анхаарч бичих болжээ.

ХБНГУ-с Монгол улсад Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар ажиллаж байсан Петер Шаллер Монголын ардчиллыг “том зургаар” нь харвал амжилттай гэж хэлж болох ч улс төрийн тогтолцоонд нь ноцтой дутагдалууд байна. Үүнд:

1. Улс төр, эдийн засгийн элитүүдийн ёс суртахуунд өөрчлөлт хийх, байгалийн баялагтайгаа хэрхэн харьцах талаар улс төр, нийгмийн хүрээнд зөвшилцөлд хүрэх явдал чухал ач холбогдолтой. Ардчилсан тогтолцооны чухал хүчин зүйл болсон эрх мэдлийн хуваарилалт, түүнтэй уялдсан “хяналт, тэнцвэрийн” механизм зохистой хэмжээнд бүрдээгүй.
2. Засгийн газар нь тогтворгүй байгаа том шалтгаан нь УИХ-ын давамгайл байдал. “Төрийн эрх барих дээд байгууллага” болохын хувьд УИХ бүхий л асуудалд оролцож, өөрийн мэдлийн хүрээнд аваачин шийдвэрлэдэг. Ерөнхий сайд нь УИХ-даа бүрэн “дөрлөгдсөн” бөгөөд сайд нарыг томилох, огцруулахын алинийг нь ч бие даан шийдэж чаддаггүй.
3. Ерөнхийлөгчийн албан тушаал нь гүйцэтгэх болон төлөөллийн “хоёрдмол” шинж агуулж байна. Төрийн тэргүүний хувиар улс орноо төлөөлөх эрх, үүргийн тал дээр ямар нэг асуудал байхгүй. Ийнхүү төлөөлөхөөс гадна олон тооны эрх мэдэлтэй.
4. Парламент дахь “давхар дээл”-ийн асуудал, улс орны эдийн засгийн чухал салбаруудад ашиг сонирхол бүхий бизнесменүүд УИХ-д олноороо сонгогдсон байдал нь барууны орнуудынхтай харьцуулахад хачирхалтай.

¹⁷⁶ДаниелШмюкинг. “Ололт амжилт ихтэй ч хийх зүйлс чамгүй олон” Монголын ардчиллын 25 жилийн ойд. Конрад-Аденауэр-Сан., УБ. 2015. Хууд. 3 www.kas.de/mongolei

5. “Арын хаалга, татаасны тогтолцоо” нь өнөөгийн монголын улс төрийн намуудын төрхтэй таарч байна. Дагагчид нь намын даргаа өөд нь гаргаад, дараа нь татуулж албан тушаалд очих.
6. Монголчууд ямар замаар хөгжих, хаа хүрэх тухайд нийтээрээ, нэгдсэн зөвшилцөлд хүрч чадаагүй. Үүний нэг жишээ бол байгалийн баялагаа ашиглахдаа гадаадын хөрөнгө оруулагчидтай хэрхэн хамтрах талаарх эцэс төгсгөлгүй маргаан¹⁷⁷ зэргийг дурьджээ.

Мөн “Sustainable Development Solutions Network” судалгааны байгууллагаас “Дэлхийн аз жаргалын индекс 2017”-г шинчлэн гаргасан байна. Уг жагсаалтыг гаргахдаа судлаачид тухайн улс орны нэг хүнд ногдох ДНБ, эрүүл төрөлт, наслалт, амьдралын сонголтуудаа хийх эрх чөлөө өгөөмөр байдал, авлигын үзүүлэлт зэрэг хүчин зүйлсийг авч үздэг. Монгол улс “Аз жаргалын индекс”-ээр 4,955 оноогоор 155 орноос 100 дугаарт жагссан байна¹⁷⁸. Энэ нь үзүүлэлтэд оюун санаа, эдийн ядуурлаас гадна улс төрд итгэх иргэдийн улс төрийн итгэл үнэмшил алдарсантай холбоотой. Ардчилсан нийгмийн гол үзүүлэлт бол иргэд улс төрд итгэх итгэл өндөр, улс төрчдөө дэмждэг, улс төрийн боловсролтой байх нь хамгийн чухал үзүүлэлт юм. Гэтэл манай улсад сонгуулиас сонгуулийн хооронд иргэдийн улс төрд оролцох оролцоо багасаж бид ардчиллаас ухарч, тохиолдлын улс төрчдийг улс төрд орох нөхцлийг бүрдүүлсээр байна.

ДҮГНЭЛТ

“Дээрээ гүйдлээ олохгүй бол Доороо суудлаа олохгүй” гэгчээр айл гэрийн өрхийн тэргүүнээсэхлээд улс орныг удирдаж байгаа улс төрчид ч ялгаагүй аливаад ёс зүйтэй, хариуцлагатайхандаж байж гэр бүлдээ болон нийгэмд үүсээд байгаа дээрх эмх замбараагүй байдлыг багасгана. Социлогич Ральф Дарендорфын хэлсэнчлэн “ардчилал жамаараа төлөвшихийг хүлээн 60 жил үүрэглэж болохгүй. Ардчиллыг тордох, чанаржуулах нь хүн бүрийн болон иргэний нийгмийн цуцалтгүй хүчин чармайлтаас шалтгаалдаг¹⁷⁹”.

Гэр бүл, нийгэм, улс төрийн хүрээнд явагдаж байгаа эдгээр асуудлыг хууль хяналтын байгууллагын үйл ажиллагааг чанаржуулж иргэний нийгмийн байгууллагын хяналтыг сайжруулснаар шийдвэрлэх боломжтой. Тэрээр иргэний нийгэм л төр ба иргэдийн хоорондох хоосон орон зайг дүүргэж чадна. Ингэж байж л эрх чөлөөгөө удаан хугацаагаар баталгаажуулах ёстой гэжээ.

¹⁷⁷Петер Шаллер. “Монголын улс төрд учирч буй зарим сорилтын талаар”. Стратегийн судалгаа. УБ., №76, (4/2016) хууд. 92

¹⁷⁸ https://en.wikipedia.org/wiki/World_Happiness_Report

¹⁷⁹МихиалКлима. “Тоталитардэглэмээсгажуудсанардчилалруу” УБ., 2017 хууд..14

Ардчиллыг жинхэнэ утгаар нь монголын хөрсөнд нутагшуулж, хөгжүүлэхэд иргэд, иргэний нийгмийн байгууллагууд болон улс төрийн нам хүчнүүд нэг зорилгын төлөө хамтран ажиллаж гурван сая хүн ам нь эх орондоо элэг бүтэн, тайван сайхан амьдрах нөхцөл бүрдэнэ.

Шуудайнд хийсэн үхрийн эвэр шиг эв нэгдэлгүйбайгаа байдал нь төрийн бодлогын залгамж холбоог үгүй хийж улс орны аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх хэмжээнд хүрээд байна.

Ашигласан ном зүй

1. Д.Болд-Эрдэнэ. “Улс төрийн онолын сонгодог болон орчин үеийн эх сурвалж” Шинэ толь №51, УБ., 2005/2
2. Ж.Батсуурь, Э.Энхмаа. “Монгол улсын хүн ам зүйн аюулгүй байдалд тулгамдаж буй зарим асуудал”. Стратегийн судалгаа. УБ., №76, (4/2016)
3. Х.Гүндсамбуу. “Монголын нийгмийн давхраажил: хөгжил, хандлага (XX зуун)” УБ., 2002
4. МихиалКлима. “Тоталитардэглэмээсгажуудсанардчилалруу” УБ., 2017
5. Петер Шаллер. “Монголын улс төрд учирч буй зарим сорилтын талаар”. Стратегийн судалгаа. УБ., №76, (4/2016)
6. Ч.Өлзийсайхан. “Монгол дахь ардчилсан шилжилтийн үеийн улс төрийн элитүүдийн төлөвшил” УБ., 2012
7. “Улс төрийн шинжлэх ухаан” ред. Ц.Ганболд, Ё.Довчин. УБ., 2014 он

Веб хуудас

1. Б.Баабар. “Биднийг хэн тэжээдэг вэ?” <http://www.baabar.mn>
2. Д.Баярхүү. “Атаархлаа шударга ёс гээд ойлгочихсон 10 хувь” <http://www.baabar.mn>
3. Б.Баярцэнгэл. “Монголд өдөрт 10 гэр бүл салж байна”. 2017.02.24 <http://ikon.mn>
4. ДаниелШмюкинг. “Ололт амжилт ихтэй ч хийх зүйлс чамгүй олон” Монголын ардчиллын 25 жилийн ойд. Конрад-Аденауэр-Сан., УБ. 2015. www.kas.de/mongolei
5. “Ядуурлын хоёр нүүр” <http://tribunemongolica.blogspot.co.uk>
6. https://en.wikipedia.org/wiki/World_Happiness_Report

ОЛНОО ӨРГӨГДСӨН МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТУСГААР ТОГТНОЛЫН АСУУДАЛД

Г. Цэнджав

*ШУТИС-ийн Безнисиийн удирдлага, Хүмүүнлэгийн ухааны сургуулийн
Ахлах багш Доктор(Ph.D)*

Түлхүүр үг: Хаант Оросын бодлого, Монголчуудын эдийн засгийн тусгаар тогтнол, Оросын санхүүгийн зөвлөх С.А Козин, эдийн засгийн хараат байдал, зээл, татварын бодлого,

XX зуун гарснаар олон улсын тавцанд улс гүрнүүдийн харилцааны дэг жаягийг өрнөдийнхөн тодорхойлж, улмаар өөрсдийн улс төрийн нөлөөний хүрээнд шинэ шинэ бүс нутаг улс түмнүүдийг татан оруулж байлаа. Колонийн тогтолцоо нь капиталист ертөнцийн бүтцийн нэг гол хэсэг болж улмаар Ази, Африкийн орнуудад капиталист харилцааны үр хөврөл бүрэлдэж, колончлолийн мөлжлөгийн арга хэлбэр өргөжин тэлсэн явдал тус бүс нутгийн амиа аргацаасан эдлэхүүний аж ахуйн үндсийг ганхуулж, дэлхийн аж ахуйн эргэлтэнд татан оруулсан юм.

Монгол орон яалт ч үгүй энэ эргэлтэнд ямар нэгэн хэмжээгээр татагдах болж, улмаар их гүрнүүдийн геополитикийн сонирхолын бүс болон хувирсан байв. Ар Монголд Оросын, Өвөр Монголд Японы нөлөө илүү тэлэн нэвтэрч улмаар Монгол орныг хэрхэн цаашид өөр өөрсдийн хүрээндээ захирах талаар сэм үгсэж, нууц гэрээ хэлэлцээр байгуулж байлаа. Хятад оронд Манжийн ноёрхол унаж, улмаар монголчуудад гадаад таатай нөхцөл бүрдсэнийг ашиглаж, харийн эрхшээлийг эсэргүүцсэн үндэсний эрх чөлөөний тэмцэл, хөдөлгөөн өрнөж, төрийн тусгаар тогтнолоо тунхаглаж чадсан билээ.

Цаашид тусгаар тогтнолоо улам батжуулах үүднээс хөрш улс болон гуравдагч орнуудтай улс төр, эдийн засгийн харилцан ашигтай, найрамдалтай харилцах саналыг тухайн үеийн монгол улсын төр засгийн удирдлагууд байнга тавьж байлаа. Хаант Оросоос Монгол дахь нөлөөгөө өргөтгөх үүднээс Монгол улсын засгийн газартай 1912 онд дипломат хэлэлцээр хийж гэрээ байгуулсан явдал нь Монгол улс олон улсын харилцааны субъект болсныг харуулсан чухал алхам байлаа.

Өгүүлэн буй үед Олноо өргөгдсөн Монгол улсын тусгаар тогтнолыг үл зөвшөөрөх бодлого баримталж байсан нь Монголчуудын үндэсний нэгдэл, төрийн тусгаар тогтнолоо бүрэн сэргээхийн төлөө тэмцэлд ихээхэн нөлөөлж байсан хэдүй ч, Монгол улс нь 1911-

1915 он хүртэл тусгаар улсын байдлаар оршин тогтнож, бие даасан гадаад бодлого явуулж байв.

1911 оны Монгол дахь үндэсний эрх чөлөөний хувьсгалын дараа Орос улсын өмнө шийдвэрлэх шаардлагатай хэд хэдэн асуудал тулгарсан байна. Үүнд: тусламж хүсэж байсан монголчуудад туслахын зэрэгцээ Хятад улстай тогтвортой харилцаагаа хадгалж үлдэх, мөн тус бүс нутагт өөрийн сонирхолоо бэхжүүлэх явдал байв. Үүнийгээ хэрэгжүүлэх үүднээс тус оронд орон тооны зөвлөх бий болгох санаа нь 1912 оныгүед дипломатуудын хүрээнд идэвхтэй яригдаж байв.

Монголын дотоод хэргийг бүгд захиран шийтгэх яамны тэргүүн сайд Сайн ноён хан Намнансүрэн тэргүүтэй сайд нар Нийслэл Өргөөнд байрлах Оросын ерөнхий консулын газраар дамжуулан хаант Оросын засгийн газарт дахин зээл олгох хүсэлт тавихад 1912 оны 9-р сарын 10-нд Оросын Гадаад Явдлын Яамны/ ГЯЯ/ сайдын үүрэг гүйцэтгэгч А.А.Нератов Сангийн сайдадаа хүсэлтийг дамжуулсан байна. Оросын талаас зээлийн буцаан төлөлтийг хангах, зээлийн зарцуулалтанд хяналт тавьж байх зорилгоор Монголын засгийн газарт өөрийн санхүүгийн зөвлөхтэй болох ба энэ албан тушаалд бүр Хятадын Харбин хотод гаалийн төлөөлөгчөөр ажиллаж байсан комиссар Коноваловыг нэр дэвшүүлсэн байна.

Монгол улс 40 жилийн хугацаатай 2 сая алтан рублийн зээлийг шинэ зэр зэвсэг худалдан авах, армийн удирдлагыг төвхнүүлэхэд зарцуулахаар зориулж авах талаар ярилцах үед, Оросын талаас санхүүгийн хяналт тавих асуудлыг хөндсөн. Харин Монголын удирдлагын байр суурь бол И.Я.Коростовецийн хэлснээр /Монгол дахь Оросын бүрэн эрхт төлөөлөгч/ “Санхүүгийн хяналт тавих асуудлыг шууд татгалзаж, авах зээлийн хэмжээгээ ч бууруулахад бэлэн байна. Иймд Монголын засгийн газар зээлийн төлбөрөө хийгээгүй тохиолдолд бид “Монголор” татварыг болон гаалийг өөрийн гарт авч, орж ирэх төлбөрийг консулын газарт даалгаж далдлагдсан хяналтыг зохион байгуулж болох юм” гэжээ. Гэтэл зээл олгох асуудал удааширч шийдвэрлэгдэхгүй байсан тул Монголын засгийн газар арга буюу өөрөө албан ёсоор зөвлөхийн орон тоог бий болгох талаар санал тавьсан. 1913 оны 5-р сарын 5-нд И.Я.Коростовец өөрийн ГЯЯ –д явуулсан нууц цахилгаан утсандаа дараахи зүйлийг бичжээ.”Монголын засгийн газар өөрийн хүчээр хөрөнгийн зарцуулалтанд хяналт тавьж чадахгүй тул Оросын санхүүгийн зөвлөхийг Нийслэл Өргөөнд ирүүлж өгөх, мөн Зөвлөхөөр томилуулах хүнийг Монголын засгийн газрын итгэлийг хүлээсэн Оросын сангийн яамны түшмэл В.А.Котвичийг томилуулахыг хүсэж байна” гэжээ.

Бас нэг баримт нь И.Я.Коростовец илгээсэн № 928 нууц цахилгаандаа “Монголчуудын тайлагнасан орлого зарлагын мэдээ нь хангалтгүй бөгөөд үүгээр улсын төсөв болон зээлийн талаар мэдэх аргагүй байна. Ер нь ч энэ талаар Нийслэл Өргөөгийн засгийн газар

тодорхой мэдээлэл өгөх нь эргэлзээтэй, мөн энэ Далай лам, Хятадын удирдлагаас манай хүсэлтийг биелүүлэхэд их саад болж асуудлыг хурцатгаж байна... тэр Монголчуудын өгсөн баримт мэдээлэл нь дутуу хангалтгүй байгаа тул зээлийн асуудал удаашраад байгааг сануулсан...үүний зэрэгцээ мөнгөний хэрэгцээгээ шийдвэрлэх санхүүгийн бодлогоо зохистой явуулах хоорондын харилцаагаа найдвартай байлгахын тулд Оросын санхүүгийн зөвлөх урьж ажиллуулах нь зүйтэйг ойлгуулсан” гэжээ.Энэ баримт нь Оросын санхүүгийн зөвлөх урих шийдвэр нь Оросын талаас гарсан бөгөөд Монголын засгийн газар гарцаагүй байдалд хүлээж авсныг харуулж байна. Монголыг засгийн газар асуудлыг улам хурцдаж байгааг ойлгоод зөвлөхийг ажиллуулж өөрийн хөрөнгөнөөс зардлыг хариуцах болсон байна.

Оросын талас уг асуудлыг дариухан шийдвэрлэж 1912 оны 5-р сарын 15-нд Сангийн яамны сайд нь зөвшөөрч, дараа өдөр нь Гадаад хэргийн сайд нь шийдвэрээ гаргасан байдаг. Анх Монголын талаас зөвлөх түшмэлээр санал тавьсан В.А.Котвич нь гэр бүлийн байдлаар шалтаглан татгалзсан тул шинэ хүнийг сонгон шалгаруулж, томилох асуудал хүнд болсон. Тэр үед Нийслэл Өргөөнд сууж байсан А.Я.Миллер 1912 оны 5-р сарын 18-нд илгээсэн мэдээндээ”Санхүүгийн зөвлөхөөр Монголд ажиллах хүн нь Монгол хэлтэй, удирдлагатайгаа холбоотой,өргөн хэмжээний санхүүгийн мэдлэгтэй, нутгийн онцлогийг ойлгодог байх хүсэлтийг Монголын засгийн газраас тавьсан” гэжээ. Хэрэв санал болгосон В.А.Котвич зөвшөөрөөгүй тохиолдолд дээрх шаардлагыг хангах хүн нь Дорно зүгт хятадын төмөр замын худалдааны төлөөлөгчөөр ажиллаж байгаа Ладыгиныг Д.С.Коростовца санал болгосон байна. Оросын Сангийн сайд В.Н.Коковцев Гадаад хэргийн сайд С.Д.Сазоновт хандаж Ладыгинийг ийм ажилд томилоход хангалтгүй гэж итгэлтэйгээр зөвлөлгөө өгчээ.Иймээс С.Д.Сазонов өөрийн зүгээс Калмыкийн халимагийн удирдагч агсан С.А.Козиныг санал болгож байна гэжээ. Яагаад санхүүгийн зөвлөхийн албанд санхүүгийн тусгай боловсролгүй хүнийг сонгох болов гэсэн асуулт гарч ирж байна. С.Д.Сазоновт бичсэн захидалд энэ чухал албан тушаалд С.А.Козин тохирох хүн гэдгийг тодорхой тайларласан байдаг.”Козин бол дорно дахины хэл судлалын курсыг хятад-монгол-манжуур чиглэлээр төгссөн 10-н жилийн өмнөөс дотоод явдлын яаманд ажилласнаасаа эхлээд халимагийн асуудлыг хариуцаж байсан, тэгээд Астараханьд удирдагчаар томилогдож ажиллахдаа халамж, засаг захиргаа, удирдлага, цагдаа,татвар, шүүх мөрдөн байцаах, сургууль , газар зохион байгуулалт зэрэг маш олон ажлыг хийж байсан туршлагатай хүн гэжээ.”

Эндээс үзвэл С.А.Козин нь үнэхээр мэргэжлийн төрийн албан хаагч байсан нь харагдаж байна. Тэрээр ерөнхий захиргааны үүргийг биелүүлэхийн зэрэгцээгээр халимагчуудын дунд хэд хэдэн өөрчлөлтүүдийг сэдэж, дараа нь түүнийгээ амьдралд хэрэгжүүлэхэд

оролцож байжээ. Тухайлбал: Хуучин нийгмийн омгийн удирдлагын зохион байгуулалтыг дүүргийн /аймгийн/-нх болгон өөрчлөх, халимагийн ба Оросын оршин суугчдын газар нутгийг тусгаарлах, захиргааны өөрчлөн байгуулалтын төсөл, эдийн засаг статистикийн судалгааг явуулах зэрэг ажлуудыг хэрэгжүүлсэн юм.

А.С.Козиныг томилох асуудал Оросын талын хүрээнд харьцангуй хурдан шийдэгдсэн бол, Монголын засгийн газартай явуулах хэлэлцээр нилээд сунжирсан юм. Жишээлбэл: Өргөө дэх ерөнхий консулын 1913 оны 7-р сарын 16/29-ны нууц цахилгааны №120-д Сайн ноён хан өвдсөний улмаас асуудлыг шийдэхийг хойшлуулсан тухай баримт байдаг. Сайн ноён ханд Козины томилгоог бушуухан шийдэх талаар консулын талаас удаа дараа хүсэлт тавьж байлаа. Тэрбүү хэл ГЯЯ-ны сайдын анд нөхөр А.А.Нератов 1913 оны 7-р сарын 18-ны цахилгаандаа “Зөвлөхийг томилох баримтуудад гарын үсэг зурах зөвшөөрөл авахыг ерөнхий консулд шамдуулан зөвлөж...Козины томилолтыг хурдавчлахыг шаардахын тулд ямар ч хамаагүй тохиолдлыг ашигла” гэжээ.

Сайн ноён хан Санкт-Петербургд 1913 оны 10-р сард хүрч очив. Гадаад явдлын яам гэрээг яаравчлан байгуулахын тулд С.А.Козиныг Сибирьт шууд ирүүлэлгүйгээр Санкт-Петербургд дуудсан байлаа. Сайн ноён ханыг албан ёсоор хүрэлцэн очтол гэрээ байгуулагдах эсэх нь тодорхойгүй байлаа. Гэсэн ч дипломат шахалт даралт байсан ч хэлэлцээр амжилттай явагдаж Монголд иргэний болон санхүүгийн шинэчлэлт хийх гэрээг 1913 оны 12-р сарын 26-нд гарын үсэг зурж хоёр тал сайшаан баталлаа.

С.А.Козин улс орны иргэний удирдлага ба санхүүгийн удирдлагыг сайжруулахад чиглэсэн дүрэм журам боловсруулах ба Монголын засгийн газраас түүнд даалгасны дагуу хуулийн төсөл боловсруулах ажил гүйцэтгэх зөвлөхөөр ажиллахаар Монголын албанд ажиллах болжээ. Гэрээ байгуулагдсаны дараа 12-р сарын 27-нд ГЯЯ-наас Сангийн сайд М.Н.Коковцовд С.А.Козиныг санхүүгийн онцгой даалгавар гүйцэтгэгч түшмэлээр бүртгэн авахыг өргөн мэдүүлжээ.

Монголд С.А.Козины явуулсан үйл ажиллагаа

Орос улсаас ирсэн санхүүгийн зөвлөх С.А.Козин түүний орлогч барон Витте нарын мэдээ баримтаар Монгол улсын төсвийн бүх орлого нь 1913 онд 707418 рубль болж байсны гаалиас 486720, алтны уурхайгаас 353310, газар загас агнуур зэрэг бусад түрээснээс 110815 рубль тус тус авч байжээ.

Монгол улсын Засгийн Газар мөнгөн хөрөнгө дутагдалтай байсан учир хаант Оросоос 3 удаа зээл авсан юм.

Он	1913	1914	1914
Хэмжээ	100,000	2 сая	3 сая
Хэдэн жил	10	20	30

Зээллэг болгоны дараа Монголын ЗГ Орос улсад ямар нэгэн буулт хийдэг байжээ. Сүүлчийн 3 сая зээллэгийн хариуд хаант Оросоос санхүүгийн зөвлөхөөр С.А.Козин түүний туслах Витте нарыг явуулжээ. Тэд Монгол улсын орлогын эх булгыг судалж, гадаад дотоод худалдаанаас хураах гаалийн хэмжээг өөрчлөх газар, ашигт малтмалын түрээс улсын орлогыг нэмэгдүүлэх санал боловсруулжээ.

1913 онд тус улсын ба гадаадын харьяат нарын тариалангийн газраас жил бүр хураах түрээсний дүрмийг батлан гаргажээ.

Дүрэмд : Улсын сангаас анх тариа тарихад чухал хэрэглэгдэх анжис, хадуур мөн жил бүр тарих үрийг тавин олгож, намар хураасан тариалангийн 1% -г үр болгох, 1%-г улсын санд тушаах, 1%-г харьяат хошууны албан хэрэглэл болгон ашиглах, үлдсэн хэсгийг нь тариа тарьсан хүнд олгож байхаар заасан байна. Хагалж боловсруулсан газрын үр тутмаас дунджаар 2 цэн хураамж байхаар тогтоож, газрыг “ жилийн хугацаатай түрээсэлж, хугацаа дуусмагц /1 үр=0,09216 га/ гурав, гурван жилээр сунгаж байхаар тогтжээ.

1913 онд 25 зүйлээс бүрдсэн “МУ-ын дотор алт, мөнгө зэрэг олон зүйлийн уурхай нээх дүрэм¹”ийг батлан гаргасан. уг дүрэмд алтны 100% -иас 20-30% мөнгө ба мөнгөний ус, цагаан хоргожсны 100%-иас 15-25% , чулуун нүүрсний тос ба гууль, зэс тугалгын 100%-иас 10-20 %, чулуун нүүрс ба төмрийн 100%-иас 5-15% цагаан алт ба очир алмаз чулууны 100%-иас 40-50% , олон зүйлийн эрдэнийн чулууны 100%-иас 30-40%-д бодож тус улсын санд тушаахаар заажээ.

Улмаар нутаг орны баялгийг гадаадын хүмүүст концессийн журмаар ашиглуулж олз ашиг олохын тулд “Улсын хөрөнгийн захирах газар” гэдгийг байгуулж тусгай дүрэм хэмжээс тогтоосон ажээ. Түүнд: “Засгийн газраас аливаа хүнд түрээслэх ба тогтоосон үнээр худалдах , бас улсын сангаас өөрийн хүчээр үйлдүүлэх зэрэг мод, ус элдэв уурхай, газраас элдэв ашиг гаргаж буй ба бас нэмэн ашиглавал зохих сул газрууд цөм Монгол улсын хөрөнгө болно”² гэжээ.

С.А.Козин тэргүүтэй Оросын санхүүгийн зөвлөхүүд Монголын түүхэнд анх удаа улсын зарлагыг тогтоож төсөв зохиож эхэлсэн юм. Улсын төсөвт гэгээрэл, мал эмнэлэг, эрүүлийг хамгаалахад зориулах зардал бага боловч тусгагдаж байв. Мөн аж ахуй, соёл боловсролыг хөгжүүлэх зорилготой “шинэтгэлийн хөрөнгө”³ хэмээх зүйл байсан нь ой модны гоожин, цахилгаан, утасны харилцаа, тоосгоны завод, Налайхын чулуун нүүрсний уурхай зэргийн орлогоос бүрддэг байжээ. 1916 онд тэрхүү хөрөнгөнд 524726 алтан рубль орсны 20 хүрэхгүй %-ийг нь нийгэм соёлын зүйлд, 40 орчим %-ийг нь аж ахуйн арга хэмжээнд, 40 гаруй % -ийг нь уг шинэтгэл эрхлэх газрын албан хаагчдын зардалд зарсан

байна. Энэхүү шинэтгэлийн хөрөнгө нь өчүүхэн зүйл байв. Шинэтгэл эрхлэх газрын байгуулсан цахилгаан гэрлийн хороо, телефон станц, хэвлэх үйлдвэр тоосгоны завод зэрэг үйлдвэр нь их төлөв нийслэлийн сайд түшмэдийн хэрэгцээг голлон хангаж, ардын боловсролын салбарт авсан арга хэмжээ нь Их хүрээнд ганц дунд сургууль, хэд хэдэн хошуун дахь бага сургууль зэргийг байгуулснаар хязгаарлагджээ.

Мөн мал эмнэлэг нь гагцхүү гадаадад гаргах малд тариа хийх төдий байсан нь шинэтгэлийн зүйл нь нийт ард олонд тус нэмэргүй шахуу байсныг харуулж байна.

С.А.Козин нарын бас явуулсан арга хэмжээ бол Оросоос Монголд ажиллаж байсан судалгааны олон экспедицийн дотроос нилээд бодитой судалгаа хийсэн баримт мэдээ байна.

Тэр үеийн Англи улсын гарын авлага болох “States man’s year book” 1912 онд Монголын хүн ам 2,600 мянга хэмээн тэмдэглэсэн байдаг. Мөн 1913 онд Хаант оросд хүрэлцэн ирсэн Монголын төлөөлөгчид тусгаар тогтносон МУ –ын хүн ам 500-600 мянга хэмээн гэсэн тоо баримт бас бий. Аркадий Петеров 1914 оны 1сард Оросын худалдаа аж үйлдвэрийг судлах нийгэмлэгт тавьсан монголын эдийн засгийн тухай тавьсан нэгэн илтгэлдээ хүн ам нь 5 сая гэсэн тоог дурьдсан байдаг. 1909-1911 онуудад Монгол орноор аялсан гүн А.П.Беннингсен Халхын хүн 330-500 мянга, Баруун хойт Монголынх 300 мянга, дорнод Монголын 500-550 мянган, нийтдээ 1300-1500 мянга хүн амтай гэсэн байдаг. Энэ бүх зөрөөтэй тоог эцэс болгож Монгол хүн амын тооллого хийх хэрэгтэй юм байна гэж Оросын хөрөнгөтнүүд үзэж байжээ. Тиймээс хожим нь хаант Оросоос санхүүгийн зөвлөхөөр хүрэлцэн ирсэн Козин, Витте нар 1915 онд монголын хүн ам, малын тоог гаргахыг оролдсон юм.

Оросын судлаачид Монголын зах зээлийн багтаамжийг цаашид судлахын тулд монгол айл өрхийн аж ахуй, санхүүгийн орлого зарлагыг тооцоолон гаргах хэрэгтэй хэмээн үзэж байжээ. Тиймээс ч Орос санхүүгийн зөвлөх нар энэ талаар нилээд судалгаа хийжээ. Тэдний зохион байгуулсан экспедиц нь Монголын эдийн засгийн нөөц болон статистик мэдээ цуглуулах зорилготой байв. 1915 онд хийсэн уг судалгааг 42 хошуу болон зарим нэгэн харуулын хамарсан бөгөөд өмнөх экспедицийн судалгааг бодвол нилээд нарийвчилсэн судалгаа байв. Ингээд уг социологийн судалгаа нь анкетийн асуултын дагуу бүртгэгдсэн зүйлийг нэгтгэн, зүйлээр ангилан өрх гэрийн аж ахуй, санхүүгийн байдлыг гаргажээ. Анкет нь:

1. Газар нутгийн нэр, суурин айл буюу нутгийн нэрийг дурьдан газрын зураг дээр тэмдэглэсэн байх.

2. Гэрийн эзэн хүн, гэр өрхийн тоо түүний дотор хэд нь харьяат хошууны ба шавийн, хэд нь бусал аошууны айл болох, тухайн өрх айлд цэргийн алба хааж буй хүн болон лам бологч бий эсэх
3. Суурин айл ямар гол мөрөн . усны дэргэд байрлаж буйг дурьдаад газрын зураг дээр тэмдэглэх
4. Уг айл суурьшихад тохиолдох ямар байгалийн нөхцөл бүрдсэн шалтгааныг бичих
5. Өвөл, зун эрхлэх ажил төрөл. Уг айл өрхийн баялаг нь чухам юунд байна. Тэрээр эрхэм баян, дунд баялагтай, үгээгүй зэргийн аль нь болохыг бичих-гэсэн асуултуудтай байв. Өрх гэрийн аж ахуйн хүчин чадлыг тодорхойлохын тулд мал сүрэг, малын тоог нь гаргаж энэ нь мөнгөнд шилжүүлэхэд хэдий хэмжээний үндсэн капиталтай болохыг тодорхойлжээ. Мөн түүнчлэн уг айлын орон гэр, хэрэглээний зүйлсийн жагсаалтыг гаргаж, тэдгээрийн хэрэглээний хугацаа үнэ өртөгийг нь тодорхойлон бичжээ. Эцэст нь өрх гэрийн орлого, зарлагыг чухам юун дээр тогтож байгааг дэлгэрэнгүй гаргаад мөн мөнгөн зарлагыг алба татвар төлөхөд, ажиллах хүч хөлслөн авахад, шашин ламын зардалд хэдийг нь зарцуулдагийг судлахаар төлөвлөжээ. Сүүлчийн өгүүлсэн зүйлийн талаар хожим нь И.М.Майский 1919 онд Орос-Монголын худалдааны хөгжлийн хэтийн төлөвийг тодорхойлох үүднээс Центросоюзийн Эрхүүгийн конторын захиалгын зохион байгуулсан экспедицийг толгойлон явахдаа нилээд судалгаа хийж гаргасан билээ. Түүний судалгааны давуу тал нь тэрбээр 1918 оны хүн, малын тооллогын материалыг ашигласанд оршиж байгаа юм. Эцэст нь хэлэхэд Оросын аль ч судлаач нүүдэлчин Монголчуудын зах зээлийн нууцыг нээн харуулж чадаагүй ажээ.

Дүгнэлт

1911 оноос өмнө Оросын хаант засгаас Монголын талаар баримтлах бодлого нь харьцангуй идэвхтэй биш байсан нь монголын талаархи мэдээлэл хомс байсантай холбоотой юм. Харин Орос улсаас Чин улсад хандаж Монголд Оросуудын худалдааг хүлээн зөвшөөрүүлэх санал тавьсаны дагуу Бээжингийн гэрээг хоёр улс байгуулжээ. Удалгүй 1861 онд халх монголын гол хот Хүрээнд Оросын консулын газар нээгдэж, Оросын анхны дипломатууд болон худалдаачид нэвтрэн ирсэн.

Ийнхүү Монголын асуудалд хаант Оросын зүгээс баримтлах явдал 1910-аад оноос өөрчлөгдөж ирсэн. 1911 оны 6-р сараас Монголын нөлөө бүхий феодал ноёдууд хошой чин ван Ханддорж, да лам Цэрэнчимид, гүн Хайсан нарын хэсэг Оросын Гадаад Явдлын Яаманд хүсэлт тавьснаар Монголд хандах хандлага улам идэвхжиж иржээ. Тиймээс хаант

Орос зэр зэвсгээр болон санхүүгийн зээл тусламж үзүүлснийхээ хариуд Монгол улсыг өөрийн бамбай улс болгох санаатай байв. Бамбай улсынхаа олон улсын эрх зүйн байдлыг нь бүрдүүлэх, өөрсдийн цэргийн зөвлөхүүдээр дамжуулан цэргийн хүч чадалд нь санаа тавих, өгсөн зээлээ эргүүлэн авах нөхцөлийг бүрдүүлэх үүднээс санхүүгийн зөвлөх нарыг илгээсэн байна. Үүнд:

1.Эх газрын түгжидмэл байдалд олон зуун мянган жилээр оршин тогтносон нүүдэлчин монголчууд нь өмнөт болон хойт хөршийн худалдааны капиталын байнгын дарамтанд байхад хүргэсэн. Нөгөөтэйгүүр Хятад болон түүний ар тал дахь Япон, Америк, Англи г.м империалист гүрнүүдийн колончлох бодлого явуулж ирмэгц өөрийн эрхгүй хойд хөршдөө хандаж тусламж хүссэн. Үүнийг Оросын талаас ашиглаж өөртөө ашигтай олон болзлуудыг тавьж шийдвэрлүүлсэн.

2. Оросын санхүүгийн зөвлөх нар нь Монголд ажиллахдаа монголын байгалийн баялгийн ерөнхий нөөц хэмжээг тогтоож, улмаар уул уурхайн ашигт малтмалаар өөрийн зээлийн хүү ашгийг илүүтэйгүүр гарган авах

3.Хаант оросын пүүс компаниуд ямар нэгэн гааль татваргүй өргөн цар хүрээтэй давуу эрхээр ажиллаж улмаар Хятад, Америк, Англи, Японы пүүс компаниудыг шахах бодлого явуулж байсан байна.

4.Монгол орны газрын хөрсөн доорхи байгалийн баялаг, мөн багагүй тооны мал сүрэг нь монголчуудыг гадаад орнуудад бүрэн колончлуулахаас хамгаалж байсан байна.

Энэ байдлаас харахад Оросын хаант засгаас Монголын цаашдын хөгжил, эрх ашгийн тусын тулд бус гагцхүү өөрсдийн эрх ашгийн үүднээс хандаж байжээ.

Гэвч монголчууд Оросын цэргийн болон санхүүгийн зөвлөхүүдийн ач тусаар эрдэмтэй чадалтай хүмүүсийн язгуур угсаа харгалзахгүйгээр улс төрийн үйл ажиллагаанд оролцуулах, төрийн байгууллагуудын үйл ажиллагааг төгөлдөржүүлэх, өөрийн цэрэг, цагдаатай болох, иргэний сургууль, соёлын ажлыг хөгжүүлэх, эмнэлэг анагаах ухааны зэрэг улс орны олон шинэ шинэ салаа мөчрүүдийг эхлүүлсэн билээ. Түүний үрээр монголын нийгмийн гүнд үүсэж байсан зах зээлийн харилцааны үр хөврөл цаашид дэлгэрэн хөгжих эдийн засгийн таатай нөхцөлийг бүрдүүлсэн юм.

Abstract: When in the 29th of December of 1911 the Mongols established own state for strengthening it and liberation own territory from the Manchu-Chinese troops unite the rest of Mongolia under the Mongol rule need a huge amount of financial sources. So make the fund rising in the Mongolian ground was impossible. For that purpose the Mongols seek the financial aid from Russia and heavily talk how the Mongols should have own financial sources and how payback the Russian loan and how the Mongols should develop their financial ability. All those

internal policy moods in the Mongolian society described in this article using the historical sources of that time.

Ном зүй

1. Ж.Урангуа “Монголын тусгаар тогтнолд Хаант Оросын үзүүлсэн хүчин зүйлс” УБ.,2010
2. Е.М.Даревская “Сибирь и Монголия.” Очерки русско-монгольских связей в конце XIX начала XX веков. Иркутск., 1994
3. О.Батсайхан “Хятад, Орос, Монгол гурван улсын 1915 оны Хиагтын гэрээ” УБ.,1999
4. Ц.Батбаяр “Богд хаант Монгол улс гуравдахь хөршийн эрэлд “ УБ.,2011
5. Г.Цэнджав”Монгол дахь хаант Оросын санхүүгийн зөвлөх түшмэлийн үйл ажиллагаа” УБ.,2014

ХҮН АМЫН ШИЛЖИН СУУРЬШИХ ҮЙЛ ЯВЦ: ХОТЖИЛТ БА ХӨГЖЛИЙН СОРИЛТУУД

М.Батбаатар

МУИС, ШУС

Социологи, нийгмийн ажлын тэнхимийн ахлах багш, доктор

Хүн амын шилжих хөдөлгөөнтэй холбоотой иргэдийн дахин суурьших үйл явц бол зөвхөн хүн ам зүйн бодлогын асуудал биш, өргөн хүрээтэй нийгэм, эдийн засаг, улс төрийн бодлогын асуудал болно. Хүн ам шилжин суурьшсанаар тухайнорон нутаг, төрийн үйлчилгээний ачааллыг ихэсгэхийн зэрэгцээ хотын ажилгүйдэл, ядуурлыг гүнзгийрүүлэх, ядуусын хорооллыг тэлэх зэргээр нийгэм, эдийн засаг, боловсрол, ажил мэргэжил, хөдөлмөрийн салбартолон тооны тулгамдсан асуудал хуримтлагддаг. Иймд Монгол Улсын хотжилт, хүн амын шилжин суурьших үйл явцтай холбоотой бодлогын зангилаа асуудлыг энэхүү өгүүлэлд хөндөхийг зорьсон болно.

Хүн амын нутагшилт, суурьшил: хот шинэ амьдралын хэв маяг болох тухайд

Дэлхий дээр Нийтийн тооллын өмнөх 3500 жилийн тэртээ эртний Египет, Нил мөрний хөндийд, одоогийн Тигр, Евфрат мөрний ойролцоо, өнөөгийн Пакистан дахь Инд мөрний орчимд анхны хотууд байгуулагдсан (А.Гидденс, 2006) гэж үздэг. Эртний ихэнх хотуудыг авч үзэхэд соёлын ялгаанаас үл хамаарч тогтсон морфологийн нийтлэг шинж бол хот хөдөөг тусгаарласан хана хэрэм, хотын төвд байрлах талбай, тэрхүү талбайн ойр орчимд байрлах сүм хийд, төрийн ордон, шүүх зэрэг болно. Уламжлалт нийгэм дэх ихэнх хотуудыг газарзүйн хувьд авч үзвэл гол мөрний эрэгт байгуулагдаж байснаараа нийтлэг шинжтэй юм. Тухайн үеийн томоохон хотууд хүн амын хувьд 300 мянгаас хэтэрч байгаагүй тул хүн амын багахан хувийг хотын иргэд бүрдүүлдэг байжээ.

Энэ зууны 1900-аад он хүртэлх хотуудын өсөлт нь ихэвчлэн өрнөдийн улс орнуудад явагдсан бөгөөд өнөө цагт үйлдвэржсэн улс орнуудын хүн амын 60-90 хувь нь хотод амьдрах болжээ. Эдүгээ гуравдагч ертөнцийн орнууд болон аж үйлдвэржилт хөгжиж байгаа улс орнуудад ч хотжилт асар хурдацтайгаар явагдаж байна.

1990 оноос хойш дунд зэргийн болон хөгжиж буй орнуудад хотжилт эрчимтэй явагдаж байна. НҮБ-ын тооцоолсноор (United Nations Organization, 1998) сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд дэлхийн нийт хүн амын тэн хагас нь хотод суурьших болсон бөгөөд хүн амын энэхүү өсөлтийг дагаад хүрээлэн буй орчны доройтол, хотын даац хэтрэх, дэд бүтэц


ачааллаа даахгүйд хүрэх, бүс нутгийн тэнцвэрт байдал алдагдах, ядуусын хороолол үүсэх, арьяалаа тэлэх зэрэг нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаварууд ихээр бий болсон. Ялангуяа хүн ам олноор шилжин суурьшиж буй Латин Америкийн улс орнууд болох Бразил, Мексик, Африкийн зарим орнууд тухайлбал Конго, Сенегал, Нигери болон Азийн Бангладеш, Энэтхэг, Пакистан зэрэг улсууд хотжилтын сөрөг нөлөөг амсчээ. Хотжилт гэдэг нь хот, хот маягийн суурин газруудад оршин суугчдын нийт хүн амд эзлэх хувийн жин өсөх үйл явц юм. Судлаачид хотыг тодорхойлохдоо дараах үндсэн шалгуурыг ашигладаг. Үүнд:

1. Хүн амын тоо
2. Газар нутаг, арьяалын хэмжээ
3. Газар нутаг, хүн амын харьцаа буюу төвлөрөл
4. Эдийн засаг, нийгмийн байгуулал зэрэгтэй холбодог байна.

Харин хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулинд хотыг тодорхойлохдоо “Хот нь 15 мянгаас доошгүй оршин суугчидтай, тэдгээрийн дийлэнх хувь нь гол төлөв үйлдвэр, үйлчилгээний салбарт ажилладаг, хот бүрдүүлэгч дэд бүтэц нь хөгжсөн, өөрсдийн удирдлага бүхий төвлөрсөн суурин газар мөн (УИХ, 1993)” гэжээ.

Монгол Улсын хүн амын нутагшилт суурьшлын үндсэн хоёр хэлбэр нь хот, хөдөө бөгөөд хүн ам олноор шилжин суурьшсантай холбоотойгоор хотжилт эрчимтэй явагдаж, 2010 оны байдлаар 67.9 хувь байсан (Үндэсний хөгжлийн хүрээлэн, 2011) бол эдүгээ 70 орчим хувьд хүрээд байна.

Зураг 1. Монгол Улсын хүн амын өсөлт, хот, хөдөөгөөр



Монгол Улсын нийт хүн амын 44 хувь нь нийслэлд/агломераци буюу том хот дагасан/, 30 хувь нь нийт 350 хот суурин газарт үлдсэн 26 хувь нь хөдөөд амьдарч байна. Харин хот суурин газарт оршин сууж буй хүмүүсийн 70 орчим хувь нь нийслэл Улаанбаатар хотод

амьдарч байгаа болно. Хүн ам хэт төвлөрсөн, тулгарч буй асуудал, хүн ам, нийгмийн бүлгүүдийн тоо хэмжээ, соёлын төв болох утгаараа хотын амьдралын хэв маяг, судалгааны хүрээнд нийслэл Улаанбаатар хотын нөхцөл байдлыг авч үзэв.

Судалгааны баримт, материалаас үзэхэд хотжилтын талаар яв цав тодорхойлолт өнөө хэр нь үгүй байна. Хотжилт бол түүхэн талаасаа аж үйлдвэржилттэй холбоотой, шууд хэлэхэд эдийн засгийн өөрчлөлтийн үйл явц боловч хөдөөгийн хил хязгаараас хальж хотын хил хязгаар болж өөрчлөгдөх үйл явцынхаа хувьд социаль агуулгатай, бодлогын болон нийгмийн үй түмэн асуудлыг агуулсан, хүн амын шилжих хөдөлгөөн, сэлгэн суурьшилтаар тайлбарлагдах үйл явц, шинэ амьдралын хэв маяг юм.

Шилжих хөдөлгөөний эрчимжилт ба хотжилт

Монголчууд мянганы зааг үест тохиосон нийгэм эдийн засгийн шилжилтийн үеийн хямрал, бэрхшээл болох ажилгүйдэл, орлого, хүнс тэжээлийн гачигдал, амьжиргааны түвшний доройтол, ядуурал, үнийн өсөлт, баян ядуугийн ялгаа, боловсрол хүмүүжлийн хоцрогдол зэрэг асуудлыг даван туулахын тулд хөдөөнөөс хотыг чиглэсэн шилжих хөдөлгөөнд ихээр татагдан орсон юм. Хот хөдөөгийн амьжиргааны нөхцөлийн ялгаа ихсэхийн хэрээр хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөн бий болсон. Хот, хөдөөгийн шилжих хөдөлгөөний дүнд хөдөө сумдад хүн ам цөөрч, оршин тогтнох хүн ам, эдийн засгийн бодит нөөцөө шавхсан бол хотын хувьд ачаалал 2-3 дахин ихэсч, механик өсөлтийн дүнд гэр хороолол өргөжин, хотын хүн амын амьдралын нөхцөл эрс муудсан байна. Барууны судлаачдын үзсэнээр дэлхий ертөнц дээр амьдарч буй хүмүүсийн тоо хэдий чинээ өснө тэр хэмжээгээр амьдралын чанар “муудах” тал бий ажээ. Энэ нь амьдралын чанар бол хүмүүсийн тоо, нийт хүн амын хэмжээтэй урвуу хамааралтай гэсэн үг болно. Тухайн үзлийг баримталдаг Америкийн нэрт биологич Дол Эрлих “Хүн амын тэсрэлт” нэртэй номондоо ирээдүйд чухалд тооцогдох үндсэн асуудал бол хүн амын тоо хэт олон болж өсөх явдал бөгөөд хүн амын амьдралын чанарын асуудлыг авч үзэхдээ энэхүү хүн амын өсөлтийн тоо хэмжээг харгалзан үзэх нь зайлшгүй гэжээ. Чухамхүү үүний жишээ бол Улаанбаатар хотын хүн амын механик өсөлт, арьяалын тэлэлт мөн. 1990-ээд оны сүүл, 2000 оны эхэн үед болсон зудын гамшгийн улмаас хөдөө, орон нутгийн хүн ам эдийн засгийн хувьд ихээхэн хохирол амсаж, амьжиргаагаа залгуулах боломжгүй болсноос шалтгаалан хөдөө орон нутгаас бусад хот суурин газар болон Улаанбаатар руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн эрчимжиж, ялангуяа нийслэлийн хүн ам жилээс жилд өсөн нэмэгдсэн байна. 2000 оны хүн ам, орон сууцны тооллогоор Монгол Улсын нийт хүн амын 56.6 хувь нь хот суурин газарт амьдардаг байсан бол 2008 онд 61.8 хувь болж, 5.2 пунктээр өссөн (ШУА, ФСЭХ, 2014) байна.

Хүснэгт 1. Улаанбаатар хотын хүн амын тоо ба хүн амын өсөлт

Он	Хугацааны эхэн дэх хүн амын тоо	Хугацааны эцэс дэх хүн амын тоо	Дундаж өсөлт
1980-1990	418.7	560.6	2.8
1990-2000	560.6	760.1	3.1
2000-2010	760.1	1112.3	3.8
2010-2012	1112.3	1287.1	4.4
2012-2016	1287.1	1380.7	2.9

ҮСГ-аас 1995 онд хийгдсэн амьжиргааны түвшин тогтоох судалгааны үр дүнг 1998 оны түүвэр судалгааны үр дүнтэй харьцуулахад зөвхөн энэ хугацаанд хотын хүн ам 1,5 дахин ихэсч, хотын захын гэр хороололд амьдардаг хүмүүсийн тоо даруй арав дахин өссөн байна. Энэ үед шилжилтийн эцсийн цэг болсон нийслэлийн хувьд шилжин ирсэн захын гэр хороололд зохицох байдлаар дэд бүтэц болон зам харилцааг тавих үүрэг хүлээж иржээ. Хүн ам орон сууцны 2000, 2010 оны улсын тооллогын мэдээлэлд үндэслэн арван жилийн үечлэлээр шилжих хөдөлгөөний эрчим, идэвхжилийг харьцуулан үзэхэд Улаанбаатар хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөний урсгал сүүлийн 10 жилийн дотор өмнөх үеэс 54.4 хувиар нэмэгдсэн бөгөөд 2000 онд нийт хүн амын 57 хувь буюу 1,345.0 мянган хүн хот суурин газар амьдарч байсан бол 2010 он гэхэд нийт хүн амын 67.9 хувь буюу 1,798.1 мянга нь хот сууринд амьдарч байна. Ядуу өрхийн дунд явуулсан судалгаанаас үзэхэд 37.1 хувь нь шилжин ирэгч байна. Улаанбаатар хотыг чиглэсэн шилжих хөдөлгөөнд оролцогчдыг авч үзэхэд залуучууд, тэр дундаа эмэгтэйчүүд зонхилж байна. Нийт шилжин ирэгчдийн 56.4 хувь нь эмэгтэйчүүд байгаа нь шилжих хөдөлгөөнд эмэгтэйчүүд түлхүү оролцож байгааг харуулах юм.

Хотжилтын нөлөө, хүн амынхэт төвлөрлийн дүнд эхний ээлжинд үнс шороо, хог хаягдал бүхий гудамж, хороог бий болгож, улмаар хавар, намартаа их хэмжээний “шороо, түйрэн” дэгдэх, өвөлдөө агаарын бохирдлыг үүсгэхэд зонхилох нөлөө үзүүлэх болсны дээр амьжиргаа тааруу, ажилгүйдэл, гэмт хэрэг нүүрлэсэн, ядуу өрхүүд олноор төвлөрсөн захын гэр хорооллыг өргөжин тэлэхэд хүргэжээ.


Хотын хөгжлийн сорилт 1. Ядуурлын цар хүрээний өсөлт, тэлэлт

Статистик мэдээлэл болон суурь судалгааны үр дүнд тулгуурлан хүн амын амьжиргаанд гарсан өөрчлөлтийн үр дүнг нэгтгэн үзвэл дараах зүйлс ажиглагдаж байна. Өмч хувьчлал, үнэ чөлөөлөх үйл явц болон өргөн хэрэглээний барааны хомсдлоос үүдэн бараа бүтээгдэхүүний үнэ/инфляц/ урьд байгаагүй ихээр өссөн ба үүнээс шууд хамааран худалдан авах чадвар буурч, ядуурал дам байдлаар нэмэгдэж, хүн амын амьжиргаа

доройтох, улмаар цалин орлого хангалтгүйгээс ажлаа солих, түр болон урт хугацаанд ажилгүй болох үйл явц давхацсанаас үүдэн хүн амын дунд ядуурлын цар хүрээ тэлсэн байна. Монгол Улсын засгийн газраас 1995, 1998 онд Дэлхийн банкны оролцоо дэмжлэгтэйгээр ажилгүйдэл, ядуурлын байдалд улсын хэмжээний дүгнэлт, шинжилгээ хийсэн тайланд дурьдсанаар “хүн амын 36.3% буюу 800 мянган иргэн, 230 гаруй мянган өрх ядуурлын нөхцөлд амьдарч байна” хэмээн үнэлжээ. Мөн амьжиргааны түвшин тааруу буюу ядууралд өртөж байгаа өрхүүдийг бүтэн ба хагас өнчин хүүхэдтэй, цөөн малтай, ажилгүй, олон хүүхэдтэй, өрх толгойлсон эмэгтэйчүүд бүхий өрх хэмээн тодорхойлсон(ҮСГ, 1998) юм.

Эдийн засгийн боломжоос хамаарч ядуурлын хамралт хот, хөдөөд ихээхэн ялгаатай байгааг Монголын хүний хөгжлийн илтгэлд дурджээ. Уг илтгэлд (МУЗГ, НҮБХХ, 2004) дурдсанаар нийслэл хот болон бусад томоохон хот сууринд уул уурхай, дулааны эрчим хүч, нийтийн ахуй үйлчилгээ, барилга байгууламж, худалдаа, тээвэр, харилцаа холбоо болон боловсролын байгууллагууд төвлөрч, харин хөдөө орон нутагт зах зээл хөгжөөгүй, дэд бүтэц сул, ажил эрхлэх боломж тааруу төрийн алба, худалдаа наймаанаас өөр эрхлэх ажил бараг байхгүй, зах зээлээс хараат байдалтай мал аж ахуй зонхилсон нийтлэг талууд хөдөөгийн хүн амын орлогобуурахад нөлөөлж, хөдөө, орон нутгийн амьдралын чанарт сөрөг нөлөө үзүүлсэн гэж дүгнэсэн байна. Судалгааны баримт, мэдээлэлд тулгуурлан авч үзэхэд Монгол Улсын хэмжээнд ядуурал өсөн нэмэгдэж, цар хүрээгээ тэлэхэд дараах хүчин зүйл нөлөө үзүүлсэн (М.Батбаатар, 2016) байна.

Зураг 2. Эдийн засгийн уналт ба ядуурлын цар хүрээний тэлэлт



ХАССТ, НҮБХХ-ийн 2004 оны “Улаанбаатар хотын ядуурал ба шилжих хөдөлгөөн” судалгааны тайлангаас харахад хүн амын 33% нь орлогын, 24% нь нийгмийн оролцооны, 24% нь хүртээмжийн ядууралтай байна гэж дүгнэсэн. Ядуурлын үндсэн шинж бол орлогын хомсдол юм. Орлогогүй болох, бодит орлого буурах зэрэг үйл явц нь хот, хөдөөд хүн амыг ядуурахад хүргэж буй үндсэн шалтгаан болж байна. Харин хүн ам нийгмийн үйлчилгээнээс хүртэж чадахгүй байх, чадавхи оролцооны хувьд ядуурах зэрэг үзэгдэл Монгол Улсын хувьд хот хөдөөд харьцангуй ялгаатай байгаа болно.

Хотын хөгжлийн сорилт 2. Хүн амын боловсрол ба ажил эрхлэлт

Монгол Улс хотжилт эрчимтэй явагдаж буй орнуудын тоонд ордог. Дэлхийн томоохон 200 хоттой харьцуулсан хотын эдийн засгийн хөгжлийн судалгаанаас үзэхэд (ШУА, Монгол дахь хотжилт:үйл явц ба төлөв байдал, 2014) 2010 онд хүн амын шилжилт хөдөлгөөн болон үйлдвэрлэлийн өсөлтийг дагаад ажил эрхэлж буй хүн амын өсөлт улсын дунджаас 3 дахин өсөж дэлхийн 200 хотыг тэргүүлэх хэмжээнд хүрсэн байна.

Өмнө дурдсанаар хот орчимд бий болсон ядуурлын үндсэн нөхцөл бол хотын захын гэр хороололд үй олноор шилжин суурьшсан, мэргэжил боловсролгүйн улмаас ажил эрхлэх боломжгүй, цалин орлого багатайн улмаас амьжиргаа тааруу байх явдал нийтлэг тохиолдож байна. Шилжин ирэгчдийн дунд ган зудаас хамаарч малгүй болсон малчид буюу ажлын дадлага туршлагагүй хүмүүс, бүртгэл бичиг баримтгүй хүмүүс тодорхой хувийг эзэлж байгаа нь (НХХЯ, НҮБХХ, 2004) ажил эрхлэлт, амьжиргааны түвшин доогуур байгаагийн үндсэн шалтгаан болдог байна.

Боловсрол өндөр, шилжих хөдөлгөөнд оролцоогүй хотын иргэд албан секторт ажилладаг бол боловсрол багатай, шилжин ирсэн хүмүүс боловсрол, мэргэжил төдийлөн шаарддаггүй ажил эрхлэх буюу нийгмийн хангамж, тэтгэмж байхгүй, баталгаатай бус салбарт ажиллаж, орлогын эх үүсвэрээ тэр бүр хангаж чадахгүй байна. Шилжин ирсэн ядуу өрхийн албан бус секторт ажиллаж буй хоёр ажилчин тутмын нэг нь эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байна. Тэрчлэн ядуу өрхүүд зөвхөн нэг эх үүсвэрээс орлого бүрдүүлж, амьдралаа залгуулах явдал нийтлэг харагдаж байна. Энэ нь тухайн ажилтай өрхийн гишүүн ажлаас халагдах буюу улирлын чанартай ажил зогсоход тухайн өрх огт орлогогүй болох, улмаар ядуурах, эмзэг болон эрсдэлт байдалд оршиж байна гэсэн үг. Нөгөө талаар эмзэг бүлгийн хүмүүсийн хувьд нийгмийн халамжийн сангаас авдаг тэтгэвэр, тэтгэмж нь тэдний амьжиргааны гол эх үүсвэр болдог. Гэсэн хэдий ч шилжих хөдөлгөөний бүртгэл хийлгээгүйн улмаас албан ёсоор хотын иргэн болоогүй, бүртгэлгүй иргэдийн хувьд тэтгэвэр тэтгэмж авч чадахгүй, нийгмийн халамжийн үйлчилгээний гадна хоцроход хүрдэг.

Шилжин ирсэн өрх, иргэд ядуурах дараагийн үндсэн шалтгаан бол боловсрол мэргэжилгүй, танил талын хүрээ хомс, өндөр цалин орлоготой ажилд орох боломжгүй байх явдал болно. Шилжин ирсэн хотын захын гэр хороололд амьдарч буй хүн амын гуравны нэгээс илүү нь албан бус сектороос тухайлбал зах дээр болон гудамжинд жижиг худалдаа эрхлэх, хүмүүст туслах чанарын жижиг үйлчилгээнээс өрхийн орлогоо бүрдүүлж байна. Хөдөөнөөс шилжин ирсэн өрхүүдийн хувьд мал ахуйгаа зарж олсон орлогоороо хэсэг хугацаанд амьжиргаагаа залгуулдаг бөгөөд бусдаас авах тусламж, мал аж ахуйгаас олсон тухайн орлого нь орлогын найдвартай эх үүсвэр биш учраас шилжих хөдөлгөөнд оролцсон хотын зах орчимд амьдарч буй иргэдийн хувьд ядууралд өртөх магадлал харьцангуй их байдаг ажээ.

Өнөөдөр хөдөөтэй харьцуулахад хотод сургуульд хамрагдалт, бичиг үсэгт тайлагдалт, боловсролын түвшин өндөр байна. Хот руу шилжин ирэгчид голдуу гэр хороололд амьдарч байгаа ба тэднийдийлэнх нь бүрэн дундаас доош боловсролтой байна. Шилжин ирэгчдийн дийлэнх нь ажил эрхлэх, амьжиргаагаа дээшлүүлэх, суралцах болон зах зээлд ойртох зорилгоор шилжин иржээ. Шилжин ирснийдараа ажил эрхлэх, амьжиргаагаа дээшлүүлэх болон зах зээлд ойртох гэсэн зорилгууд нь хэдийгээр биелсэн боловч боловсролын байдалд нь ахиц гарсангүйгээр үл барам ядууралд өртөх эрсдэлтэй тулгарсан байна.

Хот, хөдөөгийн иргэд хувцас, сурах бичиг, хандивын зардлыг ядуурлын гурван үндсэн шалтгааны нэг гэж тодорхойлсон байна. 2000 онд явуулсан Жейнсийн судалгаанаас харахад (ЭМЯ, 2013) судалгаанд хамрагдсан өрхийн 15 хувь нь хүнд өвчин эмгэгээс болж ядуурсан буюу ядуурах нөхцөл бүрдээд байна гэсэн бол, 20 хувь нь санхүүгийн бэрхшээлээс болоод эмчийн зааврыг дагаж чадаагүйгээс өвчин эмгэг тусаж улмаар ядуурсан гэжээ. Эдгээр бэрхшээлүүд хүн амын ядуу, эмзэг бүлгийнхэнд илүү тохиолдож байна. Дэлхийн банкнаас санаачлан хэрэгжүүлсэн Ядуурлын хандлагын шинжилгээний үр дүнгээс үзэхэд (ҮСХ, Дэлхийн банк, 2009) хүн амын ядуурлын түвшин дорвитой буурахгүй, амьжиргааны түвшний тэгш бус байдал улам гүнзгийрэх байдал ажиглагдаж байна. Жини коэффициентээр тэгш бус байдлыг хэмжихэд 0.33 байгаа бөгөөд энэхүү тэгш бус байдал хот суурин газруудад хөдөөнөөс илүү байна. 2004 онд үндэсний хэмжээнд явуулсан судалгаанаас үзэхэд (ҮСГ, Дэлхийн банк, НҮБХХ, 2004) хүн амын хамгийн чинээлэг 20 хувь нь хамгийн ядуу 20 хувиас 5.5 дахин их хэрэглээтэй байна. Мөнхүү судалгаагаар 2002-2003 онд ядуурлын хамралтын хүрээ 36.1% байсан бол 2007-2008 онд 35.2% болж, 0.9 пунктээр буурсан мэдээ бий. Улаанбаатар хотын ядуурал өсөн нэмэгдэхэд улирлын чанартай, мэргэжил шаардахгүй, баталгаагүй ажлын байр, үнийн өсөлт, орлогын

найдваргүй эх үүсвэр\цор ганц\, хөдөөнөөс шилжин ирсэн ажилгүйчүүдийн тоо хэмжээ, тэгш бус байдал зэрэг олон тооны хүчин зүйл нөлөөлсөн.

Дашрамд дурдахад Улаанбаатар хотод нийт их дээд сургуулийн 95 хувь нь төвлөрч байгаа нь шилжих хөдөлгөөний эцсийн цэг болоход шууд нөлөө үзүүлж байна.

Сүүлийн 20 жил хот, хөдөөгийн орон зайн ялгаатай тэгш бус байдлын улмаас хөгжлийн мэдэгдэхүйц ялгавартай байдал бий болж, улмаар хөдөө орон нутагт хүн ажиллаж, амьдрах нөхцөл боломж байхгүйгээс амиа аргацаах, амин зуулгаа залгуулах, сурч боловсрох, эрүүл амьдрах эрхээ хангахын тулд хүмүүс олноороо хот суурин, тэр дундаа Улаанбаатар хот руу шилжин суурьших болсноор нийслэл хот орчимд хүн амын хэт төвлөрөл бий болж, хот орчмын бүс хүрээгээ ямар нэгэн төрийн бодлого төлөвлөлтгүйгээр аажимхан тэлсээр байна.

Хотын хөгжлийн сорилт 3. Шилжилтийн өмнөх ба дараах нөхцөл: хүлээлт ба бодит байдлын зөрөө

Улаанбаатар хотын үйлдвэр, үйлчилгээ, боловсрол, эрүүл мэнд зэрэг нийгмийн салбарын хөгжил хөдөөнөөс илүү, ажлын байрны олдоц харьцангуй өндөр байгаа нь хүмүүсийг ихээр татаж хотжих үйл явцыг улам бүр өргөжүүлж байна. Шилжих хөдөлгөөний татах, түлхэх хүчин зүйлийг харьцуулсан судалгааны тайлан (ХАЗССТ, 2008)гаас үзэхэд хувь хүнд олон тооны асуудлууд нөлөө үзүүлсэн байна. Эдгээр нөлөөллийг авч үзэхэд дараах хүчин зүйлс нөлөө үзүүлсэн ажээ.

- Ажил олдохгүйн улмаас амьдрал улам бүр доройтоххандлагатай байна.
- Бичиг баримтгүйн улмаас нийгмийн суурь үйлчилгээ хүртэх боломжоор хязгаарлагдах
- Шилжих хөдөлгөөнд оролцогчдын 60 хувь нь хүсэн хүлээж байсан хүлээлт, мөрөөдлөө биелүүлж чадаагүйбайв.
- Шилжин ирснээр урт хугацааны туршид ажил хөдөлмөр эрхлээгүй эмзэг өрхүүд ядуу, ядуу өрхүүд нэн ядуу болж, нэн ядуу хүмүүс үгээгүй ядуу болон туйлдаж байна.

Хүснэгт 2. Шилжилтийн өмнөх ба дараах нөхцөл: хүлээлт ба бодит байдал

	Шилжилтийн өмнөх хүлээлт	Шилжилтийн дараах бодит байдал
Орчны хувьд:	Амьжиргааны түвшин, аж байдлаа сайжруулах, Нийгмийн үйлчилгээний чанар,	Амьжиргааны түвшин улам муудсан, Үйлчилгээний чанар, хүртээмж сайжирсан, Дэд бүтцийн хөгжил хотын

	хүртээмжээ нэмэгдүүлэх, Дэд бүтцийн хөгжил, Зах зээлийн хөгжил, Мэдээллийн хангамж	захын хороололд амьдрах болсноор муудсан, Зах зээлийн хөгжилд ойртсон, Мэдээллийн хангамж тааруу болсон
Боломж, нөхцлийн хувьд:	Ажил, үйлчилгээ эрхлэх, нийгмийн үйлчилгээнд хамрагдах, эрүүл, аюулгүй орчинд амьдрах хэрэгцээ	Ажил, үйлчилгээ эрхлэх боломжгүй болсон, Нийгмийн үйлчилгээнд хамрагдах боломжгүй болсон, Эрүүл, аюулгүй орчинд амьдрахад хүндрэлтэй.
Чадавхийн хувьд:	Боловсролын түвшин, аливаа боломжийг ашиглах чадвар, орчиндоо дасан зохицох зэрэг хүчин зүйлс давамгайлж байгаа юм.	Боловсролын түвшин сайжирсан боловч өндөр төлбөр төлөх болсон Аливаа боломжийг ашиглах чадвар нэмэгдсэн боловч эрсдэлтэй тулгарах болсон Орчиндоо дасан зохицоход бэрхшээлтэй, орчны ялгаварлал үүсч байна/хөдөөгийнхөн,бүдүүлгүүд гм/

Шилжин ирэгчдийн дийлэнх нь ажил эрхлэлт, амьжиргаагаа дээшлүүлэх, суралцах болон зах зээлд ойртох зорилготой байжээ. Тухайн шинжилгээнээс үзэхэд шилжих хөдөлгөөний түлхэх хүчин зүйлсэд мал ахуйгаа зуд турханд алдаж амин зуулгагүй болсон, ажилгүйдэл, амьдралын тааруу нөхцөл, суралцах хүсэл эрмэлзэл, зах зээлийн алслагдмал байдал, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжсул зэрэг зүйлс багтаж байгаа бол, харин ажил эрхлэх боломж, амьдралын таатай нөхцөл, боловсрол эзэмших боломж, эрүүл мэндийн үйлчилгээ, зах зээл зэрэг нь шилжин ирэгчдийг зонхилон татах хүчин зүйлс болж байна.

Улаанбаатар хот руу шилжин ирэх хүн ам зүйн хөдөлгөөнд ихэвчлэн нийгмийн болон эдийн засгийн хүчин зүйлс голлох нөлөө үзүүлсэн байна.Шилжилтийн өмнөх болон дараах нөхцөл байдлыг харьцуулан үзэхэд шилжих хөдөлгөөнд татагдан орсон иргэдийн хүлээлт бодит байдалд биелээгүй төдийгүй нөхцөл байдал өмнөхөөс дордсон байна.

Шилжих хөдөлгөөний эхний үр дүн бол төлөвлөлтөөс гажуудсан хотжилтын хэв маяг байсан бол дараагийн үр дүн болж хөдөөгийн сум суурин эзэнгүйдэх үйл явц эхлээд байна. Иймд төрөөс тухайн чиглэлд анхаарч шилжилтийн үйл явцыг зохицуулах ньхүн амын ядуурлыг бууруулах бодлогын томоохон хүчин зүйл болно.

Хотын хөгжлийн сорилт 4. Шилжин ирсэн өрхийн амьжиргааны өөрчлөлт

Сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөнөөс шууд шалтгаалж, гэр хорооллын өрх, хүн амын тоо эрс өсч байна. Өөрөөр хэлбэл, Улаанбаатар

хотод шилжин ирсэн жилдээ багтаж байшин, орон сууц худалдан авах нь бага байгаа бөгөөд гэр хороололд суурьшсан 184 мянган өрхийн 80 гаруй мянга нь монгол гэрт, 100 гаруй мянга нь байшин сууцанд амьдарч байна. Гэр хороололд оршин сууж буй хүн ам, өрхийн тоо нэмэгдсэний улмаас хүйтний улиралд агаарын бохирдол хот орчмын экологийн тулгамдсан асуудлын нэг болоод байна. Агаарын бохирдол нийслэлийн хүн амын эрүүл мэндэд маш муугаар нөлөөлж, цаашилбал хүний аюулгүй амьдрах ахуйн нөхцөлд сөргөөр нөлөөлж байна.

Шилжин ирэгчдийн ихэнх нь (71 хувь) шилжин ирсэн зорилгоо биелсэн гэжүзэж байгаа ч, боловсролын байдалд ахиц гараагүйн зэрэгцээерхийн амьжиргааны бодит түвшин буурсан дүр зураг харагддаг.Төр засгийн зүгээс хэрэгжүүлж буй бүртгэлийн тогтолцоо Улаанбаатар руу шилжин ирэх хөдөлгөөнийг багасгахад нөлөөлж чадахгүй байна. (шилжигчдийн тал хувь нь бүртгэлгүй байна). Гэвчбүртгэлгүй байдал нь эрүүл мэндийн даатгалгүй шилжигчдийн (1/3) эрүүлмэндийн даатгалд хамрагдаж чадахгүй байгаа үндсэн шалтгаануудын нэг(эрүүл мэндийн даатгалд хамрагдаж чадахгүй байгаа шилжигчдийн 1/4 ньбүртгэлгүй гэсэн шалтгаанаар хамрагдаж чадахгүй байна) болж байна. Эндээс, шилжих хөдөлгөөний зохицуулалтыг цаашид анхаарах хэрэгтэй болохыг төвөггүй харж болно. Шилжих хөдөлгөөнийг бууруулахын тулд орон нутагт ажлын байр нэмэгдүүлэх, хүн амын эдийнзасгийн байдал болон боловсролын чанарыг сайжруулах асуудал хамгийнчухал байна.

Шилжин ирэгчдийн гол асуудал бол ажилд орох, амьдралаа залгуулах, амьдрах сууц, орон байр олох нэг ёсондоо хотод байр сууриа олох явдал байдаг ажээ. Улаанбаатар хотод нийт шилжин ирэгчдийн 38.4 хувь нь амьдрах байр сууриа олоогүй хүмүүс байна. Зарим судалгааны дүн (ШУА, 2013)-гээс харахад шилжин ирээд нэг жил болоогүй хүмүүс 100 хувь нийгэмд эзлэх байр сууриа олж чадаагүй байдаг бол харин нэг жил амьдарсан хүмүүсийн 60 орчим хувь нь байр сууриа олж, дасан зохицож эхэлдэг байна. Энэ хугацаанд тулгарч буй асуудлыг даван туулж чадаагүй тохиолдолд шилжин ирэгчдийн хувьд орлогын хувьд ядуурах, эмзэг баталгаагүй байдалд орох эрсдэл хүлээж байдаг. 2007 оноос явагдаж эхэлсэн “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа”-ны дүнгээс үзэхэд Улаанбаатар хотод ядуурлын түвшин нэмэгдэх хандлага ажиглагдаж байна. Хотын хөдөлмөрийн зах зээл нийслэл хотод амьдран суугчдыг бүгдийг шингээж чадахгүй тул шилжин ирэгсэд болон ядуучууд нь ажилгүй, орлогогүй хэвээр үлдэх магадлал харьцангуй их байгаа болно. Улаанбаатар хотын ядуурал жил бүр нэмэгдэх төлөвтэй байгаа ба 2010 оны судалгаагаар (ҮСГ, Улаанбаатар хотын хүн ам, эдийн засгийн үйл ажиллагаа, 2010) нийслэл хотын хүн амын 29.8 хувь нь ядуу амьдарч байжээ. Нийслэл хотод хүн амын дийлэнх төвлөрөх болсноор хүн амын бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт, хэрэгцээг

нэмэгдүүлж, тэр хэрээр эдийн засгийн үйл ажиллагааг өргөжүүлэх боломжийг бий болгосон. Гэсэн хэдий ч хүн амын хэт төвлөрөлтэй холбоотой, мэргэжил ур чадварын хувьд дутмаг тул бүрэн бус ажил эрхлэлтээс үүдэн нийслэл хотод ядуурал улам бүр ихэсч байна. Тэмдэглэхэд, хотын эдийн засаг буюу хөдөлмөрийн зах зээл хот сууринд амьдран суугчдыг бүгдийг шингээж чадахгүй нь нэгэнт тодорхой тул шилжин ирэгчид болон ядуус ажилгүй, орлогогүй хэвээр үлдэж, улмаар амьжиргаа дордох, ядууралд өртөх үндсэн хүчин зүйл болж байна.

Хотын хөгжлийн сорилт 5. Суурьшлын түрэлт ба дэд бүтцийн хомсдол

Хүн амын төвлөрөл ба ядуурлын хувьд авч үзэхүл 1998 оны байдлаар хотын ядуурал (39.4 хувь) хөдөөгийн ядуурлаас (32.6) өндөр байв. Нэн ядуу хүн амын тэн хагасаас илүү (57.0 хувь) хувь нь хот суурин газарт, тэдгээрээс 26.0 хувь нь нийслэл хотод суурьшиж, харин ядуу иргэдийн 43.0 хувь нь хөдөө орон нутагт амьдарч байна. 2013 оны байдлаар Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугаа хүмүүсийн 68.1 хувь нь хотын хүн ам буюу аймгийн төв, нийслэл, суурингийн хүн ам болно. Үүнээс нийт хүн амын 46.8 хувь, хотуудын хүн амын 68.7 хувь буюу гуравны хоёр нь нийслэл Улаанбаатар хотод оршин сууж байна. Улаанбаатар хот Монгол Улсын нутаг дэвсгэрийн 0.3 хувийг эзэлж байгаа боловч хүн амын нягтрал хамгийн ихтэй хотуудын нэгд зүй ёсоор тооцогдох болжээ. Хотжилтыг бий болгох суурь хүчин зүйлс болох шилжин суурьшилт, хүн амын төвлөрөлийн үр дүнд төлөвлөөгүй, эмх замбараагүй суурин, гэр хороолол бий болж, нөгөө талаас хотын нийгэм, эдийн засаг, дэд бүтэц болон засаг захиргааны ажилд асар их ачаалал үүсгэж, ядуурлыг улам бүр гүнзгийрүүлэн тэлж байна. Шилжин ирэгчдийн суурьшил, түрэлт хотын дэд бүтцийн чадавхийг шавхаж, гэрэл цахилгаан, зам харилцаанаас авахуулаад хөдөөнөөс ирээд дасан зохицох, амьжиргааны наад захын нөхцлийг бүрдүүлэхэд нь туслах, ыоловсрол, эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулах зэрэг нийгэм, эдийн засгийн олон асуудлыг шийдвэрлэхэд сайтар боловсруулсан төлөвлөгөө, зохион байгуулалтын ажлыг төр засгаас зохион байгуулахыг үгүйлж байна. 2000 онд хийгдсэн Монголын дотоод шилжих хөдөлгөөний микро түвшний судалгааны үр дүнгээс үзэхэд шилжин ирэгчдийн ахуй нөхцлийг Улаанбаатар хотын шилжих хөдөлгөөнд оролцоогүй хүн амтай харьцуулахад доогуур байгаа (НХХЯ. ХАССТ. НҮБХАС, 2001) нь өнөөгийн нөхцөлд ч хэвээр байгаа болно. Юуны өмнө гэр хорооллын оршин суугчдын олонх нь боловсролгүйн улмаас ажилгүй, эсвэл мэргэжил, боловсролын өндөр түвшин төдийлөн шаарддаггүй албан бус секторт бага цалин, орлоготой ажиллах төдий аж төрж байна. Ингэснээр нийт ядуучуудын талаас илүү хувь нь хот, суурин газарт, тэдгээрийн дөрөвний нэг орчим хувь буюу 25 хувь нь Улаанбаатар хотод төвлөрч байна.

Хотын захын гэр хорооллын ядуу өрхийн хувьд нийтлэг тулгамдсан асуудлын нэг бол сургууль болон өрхийн эмнэлгээс үйлчилгээ авах бэрхшээл болно. Хотын захын гэр хорооллын өсөлт тэлэлтээс хамаарч сургууль, эрүүл мэндийн үйлчилгээ тэр бүр жигд, хүртээмжтэй байж чадахгүй байна. Судалгаанаас үзэхэд (НҮБХХ, 2004) нэн ядуу өрхийн 16.2 хувь, ядуу өрхийн 9 хувь нь өрхийн эмнэлэгт үзүүлж, мэргэжлийн зөвлөгөө тусламж авах боломжгүй байхад ядуу бус өрхийн 4 хувь нь боломжгүй байдаг гэснээс үүнийг харж болох юм. Гэр хороололд амьдарч буй ядуу өрхийн 28 хувь нь 3-с дээш километр байрлах өрхийн эмнэлгээс үйлчилгээ авдаг байна. Сургууль, цэцэрлэгийн хүртээмж шилжигч болон гэр хорооллын хүн амд мөн л тааруухан байна. Тухайлбал, шилжин ирсэн ядуу өрхийн хувьд төлбөртэй чанартай сургууль цэцэрлэгт хүүхдээ сургах боломж хомс, сургуулийн ачаалал хэтэрсний улмаас ялангуяа гэр хорооллын эрэгтэй хүүхдүүд сургууль завсардах нь ихэссэн, хамгийн ойр гэж тодорхойлсон ерөнхий боловсролын сургууль 2 ба түүнээс дээш километр байрлаж байгаа, энэ нь өвлийн улиралд бага ангийн хүүхдэд ихээхэн хүнд нөхцөл зэрэг болно.

Хотын захын дүүрэг дэх гэр хорооллын хүн ам, өрхийн орлого нэмэгдүүлэх, амьжиргааны чадавхийг дээшлүүлэх чиглэлээр төрөөс хэрэгжүүлж буй хөтөлбөр, төслийн талаар ядуу өрхийн талаас илүү хувь нь мэдээлэл авсан боловч 10 хүрэхгүй хувь нь төслийн үр шимээс ямар нэг хэлбэрээр хүртсэн байна. Ядуу, амьжиргаа тааруу өрхийн хүн амд мэргэжлийн боловсрол, сургалт зайлшгүй хэрэгцээтэй. Гэтэл амьжиргаагаа дээшлүүлэх ард иргэдийн өөрсдийн идэвхи оролцоо хангалтгүй байна. Мэргэжлийн ажил, хөдөлмөрийн дадлага оолгох сургалтад хамрагдсан өрхийн хувьд амьжиргааны түвшингээр төдийлөн ялгаатай бус байгаа ч, сургалтад хамрагдсанаар амьжиргаагаа дээшлүүлж чадсан нэн ядуу өрхийн хувь чинээлэг өрхийнхөөс бараг гурав дахин бага байгаа нь анхаарал татаж байна. Хүмүүн капиталын онол ёсоор хүн амын чадавхид оруулах хөрөнгө оруулалт ядуурлаас гаргах нэгэн хүчин зүйл болдог хэдий ч, бодит байдалд хүн амын орлогын ядуурал чадавхи болон оролцоог хязгаарладаг болохыг эндээс харж болно.

Орлогын болон чадавхийн ядуурал өрхийн гишүүдийг нийгмийн үйл ажиллагаанд оролцох, тэгш боломжийг хязгаарлаж байна. Судалгаанаас үзэхэд өрхийн амьжиргааны түвшин дээшлэх тусам орон нутагт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн талаарх мэдээлэл, мэдлэг нэмэгдэж байна. Улаанбаатар хотын судалгаанд хамрагдсан хүн амын 33 хувь нь ядуурлын шугамаас доогуур амьжиргаатай, түүврийн 10 хувь нэнядуу (өөрөөр хэлбэл зардал нь ядуурлын шугамаас 60 хувиар доогуур) байна. Улаанбаатар хотын өрхийн тал хүрэхгүй (42.9) хувь нь сургалтад хамрагдсанаар тодорхой хэмжээгээр амьжиргаагаа дээшлүүлж чадсан гэж үзжээ. Гэр хороололд амьдарч буй иргэдийн 45 хувь, шилжин

суурьшигч иргэдийн 37хувь нь ядуу байна. Эдгээр хүмүүсийн өрх олон ам бүлтэй, мөн дийлэнх нь эмэгтэй өрхийнтэргүүлэгчтэй байна.

Тэгш бус байдал гэр хороололд амьдрагчдын дунд харьцангуй гайгүйболовч шилжин суурьшигчдын хувьд ихээхэн ялгаатай байна.Залуу насны, боловсролгүй болон гэрлээгүй хүмүүс илүү ядуу байна.Тэдний дийлэнх нь гэр хороололд, ялангуяа Баянзүрх, Сонгинохайрхан зэрэг хотын захын дүүрэгт, гэр хороололд амьдарч байгаа юм.

Хотын хүн амын эрчимтэй өсөлтийг дагасан нийгмийн салбарын хөрөнгө оруулалт ялангуяа гэр хорооллын хүн амд маш бага хийгдэж байгаа нь, нөгөө талаас хөрсний бохирдол, агаарын бохирдлын голомтод байгаа нөхцөл нь тухайн өрхүүдийг орчны хувьд баталгаагүй, эмзэг байдалд оруулж байна.

Товч дүгнэлт, эргэцүүлэл

Өгүүллийн төгсгөлд хэд хэдэн асуулт болон бодлогын асуудлыг дэвшүүлэх нь зүйтэй хэмээн үүнийг бичигч үзэж байна.

Хотын хүн амын өсөлт цааш үргэлжилсээр байх уу?. Тийм үргэлжилсээр байх болно. Сүүлийн20 гаруй жилийн хотын хүн амын жилийн дундаж өсөлтөд тулгуурлан тооцож үзэхэд 2023 он гэхэд хотын хүн ам 2 саяд хүрэх төлөвтэй байна. Гэхдээ хотын тэлэлт, сарнилын онолоор урт хугацаанд авч үзэхэдУлаанбаатар хотын хэт төвлөрөл их удлаа гэхэд 10 жилийн дараа агаар, ус хөрс гм орчны бохирдлоос үүдэн цаашид задрах ба шинээр дагуул хотууд үүсэхэд хүргэнэ. Энд уул уурхай дагасан Багануур гмхотууд, шинэ дэд бүтэц дагасан Налайх гм хотууд/жишээ нь боловсрол гм/ бий болох нь дамжиггүй.

Хотын хүн ам, нийгэм эдийн засгийн хэт төвлөрлийг сааруулах бололцоо байгаа юу?. Мөн л тийм боломж нөхцөл бий. Дэлхийн улс орнууд ын нийслэлд хүн амын хэт төвлөрлөөс үүдэлтэй хүрээлэн буй орчны бохирдлын асуудал тулгамдсан шинжтэй суурь асуудлын нэг бөгөөд энэ тохиолдолд нийслэлээ нүүлгэн шилжүүлэх, нийслэлийн дэргэд шинэ дагуул хот байгуулах, дагуул хотыг өргөжүүлэх замаар хүн амын хэт төвлөрлийг сааруулж, тогтвортой хөгжил бүхий хүн амын суурьшлын бодлогыг хэрэгжүүлж ирсэн байдаг. Иймд аймаг, орон нутагт хүн амыг тогтвортой суурьших нөхцлийг төр засгийн зүгээс хангахын зэрэгцээ нийслэлийн хувьд Зуун мод гм хотыг дагуул хот болгох арга хэмжээг нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай. Дээрх арга хэмжээг авахгүйгээр цаашид шилжин суурьшил энэ хэвээр явагдвал хөдөөд хүнгүй, хотод гишгэх газаргүй болно. Шинэ суурьшлын бүсүүд байгуулахгүйгээр шилжин суурьшлыг зөнд нь орхивол нөхцөл байдал өмнөхөөс хүндэрч, хотын хөгжил удаашрах болно.

Хот орчмын бүсийн ядуурлын цар хүрээг хэрхэн хумих вэ?

Нэрт социологич Х.Гүндсамбуу Монголын ядуурал туйлын бус харьцангуй төлөвтэй. Монголын ядуус ах дүүсийн дэм, таван хошуу малын буян, байгаль дэлхийн хишиг гээд гуравдагч ертөнцийн бусад орнуудтай харьцуулахад тартагтаа тулдаггүй. Хамгийн гол нь тэднийг халамжид бус хөдөлмөрт дагуулах ёстой (Х.Гүндсамбуу, 2002) гэсэн нь өнөөгийн хотжилтоос үүдсэн хөгжлийн сорилтуудын шийдэл, цаашилбал улс оронд тулгамдаад буй асуудлыг шийдвэрлэх бодлогын үндсэн учиг, чиг хандлага болж байна.

Тэрчлэн Улаанбаатар хотын захын болон алслагдсан дүүргүүдэд ядуурлын нөхцөл байдал жилээс жилд ихэсч, өрхийн амьдрах нөхцөл дордож байгаа нь Улаанбаатар хот орчмын ядуурлыг тусгайлан судлах хэрэгцээ шаардлага байгаагтодорхой харуулж байна.

Улаанбаатар хотын ядуурал бол байгал цаг уурын нөлөөллөөс илүүтэй төрийн бодлого, эдийн засгийн хөгжил зэрэг нийгэм, эдийн засгийн нийтлэг хүчин зүйлээс хамаарч байдаг тул бусад улс орны ядуурлын асуудалтай харьцуулагдах хэмжээний үр дүнг гаргахболомжтой юм.

Хотын орчмын ядуурлын өсөн нэмэгдэх үйл явцад ган зудад мал ахуй, амьжиргаагаа алдсан иргэдийн хөдөөнөөс хот руу шилжин ирэх хөдөлгөөний эрчимжилт нөлөөлж байна.Хотод шилжин ирэгсдийн 72.7 хувь нь Баянзүрх, Сонгинохайрхан,Багануур дүүргүүдэд шинээр суурьшсан байна. Эдгээр дүүргүүд хотын захад байрладаг,мөн хөдөөгөөс шилжин ирсэн өрхүүд зөвшөөрөлгүйгээр оршин суух буюу газарнуггийн хувьд тэлэх боломжтой нь шилжин ирэгсдийг хүлээн авах гол бүс болоходнөлөөлж, улмаар эдгээр дүүргүүдэд ядуурал өндөр байх, газар нутгийн хувьд тэлэх үндэс болж байна.

Угтаа төрийн бодлого шилжих хөдөлгөөний улмаас үүссэн асуудлын хойноос, гал унтраах хэлбэрээр явах учиргүй бөгөөд шилжих хөдөлгөөн, хотжилт, хүн амын дахин суурьших үйл явцыг урьдчилан харах бодлого стратеги одоогоор байхгүй байна. Нөгөө талаар хүн амын төвлөрлийн ачааллыг даахгүй, төрийн үйлчилгээ хоцролттой жигд бус, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээнээс шилжин суурьшигчид хоцрох хандлага ажиглагдаж байна.

Abstract

The article was written with evidence and fact to identify human settlement some faced problems during urbanization process in Mongolia. Furthermore, author analyzed urban planning experiences of the developed countries and territorialization ofMongolian cities and its perspectives.

Ашигласан ном зохиол, материал

- United Nations Organization. (1998). *Sustainable development of human settlements: Achievements and challenges in housing and urban policy in Latin*. Geneva: UN.
- А.Гидденс. (2006). *Социологи*. Улаанбаатар: Адмон хэвлэл.
- М.Батбаатар. (2016). *Монголчуудын амьдралын чанарт хийсэн социологийн дүн шинжилгээ*. Улаанбаатар: Соёмбо хэвлэл.
- МУЗГ, НҮБХХ. (2004). *Хүний хөгжлийн илтгэл*. Улаанбаатар: МУЗГ.
- НҮБХХ, Х. (2004). *Хотын ядуурал ба шилжих хөдөлгөөн*. Улаанбаатар: Мөнхийн үсэг.
- НХХЯ, НҮБХХ. (2004). *Улаанбаатар хотын ядуурал ба шилжих хөдөлгөөн судалгааны тайлан*. Улаанбаатар: Адмон хэвлэл.
- НХХЯ. ХАССТ. НҮБХАС. (2001). *Монголын дотоод шилжих хөдөлгөөний микро түвшний судалгааны тайлан*. Улаанбаатар: Адмон.
- УИХ. (1993). *Хот байгуулалтын тухай Монгол улсын хууль*. Улаанбаатар: УИХ.
- Үндэсний хөгжлийн хүрээлэн. (2011). *Хүн амын нутагшилт, суурьшил, хөдөлмөрийн зах зээлийн судалгаа*. Улаанбаатар: ҮХХ.
- ҮСГ. (1998). *Амьжиргааны түвшний судалгаа*. Улаанбаатар: ҮСГ.
- ҮСГ. (2010). *Улаанбаатар хотын хүн ам, эдийн засгийн үйл ажиллагаа*. Улаанбаатар: ҮСГ.
- ҮСГ, Дэлхийн банк, НҮБХХ. (2004). *Өрхийн орлого, зарлага, амьжиргааны түвшний түүвэр судалгааны тайлан*. Улаанбаатар.
- ҮСХ, Дэлхийн банк. (2009). *Ядуурлын хандлагын шинжилгээний үр дүн*. Улаанбаатар: Дэлхийн банк.
- Х.Гүндсамбуу. (2002). *XX зууны Монголын нийгмийн давхраажил. УБ.2001*. Улаанбаатар: Удирдлагын академи.
- ХАЗССТ. (2008). *Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний чиг хандлага, үр дагавар судалгааны тайлан*. Улаанбаатар: Адмон.
- ШУА. (2013). *Proceedings of the Mongolian Academy of Sciences. Volume 53, No02(206) 2013*. Улаанбаатар: ШУА.
- ШУА. (2014). *Монгол дахь хотжилт: үйл явц ба төлөв байдал*. Улаанбаатар: ШУА хэвлэл.
- ШУА, ФСЭХ. (2014). *Монгол дахь хотжилт: үйл явц ба төлөв байдал*. Улаанбаатар: ШУА хэвлэл.
- ЭМЯ. (2013). *Хүн амын үзүүлэлтийн өөрчлөлт, өнөөгийн байдал*. Улаанбаатар: ЭМЯ.

ИСЛАМЫН УЛС ТӨРИЙН СЭТГЭЛГЭЭ

А. ЖАМБАЛ

ШУА-ийн Философи, Эрхийн Хүрээлэнгийн

Эрдэм шинжилгээний ажилтан

(Islamic Political Thought – Исламская политическая мысль) ислам шашны тулгуур ном судрууд болон эл шашны сэтгэгч мэргэдийн бүтээлд томъёологдон боловсорсон улс төрийн үзэл санаа, үзэл баримтлал, номлол, сургаалын цогц нийлбэрийг ерөнхийд нь нэгтгэж нэрлэсэн ойлголт болно. Тус сэтгэлгээний үүсэл хөгжил нийтийн он тооллын VII зуунд үүсэж бий болсон ислам шашин, түүний тулгуур хөлгөн судар болох Коран, Кораны тайлбар (тафсир), Сунна ба Хадисууд, түүнчлэн шашны сэтгэгч, эрдэм номтой зүтгэлтэнүүдийн зохиол бүтээлд тусгалаа олжээ. Ислам шашны улс төрийн сургаал номлолын тулгуур үзэл санаа, үндэс Коран сударт томъёологджээ.

VII зуунд Арабын нэгдсэн Халифат улс байгуулагдах, ислам шашин нийт арабуудын нэгдмэл шашин шүтлэг болж бүрэлдэн хэвших үйл явц орон, цаг хугацааны хувьд давхцаж нэгэн зэрэг явагджээ. Үүний эрхээр шинээр үүсэн бүрэлдэж байсан ислам шашин нь тэр үед нэгдсэн халифат төр улсыг мөн адил шинээр байгуулагдах үйл явцыг нэг талаар шашны агуулгатай нийгэм, улс төр, ёс зүй, эрх зүйн болон эдийн засгийн үзэл санаа, сургаалын хэлбэрээр өөртөө тусгасан, нөгөөтэйгүүр тэрхүү үйл явцад өөрийн сургал, номлол, хэм хэмжээнүүдээр дамжуулж эргэж идэвхитэй нөлөөлж байв. Үүний дагуу Исламд шашин төрийг хослон барих, шашны номлол ба улс төрийн бодлого хоорондоо салшгүй холбоотой, нэгдмэл байх ёс зарчим, үзэл санаа бүрэлдэн тогтжээ. Коран сударт төр, засаг, улс төрийн бодлого, эрх зүй, хууль цааз, нийгмийн хэв журмын талаар олон чухал заалт тэмдэглэгдсэн байна. Тэдгээрийг ерөнхийд нь тоймлон дурдбал нийгэм бол хүмүүсээс бүрэлдэж бүтнэ. Хүмүүс төрөлхийн тэгш бус, харилцан адилгүй, нэг хэсэг нь ухаантай, баян чинээлэг, өөр нэг хэсэг нь ухаан мөхс, залхуу хойрго, ядуу зүдүү байдаг. Үүнээс шалтгаалж хүмүүсийн хооронд нийгмийн ялгаа үүсэж, нэг нь нөгөөгөө удирдах, захирч засаглах, бүхэлдээ нийгмийг дэг журамтай байлгах хэрэгцээ шаардлага гарна. Энэ зорилтыг төр гүйцэтгэнэ. Төр, төрийн тэргүүн бол нэг ёсондоо Аллахаас газар дэлхийд тогтоосон зүйл, түүний хүсэл зоригийн илрэл, хэрэгжилт болно. Тиймээс төрийн эсрэг гэмт хэрэг үйлдэх, нийгмийн дэг журам, амаглан тайвныг эвдэж үймээн самуун дэгдээх, төрийн албан үүрэг, даалгаварыг зөрчих, үл биелүүлэх явдлыг хатуу цээрлэх тухай олон заалт Коранд томъёологджээ.

Коран ба Суннад Исламын төр засаг ямар хэлбэр, зохион байгуулалттай байх, төрийн үйл ажиллагаа ямар механизм, арга хэрэгсэлээр явагдаж зохицуулагдах талар тодорхой заалт тусгагдаагүй ажээ. Гэвч төрийн засаглалыг хэрэгжүүлэх амьдралын

зайлшгүй шаардлагаар Ислам шашны эрдэм номтой сэтгэгч мэргэд Коран ба Суннаг нягтлан судлах, тэдгээрийн нийгэм, улс төр, эрх зүйн үзэл санаа, утга агуулгыг чөлөөтэй тайлбарлах замаар Исламын төр улс, түүний засаглалын хэлбэр, зохион байгуулалт, эрх баригчийн тухай шашны агуулгатай улс төр, эрх зүйн номлол сургаалыг боловсруулж холбогдох ном бүтээлүүдийг туурвижээ. Тэд ингэхдээ Аллах бол төрийн засаглал, хууль цааз, эрх зүйн цорын ганц эх үндэс, нийгэм, улс төр, эдийн засаг, хүмүүсийн ахуй амьдралд юу зөвшөөрөгдөх, юу хориотой байх, ямар зүйл буян, ямар нь нүгэл болохыг заагч болох тухай Кораны заалт, үзэл санааг үндэс тулгуур болгосон байна.

Төрийн тухай Ислам шашны сургаал, төрийн эрх зүйн онолоор гарсан бүтээлүүдийн дотроос хамгийн нэр хүндтэй нь XI зууны шашны эрх зүйч эрдэмтэн аль-Мавардигийн (974-1058) халифатын тухай сургаал бөгөөд тэрбээр Исламын төр засгийн эрхэм сайн загварыг боловсруулан гаргажээ. Тэр нь Ислам шашны хамгийн нөлөөтэй, гол урсгал чиглэл болох Суннитын улс төрийн номлолын үндэс болсон байна. Суннитын улс төр, эрх зүйн номлол ёсоор мусульманчуудын төр засаг нь төр ба шашны дээд эрх мэдлийг нэгэн зэрэг имам бөгөөд халиф бүхий нэг хүн хослон барих, мусульманы төр засаг нэгдмэл, хуваагдашгүй, нэг тэргүүнтэй байх, төрийн тэргүүн нь Мухаммадын нэгэн адил арабын курейш овгоос гаралтай, төгс төгөлдөр хүмүүжил, эрдэм номтой байх, төрийн тэргүүн халиф нь нэг бол ард түмний сонголтоор, эсвэл өмнөх халифын гэрээслэл, саналаар төр барих, халиф ба мусульманы нийгэм хоорондоо хамтын гэрээтэй, нэг нь нөгөөгийнхөө өмнө үүрэг, хариуцлага хэлээнэ.

Ислам шашны урсгал чиглэлийн улс төрийн номлол, төрийн засаглал, түүний дээд эрх мэдлийн тухай сургаал ёсоор исламын халифат төрийг Мухаммадын зүй ёсны залгамжлагч Али ба түүний үр удам угсаа залгамжлан барих ёстой.

Ислам шашны шийтийн улс төрийн сэтгэлгээний уламжлалд шашны ариун дайн (жихад) энх тайван, Исламын газар нутаг, геополитикийн тухай сургаал чухал байр суурь эзлэнэ.

Ислам шашны төр, засгийн тухай номлол исламын орнуудын нийгэм, улс төрийн амьдрал, бодит байдлаас хөндий, шашны хийсвэр сэтгэлгээний хүрээнд боловсрогдож иржээ. Халифат төр засгийн тухай ислам шашны номлол XIX зууны дундаас XX зууны дунд үе хүртэлх үед дахин сэргэж, шашны сэтгэгчдийн анхаарлыг татаж тэд уг асуудлыг шинэ эрин цагийн нөхцөл байдалтай уялдуулан авч үзжээ. Энэ явцад боловсрогдсон үзэл баримтлал, номлолын дотроос XIX зууны ислам шашны шинэтгэлийн хөдөлгөөний үзэл сурталч, онолч Рашид Ридагийн (1865-1935) сургаал чухал байр суурь эзлэнэ. Тэрбээр <<Халифат буюу Агуу их Имадат>> гэсэн сонгодог бүтээлдээ төрийн засаглалын төгс төгөлдөр, шилдэг хэлбэрийг ислам шашин бий болгосон бөгөөд халиф бол Аллахын газар

дэлхий дэх сүүдэр юм, ислам шашин ба исламын улс орнуудын сэргэн мандалтад халифат төр улс шийдвэрлэгч үүрэг гүйцэтгэнэ, халифат төр исламын зарчим, шариат хуулинд бүрэн захирагдах ёстой, халифат төр, түүний улс төрийн систем төгс төгөлдөр бөгөөд тэдгээрт Европын парламентад ёс, үндэсний төрийн бүрэн эрх, тусгаар тогтнол, шүүх засаглалын тухай үзэл санаа, аль хэдийнээс агуулагдсан гэжээ. Рида үүний зэрэгцээ исламын орнууд дахь нийгмийн хоцрогдолыг бодитой харж үзэж түүнээс ангижран хөгжиж дэвжих ёстой, үүнд нийгмийн шинэтгэлд хамгийн түрүүнд хөл тавьж ололт амжилтанд хүрсэн Турк улс үлгэр жишээ болж чухал үүрэг гүйцэтгэнэ гэжээ.

XIX зуунд ислам шашинтай улс орнуудын дотроос Египет, Сири, Ливан зэрэг орны соёл, оюун санааны амьдралд шинэ ахиц дэвшил гарч түүнийг нахда буюу арабын сэргэн мандалт гэж нэрлэх болжээ. Үүний дагуу эдгээр оронд шашны шинэтгэлийн хөдөлгөөн үүсэж түүний үзэл санааг шашны нэрт зүтгэлтэн Жамаль ад-Дин аль-Афгани (1893-1897) үндэслэн боловсруулсныг түүний шавь, Египетийн нэрт сэтгэгч, эрх зүйч Мухаммад Абдо (1849-1905) цааш үргэлжлүүлэн цэгцтэй сургаал болгож хөгжүүлсэн байна. Тэд Ислам шашныг ойлгож, шүтэн баримталж ирсэн дундад зууны уламжлалт, догматик, хөшүүн үзэл хандлагыг арилгах, исламыг шинэ цагийн нийгмийн дэвшилт харилцаа, амьдралд нийцүүлэх, барууны соёл, иргэншлийн тэргүүний бөгөөд дэлхийн ард түмнүүдэд нийтлэг ач холбогдолтой ололт амжилтаас суралцах, тэгэхдээ өөрийн үндэсний соёл, иргэншил, түүхэн онцлог, бие даасан байдлаа алдахгүй байх, хөгжлийн араб-мусульманы онцлогтой өвөрмөц зам чиглэл бий гэдгийг мартаж болохгүй гэжээ.

XIX-XX зууны исламын улс төрийн сэтгэлгээнд панисламизм, мусульманы үндэсний үзэл, исламын ардчилал, хөгжлийн исламын замнал, загвар, исламын социализм гэсэн үзэл баримтлал боловсрогдон гарч тэдгээрт ислам шашны нийгэм-улс төрийн сэтгэгчид ислам шашинтай улс орон, ард түмнүүд эв нэгдэлтэй байх, ислам шашинтай холбоотойгоор бий болсон соёл, үнэт зүйл, хөгжлийн өөрийн гэсэн өвөрмөц замнал, загварыг эрхэмлэн баримтлах, тэдгээрийг шинэ эрин цагийн нөхцөл байдал, шаардлагатай зүй зохистой хослуулах тухай үзэл санааг дэвшүүлэн тавьжээ.

Утга зохиол:

- IPSA Encyclopedia, Kurian (eds) Encyclopedia (2010)
- A History of Muslim Philosophy (Ed. By M.M. Shorif. Vol. I-II. Wiesbaden, 1966)
- Adams C.J. Key political concepts in the Quran/Islamic Studies. 1971.
- Crone Patricia. Medieval Islamic Political Thought. Edinburgh. 2005
- Степанянц М.Т. Мусульманские концепции в философии и политике (XIX-XX вв.) М., 1982

- История политических и правовых учений. Средние века и возрождение. Отв.ред В.С.Нерсесянц. М., 1986
- Фролова Е.А.История арабо-мусульманской философии. М., 1995
- Туманян Т.Г.Философия идеальной власти. Политические концепции средневекового ислама. Санкт-Петербург, 2009

АРАБЫН УЛС ТӨРИЙН СЭТГЭЛГЭЭ

А. ЖАМБАЛ

ШУА-ийн Философи, Эрхийн Хүрээлэнгийн

Эрдэм шинжилгээний ажилтан

(Arab Political Thought- Арабская Политическая мысль)- өөрсдийгөө <<аль-араб>>- <<даянч, аглаг суугч>>(оросоор- пустынный) гэж нэрлэдэг семит угсааны арабуудын дундад зууны үеийн соёл, иргэншил, төрт ёсны түүхэн явцад үүсэн боловсорч уламжлагдсан улс төрийн үзэл санаа, номлол, шашны улс төрийн сургаалын цогц нийлбэрийг нэрлэж илэрхийлсэн ойлголт. Арабын улс төрийн сэтгэлгээ, арабын философи, эсвэл арабын соёл гэсэн ойлголтын утга агуулга болзвол, харьцангуй бөгөөд учир нь тэдгээр сэтгэлгээ, соёлыг зөвхөн арабууд төдийгүй Дундад зуунд Арабын Халифат гүрний ноёрхол дор оршиж байсан бусад улс орны ард түмнүүд ч хамтран бүтээлцэж чухал хувь нэмэр оруулжээ. Арабын философи, улс төрийн сэтгэлгээний бүтээлүүд нэгдмэл араб хэлээр бичигдсэн тул тэдгээрийг заримдаа араб хэлээрх философи, араб хэлээрх нийгэм-улс төрийн сургаал гэж нэрлэдэг.

Арабууд Араб орон (Arabia- Аравия) гэж нэрлэгддэг Арабын хойг буюу Өмнөд Азийн баруун хэсэг, Хойт Африк дахь одоогийн Саудын Араб, Кувейт, Катар, Оман, Йемен, Иордан, Арабын Нэгдсэн Эмират Улсын нутаг дэвсгэрийг бүхэлд нь, Сири, Иракийн зарим хэсгийг багтаасанЕвроазийн өргөн уудам нутагт нийтийн он тооллын өмнөх хоёр дахь мянганаас овог аймгийн зохион байгуулалтаар тархай бутархай оршин сууж ирснийг ислам шашныг үндэслэгч зөнч мэргэн Мухаммад VI зууны сүүлч, VII зууны эхний гучаад жилд өөрийн хамтран зүтгэгчдийн хамт цэрэг-улс төр, шашны үйл ажиллагаагаараа нэгтгэн Арабын халифат улсыг байгуулан бэхжүүлжээ. Халифат төр улс богино хугацаанд хүчирхэгжин Хойт Африк, Дундад Ази, Ар Кавказын ард түмэн, Испанийг эзлэн эрхшээж зургаан зуун жил орчим оршин тогтжээ. Халифат гүрний дотоод гадаад амьдралын улс төр, хууль эрх зүй, нийгэм-эдийн засаг, соёл, шашны олон талтай үзэгдэл, үйл явц нь арабын нийгэм-улс төрийн болон философи, эрх зүйн сэтгэлгээний үүсэл тэрлэл, хөгжилд шимтэй хөрс суурь болсон байна. Үүний дээр Арабын халифат төрийн эрх баригчид эртний Грек, Ромын хөгжингүй соёл, философи, нийгэм-улс төрийн сэтгэлгээ, мэдлэгийн баялаг өв санг уламжлан авч тэдгээрийн үндсэн дээр шинжлэх ухаан, урлаг, утга зохиол, уран барилга, ер оюуны соёлыг эрхэмлэн хөгжүүлэхэд ихээхэн анхаарч байв. Энэ нь арабын философи, нийгэм-улс төрийн сэтгэлгээний хөгжилд чухлаар нөлөөлжээ.

Арабын улс төрийн сэтгэлгээний үүсэл хөгжил нь ислам шашны үүсэл, дэлгэрэлт, ялангуяа түүний нийгэм, улс төрийн номлол, сургаалтай холбоотой. Гэхдээ арабын улс

төрийн сэтгэлгээ ба ислам шашны улс төрийн сэтгэлгээ хоорондоо багагүй ялгаатай, хоёр дахь нь эхнийхээсээ агуулга, багтаамж, хүрээ тархцаараа өргөн, зөвхөн арабууд ба Халифат гүрний харьяанд байсан орнууд төдийгүй ер ислам шашин дэлгэрсэн бусад улс орны сэтгэгч мэргэдийн бүтээл туурвилыг ч өөртөө багтааж агуулна.

Арабын улс төрийн сэтгэлгээний сонгодог төлөөлөгч бол Аль-Фараби, Ибн Рушд, Ибн-Халдун нар болно. Аль-Фараби одоогийн Казахстаны нутаг Сыр-Дария мөрний орчим төрсөн, 870-950 онд аж төрж, туурвин бүтээсэн, тухайн үеийн байгаль шинжлэл, философи, нийгэм-улс төр, хүмүүнлэгийн ухааны мэдлэгт нэвтэрсэн агуу их эрдэмтэн, сэтгэгч, <<арабуудын анхны гүн ухаантан>> гэж алдаршсан, Аристотелийн бүтээлүүдийг гүнзгий судлаж тайлбар бичсэн, нийгэм-улс төрийн үзэл сургаал нь томъёологдон туссан гол бүтээл нь <<Буянтай хотын оршин суугчдын үзэл бодолууд>>, <<Төрийн зүтгэлтний онч мэргэн үгс>>, <<Иргэний улс төр>> гэсэн зохиолууд юм. Аль-Фараби улс төрийн мэдлэг ухаан нь ач буянтай засаг захиргааг ямар аргаар хэрхэн зохион байгуулж хэвийн ажиллуулах, хот орны оршин суугчид хэрхэн яаж ач буянтай болж, түүнийгээ яаж эзэмшин хүртэх вэ гэдгийг судална гэж үзээд үлгэр жишээч хот улс бүхий төгс нийгмийн загвар, дүр зургийг боловсруулан гаргахыг зорьжээ. Тэрбээр хүний нийгмийг газар дэлхийн бүх хүн ардыг нэгтгэсэн агуу том нийгэм, аль нэг тодорхой ард түмний буюу дунд зэргийн нийгэм, аль нэг хот орны хүн ард оршин суух бага нийгэм гэж ангилаад төр улс бол тухайн нийгэмд аж төрөн буй хүн ардын ёс суртахууны нийтлэг нэгдэл юм. Тиймээс хүн ард буян ба нүгэл, аз жаргал, хөдөлмөрт хэрхэн яаж ханддагаар нь төр буюу хот улс нь ач буянтай, хамтын, харанхуй бүдүүлэг гэсэн гурван хэв маягтай байна гэжээ. Ач буянтай, үлгэр жишээч төр улс нь эрдэм мэдлэг, нийтийн аз жаргал, сайн сайханд үндэслэж орших ба төр баригчид нь нийгэм нийтийн ашиг тусыг эрхэмлэнэ. Тийм төр улсад: 1. Ухаантан мэргэд ба нэр хүндтэй бусад хүмүүс, 2. Санваартан, яруу найрагчид, хөгжимчид, бичээчид, 3. Тоо бүртгэгч, газар хэмжигч, эмч, зурхайч, 4. Цэрэг дайчид, 5. Өмч хөрөнгөтэй баячууд буюу тариалан, цэцэрлэг эрхлэгчид, худалдаачид гэсэн нийт таван давхраа, бүлэг оршин суудаг ажээ. Ач буянтай төр улсын эсрэг хэв маяг бол харанхуй бүдүүлэг төр улс юм. Түүний хүн ардын хоорондын харилцаанд нүгэл, эсрэг тэсрэг эрх ашиг ноёрхоно, эрх баригчид нь ёс суртахуунгүй, мэдлэг чадвар муу, хувийн ашиг тусаа бодож эрхэмлэнэ. Хамтын төр улс нь ач буянтай ба харанхуй бүдүүлэг төр улсын засварын шинж чанартай юм. Эл төр улсын хүн ардын дотор харанхуй бүдүүлэг хүмүүс олонх болж, ач буянтай, эрдэм мэдлэгтэй хүмүүс цөөхөн байх ажээ. Аль-Фарабигийн улс төрийн үзэл санаанд Платоны улс төрийн сургаалын нөлөө ажиглагддаг.

Ибн-Рушд 1126-1198 онд аж төрж туурвин бүтээсэн, Европ дахинд Авверрээс гэж алдаршсан бөгөөд түүний философи, нийгэм-улс төрийн үзэл сургаалын үндэс нь

<<хоёр үнэний >> онол юм. Тэрбээр үүний дагуу бодит байдлыг танин мэдэх философийн ба шашны гэсэн хоёр үнэн байдаг, жирийн олон түмэн мэдлэгийг зөвхөн шашны сургаалын хэлбэрээр олж эзэмшинэ, философийн үнэн зөвхөн эрдэмтэн мэргэдэд хүртээлтэй, шашин хэдийгээр улс төрийн урлаг болоод үлгэр жишээч, төгс төгөлдөр төрд хэрэгтэй боловч нийгмийн амьдрал, төр улсыг эрдэм мэдлэгийн үндсэн дээр зохион байгуулж, төрийн эрх мэдлийг шашны төлөөлөгчдөд олгохгүй байж болно гэж үзжээ. Хүмүүс оюун ухаан, бие бялдар, чадвараараа төрөлхийн тэгш бус байдаг учраас нийгэм янз бүрийн анги, давхраа, бүлэгт хуваагдах нь жам ёсны юм. Хэдийгээр тийм боловч нийгэмд нийтлэг эрх ашиг, зорилго бий бөгөөд тэдгээрийг хэрэгжүүлэн хангах хэрэгцээ шаардлагаар төр бий болж байгуулагдана. Үлгэр жишээч төгс төр нь хүмүүсийн хамтын нийтлэг, нийгэмлэг болж сайн үйл ба эрдэм мэдлэгт үндэслэж зохион байгуулагдах ёстой, төр улсад нийгмийн ажил үүрэг ба хөдөлмөрийг хуваарилах хэрэгтэй., тэр нь хүмүүс, анги давхраа, бүлгүүдийн хоорондын харилцан туслалцаа ба бие биеэсээ харилцан хамааралтай байх явдлыг хангана. Төр улсад шашны зүтгэлтнүүдийн ноёрхлыг тогтоож болохгүй, төрийн дээд эрх мэдлийг ач буянтай, мэргэн ухаантай иргэдийн сонгосон эрх баригч хэрэгжүүлбэл зохино, төр шударга, төрөлжин салбарласан хуулийн тогтолцоонд тулгуурлах ёстой. Төр улсад шашин шүтлэг хэрэгтэй бөгөөд тэр нь өдөр тутам биеийн хөдөлмөр эрхэлдэг өргөн олон түмний оюун санааны хэрэгцээг хангана.

Дундад зууны арабын улс төрийн сэтгэлгээний хөгжилд арабын гарамгай эрдэмтэн сэтгэгч Ибн-Халдун (1332-1406) томоохон хувь нэмэр оруулжээ. Түүний гол бүтээл бол гурван боть <<Их түүх>>(<<Сургамжтай үлгэр жишээний шаштир ном>>), <<Мукаддима>> буюу <<Удиртгал >> болно. Ибн-Халдун нийгэм ба төрийг хооронд нь ялган авч үзээд тэдгээр тус бүрийн үүсэл, хөгжил, уналт задралын жам ёс, үе шатуудыг шинжлэн илэрхийлэх зорилт тавьжээ. Түүний улс төрийн сургаалийн чухал онцлог, ололт бол тэрбээр төрийн асуудлыг санаалаг загвараар, онолын үүднээс төдийгүй тухайн үеийн мусульманы төр улсуудын түүх, бодит байдлын жишээ баримтаар авч үзэж түүх, философи, социологийн аспектээр нэгтгэн дүгнэсэн явдал болно.

Ибн-Халдун хүмүүс өөрсдийн аж амьдрал, оршин тогтнолынхоо хэрэгцээг тус тусдаа ганцаарчилсан байдлаар хангаж чадахгүй тул хамтарч, хөдөлмөрөө хуваарилах замаар хангах, бас өөрсдийгөө гадны аюулаас хамтарч хамгаалах, түүнчлэн хүмүүс өөрсдийнхөө угийн түрэмгий шинж чанарын элдэв илрэлээс бие биеэ хамтарч урьдчилан сэргийлэх зорилгоор хамтын амьдралын зохион байгуулалттай хэлбэр болгож нийгмийг үүсгэн байгуулж нэгдэн нийлсэн гэжээ. Нийгэмд хүрээлэн буй байгаль орчин, түүний уур амьсгал, соёл, шашин нөлөөтэй байх боловч аж ахуйн хэлбэр, үйлдвэрлэлийн арга, хэрэгсэл шийдвэрлэгч үүрэгтэй болно. Үүний дагуу нийгэм бүдүүлэг буюу

<<хөдөөгийн>>, иргэншил буюу <<хотын>> төлөв байдал бүхий хоёр үе шатыг дамжин хөгжинө. Эхний үед хүмүүс зөвхөн тариалан ба мал аж ахуй эрхэлнэ, хүмүүс энэ үед хэрэгцээнээсээ илүү зүйл үйлдвэрлэж чадахгүй, амьдрал ахуй нь адил тэгш байна. Хоёр дахь шатад гар урлал, худалдаа, шинжлэх ухаан, урлаг бий болж хөгжинө, хөдөлмөрийн хуваарь гарч илүү бүтээгдэхүүн буюу баялаг үйлдвэрлэгдэнэ, түүгээр нийгэмд баян ядуугийн ялгаа, тэгш бус байдал гарна, чухам үүгээр нөхцөлдөж төр бий болох бөгөөд түүний зорилго, мөн чанар нь илүү бүтээгдэхүүн бүхий баялагийг нийгмийн тодорхой хэсэг нь хувьдаа эзэмшиж өмчилсөн хувийн өмчийг хамгаалах явдал болно. Нийгмийн хөгжлийн эхний бүдүүлэг буюу <<хөдөөгийн>> төлөв байдлын шатад хүмүүс цусан төрлийн харилцаагаар тэгш байдлаар аж төрнө, тэднийг овгийн ахлагч элдэв хүч албадлагагүйгээр удирдаж зохион байгуулна.

Эдийн засгийн үндэс шалтгаанаар болон нийгмийг засаглан захирах хэрэгцээ шаардлагаар бий болсон төр цаашдаа үүрэг, үйл ажиллагаагаа эдгээр чиглэлээр улам хүчтэй болгож татвар хураах төдийгүй худалдаа арилжаанд хөндлөнгөөс оролцож бараа бүтээгдэхүүнийг хүч албадлагаар хамгийн хямд үнээр худалдан авч эргүүлээд хамгийн өндөр үнээр худалдаж зах зээл, эдийн засгийг уналтад оруулна, энэ нь эргээд төр өөрөө хүч суларч нурахад хүргэнэ. Төр яваандаа анх тулгуурлаж үүссэн нийгмийн бааз сууринаасаа хөндийрч хөлсний хүч буюу үүсмэл, зохиомол бүлэгт тулгуурлах ба тэр нь бат найдвартай биш учраас төр суларч унах бас нэг шалтгаан болно.

Ибн-Халдун тийнхүү аливаа төр урт удаан хугацаагаар бат бэх, тогтвортой оршин тогтож чадахгүй, үүсэл төлөвшил, хөгжил цэцэглэлт, доройтол уналт гэсэн гурван үе шатыг давтамжаар дамжин солигдоно. Эл давтамж 120 жилд нэг удаа тохиолдох бөгөөд тэр нь тухайн төр засгийг барьж хаанчилсан удамынхны гурван үеийнхний амьдралын хугацаатай тохирч холбогдоно. Аливаа төр засаг 120 жилийн настай байдаг нь дотоод шалтгаанаараа төр барьсан удамынхны гурван үеийнхний ёс суртахуун, эрхэмлэл, аж төрөх ёсны шинж чанар, төлөв байдлын уруудалт, эвдрэлтэй нягт холбоотой. Эхний үеийнхэн даруу төлөв, хоорондоо эв нэгдэлтэй, тэгш байдалтай байна, хоёр дахь үеийнхэн хээнцэр тансаг, эрх танхи, хоорондоо тэгш бус, дайсагнасан харилцаатай, тэгсэн хэрнээ аймхай, өөрөө өөрийгөө хамгаалах чадваргүй тул хөлсний арми, хамгаалагчтай байна, гурав дахь үеийнхэн ёс суртахуун, амьдрал үйл ажиллагаагаараа бүрэн доройтон мөхснөөр төр улс мөн задарч жижиг хэсгүүдэд хуваагдна, эсвэл гадны төр улсуудад эзлэгдэж мөхнө. Тухайн төр улсын оршин тогтнолын давтамжит хугацаа дотроо таван шаттай. Эхний шатад төр үүсэхээс өмнөх үе шувтарч хүч албадлагад тулгуурласан засаг захиргаа бий болно, хоёр дахь шатад эрх баригч анх өөрт нь засгийн эрхэнд гарахад туслан дэмжсэн хамтран зүтгэгчдээ хэрцгийлэн дарж эрх мэдлийг гартаа авч ганцаар захирна, гурав дахь

шатад төр улс тогтвортой, тайван, дэг журамтай, хөгжил цэцэглэлттэй болно, дөрөв дэх шатад эрх баригч сөрөг хүчнийхнийг хүч хэрэглэж хэрцгийлэн дарж хатуу хахир дэглэм тогтооно, тав дахь шатад төр улс уруудан доройтож мөхнө.

Ибн-Халдун хаант засгийг явуулж буй улс төрийн бодлого, үйл ажиллагаа, шашин, захирах захирагдах харилцаагаар нь гурван хэлбэрээр ангилжээ. Эхнийх нь <<жам ёсны>> хаант засаг бөгөөд тэр нь хэрцгий дарангуй төртэй, зөвхөн эрх баригчдын ашиг сонирхолыг хамгаалж биелүүлдэг, хүчирхийлэлд тулгуурладаг. Хоёр дахь хэлбэр нь <<улс төрийн хаант засаг>> бөгөөд түүний төр нь улс төрийн ухаалаг бодлого явуулна, харьяат ардын аж амьдралын эрх ашгийг хамгаална, гэхдээ бодлого, үйл ажиллагаа нь шашны үнэт зүйл, эрхэмлэлтэй холбоогүй байдаг дутагдалтай. Гурав дахь хэлбэр нь <<халифат>> төр засаг бөгөөд тэр нь шашин шүтлэг, нийгэм, нийтийн тайван байдал, дэг журмыг хамгаалан хангана, ийм нөхцөлд мусульманчууд өөрийн эзэн хаантай байна. Ер эдгээр гурваас хамгийн үлгэр жишээч, төгс төгөлдөр нь шашин төрийн дээд эрх мэдлийг хослон барьсан <<халифат>> төр болно.

Дундад зууны арабын улс төрийн сэтгэлгээ Ибн-Халдуны улс төрийн онол, сургаалаар хөгжлийнхөө оргил оройдоо хүрсэн бөгөөд түүнээс цааш ахиж хөгжөөгүй, үндсэндээ зогссон, энэ нь арабын орнууд Туркийн байлдан дагууллаар Османы эзэнт гүрний ноёрхол дор урт удаан оршсон, энэ үед мэдлэг ухаан, нийгэм-улс төрийн сэтгэлгээ эзэнт гүрний бодлого, ноёрхлыг хамгаалж илэрхийлсэн шашны номлолтон, сүм хийдийн явцуу бүлэгүүдийн нөлөөнд орж хумигдсантай холбоотой байв.

Утга зохиол:

- IPSA Encyclopedia, Kurian (eds) Encyclopedia (2010)
- Abu-Rabi, Ibrahim. Contemporary Arab Thought: Studies in Post 1967 Arab Intellectual History. London: Pluto, 2004
- Browsers, Michaele. Democracy and Civil Society in Arab Political Thought: Truncultural Possibilities. Syracuse.N.Y. Syracuse University Press, 2006
- Бартольд В.В. Работы по истории ислама и Арабского халифата. М., Восточная литература, 2002
- Беляев Е.А. Арабы, ислам и арабский халифат в раннее средневековье. М., 1996
- Григорян С.Н. Средневековая философия народов ближнего и Среднего Востока. М.,1966
- Туманян Т.Г. Философия идеальной власти. Политические концепции средневекового ислама. Санкт-Петербург, 2009
- Избранные произведения мыслителей стран Ближнего и Среднего Востока. IX-XIV вв. Составители: С. Н. Григорян и А.В. Сагадеев. М.,1961

- Левин З.И. Развитие арабской общественной мысли (О некоторых течениях после второй мировой вайны). М.,1984
- Фролова Е.А. История арабо-исламской философий. М., 1995

ЕВРЕЙН УЛС ТӨРИЙН СЭТГЭЛГЭЭ

А. ЖАМБАЛ

ШУА-ийн Философи, Эрхийн Хүрээлэнгийн

Эрдэм шинжилгээний ажилтан

Еврейн улс төрийн сэтгэлгээ (Jewish Political Thought-Еврейская политическая мысль)- еврей үндэстний шашин номын хүмүүс, нийгэм-улс төр, гүн ухааны сэтгэгчдээс еврейчүүдийн овог, аймаг, нийгэм, улс төрийн амьдрал, төрийн байгуулал, шашин ба төр, ард иргэд ба хааны хоорондын харилцаа, захирах захирагдах ёс, Израйлын төр улсын түүх, хувь заяа зэрэг асуудлыг эргэцүүлэн бясалгаж сэтгэсэн гурван мянга орчим жилийн түүхтэй үзэл санаа, сургаал, номлол, үзэл суртал, онолын баримтлалын цогц нийлбэрийг илэрхийлсэн ерөнхий ойлголт. Еврейн улс төрийн сэтгэлгээ нь еврей угсааны ард түмний түүх, нийгэм, улс төрийн амьдрал, бусад орон, үндэстэнтэй харилцсан гадаад харилцаа зэрэг түүхэн нөхцөл, бодит байдлыг тусган бүрэлдэж, уламжлагдан иржээ. Еврейн улс төрийн сэтгэлгээ өрнөдийн улс төрийн сэтгэлгээний уламжлалаас хэд хэдэн онцлогоороо ялгаатай бөгөөд тэдгээр нь өрнөдийнх шиг философийн ямар нэг тогтолцоонд голлон суурилаггүй, төр ёсны урт түүхтэй уламжлал, төрийн аль нэг тогтвортой байгууллын тусгал болж хязгаарлагдаагүй, хамгийн сайн засаг төрийг хэрхэн яаж үүсгэн байгуулах вэ гэсэн асуултыг шууд тавьж хариу тайлбар өгөөгүй явдал юм. Еврейчүүдийн улс төрийн сэтгэлгээ ерөнхийдөө тухайн түүхэн тодорхой нөхцөл байдлыг цаг үед нь амьдрал практикийн шаардлагын үүднээс тусгасан, гэхдээ иудайн шашны номлол сургаалтай ихээхэн холбоо хамааралтай байсаар ирсэн нь зонхилно. Еврейн улс төрийн сэтгэлгээний түүхэнд домог, шашны нөлөө, уламжлалаас харьцангуй ангид, бие дааж туурвигдсан улс төрийн алдартай шаштир, зохиол бүтээл, системтэй онол номлол боловсрогдон гараагүй байна. Гэвч еврейн улс төрийн сэтгэлгээ, түүний тодорхой үзэл санаа, сургаал, заавар баримтлал Библийн Хуучин гэрээс буюу Тора, Талмуд, шашны санваартнуудын сургаал, айлдал, нийтийн дүрэм журам, хуулийн бичиг баримт, уран зохиол, түүхийн ном бүтээл, философич, нийгэм-улс төрийн сэтгэгчдийн зохиолд тодорхой хэмжээгээр тусгалаа олж тэмдэглэгджээ. Тэдгээр нь еврейн улс төрийн сэтгэлгээний түүхийг тодорхой эх сурвалжаар авч үзэж судлах үндэс болдог.

Төр засгийн гарал үүсэл, зорилго, зохион байгуулалт, хэлбэрийн тухай эртний еврейн бичиг номын хүмүүсийн үзэл санаа, ойлголт, үнэлгээ нь Торад тусгагджээ. Еврейн ард түмэн эртний үед овог аймгийн зохион байгуулалттайгаар элсэн цөлд нүүдэллэн аж төрж байсныг Тора сударт өв тэгш, маш зохистой цаг үе байсан, учир нь энэ үед нийгмийг Бурхан тэнгэр өөрийн хуулиар зарц Моисейгээр дамжуулан засаглаж байснаар нийгмийн байгуулал дээд зэргийн төгс төгөлдөр хэлбэртэй байсан гэжээ. Торад үүний зэрэгцээ үе

удам залгамжилсан хаант төрийн тухай үзэл санаа агуулагджээ. Тэр нь нэг талаар Бурхан тэнгэр ард түмнээ өөрөө шууд эрхшээн засаглана гэсэн үзэл санаанд хаант төр харшилна, гэхдээ хаант төр зайлшгүй хэрэгтэй гэж үзснээрээ зөрчилтэй, хоёрдмол утга санаатай ажээ. Энэ нь эртний Израилийн нийгмийн тодорхой хэсэг нь овог аймгийн зохион байгуулалтын уламжлалд илүү талтай байсан, нөгөөтэйгүүр хаант засгийн тухай израилчуудын ойлголтод хөрш зэргэлдээ Египет, Месопотамийн төр ёс, иргэншил дам байдлаар нөлөөлсөнтэй холбоотой. Библийн Хуучин гэрээний хэсэгт хаант засаг нь бурхнаас хүмүүст хайрласан тэнгэрлэг бэлэг биш, гэхдээ газар дэлхий дэх энэ амьдралын энгийн жирийн байгуулал ч биш гэсэн хоёрдмол санаа агуулагджээ. Эзэн хаан төрийг Бурхны хуулиар үнэнч шударгаар барих ёстой, тэрээр шашин мөргөлд үйлчилж тодорхой хэмжээний ариун үүрэг гүйцэтгэх боловч шашин, сүм хийдийн тэргүүн биш, мөн бурханлаг, ер бусын шинж чанартай биш, гэхдээ онцгой эрх мэдэл эдлнэ.

Эртний еврейчүүдийн улс төрийн үзэл санааны нэгэн чухал элемент бол хаан ба ард түмний хоорондын гэрээний тухай ойлголт юм. Эл ойлголт шашны утга агуулгатай бөгөөд гэрээний оролцогч нь эзэн хаан ба ард түмэн, бурхан гурав болно. Хааны эрх мэдэл Бурхны хуулийг сахин биелүүлэхэд оршино, түүнээс хэтрэх ёсгүй, гэхдээ хаан ард түмний өмнө биш, бурхны өмнө хариуцлага хүлээнэ, хааныг буруу үйлдлийн нь төлөө зөвхөн бурхан гэсгээнэ, тэр шийтгэлээр хааны ирээдүйн үр удам хаан ширээг залгамжлахгүй.

Хуучин гэрээс буюу Торагийн дараах еврейчүүдийн нэн чухал шаштир бол Талмуд бөгөөд түүнд улс төр, үзэл суртал, шашин шүтлэг, аж амьдрал, хууль эрх зүйн олон талтай асуудлыг шашны номлолын үүднээс тусган тогтоожээ. Талмудыг тайлбарлаж номлосон шашны бичиг номын хүмүүс хаан төрийн тухай Библи судрын үзэл санааг авч үзэхдээ төр, улс төрийн бодлогын мөн чанар, үүрэг зорилгын талаар онол, үнэлэмжийн утга агуулгатай санаа бодолуудыг өгүүлжээ. Тэд төр бол амин чухал байгууллага бөгөөд түүний гол зорилго, үүрэг нь нийгэм ба бие хүмүүсийн амьдралыг сайжруулах, боловсронгуй, төгөлдөр болгоход туслах явдал болно гэсэн үндсэн санааг хэлжээ. Энэхүү ерөнхий үзэл санааны хүрээнд дээд төр амар амгалан, сайн сайхан, засаглан захирах хүч чадал төгөлдөр байвал зохино, эс тэгвээс хүн ард төр засгаас сүрдэн айхаа больж бие биеэ барьж иднэ; нийгмийн дэг журамыг хангаж боловсронгуй болгох цорын ганц зөв арга, бодит бололцоо бол төрийн сүр хүч, албадлага биш, харин энх тайван, Бурхны хаанчлалыг тогтоох явдал юм. Төр нь соёл, иргэншлийг бий болгож хөгжүүлэх, гүүр, зам, барилга, халуун усны газар барьж байгуулах үүрэгтэй гэх зэрэг санаа бодол гарч байжээ.

Еврейчүүд нэгдмэл төр улсаа алдаж, харийн эрхшээл ноёрхолд орж, дэлхийн олон оронд цагаачлан тарж бутарсан түүхтэй боловч энэ байдалд аядуу хандсан үзэл санаа тэдний улс төрийн сэтгэлгээнд нэг биш удаа гарч байжээ. Еврейчүүд харийн төр засагт

дагаар орохгүй, захирагдахгүй байх, гадны нөлөө ноёрхлыг идэвхтэй эсэргүүцэн тэмцэх хэрэгтэй гэсэн үзэл санааг еврейн сэтгэгчид үндсэндээ дэмжээгүй, гэхдээ харийнхан еврейн шашин шүтлэг, уламжлалт аж төрөх ёсыг хавчиж гадуурхсан, еврейчүүдэд их гүрний эзэн хааныг тахин шүтэхийг шаардаж шахсан зэрэг онцгой тохиолдолд эсэргүүцэн тэмцэж болно гэсэн үзэл баримтлагдаж байв.

Ард түмний оюун санааны удирдагчид засгийн эрх баригчдад нөлөөлдөг, тэдний алдаа бурууг шүүмжилдэг, гэхдээ төрд хүндэтгэлтэй ханддаг байх ёстой гэж Талмудыг тайлбарлан сурталчилагсад сургажээ.

Дундад зуунд еврейн улс төрийн сэтгэлгээнд еврейчүүд еврей бус эрх баригчдын засаг дор хэрхэн яаж орших, Торагийн хууль, эрх зүйн сургаал нь эртний болон дундад зууны үеийн өрнөдийн улс төрийн сэтгэлгээний уламжлалаас давуу болох тухай асуудлыг голон авч үзсэн үндсэн хоёр чиглэл товойн гарчээ. Эхний чиглэлээр онолын чанартай, цэгцтэй ямар нэгэн сургаал боловсрогдоогүй боловч нэгд, еврейн хүй нэгдэл, овог аймгийн байгуулал нь угтаа өв тэгш, зүй зохистой юм, хоёрт, еврейчүүдийн хувьд тэднийг захирсан христ ба мусульманы төр засаг нь өөрийн харьяат иргэд, хэсэг бүлгийг ямар хэмжээгээр албадах вэ гэдэг нь тодорхой байвал зохино гэсэн хоёр үзэл санаа дэвшин гарчээ.

Еврейн улс төрийн сэтгэлгээний дээр дурдсан хоёр дахь чиглэлийн гол төлөөлөгч нь Маймонид бөгөөд тэрбээр хүн бол угаасаа улс төрийн амьтан учраас нийгмээс ангид гадуур оршиж чадахгүй, гэвч хүмүүсийн зан авир эрс өөр өөр байдгаас шалтгаалж нийгмийн дэглэм өөрөө аяндаа тогтохгүй, түүнийг төр засаг бий болгож тогтооно. Нийгмийн тогтвортой, хүч нөлөөтэй дэглэм нь хүмүүсийн биеийн ба оюун санааны хэрэгцээг хангах зорилготой, эхнийх нь хүмүүсийн аюулгүй байдал, материаллаг хэрэгцээ, хоёр дахь нь хүний оюун ухааны хөгжил, үнэнийг танин мэдэх хэрэгцээ юм. Маймонид үүнийг үндэслэл болгож улс төрчийн үүсгэн байгуулсан иргэний төр ба шашны зөнч мэргэний үндэслэн байгуулсан бурханлаг, өв тэгч, үлгэр жишээч төр гэсэн хоёр янзын төр байдаг, хоёр дахь төрийг чухамдаа Моисей байгуулсан бөгөөд түүний хууль нь төгс төгөлдөр, үнэнч шударга тул өөрчилж, зөрчиж болохгүй гэжээ.

Дундад зууны еврейн улс төрийн өөр нэг сэтгэгч Иехуда ха-Леви нийгмийн дэглэмийн зорилго нь нийгэм хийгээд түүний гишүүдийн амгалан тайван амьдралыг хангаж чадах өв тэгш ёслол журмыг тогтоож хэрэгжүүлэхэд оршино; түүний үлгэр жишээ бол Торагийн төр мөн бөгөөд тэр нь амьд бие организм болно; түүний зүрх нь иудайн шашны ариун сүм, бусад эрхтэн нь сүмийг тойрон хүрээлсэн еврейчүүдийн овог аймаг, үе удам юм; Торагийн төрийн энэхүү дэг журам бүхий зохион байгуулалт нийт хүн төрөлхтний ирээдүйн амьдралд үлгэр загвар болж хэрэгжинэ; түүний биелэлтийн илрэл

болж Израилийн ард түмэн Израил улсад хуран суурьшиж Иерусалим ба Ариун сүмийг тойрон оршиж өнө мөнхөд аж төрнө, дэлхийн бусад ард түмэн Израил улс, Израилийн ард түмнийг тойрон хүрээлнэ, үүгээр дэлхийд тарамдан бутарсан еврейчүүдийн цагаачлал, нэгдсэн төр улсгүй байсан түүх эцэс төгсгөл болж бурхны хаанчлал тогтно гэжээ. Энэхүү үзэл санааг сөрсөн дундад зууны ерейн улс төрийн сэтгэгч Иосеф Ибн Каспи бөгөөд тэрбээр дэлхийд тархсан еврейчүүд төрөлх эх орондоо ирж суурьшин орших нь ирээдүйн эсхатологи буюу хүн төрөлхтөн, ертөнцийн эцсийн хувь заяаны эрхээр биш, харин улс төрийн ердийн түүхэн үйл явцаар биелж хэрэгжих болно гэжээ.

Дундад зууны сүүлчээр христийн схоластик сэтгэлгээ ба Сэргэн мандалтын утга зохиолын нөлөөгөөр Испан, Итали дахь еврейн улс төрийн сэтгэлгээнд зарим шинэ үзэл санаа бий болжээ. Тухайлбал, еврейн сэтгэгч Ицхак Абраванель бодит төрийг хүний жам ёсны уг чанараас гажиж буруу зохион байгуулагдсан гэж эрс шүүмжилсэн боловч тэр нь Тораг шинээр үзэж ойлгох эх сурвалж болж чадаагүй. Бүхэлдээ дундад зууны еврейн улс төрийн сэтгэгчид төрийн онол, практикийн чухал асуудлуудад төдийлөн анхаарал хандуулж шинэлэг үзэл санаа дэвшүүлэн гаргаагүй, энэ нь еврейчүүд үндэсний төр улсгүй болсонтой холбоотой байв.

Шинэ үеийн эхэнд Нидерландын гүн ухаантан, еврей гаралтай Б. Спиноза Маймонидын үзэл санааг шүүмжилж сэтгэн бодох эрх чөлөөг хамгаалсан, сүх хийд төрийн хэрэгт оролцохыг буруушааж эсэргүүцсэн; иудайзм нь шашин төрийг хослосон теократ ёс бөгөөд Моисейн хууль еврейн ард түмэн боолчлолоос чөлөөлөгдсөн эхэн үед тэдэнд ач тус болсон ч яваандаа шашны эрх мэдэлтнүүдийн дарангуй ёс болж хувирснаар еврейчүүдийн улс төрийн түүхэнд тогтож байсан хоёр төр улс нурж унасан; цаашдаа еврейчүүд гадаад орчин ахуйд ойртон нягтрах, соёл, улс төрийн талаар нээлттэй байх нөхцөл бололцоо бүрэлдэхийн хэрээр тэд өөрсдийн аж амьдралын хаалттай, улс төрийн тусгаарлагдмал байдлаа ухаарч тэр нь улирч баларсан аж төрөх ёс болохыг ойлгох болно гэсэн үзэл санааг гаргажээ.

XVIII зуунд Германы соён гэгээрүүлэгч гүн ухаантан, еврей гаралтай Мозес Мендельсон Библийн хууль ёс хүмүүст агуу их эрх чөлөө олгож тэднийг эрх баригчдын дур зоргоос хамгаалсан; ер хэвийн нөхцөлд бүх шашны албадах арга хэрэгсэл, бололцоог нь үгүй болгож зөвхөн ёс суртахууны хүмүүжлийн эрх үүргийг нь хэвээр үлдээх хэрэгтэй, Бурхан өв тэгш, төгс төгөлдөр төрийн дээд эрх мэдлийг барьсан нь эртний түүхэнд нэг л удаа тохиолдсон бөгөөд дахин давтагдахгүй, гэхдээ Торагийн заавар тушаалыг еврейчүүд Бурханы өмнө ёсчлон биелүүлэх үүрэгтэй хэвээр байгаа болно гэжээ.

XIX-XX зуунд Баруун болон Төв Европт оршин суугаа Еврейчүүдийн нийгэм, улс төрийн амьдралд бий болсон шинэ нөхцөл байдал, үйл явдлаар нөхцөлдөж еврейн улс

төрийн сэтгэлгээнд иудайзмыг шинэтгэх, еврейчүүд өөрсдийн шашин шүтлэг, уламжлалт аж амьдралын зарчим, хэм хэмжээг хэвээр хадгалахын зэрэгцээ Европын соёл иргэншилд нээлттэй байж бусад үндэстэнтэй ойртон нягтрах тухай асуудал, еврейн социализм, сионизмын үзэл санаа дэвшин гарчээ.

Утга зохиол:

- IPSA Encyclopedia, Kurian (eds) Encyclopedia (2010)
- Encyclopedia Judaica (2nd ed., Vols.1-22).(2006).Jerusalim:Keter
- Политология: Энциклопедический словарь.М.,1993
- Философский Энциклопедический словарь.М.,1989
- История политических и иправовых учений. Древний мир. Под ред. В.С Нерсесянца. М., 1985

ПАНАРАБИЗМ БА ПАНИСЛАМИЗМ

А. ЖАМБАЛ

ШУА-ийн Философи, Эрхийн Хүрээлэнгийн

Эрдэм шинжилгээний ажилтан

(Pan-Arabism and Pan-Islamism- панарабизм и панисламизм- пан гэдэг нь эртний грек хэлний нармай, их, бүх гэсэн утгатай нийлмэл үгийн эхний хэсэг) Панарабизм нь арабууд өөрийн хэл, соёл, түүхтэй бие даасан тусгаар угсаатан ард түмэн бөгөөд угсаатны эдгээр шинж чанараараа эв нэгдэлтэй байж уламжлалт соёл, хэл, ёс заншил, аж амьдралынхаа хэвшлийг хадгалан хамгаалж мандан бадрах ёстой гэсэн үзэл санааг агуулсан нийгэм-улс төрийн номлол болно.

Панарабизм нь арабын орнуудыг эзлэн ноёрхож байсан Османы эзэнт гүрэн дэлхийн I дайнаар задран унасны дараа үүсэн бий болжээ. Энэ үе хүртэл арабууд Османы эзэн гүрний эзэмшил, ноёрхолыг эсэргүүцэн тэмцэж байсангүй. Панарабизмын үзэл санаа хийгээд түүнд үндэслэсэн панарабист хөдөлгөөн нь нурж унасан Османы эзэнт гүрнийг Европын том гүрнүүд европын эрх зүй ба засаг захиргааны зохион байгуулалтын хэлбэрээр өөрчлөн байгуулах, европын соёлын нөлөөг нэвтрүүлэхийг оролдсны хариу үйлдэл болж гарсан байна. Туркийн султан панарабист хөдөлгөөнийг дэмжиж өөрийн харьяаны араб угсаатныг нягтруулан нэгтгэж захирах арга болгохыг хичээж байв.

Панарабизм Их Британи, Францын колончилалыг эсэргүүцсэн, мөн Османы эзэнт гүрэн нурж унасны дараа түүний харьяанд байсан арабын орнууд тус тусдаа бие даасан улс болж байгуулагдахыг эсэргүүцсэн үзэл санааг агуулсны хамт улс төрийн эцсийн зорилго нь нийт араб угсаатан ард түмнийг нэгтгэх явдал байв. Үүнийг улс төрийн зарим хүч хөдөлгөөн, арабын орнуудын зарим удирдагчид харилцан ялгаатай байдлаар үзэн ойлгож байв. Тухайлбал баасистууд (Ba'athism) арабуудын эв нэгдэл гэдэг бол нийт арабуудыг нэгтгэсэн арабын үндэсний нэгдсэн төр улсыг байгуулах явдал гэж үзэж байсан бол Египетийн Ерөнхийлөгч асан Гамаль Абдель Насер арабын орнуудын төр засгийн эв нэгдэл, нягт хамтын ажиллагаа юм гэж ойлгож байв. Панарабизм 1967 онд арабын орнууд ба Израйлийн хооронд болсон дайн хүртэлх үед Ойрхи дорнод ба Хойд Африкийн орнуудын ард түмэнд итгэл найдвар төрүүлж дэмжигдэж байсан бол эл дайнд арабууд ялагсны дараа хүч нөлөө суларсны дээр арабын орнуудын төр засаг хамтран ажиллах, нийтлэг эрх ашгийн төлөө нэгдэж нягтрах сонирхолгүйгээр үл барам хоорондоо сөргөлдөх болсноор исламын улс төрийн үзэл сурталд байр сууриа бүрэн алджээ. Энэ үеэс панарабизмын оронд панисламизм хүч түрэн гарч иржээ.

Панисламизм нь дэлхийн нийт мусульманчууд үндэс угсаа, нийгмийн гарал, байдал, иргэний харьяаллаасаа үл шалтгаалан ислам шашин шүтдэг нийтлэг шинж

чанараараа улс төрийн хувьд нягтран нэгдэж мусульманчуудын оюун санааны дээд удирдагч болох халифын засаг дор захирагдах ёстой гэсэн үзэл санааг баримтлан сурталчилдаг шашин-улс төрийн үзэл суртал юм.

Панарабизм нь арабууд ямар шашин шүтдэг, ямар улс оронд аж төрдөгөөсөө үл шалтгаалан араб угсаатан ард түмэн гэсэн шинж чанараараа нягтран нэгдэх ёстой гэдэгт үндэслэн тулгуурладаг бол панисламизм нь мусульманчууд зөвхөн араб үндэстэн угсаатаны шинж чанараараа биш, исламыг шүтдэг нийтлэг чанараараа нэгдэх ёстой гэж үздэгээрээ хоорондоо ялгаатай.

Панисламизм хэдийгээр XIX зууны хоёр дахь хагаст үүсэн бүрэлдсэн боловч түүний зарим үзэл санаа зөнч мэргэн Мухаммед VII зуунд ислам шашныг үүсгэн үндэслэж түүний номлол дор арабын тархай бутархай овог аймгуудыг нэгтгэж нэгдсэн төр улсыг байгуулсан түүхэн үетэй холбоотой юм. Панисламизмыг шашин-улс төрийн үзэл суртал болгож үндэслэн номлосон анхны үзэл сурталч бол Египетийн шашин-улс төрийн сэтгэгч Жемаль ад-Дин аль-Афгани (1838-1897) юм. Тэрбээр панисламизмыг анхандаа исламын улс орнуудаас явуулсан Их Британы колончиллоос чөлөөлөгдөхийн төлөөх тэмцлийг үндэслэх зорилгоор томьёолон гаргажээ. Аль-Афгани болон түүний хамтран зүтгэгчид арабын орнууд дахь үндэсний тусгаарлах үзлийн эсрэгээр нийт мусульманчууд Египетийн хедив (төр баригч), эсвэл Ираны шах, нэг бол Туркийн султаны нэгдмэл засаг төрд харъяалагдан нэгдэж харийн колончиллоос чөлөөлөгдөн эв нэгдэл, нягтралын хүчээр дэвшин дээшилж сэргэн мандаж чадна гэж үзжээ. Тэдний эдгээр үзэл санааг ислам шашинтай арабын болон бусад орны төр засгийн удирдагчид, нийгмийн янз бүрийн давхраа бүлэг өөр өөрийн эрх ашиг, санаа зорилгоор ойлгон ашиглаж байв. Дэлхийн II дайны дараа панисламизмын чөлөөлөх үзэл санаа, номлол тодорхой хэмжээгээр өөрчлөгджээ. Палестинд еврейчүүдийн төр улс болох Израйль байгуулагдаж, 1967 оны дайнд арабууд Израйлд ялагдснаар арабын шашны номлолтон сэтгэгчид мусульманчуудын нэгдэл нягтралыг хангах, Израйлийг ялан дийлж нураахын тулд исламын тулгуур үзэл номлолд эргэн орох хэрэгтэй гэх болжээ. Үүний нөлөөгөөр Египет дэх <<Мусульманы ахан дүүс>> хөдөлгөөн, арабын бусад орон дахь панисламистууд өөрийн орны төр засагтай сөргөлдөн тэмцэлдэж засгийн эрхийг булаан эзлэхийг оролдсон ч хатуу дарагдаж байв. Ираны панисламистууд 1979 онд Исламын хувьсгалаар Пехлеви Мохаммадыг шахын суудлаас буулгаж хөөн явуулжээ.

Панисламизм сүүлийн үед исламын эв санааны нэгдлийн асуудлыг түлхүү номлож мусульманы олон улсын янз бүрийн байгууллага байгуулах, өөр шашин, соёл иргэншилтэй барууны болон бусад орны нөлөө оролцоог сөрж зогсоох тухай үзэл санааг сурталчилах болжээ. Гэвч панисламизмын үзэл санаанд ислам шашны суннит ба шийт

чиглэлийн хоорондын болон тэдгээрийг тус тус баримталдаг арабын орнуудын хоорондын тэмцэл, дайн хүчтэй цохилт болж байна.

Утга зохиол:

- IPSA Encyclopedia, Kurian (eds) Encyclopedia (2010)
- Политология: Энциклопедический словарь. М.,1993
- Ислам: Энциклопедический словарь. М., 1991
- Жамбал А. Ислам шашин. УБ., 2005

ⁱ According to the Potsdam declaration, Korea was set free from the 36 years of colonialism, and the nation was recovered its liberty on August 15, 1945.

ⁱⁱ At that time, this Special Committee on Draft Constitution consisted of 30 assemblymen, along with 10 other experts or advisory specialists as Pak said in his book (Pak, 1976: 123).

ⁱⁱⁱ This activity or function of legislatures is also described as “linkage”, as some scholars have defined (See on Loewenberg and Patterson, 1979: 44; Kim and Pai, 1981: 1).

^{iv} The Constituent Assembly of the Republic of Korea adopted a constitution containing a basically this type of government in 1948 (Park, 1998: 65).

^v As Kim and Pai (1981: 37) noted in advanced manner, this legislature is the most important linkage institution.

^{vi} See on Chapter III, Article 52 of the Constitution of Korea or The National Assembly Act, Section 2, Article 79.

^{vii} For legislative procedures, see section IV. The Legislative Procedures for Acts and Subordinate Statutes, in the *Statutes of the Republic of Korea*, Vol. 1 xv-xviii (1997).

^{viii} *The Universal Declaration of Human Rights* is a declaration adopted by the United Nations General Assembly in 10 December 1948.

^{ix} *The Universal Declaration of Human Rights*, 1948: Article 21-3.

^x *State Great Hural Electoral Law*. 2005, Ch. One, Art. 7, Sec. 2.